49531 Төмөр замын, хөнгөн төмөр замын зам засвар, үйлчилгээний зориулалттай өөрөө явдаггүй тээврийн хэрэгсэл

БТКУС-ийн 8604 ангийг үзнэ үү.

49532 Төмөр зам, хөнгөн төмөр замын өөрөө явдаггүй суудлын галт тэрэг, тээшний галт тэрэг, шуудангийн үйлчилгээний болон тусгай зориулалтын суудлын галт тэрэг /зам засвар, эсвэл үйлчилгээний зориулалтын хэрэгсэл/

БТКУС-ийн 8605 ангийг үзнэ үү.

- 49533 Хөнгөн төмөр замын өөрөө явдаггүй ачааны галт тэрэг**
БТКУС-ийн 8606 ангийг үзнэ үү.
- 4954 Хөнгөн төмөр замын зүтгүүр, хөдлөх бүрэлдэхүүний эд анги, төмөр зам, хөнгөн төмөр замын эд анги болон тоноглол, тэдгээрийн тоног төхөөрөмж, төмөр зам, хөнгөн төмөр зам, авто зам, усан зам, зогсоолын байгууламж, боомтын тоног төхөөрөмж, аэродром болон тэдгээрт зориулсан механик /цахилгаан-механик/ дохиоллын, аюулгүй ажиллагааны, хөдөлгөөний хяналтын тоног төхөөрөмж, хэрэгсэл**
- 49540 Хөнгөн төмөр замын зүтгүүр, хөдлөх бүрэлдэхүүний эд анги, төмөр зам, хөнгөн төмөр замын эд анги болон тоноглол, тэдгээрийн тоног төхөөрөмж, төмөр зам, хөнгөн төмөр зам, авто зам, усан зам, зогсоолын байгууламж, боомтын тоног төхөөрөмж, аэродром болон тэдгээрт зориулсан механик /цахилгаан-механик/ дохиоллын, аюулгүй ажиллагааны, хөдөлгөөний хяналтын тоног төхөөрөмж, хэрэгсэл**
БТКУС-ийн 8607, 8608 ангийг үзнэ үү.
- 496 Хийн бөмбөлөг, дирижабль, дельтаплан, планер, дельтаплан, тэдгээрийн сэлбэг, эд анги**
- 4961 Агаарын бөмбөлөг, агаарт хөвөх, нисэх хөдөлгүүргүй хэрэгсэл, дельтаплан, дирижабль, планер болон бусад хөлөг**
- 49610 Агаарын бөмбөлөг, агаарт хөвөх, нисэх хөдөлгүүргүй хэрэгсэл, дельтаплан, дирижабль, планер болон бусад хөлөг**
БТКУС-ийн 8801 ангийг үзнэ үү.
- 4962 Нисэх онгоц, нисдэг тэрэг**
49621 Нисдэг тэрэг
БТКУС-ийн 8802.11, 8802.12 ангийг үзнэ үү.
- 49622 Цэвэр жин нь 2000 кг-аас ихгүй байх нисэх онгоц болон бусад төрлийн /хөдөлгүүртэй/ агаарын хөлөг**
БТКУС-ийн 8802.20 ангийг үзнэ үү.
- 49623 Цэвэр жин нь 2000 кг ба түүнээс дээш байх нисэх онгоц болон бусад төрлийн /хөдөлгүүртэй/ агаарын хөлөг**
БТКУС-ийн 8802.30, 8802.40 ангийг үзнэ үү.
- 4963 Сансрын хөлөг, хиймэл дагуул, хөлгийг хөөргөгч хэрэгсэл**
49630 Сансрын хөлөг, хиймэл дагуул, хөлгийг хөөргөгч хэрэгсэл
БТКУС-ийн 8802.60 ангийг үзнэ үү.
- 4964 Нисэх онгоц, сансрын хөлгийн сэлбэг, эд анги**
49640 Нисэх онгоц, сансрын хөлгийн сэлбэг, эд анги
БТКУС-ийн 8803 ангийг үзнэ үү.
- 499 Тээврийн бусад хэрэгсэл (хөдөлгүүргүй), тэдгээрийн сэлбэг, эд анги**
4991 Мотоцикл, гурван дугуйтай мотоцикл
49911 Цилиндрийн багтаамж нь 50 см³ ихгүй дотоод шаталтын ухрах, давших хөдөлгөөнөөр ажилладаг, бүлүүрэн хөдөлгүүртэй мотоцикл болон туслах хөдөлгүүртэй дугуй
БТКУС-ийн 8711.10 ангийг үзнэ үү.
- 49912 Цилиндрийн багтаамж нь 50 см³ дээш дотоод шаталтын ухрах, давших хөдөлгөөнөөр ажилладаг, бүлүүрэн хөдөлгүүртэй мотоцикл болон туслах хөдөлгүүртэй дугуй**

БТКУС-ийн 8711.20-8711.50 ангийг үзнэ үү.

49913 Дотоод шаталтын бүлүүрэн бус хөдөлгүүр бүхий мотоцикл, мотоциклийн шаахай

БТКУС-ийн 8711.90 ангийг үзнэ үү.

4992 Унадаг дугуй, хөгжлийн бэрхшээлтэй хүний тэрэг /тэргэнцэр/

49921 Дугуй, моторгүй бусад төрлийн дугуй

БТКУС-ийн 8712 ангийг үзнэ үү.

49922 Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тэрэг /тэргэнцэр/

БТКУС-ийн 8713 ангийг үзнэ үү.

4993 Механик биш тээврийн бусад хэрэгсэл

49930 Механик биш тээврийн бусад хэрэгсэл

БТКУС-ийн 8716.80 ангийг үзнэ үү.

4994 4991, 4992-р ангид хамаарах мотоцикл, дугуй, тэргэнцэрийн сэлбэг, эд анги

49941 Мотоцикл, мотоциклийн шаахайн сэлбэг, эд анги

БТКУС-ийн 8714.11, 8714.19 ангийг үзнэ үү.

49942 Унадаг дугуй, хөгжлийн бэрхшээлтэй хүний тэрэгний сэлбэг, эд анги

БТКУС-ийн 8714.20-8714.99 ангийг үзнэ үү.

5 БАРИЛГА, БАРИЛГЫН АЖИЛ, ҮЙЛЧИЛГЭЭ

Энэ салбарт барилга, барилгын ажил, үйлчилгээ багтана.

53 БАРИЛГА

Энэ дэд салбарт барилга угсралтын үйлдвэрлэлтийн дүнд бий болсон биет бүтээгдэхүүн /барилга, байгууламж/ орно.

531 Барилга, байгууламж

5311 Орон сууцны барилга

53111 Нэг эсвэл хоёр айлын зориулалттай орон сууцны барилга

Энэ дэд ангид нэг эсвэл хоёр айлын орон сууц орно.

53112 Нийтийн орон сууцны барилга

Энэ дэд ангид гурав ба түүнээс дээш айлын орон сууцны зориулалттай байшин орно. Мөн өндөр настны асрамжийн газар, оюутны байр, ажилчдын байр, асрах байр орно.

5312 Орон сууцны бус барилга

53121 Үйлдвэрийн барилга

Энэ дэд ангид дараах барилга, байгууламж орно. Үүнд:

- үйлдвэрийн газрын үйлдвэрлэлийн болон агуулахын бүхий л үйл ажиллагааг явуулахад ашиглагддаг барилга
- үйлдвэрийн газар, үйлдвэрийн газрын цех тасаг, засварын газрын барилга
- хөдөө аж ахуйн зориулалттай барилга, агуулах, зоорь

53122 Худалдаа, үйлчилгээний зориулалттай барилга

Энэ дэд ангид дараах барилга орно. Үүнд:

- бөөний болон жижиглэнгийн худалдааны үйл ажиллагааг явуулах барилга
- агуулах
- үзэсгэлэнгийн танхим
- албан газар, банкны барилга

- төмөр зам, авто замын буудал, нисэх буудал, машины зогсоол, бензин түгээгүүрийн цэг, өртөөний барилга

53129 Орон сууцны бус барилга

Энэ дэд ангид дараах барилга орно. Үүнд:

- кино театр, драмын театр, концертын танхим, бүжгийн танхим, шөнийн клуб зэрэг олон нийтийн чөлөөт цагийн үйлчилгээний барилга
- зочид буудал, дэн буудал, нийтийн байр, зоогийн газар болон тэдгээртэй төстэй барилга
- сургууль, коллеж, их сургууль, номын сан, архив, музей зэрэг боловсролын үйлчилгээний барилга
- хурлын танхим
- эмнэлэг, сувиллын газар зэрэг эрүүл мэндийн үйлчилгээний барилга
- мөсөн гулгуурын талбай, гимнастикийн талбай, гадаа задгай теннисний талбай, нийтлэг зориулалтын спортын цэнгэлдэх хүрээлэн, завины саравч, боксын дэвжээ зэрэг спортын эсвэл тоглоомын зориулалттай барилга, байгууламж
- шашны барилга байгууламж, шоронгийн барилга байгууламж
- дээр ороогүй орон сууцны бус бусад барилга

Уурхай, цахилгаан станц, химийн үйлдвэр болон төрөлжсөн бусад үйлдвэрийн барилга 5326-т, талбайн зориулалттай амралт, спортын байгууламж 53270-т орно.

532 Инженерийн байгууламж

5321 Иргэний инженерийн гүүрэн хурдны зам ба гудамжны зам, авто зам, төмөр замын суурь бүтэц, агаарын хөлгийн хөөрч буух зурвас

53211 Хурдны зам, хурдны гүүрэн зам, гудамжны зам, авто зам

Энэ дэд ангид дараах зам орно. Үүнд:

- гүүрэн хурдны замаас бусад хурдны зам, гудамжны зам, авто зам болон тээврийн хэрэгслийн болон явган хүний зам
- хамгаалалтын хашлага болон хучилттай авто машины зогсоол, жолоодлоготой зам, тээврийн хэрэгслийн болон явган хүний газар доогуурх болон дээгүүрх зам, унадаг дугуйны зам
- зам дагуу дохиолол, аюулгүйн систем зэрэг замын хөдөлгөөний суурилуулалт

Харин дараах зам орохгүй. Үүнд:

- гүүрэн хурдны зам (53221-д),
- газар доогуурх хурдны зам/туннель (53222-т орно).

53212 Төмөр замын суурь бүтэц

Энэ дэд ангид дараах зам орно. Үүнд:

- төмөр замын далан болон төмөр замын шилжүүлэгч, гудамжны трамвайны зам, газар доогуурх гүүрэн төмөр зам
- төмөр замын цахилгааны угсралт
- төмөр зам дагуу дохиолол, хяналтын систем зэрэг суурилуулалт
- дүүжин төмөр зам, хүн зөөх зориулалтын агаарын кабелийн тэргэнцэр

53213 Агаарын хөлгийн хөөрөх буух зурвас

Энэ дэд ангид барилгаас бусад агаарын хөлгийн хөөрч, буух зурвас зэрэг агаарын тээврийн суурь бүтэц орно.

5322 Гүүр, нүхэн гарц болон газар доорхи зам

53221 Гүүр, гүүрэн хурдны зам

Энэ дэд ангид дараах зам орно. Үүнд:

- бүх төрлийн авто тээврийн хэрэгсэл, явган хүнд зориулсан төмөр, бетон эсвэл бусад материалаар хийсэн гүүр, виадукт (хөндий дээгүүр тавьсан урт, өндөр гүүр)
- моторт тээврийн хэрэгслийн хөдөлгөөнд зориулсан гүүрэн хурдны зам

53222 Нүхэн гарц ба газар доорхи зам, метроны зам

Энэ дэд ангид дараах зам орно. Үүнд:

- авто замын, хурдны замын болон төмөр замын туннель

- газар доогуурх төмөр замын хөдөлгөөнтэй холбоотой бусад газар доогуурх байгууламж болон бусад туннелийн байгууламж

Харин дараах зам орохгүй. Үүнд:

- тээврийн хэрэгсэл болон явган хүний газар доогуурх гарц (53211-д),
- газар доогуурх төмөр замын шугам (53212-т)
- уул, уурхайн үйл ажиллагаатай холбоотой туннель (53261-д орно).

5323 Боомт, усан онгоцны зогсоол, далан, усжуулалтын болон бусад төрлийн байгууламж
53231 Усан хангамжийн зориулалтаар байгуулсан ус дамжуулах шугам (хоолой орохгүй)

Энэ дэд ангид ус хангамжийн зориулалтаар байгуулсан ус дамжуулах суваг (хоолой орохгүй) орно.

Харин дараах байгууламж, хоолойнууд орохгүй. Үүнд:

- усжуулалтын эсвэл ус хуримтлуулан, усны урсгалыг хянах байгууламж (53234-т),
- холын зайд дамжуулах хоолой (53241-д),
- хотын доторх дамжуулах хоолой (53251-д орно).

53232 Усан онгоцны зогсоол, боомт болон бусад төрлийн сувгийн байгууламж

Энэ дэд ангид усан онгоцны боомт, зогсоолын суваг, ус таслагч, давалгааны хаалт, далан, усан онгоцны зогсоол болон түүнтэй төстэй байгууламж, усан замын тээврийн зориулалттай гол, мөрний усны байгууламж орно.

53233 Далан

Энэ дэд ангид далайн эрэг болон усны эргийн далан болон адил төстэй байгууламж орно.

53234 Усжуулалтын болон үерийн хамгаалалтын байгууламж

Энэ дэд ангид усжуулалт, ус дамжуулах станцын үерийн хяналтын систем орно.

Харин усан хангамжийн зориулалттай усны суваг 53231-д орно.

5324 Алсын зайн шугам хоолой, холбоо, эрчим хүчний шугам (кабель)
53241 Алсын зайн бусад дамжуулах хоолой

Энэ дэд ангид газрын тос, хий, ус болон бусад бүтээгдэхүүнийг холын зайн хуурай замын ба усан замын тээврийн зориулалттай дамжуулах хоолой орно.

Харин хотын хий, усны түгээлтийн төвлөрсөн систем 53251-д орно.

53242 Алсын зайн холбоо, цахилгааны шугам (кабель)

Энэ дэд ангид дараах шугам орно. Үүнд:

- алсын зайд хуурай замын болон усан замын холбооны дамжуулах шугам
- алсын зайд өндөр хүчдэлтэй цахилгаан эрчим хүч дамжуулах шугам (кабель)

Харин бага хүчдэлийн цахилгаан эрчим хүч түгээх шугам 53252-д орно.

5325 Хот доторх дамжуулах хоолой, кабель болон холбогдох ажил
53251 Хот доторх дамжуулах хоолой

Энэ дэд ангид орон нутгийн зориулалттай хий, ус, ариутгах татуургын хоолойн дамжуулах хоолой, кабель орно. Мөн халуун ус, уур түгээх хоолой багтана.

53252 Хот доторх шугам кабель тавих ажил, үйлчилгээ

Энэ дэд ангид дараах байгууламж орно. Үүнд:

- цахилгаан эрчим хүч дамжуулах, түгээх шугам
- холбооны дамжуулах шугам (кабель)
- орон нутаг доторх түгээх дамжуулах зориулалтын антенн ба дамжуулах станц, дэд станцтай дамжуулах цамхаг

53253 Бохир ус зайлуулах шугам болон цэвэрлэх байгууламж

Энэ дэд ангид дараах байгууламж орно. Үүнд:

- бохир ус ариутгах систем, зайлуулах байгууламж
- урсгал ус ариутгах байгууламж

Цэвэр, бохир усны шугам, хоолойг суурилуулах угсрах ажил 54241-т орно.

5326 Уул уурхай, үйлдвэрийн барилга, байгууламж

53261 Уурхайн байгууламж

Энэ дэд ангид уул уурхай болон түүнтэй холбоотой тоног төхөөрөмж, жишээ нь ачих, буулгах өртөө, газар доорх уурхай хоолой, туннель орно.

53262 Уурхайн байгууламж

Энэ дэд ангид цахилгаан үйлдвэрлэн гаргах үйлдвэр, төхөөрөмж, цөмийн эрчим хүч үйлдвэрлэгч станц, түүний тоног төхөөрөмж орно.

53263 Химийн үйлдвэрлэлийн барилга, байгууламж

Энэ дэд ангид эм болон бусад химийн бүтээгдэхүүний үйлдвэр, зуухны тэсэлгээний болон кокс үйлдвэрлэлийн байгууламжийн химийн болон түүнтэй холбоотой үйлдвэрлэлийн байгууламж орно.

53269 Бусад боловсруулах төрлийн үйлдвэрлэлийн барилга, байгууламж

Энэ дэд ангид төмөрлөгийн үйлдвэр зэрэг аж үйлдвэрийн салбарын тусгай байгууламж орно.

- үндсэн химийн, химийн нэгдлийн болон химийн бусад бүтээгдэхүүний үйлдвэр
- төмөрлөг, ган боловсруулах болон коксын үйлдвэр
- төмөрлөгийн цутгамлын үйлдвэр
- бусад төрөлжсөн боловсруулах үйлдвэр

Харин боловсруулах аж үйлдвэрийн тусгайлсан бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн байгууламжаас бусад салбарын барилга 53121-д орно.

5327 Спорт, амралт чөлөөт цагийн зориулалттай талбай, барилга байгууламж

53270 Спорт, амралт чөлөөт цагийн зориулалттай талбай, барилга байгууламж

Энэ дэд ангид сагсан бөмбөг, бейсбол, регби, машины уралдаан, дугуйн уралдаан, морины уралдаан зэрэг задгай талбайд тоглодог спортын төрлийн талбай; гольфийн талбай, далайн эрэг, уул, зугаалгын завь, цэцэрлэгт хүрээлэн, амьтны хүрээлэн, парк зэрэг тоглоом, амралт, зугаалгын байгууламж, цогцолбор орно.

Харин үзэгчдийн суудалтай зориулалтын байртай спортын байгууламж 53129-д орно.

5329 Инженерийн бусад байгууламж

53290 Инженерийн бусад байгууламж

Энэ дэд ангид дараах иргэний инженерийн бусад байгууламж орно.

- хэрэм, хоргодох байр, нуувч, суудлын талбай, зэвсгийн шалгах төв зэрэг цэргийн инженерийн байгууламж
- сансрын хөөргөх зурвас
- хогийн цэг, хог шатаах цэг
- цөмийн хаягдал боловсруулах, цэвэрлэх байгууламж
- инженерийн бусад байгууламж

54 БАРИЛГЫН АЖИЛ, ҮЙЛЧИЛГЭЭ

Энэ дэд салбарт дараах ажил, үйлчилгээ орно. Үүнд:

- барилга байгууламжийн угсралтын өмнөх үйлчилгээ, орон сууцны болон орон сууцны бус барилга ба иргэний инженерийн байгууламжийг барих, засвар хийх, сэргээх ажил орно. Барилга угсралтын ажлын эцсийн шатны ажил ба барилга угсралтын үйл ажиллагааны үе шатуудын ажил

- барилгын байгууламж, барилга байшинг нураах болон барилгын тоног төхөөрөмжийг түрээслэх ажил, үйлчилгээ

- 541 Барилга угсрах ажил, үйлчилгээ**
- 5411 Орон сууцны барилга барих ажил, үйлчилгээ**
- 54111 Амины орон сууцны барилга барих ажил, үйлчилгээ**

Энэ дэд ангид амины орон сууцны барилга барих, засварлах, нөхөн сэргээх үйлчилгээ орно.

54112 Нийтийн орон сууц барих ажил, үйлчилгээ

Энэ дэд ангид нийтийн зориулалттай орон сууцны барилга, нийтийн байр, өндөр настны асрах байр, оюутны байр, ажилчдын байр зэрэг барилгыг барих, засах, шинэчлэх, сэргээн засварлах ажил үйлчилгээ орно.

Өндөр бетонон хийцтэй барилга барих ажил 54540-д орно.

- 5412 Орон сууцны бус барилга барих ажил, үйлчилгээ**
- 54121 Үйлдвэрийн зориулалттай барилга барих ажил, үйлчилгээ**

Энэ дэд ангид аж үйлдвэр, боловсруулах аж үйлдвэр, хөнгөн аж үйлдвэр, хөдөө аж ахуйн зориулалттай агуулах зэргийг барих ажил, үйлчилгээ орно.

Харин уул уурхайн зориулалттай барилга, байгууламжийг барих ажил, үйлчилгээ 54261-т, цахилгаан станц барих ажил, үйлчилгээ 54262-т, боловсруулах үйлдвэрийн төрөлжсөн байгууламж барих ажил үйлчилгээ 54269-т орно.

54122 Худалдаа, үйлчилгээний зориулалттай барилга барих ажил, үйлчилгээ

Энэ дэд ангид дараах оффисын барилга, банкны барилга, машины зогсоол, шатахуун түгээх цэг, худалдааны төв, агаарын тээврийн буудал, төмөр замын өртөө, автомашины зогсоол, буудал зэрэг худалдаа, үйлчилгээний барилга барих ажил, үйлчилгээ орно.

54129 Орон сууцны бус бусад зориулалттай барилга барих ажил, үйлчилгээ

Энэ дэд ангид дараах ажил, үйлчилгээ орно. Үүнд:

- кино театр, театр, концертын заал, бүжгийн заал, шөний клуб зэрэг нийтийн үзвэр үйлчилгээний газрын барилга барих ажил, үйлчилгээ
- зочид буудал, дэн буудал, буурчийн газар, дотуур байр, ресторан, түүнтэй адил төстэй барилга барих ажил, үйлчилгээ
- сургууль, коллеж, их сургууль, номын сан, архив, музей зэрэг боловсрол, үйлчилгээний салбарын барилга барих ажил, үйлчилгээ
- эмнэлэг, сувиллын газар зэрэг эрүүл мэндийн салбарын барилга барих ажил, үйлчилгээ
- мөсөн гулгуурын талбай, гимнастикийн танхим, теннис, заалны спортын төрлүүд, боксын дэвжээ/ринг зэрэг заалны спорт, амралтын газрын барилга барих ажил, үйлчилгээ
- усан сангийн барилга барих ажил, үйлчилгээ
- мөсөн гулгуурын талбай, гимнастикийн танхим, теннисийн заал, талбай зэрэг спорт, амралтын барилга, байгууламж барих ажил, үйлчилгээ
- харилцаа, холбооны үйлчилгээ үзүүлэх зориулалттай барилга барих ажил, үйлчилгээ
- шашны барилга, шоронгийн барилга зэрэг өөр ангид ороогүй орон сууцны бус барилга барих ажил, үйлчилгээ

- 542 Инженерийн байгууламж барих ажил, үйлчилгээ**
- 5421 Хурдны гүүрэн замаас бусад хурдны зам, авто зам, гудамж, төмөр зам, нисэх буудлын зам, талбай барих ажил, үйлчилгээ**
- 54211 Хурдны гүүрэн замаас бусад хурдны зам, авто зам, гудамжны зам барих ажил, үйлчилгээ**

Энэ дэд ангид дараах ажил, үйлчилгээ орно. Үүнд:

- хурдны зам, гүүрэн хурдны замаас бусад гудамж, авто зам, бусад тээврийн хэрэгсэл ба явган зорчигчийн зам, машины задгай зогсоолын байгууламжийг барих ажил, үйлчилгээ
- ерөнхий гүйцэтгэгчийн замын гадаргууг сэргээн засах ажиллагаа
- явган хүний зам, замын хөдөлгөөний зохицуулалттай зам барих ажил
- ослын хашлага, замын тэмдэг, жижиг тусгаарлагчтай хана суурилуулах ажил
- зам, төмөр замын заах тэмдэг, түүний засвар, үйлчилгээ
- төмөр замын байгууламжийг барих ажил, үйлчилгээ, тухайлбал:
 - > төмөр зам болон хайрга чулуу тавих үйлчилгээ
 - > гэрэлтүүлгийн аппарат, гарц, гармын тэмдэг суурилуулах ажил
 - > төмөр замын аюулгүйн болон хяналтын систем суурилуулах үйлчилгээ
 - > дүүжин төмөр зам, cable sag-ийн системийн барилга, байгууламжийн үйлчилгээ
- төмөр зам, нисэх онгоцны талбай зэрэг нисэх онгоцны буудлын нисэх, буух зурвас барих ажил, үйлчилгээ
- хуурай замын засвар, үйлчилгээ
- төмөр замын сэргээн засварлалт, үйлчилгээ
- зам болон автомашины зогсоол тэмдэг, тэмдэглэгээг будах үйлчилгээ орно.

Харин дараах ажил, үйлчилгээ орохгүй. Үүнд:

- гүүрэн хурдны зам, туннель, гүүрийн байгууламж барих ажил (54220-д),
- дамжуулах хоолой, кабель (ус, бохир ус, хий, цахилгаан эрчим хүч, телефон зэрэг)-тай холбоотой зам засварын ажил (5424, 5425-д),
- төмөр замаар дамжих цахилгаан эрчим хүчний шугамын байгууламжийг барих ажил, үйлчилгээ (54242-т орно).

54212 Төмөр зам барих ажил, үйлчилгээ

Энэ дэд ангид дараах ажил, үйлчилгээ орно. Үүнд:

- төмөр зам, түүний дагуух далан, шилжүүлэгч, коммутатор, гудамжны трамвайн зам, газар доогуурх эсвэл гүүрэн төмөр зам зэргийг барих, засварах, шинэчлэх ажил үйлчилгээ
- төмөр зам болон хайрга чулуу тавих үйлчилгээ
- гэрэлтүүлгийн аппарат, гарц, гармын тэмдэг суурилуулах ажил
- төмөр замын аюулгүйн болон хяналтын систем суурилуулах үйлчилгээ
- дүүжин төмөр зам, cable sag-ийн системийн барилга, байгууламжийн үйлчилгээ

54213 Агаарын хөлгийн хөөрөх буух зурвас барих ажил, үйлчилгээ

Энэ дэд ангид дараах ажил, үйлчилгээ орно. Үүнд:

- нисэх онгоцны талбай зэрэг нисэх онгоцны буудлын нисэх, буух зурвас барих ажил, үйлчилгээ

5422 Гүүр, хурдны гүүрэн зам тавих ажил, үйлчилгээ

54221 Гүүр, хурдны гүүрэн зам тавих ажил, үйлчилгээ

Энд гүүр, хурдны гүүрэн зам барих, засварлах, шинэчлэх, сэргээн засварлах ажил үйлчилгээ орно.

Энэ дэд ангид дараах ажил, үйлчилгээ орохгүй. Үүнд:

- авто зам, төмөр зам, нислэгийн зам, төв замын байгууламж барих ажил, үйлчилгээ (5421-т),
- барилгын төмөр угсралтын үйлчилгээ (54550-д орно).

54222 Гүүр, хурдны гүүрэн зам тавих ажил, үйлчилгээ

Энэ дэд ангид хурдны зам, авто зам, төмөр замын нүхэн гарц, төмөр замын газар доогуурх нүхэн гарц барих, засварлах, шинэчлэх ажил үйлчилгээ орно.

Харин устай холбоотой барилгын ажил үйлчилгээ 5423-т, төмөр хийцийн угсралт 54550-т орно.

5423 Усан онгоцны зогсоол, далан, суваг, усжуулалтын байгууламжийг барих ажил, үйлчилгээ

54231 Дамжуулах хоолойноос бусад усан хангамжийн суваг, түүнтэй адил төстэй байгууламж барих ажил, үйлчилгээ

Энэ дэд ангид усан сувагтай гүүр, усан суваг болон түүнтэй адил төстэй усны суваг зэргээс бусад сувгийг барих, засварлах ажил, үйлчилгээ орно.

54232 Боомт, түүнтэй адил төстэй байгууламжийг барих ажил, үйлчилгээ

Энэ дэд ангид далайн боомтын суурь, боомтын суваг, усны урсгал таслагч, усан зогсоол, боомтын тавцан, эрэг орчмын зогсоол, эдгээртэй адил төстэй байгууламж, усан замын дохиолол, боомтын хуурай зогсоол, усны хамгаалалт зэрэг байгууламжийг барих засварлах, шинэчлэн сэргээх ажил үйлчилгээ орно.

54233 Далан барих ажил, үйлчилгээ

Энэ дэд ангид далан, ус тогтоож барих зориулалттай бусад байгууламжийг барих, засварлах, шинэчлэх ажил үйлчилгээ орно.

54234 Усжуулалтын болон үерийн хамгаалалтын байгууламж барих ажил, үйлчилгээ

Энэ дэд ангид усжуулалт, үерийн усны хяналтын байгууламж барих, засварлах, шинэчлэх ажил үйлчилгээ орно.

Харин ус хангамж, нийлүүлэлттэй холбоотой усан замын ажил үйлчилгээ 54231-т орно.

54239 Бусад төрлийн усны байгууламж барих ажил, үйлчилгээ

Энэ дэд ангид дараах ажил, үйлчилгээ орно. Үүнд:

- үер, усны хаалт, хамгаалалтын байгууламж, ус тавих, өргөх систем, усан онгоцны зогсоол, гулсуулах зам, хаалтын систем зэрэг гидрохимийн байгууламжийг барих ажил, үйлчилгээ

- газар ухах үйлчилгээд, хад чулуу, шавар зайлуулагч болон бусад усны байгууламжтай холбоотой үйлчилгээ

- усан доорх ажил, үйлчилгээ (жолооч, шумбагч болон бусад техникийн) болон төрөл бүрийн усны инженерийн ажил, үйлчилгээ орно.

Харин дараах ажил, үйлчилгээ орохгүй. Үүнд:

- кабелийг далай, усанд байршуулах үйлчилгээ (54242-т),

- цахилгаан эрчим хүчний үйлдвэрийн барилга барих ажил, үйлчилгээ (54260-д),

- шон тулгуур суулгах үйлчилгээ (54511-д орно).

5424 Алсын зайн дамжуулах хоолойн, холбооны болон цахилгааны шугам тавих ажил, үйлчилгээ

54241 Алсын зайн дамжуулах хоолой тавих ажил, үйлчилгээ

Энэ дэд ангид дараах ажил, үйлчилгээ орно. Үүнд:

- хий, газрын тосны алсын зайд тээвэрлэх зориулалтын газар дээгүүрх, доогуурх, усан доорх дамжуулах хоолой тавих ажил, үйлчилгээ

- ус шахах станц болон адил төстэй байгууламжийг барих, засварлах, шинэчлэх, сэргээн засварлах ажил, үйлчилгээ

Харин дараах ажил, үйлчилгээ орохгүй. Үүнд:

- төвлөрсөн ус хуримтлуулах, ус цэвэршүүлэх байгууламжийг барих, угсрах, суурилуулах ажил, үйлчилгээ (54232-т),

- суваг, шуудууны үйлчилгээ (54330-д орно).

54242 Алсын зайн холбооны болон цахилгааны шугам тавих ажил, үйлчилгээ

Энэ дэд ангид дараах ажил, үйлчилгээ орно. Үүнд:

- алсын зайд өндөр хүчдэлийн шугам тавих ажил, үйлчилгээ

- алсын зайд усан доорх, газар доорх болон дээрх цахилгаан эрчим хүчний шугам тавих ажил, үйлчилгээ

- дамжуулах цамраг барих, засварлах, шинэчлэх ажил, үйлчилгээ

Харин дараах ажил, үйлчилгээ орохгүй. Үүнд:

- хотын доторх кабель тавих ажил, үйлчилгээ (54252-т),

- суваг, шуудууны үйлчилгээ (54330-д орно).

5425 Хот дотор дамжуулах хоолой, цахилгааны болон холбооны шугам тавих ажил, үйлчилгээ

54251 Хот дотор дамжуулах хоолой тавих ажил, үйлчилгээ

Энэ дэд ангид дараах ажил, үйлчилгээ орно. Үүнд:

- хот дотор цэвэр, бохир усны дамжуулах хоолой барих ажил, үйлчилгээ
- хот дотор халуун ус дамжуулах хоолой барих ажил, үйлчилгээ
- хот дотор хий, уур дамжуулах хоолой барих ажил, үйлчилгээ болон холбогдох туслах үйлчилгээ

Харин суваг, шуудууны үйлчилгээ 54330-д орно.

54252 Хот дотор холбооны шугам тавих ажил, үйлчилгээ

Энэ дэд ангид дараах ажил, үйлчилгээ орно. Үүнд:

- дамжуулагч станц, түгээх дэд станцын барилга барих ажил, үйлчилгээ зэрэг орон нутгийн зориулалалттай цахилгаан эрчим хүчний шугамын барих ажил, үйлчилгээ
- хот дотор холбооны шугам, дамжуулагч цамхагийн байгууламж барих ажил, үйлчилгээ
- хот дотор дамжуулах цамхаг барих ажил, үйлчилгээ
- хот дотор дамжуулах станц, антеннын байгууламж барих ажил, үйлчилгээ
- кабелийн телевизийн газар доорх шугамын байгууламжийг барих ажил, үйлчилгээ
- хот дотор кабель, түүнтэй холбоотой засвар, үйлчилгээ

Харин дараах ажил, үйлчилгээ орохгүй. Үүнд:

- *холын зайн холбоо, цахилгаан эрчим хүчний шугам тавих ажил, үйлчилгээ (54242-т),*
- *суваг, шуудууны үйлчилгээ (54330-д),*
- *барилга доторх кабелийн телевизийн шугам суурилуулах ажил, үйлчилгээ (54614-т орно).*

54253 Бохир ус зайлуулах байгууламж барих ажил, үйлчилгээ

Энэ дэд ангид ариутгах хоолойн систем, ус ариутгах, цэвэрлэх байгууламж барих, засварлах, шинэчлэх, сэргээн засварлах ажил, үйлчилгээ орно.

5426 Уул уурхайн болон үйлдвэрийн барилга барих ажил, үйлчилгээ

54261 Уул уурхайн барилга, байгууламж барих ажил, үйлчилгээ

Энэ дэд ангид дараах ажил, үйлчилгээ орно. Үүнд:

- ачих, буулгах өртөө, химийн үйлдвэр, төмөрлөгийн үйлдвэр, кокс шатаах хатуу түлшний үйлдвэрлэл зэрэг уул уурхай, боловсруулах аж үйлдвэрийн барилга барих ажил, үйлчилгээ
- уул уурхайн үйлдвэрийн барилгын засвар, үйлчилгээ

54262 Цахилгаан станц барих ажил, үйлчилгээ

Энэ дэд ангид бүх төрлийн цахилгаан станц барих, засварлах, шинэчлэх ажил үйлчилгээ орно.

54269 Үйлдвэрийн бусад барилга барих ажил, үйлчилгээ

Энэ дэд ангид үндсэн химийн, химийн нэгдлийн, эмийн болон химийн бусад бүтээгдэхүүний үйлдвэр, түүнд холбогдох байгууламж, төмөрлөг, ган боловсруулах үйлдвэр, коксын үйлдвэр, төмөрлөгийн цутгамлын үйлдвэр болон нэр дурьдагдаагүй бусад төрлийн боловсруулах үйлдвэрийн байгууламжийг барих, засах, шинэчлэх ажил, үйлчилгээ орно.

5427 Спортын задгай талбай, амралт, чөлөөт цагт зориулсан байгууламж барих ажил, үйлчилгээ

54270 Спортын задгай талбай, амралт, чөлөөт цагт зориулсан байгууламж барих ажил, үйлчилгээ

Энэ дэд ангид дараах ажил, үйлчилгээ орно. Үүнд:

- хөл бөмбөг, сагсан бөмбөг, рагби, автомашины уралдаан, унадаг дугуйн уралдаан, морины уралдаан, тэмцээний болон бусад газрын спортын зориулалттай задгай, гадаа талбайд зохион явуулдаг спортын уралдаан, тэмцээний зориулалттай стадион ба задгай талбайн спортын цогцолбор барих ажил, үйлчилгээ

- хөл бөмбөг, сагсан бөмбөг, рагби, автомашины уралдаан, унадаг дугуйн уралдаан, морины уралдаан зэрэг задгай, гадаа талбайд зохион явуулдаг спортын уралдаан, тэмцээний болон бусад газрын спортын зориулалттайгаас бусад стадион, байгууламж барих ажил, үйлчилгээ
- гольфийн сургалт, усан сэлэлтийн талбайн суурилуулалт, уулын спортын байгууламж, цэцэгт хүрээлэн болон амралт, зугаа цэнгэлийн хүрээлэн, амьтны хүрээлэнгийн байгууламжийг барих ажил, үйлчилгээ

Харин газар, талбай бэлтгэх ажил, үйлчилгээ 54320-д орно.

- 5429 Бусад төрлийн инженерийн байгууламж барих барих ажил, үйлчилгээ**
54290 Бусад төрлийн инженерийн байгууламж барих барих ажил, үйлчилгээ

Энэ дэд ангид дараах үйлчилгээ орно. Үүнд:

- хэрэм, хоргодох байр, нуувч, суудлын талбай, зэвсгийн шалгах төв зэрэг цэргийн инженерийн байгууламжийг барих, засварлах ажил, үйлчилгээ
- сансрын хөөргөх зурвасыг барих, засварлах ажил, үйлчилгээ
- хогийн цэг, хог шатаах цэгийг барих, засварлах ажил, үйлчилгээ
- цөмийн хаягдал боловсруулах, цэвэрлэх байгууламжийг барих, засварлах ажил, үйлчилгээ
- инженерийн бусад байгууламжийг барих, засварлах ажил, үйлчилгээ

- 543 Барилгын талбай бэлтгэх ажил, үйлчилгээ**
5431 Барилга, байгууламж буулгаж зам талбайг бэлтгэх, буулгах ажил, үйлчилгээ
54310 Барилга, байгууламж буулгаж зам талбайг бэлтгэх, буулгах ажил, үйлчилгээ

Энэ дэд ангид хуучин барилга байгууламжийг буулгах үйлчилгээ, хуучин гудамж талбай, өргөн чөлөөг буулгах, зам талбайг бэлтгэх ажил, үйлчилгээ орно.

- 5432 Барилга, байгууламж барих талбай бэлтгэх, цэвэрлэх ажил, үйлчилгээ**
54320 Барилга, байгууламж барих талбай бэлтгэх, цэвэрлэх ажил, үйлчилгээ

Энэ дэд ангид дараах ажил, үйлчилгээ орно. Үүнд:

- хөдөө аж ахуй, газар тариалангийн талбай бэлтгэх үйлчилгээ
- барилгын ажлын талбай бэлтгэх үйлчилгээ
- газар доор байрласан талбайг цэвэрлэх
- хөрс шороог тэнцвэржүүлэх үйлчилгээ
- геологи, геофизикийн өрөмдлөг, туршилтын болон барилгын адил төстэй үйлчилгээ
- кабель татах, хөндлөн өрөмдөлт хийх үйлчилгээ
- малталт хийх, суваг шуудуу гаргах үйлчилгээ
- нүх, шуудуу ухах, бохир усны сан бэлтгэх үйлчилгээ

Харин дараах ажил, үйлчилгээ орохгүй. Үүнд:

- *худаг гаргах өрөмдлөгийн үйлчилгээ (54341-д),*
- *газрын тос, хий олборлолтын өрөмдлөгийн үйлчилгээ (86211-д орно).*

- 5433 Барилга, байгууламж, зам талбайн газар шорооны ажил, үйлчилгээ**
54330 Барилга, байгууламж, зам талбайн газар шорооны ажил, үйлчилгээ

Энэ дэд ангид дараах ажил, үйлчилгээ орно. Үүнд:

- хурдны зам (хуурай зам, авто зам, төмөр зам гэх мэт) барих ажилтай холбоотой ухсан нүхийг далангаар хаахад бэлтгэн их хэмжээний газрыг шороогоор булаах нүүлгэн шилжүүлэх үйлчилгээ
- уурхайн нүх ухах, хотын бохир усыг зайлуулах, төмөр зам тавих зэрэг газар, шорооны ажил, үйлчилгээ
- барилга байгууламж, уурхайн зориулалтын болон бусад зориулалтаар газар, нүх, шуудуу ухах, малтах үйлчилгээ
- амралт, зугаа цэнгэлийн зориулалттай талбайн ажил, үйлчилгээ
- хөрс шороог хуулах ажил, үйлчилгээ
- бусад ухсан нүхнүүдээс нүүлгэн шилжүүлэх ажил, үйлчилгээ

- 5434 Гүний худаг, бохирын шугам суурилуулах ажил, үйлчилгээ**
54341 Гүний худаг гаргах (өрөмдөх) ажил, үйлчилгээ

Энэ дэд ангид барилгын ажил, уурхайн малталт, худаг өрөмдөж ус гаргах болон тусгай ажил, үйлчилгээ, ус дамжуулах системийг угсрах, суурилуулах усыг шахаж дамжуулах үйлчилгээ орно.

54342 Ариутгах татуургын шугам угсрах ажил, үйлчилгээ

Энэ дэд ангид ариутгах, татуургын шугам угсрах ажил үйлчилгээ орно.

544 Угсармал барилгыг суурилуулах, угсрах ажил, үйлчилгээ

5440 Угсармал барилгыг суурилуулах, угсрах ажил, үйлчилгээ

54400 Угсармал барилгыг суурилуулах, угсрах ажил, үйлчилгээ

Энэ дэд ангид дараах ажил, үйлчилгээ орно. Үүнд:

- угсармал барилгын ажлыг босгох болон угсрах үйлчилгээ
- угсармал барилга байгууламж болон бусад барилгыг босгох болон угсрах үйлчилгээ
- гудамжны эд хогшил, тавилга бусад төрлийн зүйлийг угсрах, үйлчилгээ (автобусны граш, вандан урт сандал гэх мэт)

Харин барилга байгууламжийн гангаар хийсэн хэсгийг угсрах үйлчилгээ 54550-д орно.

545 Барилгын туслан гүйцэтгэгч мэргэжлийн байгууллагын ажил, үйлчилгээ

5451 Туслан гүйцэтгэгч байгууллагын ажил, үйлчилгээ

54511 Шон, тулгуур суулгах ажил, үйлчилгээ

54512 Суурь тавих ажил, үйлчилгээ

Энэ дэд ангид барилга, байгууламжийн тусгай суурь тавих ажил, үйлчилгээ орно.

Харин дараах ажил, үйлчилгээ орохгүй. Үүнд:

- малтлагын ажил, үйлчилгээ (54330-д),
- бетон цутгах ажил, үйлчилгээ (54540-д орно).

5452 Барилгын каркас угсрах ажил, үйлчилгээ

54521 Барилгын каркас, бүтцийн угсрах ажил, үйлчилгээ

54522 Дээвэр нуруу угсрах ажил, үйлчилгээ

Энэ дэд ангид барилгын дээврийн хүрээг угсрах, татах үйлчилгээ орно.

5453 Дээвэрлэлт, дээврийн усыг тусгаарлах ажил, үйлчилгээ

54530 Дээвэрлэлт, дээврийн усыг тусгаарлах ажил, үйлчилгээ

Энэ дэд ангид дараах ажил, үйлчилгээ орно. Үүнд:

- барилгын дээврийн бүрээс, угсралтын материалыг төрөл бүрээр нь татах үйлчилгээ
- барилгын дээвэрт төмөр яндангаар борооны ус гоожуулах яндан гаргах үйлчилгээ
- барилгын дээврийн ус нэвтэрдэггүй дэвсгийг тааруулах үйлчилгээ
- барилгын гадна тал болон газар доорхи хэсэг ус нэвтэрдэггүй байхаар зохион байгуулах үйлчилгээ
- дээврийн чийг хамгаалалтыг суурилуулах үйлчилгээ

Харин тусгаарлагч материалыг суурилуулах ажил, үйлчилгээ 54650 - д орно.

5454 Бетон зуурмаг бэлтгэх ажил, үйлчилгээ

54540 Бетон зуурмаг бэлтгэх ажил, үйлчилгээ

Энэ дэд ангид дараах ажил, үйлчилгээ орно. Үүнд:

- нарийн мэргэжлийн ур чадвартай ажилтны болон тусгай тоног төхөөрөмжийг ашиглан бетон зуурах, батжуулах үйлчилгээ
- барилгын бөмбөгөр орой болон гадна талыг бетондох үйлчилгээ
- барилгын зураг төслийн дагуу нугалах, гагнах, бетондох ажил
- барилгын суурийг тавих, гатлага онгоц, бяргаазыг суурийг цутгах, зогсоолын суурь тавих болон цутгамалын хэвэнд оруулж бетондох, шаллах зэрэг үйлчилгээ
- барилгад хэлбэр дүрс оруулсан бетон арматурыг татах, бэлтгэх үйлчилгээ

- байшингийн суурийг нягтруулах ажил, үйлчилгээ

Харин дараах ажил, үйлчилгээ орохгүй. Үүнд:

- барилгын бетонон бэлдмэл бэлтгэх ажил, үйлчилгээ (37550-д),
- бэлэн холимог бетонон бүтээгдэхүүн (37510-д),
- гудамж, хурдны зам, нийтийн явган хүний зам барих ажил, үйлчилгээ (54210-д),
- гүүр, гүүрэн хурдны зам, туннель, метроны зам барих ажил, үйлчилгээ (54220-д орно).

5455 Барилгын төмөр хийц, холбоос, бэхэлгээний ажил, үйлчилгээ

54550 Барилгын төмөр хийц, холбоос, бэхэлгээний ажил, үйлчилгээ

Энэ дэд ангид дараах ажил, үйлчилгээ орно. Үүнд:

- барилгын ган хүрээг угсрах зэрэг барилгын тусгай ажил, үйлчилгээ
- гүүр, өргөх цамхаг, эрчим хүч дамжуулах цамхаг зэрэг барилгын ган бүрэлдэхүүн хэсэг, барилгын бусад байгууламжийн угсралт (өөрөө үйлдвэрлэсэнээс бусад)
- хананд хөшиг тогтоогч суулгах үйлчилгээ
- гагнуур болон холбогдох ажил, үйлчилгээ

Харин өөрөө үйлдвэрлэсэн ган хүрээний угсралтын ажил дэд анги 421-д орно.

5456 Чулуун шал, өнгөлгөөний ажил, үйлчилгээ

54560 Чулуун шал, өнгөлгөөний ажил, үйлчилгээ

Энэ дэд ангид тоосго, хавтан, чулуун шал, өнгөлгөөний ажил, үйлчилгээ орно.

Харин дараах ажил, үйлчилгээ орохгүй. Үүнд:

- бетондох ажил, үйлчилгээ (54540-д),
- дотоод засал чимэглэлийн ажил, үйлчилгээ (дэд анги 547-д орно).

5457 Барилгын ажлын шат угсрах ажил, үйлчилгээ

54570 Барилгын ажлын шат угсрах ажил, үйлчилгээ

Энэ дэд ангид барилгын шатны тавцан болон ажлын платформын түрээсийг оруулаад барилгын шатны тавцан, ажлын платформыг угсрах ажил орно.

Харин барилгын шатыг угсралтын ажлаас бусад ачих, буулгах болон бусад төлбөрт үйлчилгээ 73122-т орно.

5459 Бусад төрлийн барилгын тусгай ажил, үйлчилгээ

54590 Бусад төрлийн барилгын тусгай ажил, үйлчилгээ

Энэ дэд ангид дараах ажил, үйлчилгээ орно. Үүнд:

- үйлдвэрийн камин зуух барих ажил, үйлчилгээ
- галд тэсвэрлэлтийн зэрэг зориулалтын зуух барих ажил, үйлчилгээ
- гоёл чимэглэлийн зориулалттай эдлэл хийх галын зуух барих ажил, үйлчилгээ
- барилга шилжүүлэх, асбестос арилгах, авах үйлчилгээ зэрэг дээр ороогүй барилгын тусгай ажил, үйлчилгээ

546 тоног төхөөрөмж суурилуулах ажил, үйлчилгээ

5461 Цахилгаан угсралтын ажил, үйлчилгээ

54611 Цахилгаан утас угсралтын ажил, үйлчилгээ

Энэ дэд ангид дараах ажил, үйлчилгээ орно. Үүнд:

- барилгын цахилгааны утасны угсралтын ажил болон бусад барилгын зураг төслийн ажил зэрэг барилгын тусгай ажил, үйлчилгээ
- нөөц (яаралтай)-ийн эрчим хүчний системд зориулсан эрчим хүчний сүлжээг суурилуулах ажил, үйлчилгээ
- цахилгааны тоног төхөөрөмжийг суурилуулахд цахилгааны ачааллын тохиргоо хийх үйлчилгээ
- цахилгаан хэмжигч тоног төхөөрөмжийг суурилуулах ажил, үйлчилгээ

Харин дараах ажил, үйлчилгээ орохгүй. Үүнд:

- галын дохиоллын системийг угсарч, суурилуулах үйлчилгээ (54612-т),
- аюулгүйн /хулгайн/ дохиоллын системийг угсарч, суурилуулах үйлчилгээ (54613-т),

- цахилгаан мотор, генератор, трансформатор болон төмөр замын зогсоолыг угсрах үйлчилгээ (87320-д орно).

54612 Галын дохиоллын систем угсралтын ажил, үйлчилгээ

Энэ дэд ангид галын дохиоллын систем угсралтын ажил, үйлчилгээ орно.

Харин дараах ажил, үйлчилгээ орохгүй. Үүнд:

- шүршигч цацагч галын хорыг суурилуулах ажил, үйлчилгээ (54621-д),
- галаас тусгаарлах ажил, үйлчилгээ (54650-д орно).

54613 Аюулгүйн /хулгайн/ дохиоллын систем угсралтын ажил, үйлчилгээ

Энэ дэд ангид барилгын аюулгүй /хулгайн/ дохиоллын системийг угсарч суурилуулах ажил, үйлчилгээ орно.

54614 Суурин антенн угсрах ажил, үйлчилгээ

Энэ дэд ангид дараах ажил, үйлчилгээ орно. Үүнд:

- сансрын суурин антенн болон бусад бүх төрлийн суурин антенн суурилуулах ажил, үйлчилгээ
- барилгын доторх кабел телевизийн шугам суурилуулах үйлчилгээ
- гэрэлтүүлгийн дамжуулагч угсрах үйлчилгээ

54619 Бусад төрлийн цахилгааны тоног төхөөрөмжийг суурилуулах ажил, үйлчилгээ

Энэ дэд ангид дараах ажил, үйлчилгээ орно. Үүнд:

- харилцаа, холбооны цахилгааны тоног төхөөрөмжийг угсрах ажил, үйлчилгээ
- боомтын зогсоол, онгоцны буудал, төмөр зам, гудамжны зэрэг гэрэлтүүлгийн системийг суурилуулах ажил, үйлчилгээ
- хүнд цахилгааны тоног төхөөрөмжийг суурилуулах ажил, үйлчилгээ
- бусад цахилгааны тоног төхөөрөмжийг суурилуулах ажил, үйлчилгээ

Харин дараах ажил, үйлчилгээ орохгүй. Үүнд:

- төмөр замын аюулгүйн болон хяналтын системийг суурилуулах үйлчилгээ (54210-т),
- кабелийн телевизийг угсрах үйлчилгээ (54614-т),
- халаалтын тоног төхөөрөмжийг суурилуулах үйлчилгээ (54631-д орно).

5462 Цэвэр, бохир усны шугам сүлжээг угсрах ажил, үйлчилгээ

54621 Цэвэр усны шугам сүлжээг угсрах ажил, үйлчилгээ

Энэ дэд ангид дараах ажил, үйлчилгээ орно. Үүнд:

- шүршигч суурилуулах үйлчилгээг оруулаад үндсэн халуун, хүйтэн ус дамжуулах систем суурилуулах үйлчилгээ (түгээх)
- суурин ариун цэврийн төхөөрөмж суурилуулах үйлчилгээ
- түгээгүүртэй холбогдолтой ажил, үйлчилгээ
- гал унтраах зориулалттай ус шахах төхөөрөмж суурилуулах үйлчилгээ (гал унтраах резинен хоолой, цорго оруулаад)

Харин агаар халаалтын тоног төхөөрөмж болон нэгдсэн хоолой суурилуулах үйлчилгээ 54631-д орно.

54622 Бохир усны шугам сүлжээг угсрах ажил, үйлчилгээ

Энэ дэд ангид дараах ажил, үйлчилгээ орно. Үүнд:

- барилга, байгууламжаас муу ус зайлуулах суваг, шуудуу барих
- эд анги суурилуулах, ус зайлуулах хоолойн засвар, барилгын гадна талбайн бохир ус зайлуулах хоолойн ажил

Харин байшин барилгаас тусдаа хоолойн засвар орохгүй.

5463 Халаалт, салхивч, агааржуулагчийн системийг угсрах ажил, үйлчилгээ

54631 Халаалтын системийг угсрах ажил, үйлчилгээ

Энэ дэд ангид дараах ажил, үйлчилгээ орно. Үүнд:

- ус шүршүүрийн системийг суурилуулах, халуун, хүйтэн усны дамжуулах хоолойг (түгээгүүрийг) суурилуулах ажил, үйлчилгээ
- төвлөрсөн халаалтын хяналтын системийн ашиглалт болон суурилуулах ажил, үйлчилгээ
- дэд (дүүргийн) халаалтын системд холбох ажил, үйлчилгээ
- дотоод бойлер, халаалтын системийг суурилуулах, засварлах ажил, үйлчилгээ

Харин дараах ажил, үйлчилгээ орохгүй. Үүнд:

- камен зуух цэвэрлэх үйлчилгээ (85340-д),
- үйлдвэрлэлийн зориулалттай ус халаах төхөөрөмжийг суурилуулах, засварлах үйлчилгээ (87110-д орно).

54632 Салхивч агааржуулагчийн системийн угсрах ажил, үйлчилгээ

Энэ дэд ангид гэр сууц, компьютер мэдээллийн төв, албан байгууллага болон дэлгүүрийн зориулалттай салхивч, агааржуулалтын системийн тоног төхөөрөмж суурилуулах ажил, үйлчилгээ, дамжуулах хоолойн ажил, үйлчилгээ орно.

Харин аж үйлдвэрүүдэд агааржуулалт болон хөргөлтийн системийн тоног төхөөрөмж суурилуулах, засварлах, техникийн үйлчилгээ үзүүлэх 87110-д орно.

5464 Хийн системийг угсрах ажил, үйлчилгээ

54640 Хийн системийг угсрах ажил, үйлчилгээ

Энэ дэд ангид олон төрлийн шингэн нийлүүлэх (жишээлбэл, эмнэлэгийн хүчилтөрөгч) болон бусад хийн системийн угсралтын ажил, үйлчилгээ орно.

Харин дараах ажил, үйлчилгээ орохгүй. Үүнд:

- агаар халаах төхөөрөмж суурилуулах ажил, үйлчилгээ (54631-д),
- агааржуулалтын системийг суурилуулах ажил, үйлчилгээ (54632-т орно).

5465 Тусгаарлагчийг угсрах, суурилуулах ажил, үйлчилгээ

54650 Тусгаарлагчийг угсрах, суурилуулах ажил, үйлчилгээ

Энэ дэд ангид дараах ажил, үйлчилгээ орно. Үүнд:

- гадна ханыг тусгаарлах, дулаан тусгаарлах үйлчилгээ
- халуун, хүйтэн ус дамжуулах, буцалгах, хөргөхөд тусгаарлах үйлчилгээ
- дуу, чимээнээс тусгаарлах үйлчилгээ
- галаас тусгаарлах үйлчилгээ

Харин дараах ажил, үйлчилгээ орохгүй. Үүнд:

- усыг тусгаарлах үйлчилгээ (54530-д),
- дуулдацын/акустикийн үйлчилгээ (54790-д орно).

5469 Бусад төрлийн тоног төхөөрөмжийн угсралт, үйлчилгээ

54691 Цахилгаан шат болон галын шатыг угсрах, үйлчилгээ

Энэ дэд ангид лифт, цахилгаан шат, зөөх төхөөрөмж, явган хүнд зориулсан урсдаг шат зэргийг суурилуулах тусгай үйлчилгээ орно.

Харин лифт, цахилгаан шатны техникийн болон засварын үйлчилгээ 87156-д орно.

54699 Хаяг реклам болон бусад төрлийн угсрах, суурилуулах ажил, үйлчилгээ

Энэ дэд ангид дараах ажил, үйлчилгээ орно. Үүнд:

- цонхонд хөшиг тогтоох, суурилуулах үйлчилгээ
- цонхны хаалт ба саравч суурилуулах үйлчилгээ
- тэмдэг суурилуулах үйлчилгээ (гэрэлтэй эсвэл гэрэлгүй)
- барилга, байгууламжийн дотор эд зүйлийг байрлуулах, суурилуулах ажил, үйлчилгээ
- хаяг реклам болон бусад суурилуулах үйлчилгээ

547 Барилгын засал, чимэглэлийн ажил, үйлчилгээ

5471 Шиллэх ажил, үйлчилгээ

54710 Шиллэх ажил, үйлчилгээ

Энэ дэд ангид дараах ажил, үйлчилгээ орно. Үүнд:

- шил хийх, ханын толь болон бусад шилэн бүтээгдэхүүн суурилуулах үйлчилгээ
- цонхны шил суулгах зэрэг ажил, үйлчилгээ

Харин цонхны хэсгүүдийг нийлүүлэн суурилуулах үйлчилгээ 54760-д орно.

5472 Шавардлагын ажил, үйлчилгээ

54720 Шавардлагын ажил, үйлчилгээ

Энэ дэд ангид дараах ажил, үйлчилгээ орно. Үүнд:

- барилгын дотор болон гадаад шохойдолт, эсвэл бусад материал шохойдох үйлчилгээ
- хуурай хана, ханын самбар, гипс суурилуулах үйлчилгээ

Харин дуунаас тусгаарлах үйлчилгээ 54650-д орно.

5473 Будгийн ажил, үйлчилгээ

54730 Будгийн ажил

Энэ дэд ангид дараах ажил, үйлчилгээ орно. Үүнд:

- барилгын дотор талыг чимэглэх, будах болон түүнтэй ижил төрлийн будах үйлчилгээ
- барилгын гадна талыг будах үйлчилгээ
- хашаа, хаалга, цонхны хүрээ будах үйлчилгээ
- бусад инженерийн байгууламжийг будах үйлчилгээ
- будаг арилгах үйлчилгээ

Харин дараах ажил, үйлчилгээ орохгүй. Үүнд:

- зам, машины зогсоолын тэмдэглэгээ хийх үйлчилгээ (54210-д),
- усны хамгаалалт хийх үйлчилгээ (54530-д орно).

5474 Шал, хана, тааз өнгөлөх ажил, үйлчилгээ

54740 Шал, хана, тааз өнгөлөх ажил, үйлчилгээ

Энэ дэд ангид дараах ажил, үйлчилгээ орно. Үүнд:

- барилга болон бусад байгууламж дээр керамик, цемент, чулуугаар ханыг өнгөлөх, хавтгай чулуугаар шал хийх үйлчилгээ
- барилгын гадна ханыг керамик материал болон чулуу, тоосгоор өнгөлөх үйлчилгээ

5475 Шал байрлуулах, хана бүрэх болон ханын цаас наах ажил, үйлчилгээ

54750 Шал байрлуулах, хана бүрэх болон ханын цаас наах ажил, үйлчилгээ

Энэ дэд ангид дараах ажил, үйлчилгээ орно. Үүнд:

- хулдаас болон бусад зөөлөн эдээр хивслэх, шал хийх, өнгөлөх, паркетлах, лакдах, дуусгах шатны ажил
- паркет болон бусад модон материалаар шалыг шаллах, бүрэх үйлчилгээ, өнгөлөх, паркетлах, лакдах болон дуусгах шатны ажил
- ханын цаас болон бусад ханын өнгөлгөөний зүйлээр өнгөлөх, наах
- ханын цаас хуулах үйлчилгээ

Харин дараах ажил, үйлчилгээ орохгүй. Үүнд:

- цементэн шал угсрах үйлчилгээ (цементэн царууцаас бусад) (54540-д),
- чулуу, цемент, керамик шал хийх үйлчилгээ (54740-д орно).

5476 Мужааны болон дарханы ажил, үйлчилгээ

54760 Мужааны болон дарханы ажил, үйлчилгээ

Энэ дэд ангид дараах ажил, үйлчилгээ орно. Үүнд:

- төрөл бүрийн материалаар хийгдсэн хаалга, цонхны хүрээ, цонх, хаалга, гаражны хаалга зэргийг суурилуулах үйлчилгээ
- хамгаалалтын гадна хаалга суурилуулах, гадны хаалганд хамгаалалт хийх үйлчилгээ
- галын хаалга суурилуулах үйлчилгээ
- төмөр байгууламж дээр хөдөлгөөнт хэсэг, дүүжин тааз суурилуулах үйлчилгээ
- хувийн байшинд хүлэмж, тагт барих үйлчилгээ
- төмрөөс бусад материалаар хийх мужааны ажил
- дотор сандал, ханын шүүгээ, гал тогооны шүүгээ хийх ажил
- цаг уурын самбар, удирдлагын самбар суурилуулах үйлчилгээ

- стандарт болон өөрөө үйлдвэрлэсэн металл эд анги суурилуулах үйлчилгээ
- гоёлын төмөр эсвэл ган эдлэл, гоёл чимэглэл, архитектурын металлан зүйл хийх үйлчилгээ
- халаах/радиаторын хэрэгслийн гадуур хаалт хийх үйлчилгээ

Харин хашаа, хайс барих үйлчилгээ 54770-д орно.

5477 Хашаа, хайс барих ажил, үйлчилгээ

54770 Хашаа, хайс барих ажил, үйлчилгээ

Энэ дэд ангид дараах ажил, үйлчилгээ орно. Үүнд:

- хашаа, хайс, хашлага хийх зэрэг тэдгээртэй адил төстэй үйлчилгээ /Хашааг төрөл бүрийн материалаар (утас, төмөр, мод, ган, шил) хийж болох бөгөөд төрөл бүрийн байгууламжийн (спорт тоглоомын талбай, тоглоомын талбай, орон сууцны болон үйлдвэрийн зэрэг) зориулалттай байж болно/
- галын аюулын үед хэрэглэх шат (металл) суурилуулах үйлчилгээ

5479 Барилгын засал, чимэглэлийн бусад төрлийн ажил, үйлчилгээ

54790 Барилгын засал, чимэглэлийн бусад төрлийн ажил, үйлчилгээ

Энэ дэд ангид дараах ажил, үйлчилгээ орно. Үүнд:

- гадна ханыг уураар болон элсээр үлээн цэвэрлэх үйлчилгээ
- дотор хана, таазанд дуу, чимээний төхөөрөмж суурилуулах
- гантиг, боржин чулуу, занар зэрэг чулуугаар шал хийх
- барилгын ерөнхий засвар, үйлчилгээ
- барилгын ажлыг дуусгах бусад үйлчилгээ

Харин дуунаас тусгаарлах үйлчилгээ 54650-д орно.

6 ХУДАЛДАА, ЗОЧИД БУУДАЛ, ХҮНС, УНДАА, ТЭЭВРИЙН БОЛОН УС, ЦАХИЛГААН ХАНГАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭ

61 БӨӨНИЙ ХУДАЛДААНЫ ҮЙЛЧИЛГЭЭ

611 Төлбөр болон гэрээгээр хийгдэхээс бусад бөөний худалдаа

Бөөний худалдааны үйлчилгээнд их хэмжээний бараа худалдан авч жижиглэн худалдаачдад зарах, дахин баглаж жижиг хэсгүүд болгох үйлчилгээ орно.

612 Төлбөр болон гэрээгээр хийдэг бөөний худалдаа

Энэ бүлэгт дараах үйлчилгээ орно. Үүнд:

- комиссын төлөөлөгч, өргөн хэрэглээний барааны брокер, бүх төрлийн дуудлагын худалдаачин зэрэг худалдаачдын худалдааны гэрээ, хэлэлцээрийн дагуу худалдан авагч, худалдагчдын хооронд хийгдэх бөөний худалдаа
- электрон барааны бөөний худалдааны төлөөлөгч, брокерын үйлчилгээ
- орон сууцны үнэ хаялцуулах бөөний худалдаа

62 ЖИЖИГЛЭН ХУДАЛДААНЫ ҮЙЛЧИЛГЭЭ

621 Төрөлжсөн бус дэлгүүрийн жижиглэн худалдаа

Энэ бүлэгт дараах үйлчилгээ орно. Үүнд:

- төрөл бүрийн барааны, шинэ эсвэл хуучин/комиссын барааны супермаркет, их дэлгүүр зэрэг төрөлжсөн бус дэлгүүрийн худалдан авагч өөрөө сонголт хийх боломжтой, кассанд тооцоогоо хийдэг жижиглэн худалдаа
- байрны дуудлагат/үнэ хаялцуулах жижиглэн худалдаа

622 Төрөлжсөн дэлгүүрийн жижиглэн худалдаа

Энэ бүлэгт шинэ, хуучин барааны дэлгүүрийн эзэн эсвэл ажилтан худалдан авагчид тусалж хэрэгтэй бараагаар нь хангадаг төрөлжсөн дэлгүүрийн жижиглэн худалдаа орно.

623 Захиалга болон интернэтээр хийгддэг жижиглэн худалдаа

Энэ бүлэгт шинэ бараа бүтээгдэхүүний захиалгыг шуудан, утас, цахим захидал зэргээр хүлээн авч бараа, бүтээгдэхүүнийг хэрэглэгчийн гэрт хүргэж өгөх үйлчилгээ орно.

624 Дэлгүүрээр дамжин хийгддэггүй жижиглэн худалдаа

Энэ бүлэгт дараах үйлчилгээ орно. Үүнд:

- өөртөө үйлчлэх машинаар худалдаа хийх
- захын лангуугаар үйлчлэх
- тогтмол нэг газраас бие даасан худалдааны ажилтан, албан ёсны дистрибьютороор дамжуулан хийгдэх хаалганаас хаалганд хүргэх буюу шууд худалдах жижиглэн худалдаа

625 Төлбөр болон гэрээгээр хийгддэг жижиглэн худалдаа

Энэ бүлэгт дараах үйлчилгээ орно. Үүнд:

- жижиглэнгийн худалдаа хийснийхээ төлөө төлбөр авдаг худалдааны агентын үйлчилгээ
- цахим үнэ хаялцуулах жижиглэнгийн худалдаа

Тайлбар: *1-ээс ***99 хүртэл кодууд байна. *** тэмдэглэгээнд 610, 620, 611, 612, 621, 622, 623, 624, 625 бүлгүүдийн кодын аль нэг нь байна. Бөөний болон жижиглэнгийн ямар худалдаа вэ гэдгээс хамаарч худалдааны төрлийн сонголтоо хийнэ.**

*****1 Хөдөө аж ахуйн түүхий эд болон мал, амьтад**

*****11 Үр тариа, тосон ургамал, тослог жимс болон малын тэжээл**

Энэ дэд ангид дараах барааны худалдаа, үйлчилгээ орно. Үүнд:

- 011-р бүлэгт хамаарах бараа (үр тариа)
- 014-р бүлэгт хамаарах бараа (тос, тослог жимс)
- 015-р бүлэгт хамаарах бараа (инулин агуулсан эсвэл цардуул ихтэй хүнсэнд хэрэглэж болох үндэст, булцуут ургамал)
- 016-р бүлэгт хамаарах бараа (ундаа, халуун ногоо зэрэг сэргээх үйлчилгээтэй ургамал)
- 017-р бүлэгт хамаарах бараа (төрөл бүрийн хатаасан буурцагт ургамал)
- 018-р бүлэгт хамаарах бараа (саахрын ургамал)
- 0191-р ангийн бараа (тэжээлийн ургамал)
- 0192-р ангийн бараа (хөвөнгийн ургамал)
- 0194-р ангийн бараа (чихрийн манжингийн үрнээс бусад улаан манжингийн болон тэжээлийн ургамлын үр)
- 233-р бүлэгт хамаарах бараа (малын тэжээлийн зориулалттай бэлдмэл)

*****12 Цэцэг ба ургамал**

Энэ дэд ангид дараах барааны худалдаа, үйлчилгээ орно. Үүнд:

- 0193-р ангид хамаарах бараа (үнэртэн, гоо сайхан, эмчилгээний болон хортон шавьж устгах, мөөгөнцөрийн эсрэг зориулалттай ургамал)
- 0196-р бүлэгт хамаарах бараа (амьд ургамал; бэлтгэсэн цэцэг, цэцгийн баглаа; цэцгийн үр)

*****13 Боловсруулаагүй тамхи**

Энэ дэд ангид 0197-р ангид хамаарах бараа буюу боловсруулаагүй тамхины худалдаа орно.

*****14 Амьд мал болон гэрийн тэжээмэл амьтад**

Энэ дэд ангид дараах барааны худалдаа, үйлчилгээ орно. Үүнд:

- 021-р бүлэгт хамаарах бараа (амьд мал, амьтан)
- 0411-р дэд ангид хамаарах бараа (амьд загас)

*****15 Арьс болон савхин эдлэл**

Энэ дэд ангид 0295-р ангид хамаарах бараа (арьс, шир, үслэг эдлэл) орно.

*****19 Бусад хөдөө аж ахуйн түүхий эд**

Энэ дэд ангид дараах барааны худалдаа, үйлчилгээ орно. Үүнд:

- 0195-р ангид хамаарах бараа (байгалийн анхдагч каучук)
- 0199-р ангид хамаарах бараа (бусад боловсруулаагүй ургамал)
- 022-р бүлэгт хамаарах бараа (түүхий сүү)

- 023-р бүлэгт хамаарах бараа (шинэ тахианы өндөг, шувууны мах)
- 024-р бүлэгт хамаарах бараа (малын үржлийн түүхий эд)
- 0291-р ангид хамаарах бараа (зөгийн бал)
- 0292-р бүлэгт хамаарах бараа (эмгэн хумс (далайн эмгэн хумс орохгүй))
- 0293-р бүлэгт хамаарах бараа (малын гаралтай хүнсний бүтээгдэхүүн)
- 0294-р бүлэгт хамаарах бараа (нэхмэлд ашигладаг малын түүхий эд)
- 0296-р бүлэгт хамаарах бараа (шавьжны лав болон бусад шавьжны лав (цэвэршүүлсэн, цэвэршүүлээгүй, будсан, будаагүй))
- 032-р бүлэгт хамаарах бараа (ойн дагалт нөөц)

*****2 Хүнсний бараа, ундаа, тамхи**

*****21 Жимс, хүнсний ногоо**

Энэ дэд ангид дараах барааны худалдаа, үйлчилгээ орно. Үүнд:

- 012-р бүлэгт хамаарах бараа (хүнсний ногоо)
- 013-р бүлэгт хамаарах бараа (жимс, самар)
- 213-р бүлэгт хамаарах бараа (нөөшилсөн, бэлтгэсэн хүнсний ногоо, төмс)
- 214-р бүлэгт хамаарах бараа (нөөшилсөн, бэлтгэсэн жимс, самар)

*****22 Сүү, сүүн бүтээгдэхүүн, өндөг, хүнсний зориулалттай тос, өөх**

Энэ дэд ангид дараах барааны худалдаа, үйлчилгээ орно. Үүнд:

- 215-р бүлэгт хамаарах бараа (ургамал, амьтны гаралтай өөх, тос)
- 217-р бүлэгт хамаарах бараа (ургамлын тосноос гаргаж авсан, шахдас, тунадас, үлдэгдэл; гичнээс бусад тосны ургамлын, тослог жимсний лав; малын, ургамлын лавын боловсруулалтын үлдэгдэл)
- 221-р бүлэгт хамаарах бараа (боловсруулсан сүү, цэцгий)
- 222-р бүлэгт хамаарах бараа (бусад цагаан идээ, сүү, сүүн бүтээгдэхүүн)
- 223-р бүлэгт хамаарах бараа (нөөшилсөн, чанасан өндөг)

*****23 Мах, махан бүтээгдэхүүн, шувуу ангийн мах**

Энэ дэд ангид 211-р бүлэгт хамаарах бараа (мах, махан бүтээгдэхүүн) орно.

*****24 Загас болон бусад далайн бүтээгдэхүүн**

Энэ дэд ангид дараах барааны худалдаа, үйлчилгээ орно. Үүнд:

- 0412-р бүлэгт хамаарах бараа (шинэ буюу сэврээсэн загас)
- 042-р бүлэгт хамаарах бараа (хөлдөөгөөгүй хавч, хясаа, нялцгай биетэн, шинэ, сэврээсэн усны сээр нуруугүй бусад амьтан)
- 049-р бүлэгт хамаарах бараа (усны бусад ургамал, амьтан)
- 212-р бүлэгт хамаарах бараа (загасан бэлдмэл, нөөшилсөн загас, хавч, нялцгай биетэн, усны сээр нуруугүй бусад амьтад)

*****25 Чихэр, нарийн боов, талх, талхан бүтээгдэхүүн**

Энэ дэд ангид дараах барааны худалдаа, үйлчилгээ орно. Үүнд:

- 234-р бүлэгт хамаарах бараа (талх, талхан бүтээгдэхүүн)
- 235-р бүлэгт хамаарах бараа (саахар)
- 236-р бүлэгт хамаарах бараа (какао, шоколад, чихэрлэг бүтээгдэхүүн)

*****26 Ундаа**

Энэ дэд ангид дараах барааны худалдаа, үйлчилгээ орно. Үүнд:

- 241-р бүлэгт хамаарах бараа (этилийн спирт, спирт, ликёр болон спиртийн төрлийн бусад ундаа)
- 242-р бүлэгт хамаарах бараа (дарс)
- 243-р бүлэгт хамаарах бараа (соёолж, түүний ханд, ликёр)
- 244-р бүлэгт хамаарах бараа (согтууруулах бус ундаа, савласан рашаан)

*****27 Кофе, цай, халуун ногоо**

Энэ дэд ангид дараах барааны худалдаа, үйлчилгээ орно. Үүнд:

- 2391-р бүлэгт хамаарах бараа (кофе, цай)
- 2392-р бүлэгт хамаарах бараа (боловсруулсан амт, үнэр оруулагч бэлдмэл)

*****28 Тамхин бүтээгдэхүүн**

Энэ дэд ангид дараах барааны худалдаа, үйлчилгээ орно. Үүнд:
- 250-р бүлэгт хамаарах бараа (тамхи)

*****29 Хүнсний бусад бүтээгдэхүүн**

Энэ дэд ангид дараах барааны худалдаа, үйлчилгээ орно. Үүнд:
- 231-р бүлэгт хамаарах бараа (гурилын үйлдвэрийн бүтээгдэхүүн)
- 232-р бүлэгт хамаарах бараа (цардуул, цардуулан бүтээгдэхүүн, саахар, саахрын уусмал)

- 237-р бүлэгт хамаарах бараа (гоймон)
- 2399-р ангид хамаарах бараа (хүнсний бусад бүтээгдэхүүн)

*****3 Нэхмэл хувцас, гутал**

*****31 Нэхмэлийн утас, бөс даавуу**

Энэ дэд ангид дараах барааны худалдаа, үйлчилгээ орно. Үүнд:
Энэ дэд ангид дотоодын усан замд аяллын завьнаас бусад хөлөг онгоц, газрын тос зөөвөрлөх зориулалттай усан онгоц, овор ихтэй хуурай ачаа тээвэрлэх усан онгоц, тээшийн/карго болон ачааны усан онгоц, чирэгч усан онгоц, загас агнуурын усан онгоц зэрэг бүх төрлийн өөрөө удирдлагатай усан онгоцыг жолоочтой нь түрээслэх ба лизингийн үйлчилгээ орно.

Харин дараах үйлчилгээ орохгүй. Үүнд:

- *онгоцны баггүйгээр усан онгоцны түрээсийн ба лизингийн үйлчилгээ (73115-д),*
- *аяллын завьны түрээсийн ба лизингийн үйлчилгээ (73240-д орно).*

6603 Агаарын хөлгийн түрээсийн үйлчилгээ
66031 Зорчигчийн агаарын хөлгийг түрээслэх үйлчилгээ (багтай нь)

Энэ дэд ангид агаарын тээврийн зорчигч тээвэрлэх онгоц эсвэл зорчигч, ачаа тээвэрлэх зориулалттай онгоцыг (нисдэг тэргийг оруулаад) багтай нь түрээслэх ба лизингийн үйлчилгээ орно. Энэ төрлийн үйлчилгээ тодорхой хугацаагаар болон хэд хэдэн чиглэлд байж болно.

66032 Ачааны агаарын хөлгийг түрээслэх үйлчилгээ (багтай нь)

Энэ дэд ангид агаарын тээврийн ачааны онгоцыг (нисдэг тэргийг оруулаад) багтай нь түрээслэх ба лизингийн үйлчилгээ орно. Энэ төрлийн үйлчилгээ тодорхой хугацаагаар болон хэд хэдэн чиглэлд байж болно.

67 ТЭЭВРИЙН ТУСЛАХ ҮЙЛЧИЛГЭЭ

671 Ачаа, тээшийн үйлчилгээ

6711 Чингэлгийн үйлчилгээ

67110 Чингэлгийн үйлчилгээ

Энэ дэд ангид дараах үйлчилгээ орно. Үүнд:

- *тусгай зориулалтын ачааны чингэлгээр тээшийн/карго үйлчилгээ үзүүлэх*

- онгоцонд ачааг ачих, буулгах үйлчилгээ, бүх төрлийн тээврийн хэрэгслийн ачааны терминалын үйлчилгээ (усан онгоцны зогсоолын ачааг буулгах, ачих болон усан онгоцыг цэнэглэх үйлчилгээ)

6719 Ачаа, тээшийн/карго бусад төрлийн үйлчилгээ

67190 Ачаа, тээшийн/карго бусад төрлийн үйлчилгээ

Энэ дэд ангид дараах үйлчилгээ орно. Үүнд:

- чингэлэгтэй ачааны карго үйлчилгээ
- онгоцонд бусад ачааг ачаалах, буулга үйлчилгээг оруулаад бүх тээврийн хэрэгслийн терминалын үйлчилгээ (усан онгоцны зогсоолын ачааг буулгах, ачих болон усан онгоцыг цэнэглэх үйлчилгээ)
- бусад ачаа тээврийн үйл ажиллагааны туслах үйлчилгээ
- нисэх онгоцны буудал, автобусны зогсоол, төмөр замын болон метроны зогсоол дээр ачааг баглах үйлчилгээ

672 Агуулах, хадгалах байрны үйлчилгээ

6721 Хөргөөх системтэй агуулахын үйлчилгээ

67210 Хөргөөх системтэй агуулахын үйлчилгээ

Энэ дэд ангид амархан мууддаг хүнсний бүтээгдэхүүн, хөлдөөсөн, хөргөсөн бусад бүтээгдэхүүнийг хадгалах агуулахын үйлчилгээ орно.

Харин төлбөр болон гэрээгээр хийгдэх бүтээгдэхүүнийг хөлдөөх үйлчилгээ 88111-д орно.

6722 Шингэн, хийн хэлбэртэй бүтээгдэхүүнийг хадгалах үйлчилгээ

67220 Шингэн, хийн хэлбэртэй бүтээгдэхүүнийг хадгалах үйлчилгээ

Энэ дэд ангид газрын тос, газрын тосны бүтээгдэхүүн, дарс болон адил түүнтэй төстэй бүтээгдэхүүн, шингэн болон хийн хэлбэртэй бусад бүтээгдэхүүний агуулахын үйлчилгээ орно.

6729 Бусад төрлийн бүтээгдэхүүнийг агуулах, хадгалах үйлчилгээ

67290 Бусад төрлийн бүтээгдэхүүнийг агуулах, хадгалах үйлчилгээ

Энэ дэд ангид үр тариа болон бусад барааг агуулах, хадгалах байрны үйлчилгээ орно.

673 Төмөр замын тээврийн туслах үйлчилгээ

6730 Төмөр замын тээврийн туслах үйлчилгээ

67301 Төмөр замын тээврийн сэлгээний ажил, үйлчилгээ

Энэ дэд ангид төмөр замын вагоныг татах, чирэх болон зогсоолын талбайд авчрах, салаа зам руу оруулах зэрэг татах/чирэх, түлхэх үйлчилгээ орно.

67309 Төмөр замын тээврийн бусад төрлийн туслах үйлчилгээ

Энэ дэд ангид төмөр замын буудлын үйлчилгээ (тасалбарын худалдаа, захиалга хийх үйлчилгээ, ачаа, тээшийн үйлчилгээ, гээгдсэн ачааны үйлчилгээ зэрэг) болон тээврийн бусад туслах үйлчилгээ орно.

674 Хуурай замын тээврийн туслах үйлчилгээ

6741 Автобусны зогсоолын үйлчилгээ

67410 Автобусны зогсоолын үйлчилгээ

Энэ дэд ангид хотын, хот орчмын болон хот хоорондын автобусны зогсоолын үйлчилгээ (тасалбарын худалдаа, захиалга хийх үйлчилгээ, ачаа, тээшийн үйлчилгээ, гээгдсэн ачааны үйлчилгээ зэрэг) орно.

Харин ачаа, тээшийг баглах үйлчилгээ 67190-д орно.

6742 Зам, гүүр, нүхэн гарц/туннел-ын үйлчилгээ

67420 Зам, гүүр, нүхэн гарц/туннел-ын үйлчилгээ

Энэ дэд ангид хурдны зам, зам, гүүр, нүхэн гарцын болон бусад хаалттай замын үйлчилгээ, нүхэн гарцын үйлчилгээ орно.

Харин тээврийн хэрэгслийн зогсоолын үйлчилгээ 67430-д орно.

6743 Автомашины зогсоолын үйлчилгээ

67430 Автомашины зогсоолын үйлчилгээ

Энэ дэд ангид дараах үйлчилгээ орно. Үүнд:

- дээвэртэй/дээвэргүй автомашины парк, зогсоолын талбай, моторт тээврийн хэрэгсэл, мотоцикл, унадаг дугуйны паркийн үйлчилгээ
- гудамж, зам, нийтийн үйлчилгээний газрын паркийн төлбөрт үйлчилгээ

Харин дараах үйлчилгээ орохгүй. Үүнд:

- *цоожтой гарааж эсвэл байшингийн доорх гараажид сар, жилээр хадгалах үйлчилгээ (72112-т),*
- *машины гараажийн үйлчилгээ (97990-д орно).*

6744 Худалдаа, үйлчилгээний болон хувийн тээврийн хэрэгслийг татах, чирэх үйлчилгээ

67440 Худалдаа, үйлчилгээний болон хувийн тээврийн хэрэгслийг татах, чирэх үйлчилгээ

Энэ дэд ангид дараах үйлчилгээ орно. Үүнд:

- худалдаа, үйлчилгээний болон хувийн тээврийн эвдэрсэн хэрэгслийг татах, чирэх үйлчилгээ
- зогсоолын бус газар тавьсан моторт тээврийн хэрэгслийг татах, чирэх үйлчилгээ

6749 Хуурай замын тээврийн бусад төрлийн туслах үйлчилгээ

67490 Хуурай замын тээврийн бусад төрлийн туслах үйлчилгээ

Энэ дэд ангид хуурай замын бусад төрлийн туслах үйлчилгээ орно.

Энэ дэд ангид автобус болон бусад тээврийн хэрэгслийг цэвэрлэх үйлчилгээ орохгүй, харин 85340-д орно.

675 Усан замын тээвэрт дэмжлэг үзүүлэх үйлчилгээ

6751 Усан замаар болон боомтын үйл ажиллагаагаар дэмжлэг үзүүлэх үйлчилгээ (дамжуулан тээвэрлэх ачаа/карго орохгүй)

67511 Далайн болон далайн эрэг орчмын аялалд усан замаар, боомтын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх үйлчилгээ (дамжуулан тээвэрлэх ачаа/карго орохгүй)

Энэ дэд ангид дараах үйлчилгээ орно. Үүнд:

- далайн эрэг орчмын болон далайн усан онгоцны зорчигч тээврийн үйлчилгээ, усан онгоцны зогсоол, хөлөг онгоцны зогсоол, усан боомтын үйлчилгээ
- онгоцны замаг, завь өргөх, буулгах үйлчилгээ, далан хаалт, ус тавих үйлчилгээ
- гэрлийн байшин, гэрэлт усан онгоц болон хөлөг онгоц, усны хөвүүр тэмдэг, сувгийн тэмдэглэгээ, хөлөг жолоодох/навигацийн тэмдэглэгээ зэргийн үйлчилгээ

Харин дараах үйлчилгээ орохгүй. Үүнд:

- *чингэлэгтэй ачааг ачих, буулгах үйлчилгээ (67110-д), чингэлэггүй ачааг ачих, буулгах үйлчилгээ (67190-д),*
- *боомтын хадгалах болон агуулахын үйлчилгээ (672-т орно).*

67512 Дотоодын усан замын аялалд усан замаар болон боомтын үйл ажиллагаагаар дэмжлэг үзүүлэх үйлчилгээ (дамжуулан тээвэрлэх ачаа/карго орохгүй)

Энэ дэд ангид дараах үйлчилгээ орно. Үүнд:

- суваг татсан гол, хиймэл нуур, ус болон нуур усанд завь, ачааны усан онгоцыг удирдах үйлчилгээ
- онгоцны замаг, завь өргөх, буулгах үйлчилгээ, далан хаалт, ус тавих үйлчилгээ
- татах завьнаас зүтгүүрийн тэрэг, трактороор усан онгоцыг татах, чирэх үйлчилгээ
- гэрэлт усан онгоц болон хөлөг онгоц, усны хөвүүр тэмдэг, сувгийн тэмдэглэгээ, хөлөг жолоодох/навигацийн тэмдэглэгээ зэргийн үйлчилгээ

Харин дараах үйлчилгээ орохгүй. Үүнд:

- *чингэлэгтэй ачааг ачих, буулгах үйлчилгээ (67110-д),*

- чингэлэггүй ачааг ачих, буулгах үйлчилгээ (67190-д),
- боомтын хадгалах болон агуулахын үйлчилгээ (672-т орно).

6752 Газарчингийн ба зогсоолын үйлчилгээ

67521 Далайн болон далайн эрэг орчмын усан замын газарчингийн ба зогсоолын үйлчилгээ

Энэ дэд ангид дараах эд зүйлийг оруулна:

- усан онгоц боомтод орох болон гарах, эсвэл навигацийн аюулын холбооны үйлчилгээ үзүүлдэг эсвэл үзүүлдэггүй эргийн болон далайг хөндлөн огтолсон усан онгоцны удирдлагын үйлчилгээ
- эргийн болон далайг хөндлөн огтолсон усан дээрх бүх төрлийн усан онгоцыг зогсоолд хүргэх болон зогсоолоос гаргах чирэгч онгоцны үйлчилгээ

Энэ дэд ангид дараах эд зүйлийг оруулахгүй:

- эргийн усан дээрх болон задгай тэнгис дэх татах, түрэх үйлчилгээ, 65219-ийг үзнэ үү.

67522 Дотоодын усан замд газарчингийн ба зогсоолын үйлчилгээ

Энэ дэд ангид дараах эд зүйлийг оруулна:

- Усан онгоцонд боомтод орох болон гарах, эсвэл навигацийн аюулын холбооны үйлчилгээ үзүүлдэг эсвэл үзүүлдэггүй гол, нуурын усан дээрх усан онгоцны удирдлагын үйлчилгээ
- Гол, нуурын усан дээрх бүх төрлийн усан онгоцыг зогсоолд хүргэх болон зогсоолоос гаргах чирэгч онгоцны үйлчилгээ

Энэ дэд ангид дараах эд зүйлийг оруулахгүй:

- гол, нуурын усан дээрх татах, түрэх үйлчилгээ, 65229-ийг үзнэ үү.

6753 Хөлөг онгоцыг аврах ба живсэн хөлөг онгоцыг татан гаргах үйлчилгээ

67531 Далайн болон далайн эрэг орчмын аялалд хөлөг онгоцыг аврах, живсэн хөлөг онгоцыг татан гаргах үйлчилгээ

Энэ дэд ангид дараах эд зүйлийг оруулна:

- эргийн болон далайг хөндлөн огтолсон усан дээр усан онгоцыг аврах, дахин хөвүүлэх үйлчилгээ, өөрөөр хэлбэл живсэн усан онгоцыг татаж гаргах, хөмөрсөн онгоцыг тэнцвэржүүлэх, эрэг дээр тавьсан усан онгоцыг хөвүүлэх, даац нь хэтэрсэн усан онгоц, түүний чиргүүлийг аврах үйлчилгээнүүд

- эргийн усан дээрх болон далайн хөндлөн огтолсон усан дээрх ачаатай усан онгоцыг чирэх үйлчилгээ

Энэ дэд ангид дараах эд зүйлийг оруулахгүй:

- эргийн усан дахь болон задгай тэнгис дэх даац нь хэтэрсэн усан онгоцонд үзүүлж буй чирэх үйлчилгээ, 65219-ийг үзнэ үү

- аврах завьны үйлчилгээ, тэнгисийн гал унтраах завьны үйлчилгээ, тэнгисийн хайх, аврах бусад үйлчилгээ:

• цагдаагийн үйлчилгээ, 91260-ийг үзнэ үү

• тэнгисийн гал унтраах завьны үйлчилгээ, 91260-ийг үзнэ үү

• нийтийн зориулалттай, аюулгүй байдлын болон тэдгээртэй холбоотой бусад үйлчилгээ, 91290-ийг үзнэ үү

67532 Дотоодын усан замын аялалд хөлөг онгоцыг аврах, живсэн хөлөг онгоцыг татан гаргах үйлчилгээ

Энэ дэд ангид дараах эд зүйлийг оруулна:

- гол, нуурын усан дээр усан онгоцыг аврах, дахин хөвүүлэх үйлчилгээ, өөрөөр хэлбэл живсэн усан онгоцыг татаж гаргах, хөмөрсөн онгоцыг тэнцвэржүүлэх, эрэг дээр тавьсан усан онгоцыг хөвүүлэх, даац нь хэтэрсэн болон живсэн усан онгоц, түүний чиргүүлийг аврах үйлчилгээнүүд
- гол нуурын усан дээр ачаатай усан онгоцыг чирэх үйлчилгээ

Энэ дэд ангид дараах эд зүйлийг оруулахгүй:

- гол нуурын усан дээр ачаатай усан онгоцонд үзүүлж буй чирэх үйлчилгээ, 65229-ийг үзнэ үү
- аврах завьны үйлчилгээ, тэнгисийн гал унтраах завьны үйлчилгээ, тэнгисийн хайх, аврах бусад үйлчилгээ:

- цагдаагийн үйлчилгээ, 91260-ийг үзнэ үү
- тэнгисийн гал унтраах завины үйлчилгээ, 91260-ийг үзнэ үү
- нийтийн зориулалттай, аюулгүй байдлын болон тэдгээртэй холбоотой бусад үйлчилгээ, 91290-ийг үзнэ үү.

6759 Усан замын тээвэрт дэмжлэг үзүүлэх бусад төрлийн үйлчилгээ

67590 Усан замын тээвэрт дэмжлэг үзүүлэх бусад төрлийн үйлчилгээ

Энэ дэд ангид дараах эд зүйлийг оруулна:

- бусад газар ангилагдаагүй усан онгоцны үйл ажиллагаатай шууд холбоотой болон мөс зүсэх, усан онгоц бүртгэх, давирхайдах, хадгалах зэрэг усан онгоцны үйл ажиллагаатай шууд холбогдохгүй усан замын тээврийн бусад туслах үйлчилгээ

Энэ дэд ангид

дараах эд зүйлийг оруулахгүй:

- түлшний болон газрын тосны хордлогыг арилгах зэрэг усан онгоц цэвэрлэх үйлчилгээ, 853-ийг үзнэ үү
- усан онгоцыг ариутгах үйлчилгээ, 85310-ийг үзнэ үү
- аврах завьны үйлчилгээ, тэнгисийн гал унтраах завьны үйлчилгээ, тэнгисийн хайх, аврах бусад үйлчилгээ:
- цагдаагийн үйлчилгээ, 91260-ийг үзнэ үү
- тэнгисийн гал унтраах завины үйлчилгээ, 91260-ийг үзнэ үү
- нийтийн зориулалттай, аюулгүй байдлын болон тэдгээртэй холбоотой бусад үйлчилгээ, 91290-ийг үзнэ үү.

676 Агаарын болон сансрын тээврийн туслах үйлчилгээ

6761 Нисэх буудлын үйлчилгээ (ачаа тээвэрлэх үйлчилгээнээс бусад)

67610 Нисэх буудлын үйлчилгээ (ачаа тээвэрлэх үйлчилгээнээс бусад)

Энэ дэд ангид зорчигч тээврийн онгоцны зогсоолын болон нислэгийн талбай, нислэгийн зурвасын үйлчилгээ орно.

Харин дараах үйлчилгээ орохгүй. Үүнд:

- чингэлэгтэй ачааны каргоны зогсоолын үйлчилгээ (67110-д),
- чингэлэггүй ачааны каргоны зогсоолын үйлчилгээ (67190-д орно).

6762 Нислэгийн хөдөлгөөний (хяналтын) үйлчилгээ

67620 Нислэгийн хөдөлгөөний (хяналтын) үйлчилгээ

Энэ дэд ангид дараах үйлчилгээ орно. Үүнд:

- онгоц буулгах, нисгэх хяналт болон нислэгийн хяналтын цамхагийн үйлчилгээ
- онгоцны буудлын ойролцоох радарын станцын үйлчилгээ

Харин радио навигацын тусламжийн үйлчилгээ 67990-д орно.

6763 Агаарын тээврийн бусад төрлийн туслах үйлчилгээ

Энэ дэд ангид дараах үйлчилгээ орно. Үүнд:

- онгоцны гал унтраах болон галын дохионы үйлчилгээ
- онгоцны засвар, үйлчилгээ
- онгоцны байрны үйлчилгээ
- онгоц чирэх үйлчилгээ

Харин дараах үйлчилгээ орохгүй. Үүнд:

- онгоцны цэвэрлэгээ (85340-д),
- онгоцны ариутгал, хортон устах үйлчилгээ (85310-д),
- агаар, усны аврах багийн үйлчилгээ (91290-д),
- нисэхийн дунд боловсрол олгох үйлчилгээ (91290-д),
- нислэгийн зурвас цэвэрлэх, цас цэвэрлэх үйлчилгээ (94510-д орно).

6764 Сансрын тээврийн туслах үйлчилгээ

67640 Сансрын тээврийн туслах үйлчилгээ

Энэ дэд ангид сансрын тээврийн туслах үйлчилгээ орно.

679 Тээврийн үйлчилгээний бусад төрлийн туслах болон нэмэлт үйлчилгээ

6791 Төмөр замын тээвэр зуучлалын үйлчилгээ

67910 Төмөр замын тээвэр зуучлалын үйлчилгээ

Энэ дэд ангид дараах үйлчилгээ орно. Үүнд:

- ачаа явуулах, хүлээн авах зуучийн үйлчилгээ
- ачаа тээврийн үйл ажиллагааг зуучлах брокерын үйлчилгээ
- ачаа тээврийн анхдагч үйлчилгээ (ачааг илгээгч эсвэл тээвэрлэгчийн нэрийн өмнөөс ачаа тээврийн үйлчилгээг зохион байгуулах үйлчилгээ)
- агаарын тээврийн үйл ажиллагааг зуучлах үйлчилгээ
- ачааг бөөнөөр нийлүүлж тээвэрлэхэд бэлтгэх үйлчилгээ

6799 Тээврийн бусад төрлийн туслах үйлчилгээ

67990 Тээврийн бусад төрлийн туслах үйлчилгээ

Энэ дэд ангид дараах үйлчилгээ орно. Үүнд:

- тээврийн хэрэгслийн төрлөөс шалтгаалан татвар ногдуулах үйлчилгээ (агаарын тээврийн онгоцны нэвтрэх зөвшөөрөл олгох)
- тээврийн хэрэгслийг шатахуун, хийгээр цэнэглэх үйлчилгээ
- хот доторх радио навигацийн үйлчилгээ, жишээлбэл GPS (дэлхийн байршлын систем)-ийн үйлчилгээ

68 ШУУДАН, ЗАРЛАГА, ЭЛЧИЙН ҮЙЛЧИЛГЭЭ

681 Шуудан, зарлага, элчийн үйлчилгээ

6811 Шуудангийн үйлчилгээ

68111 Шуудангийн бичиг захидал, хэвлэлийн үйлчилгээ

Энэ дэд ангид дараах үйлчилгээ орно. Үүнд:

- нийтлэг үйлчилгээний зөвшөөрөлтэй дотоодоос эсвэл гадаадаас гэдгээс үл хамааран сонин, сэтгүүл, тогтмол хэвлэлийг цуглуулах, тээвэрлэх, хүргэх үйлчилгээ
- нийтлэг үйлчилгээний зөвшөөрөлтэй, дотоодоос эсвэл гадаадаас гэдгээс үл хамааран захиа, танилцуулга, ухуулах хуудас болон тэдгээртэй төстэй хэвлэмэл материалыг цуглуулах, тээвэрлэх, хүргэх үйлчилгээ

68112 Шуудангийн илгээлтийн үйлчилгээ

Энэ дэд ангид нийтлэг үйлчилгээний зөвшөөрөлтэй, дотоодынх болон гадаадынх гэдгээс үл хамааран илгээмж, боодлыг цуглуулах, тээвэрлэх, хүргэх үйлчилгээ орно.

68113 Шуудангийн салбарын/уламжлалт/ үйлчилгээ

Энэ дэд ангид шуудангийн салбарын лангуугаар хийх үйлчилгээ, өөрөөр хэлбэл, шуудангийн марк худалдах, баталгаатай эсвэл бүртгэгдсэн захиа, илгээмжийг гарт нь хүргэж өгөх болон шуудангийн салбарын лангуугаар хийх бусад үйлчилгээ орно.

68119 Шуудангийн бусад төрлийн үйлчилгээ

Энэ дэд ангид шуудангийн хайрцаг түрээслүүлэх үйлчилгээ, тамгатай, хаяг тодорхойгүй захианы хаяг тодорхойлох үйлчилгээ болон дээр дурьдаагүй нийтийн шуудангийн үйлчилгээ орно.

Харин дараах үйлчилгээ орохгүй. Үүнд:

- шуудангийн мөнгөн гуйвуулга болон шуудангийн хадгаламжийн дансны үйлчилгээ (салбар 71-д),
- холбооны үйлчилгээ (дэд салбар 84-т орно).

6812 Буухиа шуудангийн үйлчилгээ

68120 Буухиа шуудангийн үйлчилгээ

Энэ дэд ангид дараах үйлчилгээ орно. Үүнд:

- нийтлэг үйлчилгээний зөвшөөрөлтэйгээс бусад дотоод, гадаадаас үл хамааран захиа, илгээмжийг цуглуулах, тээвэрлэх, хүргэх үйлчилгээ
- мэдээг дугуйтай зарлагаар хүргэх үйлчилгээ

Харин хотын доторх ачаа хүргэх үйлчилгээ 68130-д орно.

6813 Дотоодын шуудангийн хүргэх үйлчилгээ

68130 Дотоодын шуудангийн хүргэх үйлчилгээ

Энэ дэд ангид хүнсний болон худалдааны бусад бараа, материалыг хот дотор хүргэх үйлчилгээ орно.

Харин мэдээг дугуйтай зарлагаар хүргэх үйлчилгээ 68120-д орно.

69 ЦАХИЛГААН, ХИЙ, УС ТҮГЭЭХ ҮЙЛЧИЛГЭЭ

691 Цахилгаан, хий түгээх үйлчилгээ

6911 Цахилгаан дамжуулах, түгээх үйлчилгээ

69111 Цахилгаан дамжуулах үйлчилгээ

Энэ дэд ангид цахилгаан дамжуулах үйлчилгээ орно.

Харин дараах үйлчилгээ орохгүй. Үүнд:

- цахилгааны тоолуурыг суурилуулах үйлчилгээ (54611-д),
- цахилгаан түгээх үйлчилгээ (69112, 86312-т),
- төлбөр эсвэл гэрээний үндсэн дээр хийгдэх цахилгаан дамжуулах үйлчилгээ (86312-т орно).

69112 Цахилгаан түгээх үйлчилгээ

Энэ дэд ангид цахилгаан түгээх үйлчилгээ болон цахилгааны тоолуурыг засварлах үйлчилгээ орно.

Харин дараах үйлчилгээ орохгүй. Үүнд:

- цахилгааны тоолуурыг суурилуулах үйлчилгээ (54611-д),
- цахилгаан дамжуулах үйлчилгээ (69111, 86312-т),
- цахилгааны тоолуурыг унших үйлчилгээ (85999-д),
- төлбөр эсвэл гэрээний үндсэн дээр хийгдэх цахилгаан дамжуулах үйлчилгээ (86312-т орно).

6912 Төвлөрсөн сүлжээгээр хий түгээх, хуваарилах үйлчилгээ

69120 Төвлөрсөн сүлжээгээр хий түгээх, хуваарилах үйлчилгээ

Энэ дэд ангид төвлөрсөн сүлжээний хийн түлшийг түгээх үйлчилгээ болон хийн тоолуурыг засварлах үйлчилгээ орно.

Харин дараах үйлчилгээ орохгүй. Үүнд:

- хийн тоолуурыг суурилуулах үйлчилгээ (54611-д),
- дамжуулах хоолойгоор хийг тээвэрлэх үйлчилгээ (65131-д),
- төлбөр эсвэл гэрээнд үндэслэн хийгдэх төвлөрсөн сүлжээний хий түгээх үйлчилгээ (86320-д),
- хийн тоолуурыг унших үйлчилгээ (85999-д орно).

- 692 Ус түгээх үйлчилгээ
6921 Төвлөрсөн сүлжээгээр цэвэр, бохир ус дамжуулах, түгээх үйлчилгээ (уур, халуун уснаас бусад)
69210 Төвлөрсөн сүлжээгээр цэвэр, бохир ус дамжуулах, түгээх үйлчилгээ (уур, халуун уснаас бусад)

Энэ дэд ангид төвлөрсөн сүлжээгээр ус түгээх үйлчилгээ болон усны тоолуурыг засварлах үйлчилгээ орно.

Харин дараах үйлчилгээ орохгүй. Үүнд:

- хийн хэмжүүрийг суурилуулах үйлчилгээ (54611-д),
- усны хэмжүүрийг шалгах үйлчилгээ (85999-д),
- хөдөө аж ахуйн зориулалттай усжуулах системийн үйлчилгээ (86110-д),
- төлбөр эсвэл гэрээнд үндэслэн хийгдэх төвлөрсөн сүлжээний ус түгээх үйлчилгээ (86330-д орно).

- 6922 Төвлөрсөн сүлжээгээр агааржуулалт уур, халуун усны хангамжийн үйлчилгээ
69220 Төвлөрсөн сүлжээгээр агааржуулалт уур, халуун усны хангамжийн үйлчилгээ

Энэ дэд ангид дараах үйлчилгээ орно. Үүнд:

- халаалт, эрчим хүч болон бусад зориулалтаар уур, халуун ус түгээх үйлчилгээ
- хүйтэн агаар түгээх үйлчилгээ
- сэрүүцүүлэх зориулалтаар хөргөсөн ус түгээх үйлчилгээ

Харин төлбөр, гэрээний үндсэн дээр хийгдэх төвлөрсөн системийн уур, халуун ус түгээх үйлчилгээ 86340-д орно.

- 6923 Төвлөрсөн сүлжээнээс бусад ус түгээх үйлчилгээ
69230 Төвлөрсөн сүлжээнээс бусад ус түгээх үйлчилгээ

Энэ дэд ангид ачааны машин болон түүнтэй төстэй түгээгүүрээр ус түгээх үйлчилгээ орно.

Харин дараах үйлчилгээ орохгүй. Үүнд:

- хөдөө аж ахуйн зориулалттай усжуулах системийн үйл ажиллагаа (86110-д),
- төлбөр, гэрээний үндсэн дээр хийгдэх төвлөрсөн системээс бусад ус түгээх үйлчилгээ (86350-д орно).

7 САНХҮҮ, ТҮҮНТЭЙ ХОЛБОГДОХ ҮЙЛЧИЛГЭЭ, ҮЛ ХӨДЛӨХ ХӨРӨНГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ, ТҮРЭЭСИЙН БОЛОН ЛИЗИНГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ

- 71 САНХҮҮГИЙН ЗУУЧЛАЛ БОЛОН ХОЛБОГДОХ ҮЙЛЧИЛГЭЭ
711 Санхүүгийн зуучлалын үйлчилгээ (хөрөнгө оруулалтын банкны үйл ажиллагаа, даатгалын үйлчилгээ, тэтгэврийн даатгалын үйлчилгээнээс бусад)
7111 Төв банкны үйлчилгээ
71110 Төв банкны үйлчилгээ

Энэ дэд ангид дараах үйлчилгээ орно. Үүнд:

- үндэсний мөнгөн тэмдэгтийг гүйлгээнд гаргах, нийлүүлэлтийг зохицуулах
- мөнгөний нийлүүлэлтийг хянах, удирдах
- санхүүгийн байгууллага хоорондын клирингийн тооцоонд ашиглагдах хөрөнгийг харилцах, хадгаламж хэлбэрээр байршуулах
- банкуудын үйл ажиллагаанд хяналт тавих
- улс орны гадаад валютын албан нөөцийг удирдах
- засгийн газрын санхүүгийн зуучлагчийн үүрэг гүйцэтгэх зэрэг үйлчилгээ

7112 Харилцах, хадгаламжийн дансны үйлчилгээ

Энэ ангид данс нээх, хаах, хадгаламж авах, чек гаргах эсвэл чекийг эргүүлэн авах, хуримтлалд зориулан чекээр мөнгө урьдчилан гуйвуулах, данс хооронд мөнгө гуйвуулах, харилцагчдад баримт бичиг бүрдүүлж өгөх зэрэг үйлчилгээ орно.

71121 Аж ахуйн нэгж, байгууллага, хуулийн этгээдэд үзүүлэх харилцах, хадгаламжийн дансны үйлчилгээ

Энэ ангид Засгийн газар болон томоохон аж ахуйн нэгж, байгууллага, хуулийн этгээд харилцагчдад үзүүлэх харилцах, хадгаламжийн үйлчилгээ орно.

71122 Хувь хүнд үзүүлэх харилцах, хадгаламжийн дансны үйлчилгээ

Энэ дэд ангид дараах үйлчилгээ орно. Үүнд:

- аж ахуйн нэгж байгууллага, хуулийн этгээдээс бусад харилцагчдад үзүүлэх харилцах, хадгаламжийн үйлчилгээ
- чекийн үйлчилгээ
- чек баталгаажуулах үйлчилгээ
- төлбөрийг зогсоох үйлчилгээ

Харин дараах үйлчилгээ орохгүй. Үүнд:

- *харилцагчдын өмнөөс цаасан болон зоосон мөнгөн тэмдэгтийг боох, багцлах үйлчилгээ (85400-д),*
- *бэлэн мөнгө, депозитын оронд хүлээн авсан өрийн бичиг, чек болон бусад солилцооны төлбөр, тооцоог цуглуулах үйлчилгээ (85920-д),*
- *төлбөр, тооцоо эсвэл гэрээний үндсэн дээр мөнгө, өр, авлага цуглуулах үйлчилгээ (85920-д орно).*

7113 Зээл олгох үйлчилгээ

Энэ дэд ангид зээл өгөх, зээлийн удирдлагын үйлчилгээ орно /банк, даатгалын компани зэрэг олон төрлийн зээлдэгчдээр дамжин хийгдэж болно/.

71131 Орон сууцны зээлийн үйлчилгээ

Энэ дэд ангид дараах үйлчилгээ орно. Үүнд:

- харьяат оршин суугчдад үзүүлэх орон сууцны зээлийн үйлчилгээ болон газар, орон сууцыг үнэт цаас хэлбэрээр ашиглах зээлийн үйлчилгээ
- зээлийн тэнцвэржүүлсэн үйлчилгээ

Харин биет хөрөнгийн үнэлгээний үйлчилгээ 72240-д орно.

71132 Орон сууцны бус зээлийн үйлчилгээ

Харьяат бус оршин суугчдын газар, орон сууцыг үнэт цаас хэлбэрээр ашиглах зээлийн үйлчилгээ орно.

Харин биет хөрөнгийн үнэлгээний үйлчилгээ 72240-д орно.

71133 Хувийн хэрэглээний зориулалттай зээлийн үйлчилгээ /бизнесийн болон орон сууцны бус/

Энэ дэд ангид дараах үйлчилгээ орно. Үүнд:

- хуваарийн дагуу эргэн төлөгдөх нөхцөлтэй орон сууцны бус хувийн хэрэглээний зээлийн үйлчилгээ
- зээлийн сангаас зээлдэгчид тогтсон хязгаар дотор зээл олгох, баталгаанд үндэслэсэн зээлийн үйлчилгээ зэрэг зээл олгохтой холбоотой гэрээ төлбөрт үндэслэн хийдэг үйлчилгээ
- хэрэглэгч бараа, үйлчилгээ худалдаж авахад нь санхүүжүүлэх зорилготой бөгөөд тэдгээр бараа нь барьцаа болдог зээлийн үйлчилгээ

71134 Зээлийн /кредит картын үйлчилгээ

Энэ дэд ангид зээлийн картыг эзэмшигч бараа, үйлчилгээ худалдаж авах үед хэрэглэх баталгаат зээл бөгөөд зээлийн нийт төлбөр нь тогтоосон хугацааны дараа төлөгдөх кредит картын үйлчилгээ орно.

71135 Бизнесийн зориулалттай, орон сууцны бус зээлийн үйлчилгээ

Энэ дэд ангид дараах үйлчилгээ орно. Үүнд:

- диллер, брокер, санхүүгийн байгууллага, улсын, бүсийн болон орон нутгийн засаг захиргааны байгууллага, сургалтын байгууллага, гадаад улсын засаг захиргааны байгууллага, бусад бизнесийн байгууллага зэрэгт олгох хөрөнгө оруулалтын зориулалттай зээлийн үйлчилгээ
- бизнесийн зориулалттай хувь хүнд олгох зээлийн үйлчилгээ

- өөрийн дансан дахь мөнгөнөөс хэтрүүлэн авах /хасах дансруу орох/ зээлийн үйлчилгээг оруулаад бусад шуурхай, хариуцлагатай зээлийн үйлчилгээ
- зээлийн баталгаа гаргах, зээлийн бичгээр хангах үйлчилгээ
- төсөл болон байгууллагаас албан ёсоор гаргасан зээлийг санхүүжүүлэхээр банк эсвэл бусад санхүүгийн байгууллагын гаргасан зөвшөөрөлтэй холбогдох үйлчилгээ

71139 Бусад төрлийн зээл олгох үйлчилгээ

Энэ дэд ангид бусад зээлийн үйлчилгээ, худалдааг санхүүжүүлэх үйлчилгээ орно.

7114 Санхүүгийн лизингийн үйлчилгээ

71140 Санхүүгийн лизингийн үйлчилгээ

Энэ дэд ангид хэрэглэгчийн талд капиталын хөрөнгө оруулалт хийхгүйгээр хэрэглэгчдэд тоног төхөөрөмж болон бусад хөрөнгийг нийлүүлэх үйлчилгээ орно. Энд түрээслүүлэгч тоног төхөөрөмж болон бусад эд зүйлсийн үнийг төлж эзэмшилдээ авах бөгөөд өмчлөгчийн зарим үүргээ хадгалж үлдэн тэдгээрийг түрээслүүлэх үйлчилгээ байна.

Харин үйл ажиллагааны лизингийн үйлчилгээ дэд салбар 73-т орно.

7119 Бусад төрлийн санхүүгийн үйлчилгээ (Хөрөнгө оруулалтын банкны үйлчилгээ, даатгалын үйлчилгээ, тэтгэвэрийн даатгалын үйлчилгээ орохгүй)

71190 Бусад төрлийн санхүүгийн үйлчилгээ (Хөрөнгө оруулалтын банкны үйлчилгээ, даатгалын үйлчилгээ, тэтгэвэрийн даатгалын үйлчилгээ орохгүй)

Энэ дэд ангид факторингийн үйлчилгээ болон зээлийн картыг худалдаалах үйлчилгээ орно.

712 Хөрөнгө оруулалтын банкны үйлчилгээ

7120 Хөрөнгө оруулалтын банкны үйлчилгээ

71200 Хөрөнгө оруулалтын банкны үйлчилгээ

Энэ дэд ангид дараах үйлчилгээ орно. Үүнд:

- үнэт цаасны эрсдлийг тодорхойлох, үнэлэх үйлчилгээ
- Засгийн газрын болон компаний тогтмол үнэтэй үнэт цаасны арилжаатай холбоотой асуудал, хөрөнгө оруулагчдад тэднийг худалдах баталгаагаар хангах үйлчилгээ
- харилцагчийн үнэт цаасанд баталгаа гаргахгүйгээр бүгдийг худалдан авах болон боломжит хэмжээнд нь хүртэл арилжих үйл ажиллагаа

713 Нийгмийн даатгалаас бусад төрлийн даатгал болон тэтгэврийн даатгалын үйлчилгээ (давхар даатгалын үйлчилгээ орохгүй)

7131 Урт хугацааны даатгал (амь насны) болон тэтгэврийн даатгалын үйлчилгээ (давхар даатгалын үйлчилгээ орохгүй)

71311 Урт хугацааны даатгал (амь насны), хувь хүнд олгох даатгалын үйлчилгээ

Энэ дэд ангид дараах үйлчилгээ орно. Үүнд:

- насанд хүрсэн, амь даатгалд даатгуулагчийн даатгалын зардлаас төлбөр төлөх хүртэл үйл ажиллагааг хангасан даатгалын гэрээний эрсдлийг тодорхойлж, үнэлэх үйлчилгээ /Гэрээ нь цэвэр хамгаалах зорилготой эсвэл хадгаламжийн орлогоос бүрддэг байж болно. Мөн хувь хүн эсвэл бүлэг хүмүүсийг хамарсан гэрээ байж болно/.
- хувь хүнд тодорхой хугацаанд, давтамжтайгаар төлбөр олгох даатгалын /annuities/ төлөвлөгөөний эрсдлийг тодорхойлж, үнэлэх үйлчилгээ /Төлөвлөгөө нь нэг эсвэл хэд хэдэн удаагийн төлбөртэй байж болно; сайн дурын эсвэл албан ёсны байж болно; урьдаас тогтсон нэрлэсэн тэтгэмжтэй эсвэл төлөвлөгөөнд тусгагдсан тухайн нөхцөлийн зах зээлийн үнээс хамаардаг байж болно. Үргэлжлэх хугацаа гэдэг нь төлбөр төлөгддөг, тогтсон, хамгийн их болон хамгийн бага хугацааг хэлнэ/.

Харин дараах үйлчилгээ орохгүй. Үүнд:

- *хөрөнгө оруулалт эзэмшлийн удирдлагын үйлчилгээ (тэтгэвэрийн сан орохгүй) (71530-д),*
- *итгэлцлийн (траст) үйлчилгээ (71541-д),*
- *тэтгэврийн сангийн зохион байгуулалтын үйлчилгээ (71640-д),*
- *тэтгэврийн сангийн удирдлага (71690-д орно).*

71312 Бүлэг иргэдэд олгох тэтгэвэр, даатгалын үйлчилгээ

Энэ дэд ангид бүлэг, хамт олны гишүүдэд тодорхой хугацааны давтамжтайгаар төлбөр төлөх даатгалын эрсдлийг тодорхойлж, үнэлэх үйлчилгээ орно. Төлөвлөгөө нь нэг эсвэл хэд хэдэн удаагийн төлбөртэй байж болно, сайн дурын эсвэл албан ёсны байж болно, урьдаас тогтсон нэрлэсэн тэтгэмжтэй эсвэл төлөвлөгөөнд тусгагдсан тухайн нөхцөлийн зах зээлийн үнээс хамаардаг байж болно. Үргэлжлэх хугацаа гэдэг нь төлбөр төлөгддөг, тогтсон, хамгийн их болон хамгийн бага хугацааг хэлнэ.

Харин дараах үйлчилгээ орохгүй. Үүнд:

- *хөрөнгө оруулалт эзэмшлийн удирдлагын үйлчилгээ (тэтгэврийн сан орохгүй) (71530-д),*
- *итгэлцлийн (траст) үйлчилгээ (71541-д),*
- *тэтгэврийн сангийн зохион байгуулалтын үйлчилгээ (71640-д),*
- *тэтгэврийн сангийн удирдлага (71690-д орно).*

7132 Гэнэтийн осол, эрүүл мэндийн даатгалын үйлчилгээ

71320 Гэнэтийн осол, эрүүл мэндийн даатгалын үйлчилгээ

Энэ дэд ангид дараах үйлчилгээ орно. Үүнд:

- эмнэлгийн болон эм, эмчилгээний зардлыг санхүүжүүлэх зорилготой даатгалын гэрээний эрсдлийг тодорхойлж, үнэлэх үйлчилгээ (Засгийн газрын хөтөлбөрүүд болон жороор бичигдсэн эм, эмчилгээний багаж, тоног төхөөрөмж, эмнэлгийн машин, хувийн асрагч зэрэг эрүүлийг хамгаалах бусад зардал орохгүй)
- шүдний эмнэлгийн зардлын даатгалын гэрээний эрсдэл тооцох, үнэлэх үйлчилгээ
- осол болон өвчний улмаас хөдөлмөрийн чадвараа алдсан даатгуулагчид тодорхой үед төлбөр төлдөг даатгалын гэрээний эрсдэл тооцох, үнэлэх үйлчилгээ
- ослын улмаас нас барах, тахир дутуу болоход төлөгдөх даатгалын гэрээний эрсдэл тооцох, үнэлэх үйлчилгээ (төлбөр нь ослын үр дүнгээс хамаарна).

Харин жуулчлалын даатгалын үйлчилгээ орохгүй. (71337-д орно).

7133 Бусад төрлийн амьдралын (амь насны) бус даатгалын үйлчилгээ (давхар даатгалын үйлчилгээ орохгүй)

71331 Авто тээврийн хэрэгслийн даатгалын үйлчилгээ

Энэ дэд ангид дараах үйлчилгээ орно. Үүнд:

- автомашины ашиглалттай холбоотой гарах эрсдэл болон тэдгээрт төлбөр төлөн зорчиж буй зорчигчдыг хамарсан даатгалын гэрээний эрсдэлийг тооцох, үнэлэх үйлчилгээ /Эрсдэл нь хариуцлага, автомашин эвдрэх, устах зэргийг хамарна/.
- ачааны авто тээврийн хэрэгслийн даатгалын үйлчилгээ

71332 Нисэх онгоц, хөлөг онгоц, галт тэрэг болон бусад тээврийн хэрэгслийн даатгалын үйлчилгээ

Энэ дэд ангид дараах үйлчилгээ орно. Үүнд:

- дараах тээврийн хэрэгсэлтэй холбоотой эрсдлийг хамарсан даатгалын гэрээний эрсдлийг тооцох, үнэлэх үйлчилгээ
 - > далай, далайн эрэг хавийн усан замын болон эх газрын дотор усан замын зорчигч болон ачаа тээврийн усан онгоц
 - > агаарын тээврийн онгоц
 - > вагон
 - > хиймэл дагуул хөөргөхөд хийгдэх даатгалын үйлчилгээ

Тайлбар: Эрсдэл нь хариуцлага, усан замын тээврийн хэрэгсэл эвдрэх, устах, агаарын болон төмөр замын тээврийн хэрэгсэл эвдрэх, устах зэргийг хамарна.

Харин агаарын болон усан замын худалдааны бус тээврийн /орлого олох зорилготой бус/ хэрэгслийн даатгалын гэрээний эрсдлийг тооцох, үнэлэх үйлчилгээ 71334-т орно.

71333 Ачаа, тээшийн даатгалын үйлчилгээ

Энэ дэд ангид тээврийн компаний санхүүгийн нэмэлт хамгаалалт буюу ачааг эвдэрч, устах эрсдэлийн даатгалын гэрээний эрсдэл тооцох, үнэлэх үйлчилгээ орно.

71334 Эд хөрөнгийн бусад төрлийн даатгалын үйлчилгээ

Энэ дэд ангид дараах үйлчилгээ орно. Үүнд:

- 71331, 71332, 71333 дэд ангиудад хамрагдсанаас бусад эд хөрөнгийн эвдрэх, устах тохиолдлын даатгалын эрсдлийг тооцох, үнэлэх үйлчилгээ /эрсдэлд гал түймэр, хулгай, дэлбэрэлт, салхи шуурга, мөндөр, хүйтрэлт, байгалийн гамшиг, радио идэвхит бодис, газар нурах зэрэг орно/.

- агаарын болон усан замын тээврийн /ашгийн бус/ хэрэгслийн даатгал
- гэрэлтүүлэх, халаах, хөргөх, уур, усны цахилгаан хэрэгслийн цахилгааны хүчнээс үүсэх гэмтлийн даатгалын үйлчилгээ

71335 Хариуцлагын даатгалын үйлчилгээ

Энэ дэд ангид 71331, 71332, 71334 дэд ангиудад орсноос бусад хариуцлага буюу бараанд гэмтэл, согог учрах, муудах, хүмүүс гэмтэж, шархдах, эд хөрөнгө эвдрэх, бохирдох, мэргэжлийн осол зэрэг хариуцлагын бүх хэлбэрийн эрсдэлийн даатгалын гэрээний эрсдэл тооцох, үнэлэх үйлчилгээ орно.

71336 Зээлийн төлбөрийн чадавхийн баталгааны даатгалын үйлчилгээ

Энэ дэд ангид дараах үйлчилгээ орно. Үүнд:

- зээл авагч төлбөрийн чадваргүй болсноос үүсэх зээлийн эрсдлийн даатгал
- гэрээ, зөвшилцөлд тусгасан санхүүгийн үүргээ биелүүлээгүй болон алдаа гаргах эрсдлийг хамарсан даатгалын гэрээний эрсдэл тооцох, үнэлэх үйлчилгээ

71337 Жуулчлалын даатгалын үйлчилгээ

Энэ дэд ангид дараах үйлчилгээ орно. Үүнд:

- жуулчлалтай холбогдох доорх зардлуудын /ихэнхдээ ачаа, тээш/ даатгалын гэрээний эрсдэл тооцох, үнэлэх үйлчилгээ орно. Үүнд:
 - > аялал цуцлагдах, зогсоогдох, хойшлогдох
 - > тээш алдагдах, гэмтэх, хоцрох
 - > аюул осол болон эмнэлгийн зардал
 - > нутаг буцаах (нас барагчдыг тээх даатгал)

Харин тээврийн хэрэгслийн даатгал орохгүй. (71331-д орно).

71339 Амьдралын (амь) бус бусад төрлийн даатгалын үйлчилгээ

Энэ дэд ангид дараах үйлчилгээ орно. Үүнд:

- хуулийн зардлын даатгал, орон сууцны даатгал, эрхийн бичгийн даатгал
- төрөл бүрийн санхүүгийн алдагдлын эрсдлийг хамарсан даатгалын гэрээний эрсдэл тооцох, үнэлэх үйлчилгээ. /эрсдэлд ажилтангүй болох, (ердийн) орлого хүрэлцэхүйц бус байх, цаг агаарын тааруу байдал, давуу байдлаа алдах, урьдчилж мэдэгдээгүй /гэнэтийн/ худалдааны зардал, зах зээлийн үнийн уналт, хүү, орлогын алдагдал, худалдааны шууд бус алдагдал, бусад санхүүгийн болон бусад хэлбэрийн алдагдал орно/.
- бусад даатгалын үйлчилгээ

714 Давхар даатгалын үйлчилгээ

Энэ бүлэгт даатгалын гэрээнүүдийн зарим хэсэг эсвэл бүгдийг өөр даатгалын компанид дахин даатгуулах үйлчилгээ орно.

7141 Урт хугацааны (амь насны) давхар даатгалын үйлчилгээ

71410 Урт хугацааны (амь насны) давхар даатгалын үйлчилгээ

Энэ дэд ангид дараах эд зүйлийг оруулна:

- амь насны даатгалын давхар даатгалын үйлчилгээ
- насан туршийн даатгалын давхар даатгалын үйлчилгээ

7142 Гэнэтийн осол, эрүүл мэндийн давхар даатгалын үйлчилгээ

71420 Гэнэтийн осол, эрүүл мэндийн давхар даатгалын үйлчилгээ

Энэ дэд ангид дараах эд зүйлийг оруулна:
- ослын болон эрүүл мэндийн давхар даатгалын үйлчилгээ
- насан туршийн даатгалын давхар даатгалын үйлчилгээ

7143 Урт хугацааны (амь насны) бус давхар даатгалын үйлчилгээ
71431 Авто тээврийн хэрэгслийн давхар даатгалын үйлчилгээ

Энэ дэд ангид дараах эд зүйлийг оруулна:
- моторт тээврийн хэрэгслийн давхар даатгалын үйлчилгээ

71432 Нисэх онгоц, хөлөг онгоц, галт тэрэг болон бусад төрлийн тээврийн хэрэгслийн давхар даатгалын үйлчилгээ

Энэ дэд ангид дараах эд зүйлийг оруулна:
- тэнгисийн, агаарын болон бусад төрлийн тээврийн давхар даатгалын үйлчилгээ

71433 Ачаа, тээшийн давхар даатгалын үйлчилгээ

Энэ дэд ангид дараах эд зүйлийг оруулна:
- ачааны давхар даатгалын үйлчилгээ

71434 Эд хөрөнгийн бусад төрлийн давхар даатгалын үйлчилгээ

Энэ дэд ангид дараах эд зүйлийг оруулна:
- моторт тээврийн хэрэгсэл, ачаанаас бусад эд хөрөнгийн давхар даатгалын үйлчилгээ

71435 Хариуцлагын давхар даатгалын үйлчилгээ

Энэ дэд ангид дараах эд зүйлийг оруулна:
- хариуцлагын давхар даатгалын үйлчилгээ

71436 Зээлийн төлбөрийн чадварын баталгааны давхар даатгалын үйлчилгээ

Үнэт цаасны давхар даатгалын үйлчилгээ орно.

71439 Урт хугацааны (амь насны) бус бусад төрлийн эд хөрөнгийн давхар даатгалын үйлчилгээ

Энэ дэд ангид бусад газар ангилагдаагүй, амь насны бус давхар даатгалын үйлчилгээ орно.

715 Тэтгэвэр болон даатгалаас бусад төрлийн санхүүгийн туслах үйлчилгээ
7151 Хөрөнгө оруулалтын банкны үйлчилгээ
71511 Бусад аж ахуйн нэгжийг өөртөө нэгтгэх, худалдан авахад хөрөнгө оруулах үйлчилгээ

Энэ дэд ангид аж ахуйн нэгж, байгууллагад хамааралтай нэгдэх, нэгтгэх үйлчилгээ орно.

71512 Аж ахуйн нэгжийн санхүүжилтийг дангаар болон хамтран гүйцэтгэх үйлчилгээ

Энэ дэд ангид дараах үйлчилгээ орно. Үүнд:
- компаний хөрөнгө, өр зэрэг санхүүгийн үйл ажиллагааг зохицуулах, хөрөнгө оруулалтын үйлчилгээ
- хөрөнгийн санхүүжилт/хөрөнгө оруулалтын/ үйлчилгээ

71519 Хөрөнгө оруулалтын банкны бусад төрлийн үйлчилгээ

Энэ дэд ангид хөрөнгө оруулалтын банкны үйл ажиллагаатай холбогдох бусад үйлчилгээ орно.

Харин дараах үйлчилгэээ орохгүй. Үүнд:

- *үнэт цаасны гүйлгээг эрхлэн хөтлөх үйлчилгээ (71530-д),*
- *хөрөнгө оруулалтын үнэт цаастай холбогдох итгэмжлэгдсэн үйлчилгээ болон үнэт цаасыг хадгалах, хамгаалах үйлчилгээ (7154-д),*
- *мэдээллийн үйлчилгээ буюу үнэт цаасны үнийн мэдээллийн үйлчилгээ (84399-д),*
- *хэвлэл мэдээллийн хэрэгслийг санхүүгийн мэдээллээр үйлчлэх үйлчилгээ (844-т орно).*

7152 Үнэт цаасны болон зориулалтын зах зээлд арилжаалах бараа, бүтээгдэхүүний брокерын /зуучлалын/ үйлчилгээ

71521 Үнэт цаасны брокерын үйлчилгээ

Энэ дэд ангид дараах үйлчилгээ орно. Үүнд:

- үнэт цаасны брокерийн үйлчилгээ
- хөрөнгө оруулалтын сангийн хувьцаа, нэгж болон бусад хэрэгсэлүүдийг арилжаалах агентийн үйлчилгээ
- Засгийн газрын бондыг зарах, солих, хүргэх үйлчилгээ
- үнэт цаасны сонголтын брокерын үйлчилгээ

71522 Зориулалтын биржид арилжаалах бараа, бүтээгдэхүүний брокерын үйлчилгээ

Энэ дэд ангид дараах үйлчилгээ орно. Үүнд:

- бараа болон санхүүгийн гэрээнд багтах барааны гэрээний брокерын үйлчилгээ
- санхүүгийн эрх, үүргийн гэрээний брокерын үйлчилгээ

Харин үнэт цаасны сонголтын брокерын үйлчилгээ орохгүй. (71521-д орно).

71523 Үнэт цаасны гүйлгээ хийх, бэлэн бус тооцоо хийх үйлчилгээ

Энэ дэд ангид компьютерт суурилсан үнэт цаас өмчлөх шилжүүлэг, дебит, кредитын гүйлгээ хийх, клирингийн тооцоо хийх үйлчилгээ орно.

7153 Тэтгэврийн сангаас бусад төрлийн хөрөнгийн багцын удирдлагын үйл ажиллагаа

71530 Тэтгэврийн сангаас бусад төрлийн хөрөнгийн багцын удирдлагын үйл ажиллагаа

Энэ дэд ангид тэтгэврийн сангаас бусад хөрөнгө оруулалт эзэмшигчдийн хөрөнгийг төлбөр болон шимтгэлтэйгээр удирдах үйлчилгээ орно. Менежер ямар хөрөнгө оруулалтын эрхийг худалдах болон худалдаж авах шийдвэрийг гаргана.

Харин дараах үйлчилгэээ орохгүй. Үүнд:

- *тэтгэврийн сангийн удирдлага (71640-д),*
- *хувийн санхүүгийн төлөвлөлтөд зөвлөгөө /шийдвэр гаргахад оролцохгүй/ өгөх үйлчилгээ (71591-д),*
- *үнэт цаасыг шилжүүлгийн төлбөрөөр худалдах, худалдан авах үйлчилгээ (71521-д орно).*

7154 Итгэмжлэл болон үнэт зүйл хадгалах үйлчилгээ

71541 Итгэмжлэлийн (траст) үйлчилгээ

Энэ дэд ангид дараах үйлчилгээ орно. Үүнд:

- өмчлөл болон итгэмжлэлийг зохицуулах, удирдлагаар хангах үйлчилгээ
- хөрөнгө оруулалтын сан болон тэтгэврийн сангийн хяналтын үйлчилгээ
- үнэт цаасны хяналтын үйлчилгээ /үнэт цаасыг бүртгэх, хүү болон ногдол ашигтай холбогдох асуудлыг удирдах үйлчилгээ/

71542 Үнэт зүйл хадгалах үйлчилгээ

Энэ дэд ангид дараах үйлчилгээ орно. Үүнд:

- хувийн үнэт зүйл болон данс тооцооны аюулгүй байдлыг ханган, тодорхой нөхцөлтэйгээр хадгалах үйлчилгээ
- сейфний үйлчилгээ
- хадгаламжийн/мөнгөний сейфийн үйлчилгээ
- хамгалаалтын үйлчилгээ
- сейфний аюулгүй байдлыг хангалтыг баталгаажуулах аудитын үйлчилгээ

7155 Санхүүгийн зах зээлийн удирдлагын үйлчилгээ

71551 Санхүүгийн зах зээлийн шуурхай үйлчилгээ

Энэ дэд ангид хамгаалалтын болон бараа солилцооны ажилд шаардлагатай төхөөрөмж, эдлэлийг байршуулах байрны үйлчилгээ орно.

71552 Санхүүгийн зах зээлийн зохицуулалтын үйлчилгээ

Энэ дэд ангид санхүүгийн зах зээл болон түүнд оролцогчдыг зохицуулах, хяналт хийх үйлчилгээ орно.

71559 Санхүүгийн зах зээлийн удирдлагатай холбоотой бусад төрлийн үйлчилгээ

Энэ дэд ангид санхүүгийн зах зээлийн бусад үйлчилгээ орно.

Харин дараах үйлчилгээ орохгүй. Үүнд:

- *хамгаалалтаар хангах үйлчилгээ (71542-т),*
- *мэдээллийн серверээр хийх үнэт цаасны үнийн хөнгөлөлтийн үйлчилгээ (84399-д),*
- *санхүүгийн шинэ мэдээг хэвлэл мэдээллийн хэрэгсэлд өгөх үйлчилгээ (844-д орно).*

7159 Санхүүгийн зуучлалын бусад төрлийн туслах үйлчилгээ

71591 Санхүүгийн чиглэлээр зөвлөгөө өгөх үйлчилгээ

Энэ дэд ангид дараах үйлчилгээ орно. Үүнд:

- санхүүгийн зөвлөгөө өгөх үйлчилгээ
- зах зээлийн судалгаа, тандалтын үйлчилгээ

Харин дараах үйлчилгээ орохгүй. Үүнд:

- *даатгал болон тэтгэврийн зөвлөгөө өгөх үйлчилгээ (71690-д),*
- *компаниудыг нэгтгэх буюу эзэмших үйлчилгээ (71511-д),*
- *хөрөнгө нийлүүлэлт, байгууллагын хөрөнгийн үйлчилгээ (71512-т),*
- *тэтгэврийн сангаас бусад багцын удирдлагын үйлчилгээ (71530-д),*
- *итгэлцэл болон үнэт зүйл хадгалах үйлчилгээ (7154-т),*
- *тэтгэврийн сангийн удирдлагын үйлчилгээ (71640-д),*
- *татварын талаар зөвлөгөө өгөх үйлчилгээ (823-т),*
- *бизнесийн орлогын татвараас бусад санхүүгийн удирдлагын зөвлөгөө өгөх үйлчилгээ (83112-т орно).*

71592 Валют арилжааны үйлчилгээ

Энэ дэд ангид валют солих товчооны/цэгийн үйлчилгээ орно.

71593 Санхүүгийн төлбөр тооцоо гүйцэтгэх болон клирингийн төвийн үйлчилгээ

Энэ дэд ангид дараах үйлчилгээ орно. Үүнд:

- санхүүгийн тэнцлийг шалгах, гүйлгээг зөвшөөрөх, санг шилжүүлэх болон түүнийг гүйлгээний данснаас шилжүүлэн авах, банкуудад (зээлийн карт олгогч байгууллагуудад) тодорхой гүйлгээ болон өдөр тутмын нийт гүйлгээний талаар мэдэгдэл гаргах зэрэг санхүүгийн гүйлгээг боловсруулах үйлчилгээ
- чек, төсөл болон төлбөрийн бусад захиалгыг хүчингүй болгох үйлчилгээ
- дебит карт худалдах үйлчилгээ

Харин хамгаалалттай гүйлгээг боловсруулах үйлчилгээ 71523-т орно.

71599 Санхүүгийн зах зээлийн удирдлагатай холбоотой бусад төрлийн үйлчилгээ

Энэ дэд ангид орон сууцны ба зээлийн зуучлах үйлчилгээ орно.

Харин зоос болон валютыг савлах, боох үйлчилгээ 85400-д орно.

716 Тэтгэвэр болон даатгалын туслах үйлчилгээ

7161 Даатгалын брокер, агентлагийн үйлчилгээ

71610 Даатгалын брокер, агентлагийн үйлчилгээ

Энэ дэд ангид даатгал болон тэтгэврийн брокерын үйлчилгээ орно.

7162 Даатгалын нөхөн олговрыг зохицуулах үйлчилгээ

71620 Даатгалын нөхөн олговрыг зохицуулах үйлчилгээ

Энэ дэд ангид дараах үйлчилгээ орно. Үүнд:

- даатгалын бодлого, хэлэлцээрийн заалтуудын дагуу алдагдлын хэмжээг тодорхойлох, даатгалын мэдүүлгийг судлах үйлчилгээ
- судлагдсан мэдүүлгийг шалгаж, төлбөрийг баталгаажуулах үйлчилгээ
- алдагдлыг үнэлэх үйлчилгээ

7163 Даатгалын үнэлгээ, тооцоо хийх актуарын /даатгалын ажилтан/ үйлчилгээ

71630 Даатгалын үнэлгээ, тооцоо хийх актуарын /даатгалын ажилтан/ үйлчилгээ

Энэ дэд ангид даатгалын эрсдэл болон шагналыг тооцох үйлчилгээ орно.

7164 Тэтгэврийн даатгалын сангийн удирдлагыг хангах үйлчилгээ

71640 Тэтгэврийн даатгалын сангийн удирдлагыг хангах үйлчилгээ

Энэ дэд ангид тэтгэврийн сангийн удирдлагын үйлчилгээ орно.

7169 Тэтгэвэр болон даатгалын туслах бусад үйлчилгээ

71690 Тэтгэвэр болон даатгалын туслах бусад үйлчилгээ

Энэ дэд ангид дараах үйлчилгээ орно. Үүнд:

- даатгал болон тэтгэврийн сангийн удирдлагын үйлчилгээ
- эд хөрөнгийг гамшгаас хамгаалах үйлчилгээ
- даатгал болон тэтгэврийн зөвлөгөө өгөх үйлчилгээ

72 ҮЛ ХӨДЛӨХ ХӨРӨНГӨТЭЙ ХОЛБОГДОХ ҮЙЛЧИЛГЭЭ

721 Үл хөдлөх хөрөнгийг түрээслэх, худалдаалах үйлчилгээ

7211 Өөрийн болон лизингийн хөрөнгийн түрээс, лизингийн үйлчилгээ

72111 Өөрийн болон лизингийн орон сууцны түрээс, лизингийн үйлчилгээ

Энэ дэд ангид дараах үйлчилгээ орно. Үүнд:

- орон сууц эзэмшигч эсвэл түрээслэгч бусдад түрээслүүлэх буюу түрээслэх үйлчилгээ, жишээлбэл:

- > байшин, орон сууцны өрөө, орон сууцны барилга
- > орон сууцны байрыг олон зориулалтаар ашиглах боломжтой байр
- > орон сууцны зөөврийн байрны үйлчилгээ

Харин зочид буудал, дэн буудал, сургуулийн дотуур байр, зуслангийн болон бусад түр орогнох байрны байраар хангах үйлчилгээ 631-д орно.

72112 Орон сууцны барилгын түрээс, лизингийн үйлчилгээ

Энэ дэд ангид дараах үйлчилгээ орно. Үүнд:

- үйлдвэр, худалдаа буюу орон сууцны бус бусад барилга, өмчийг эзэмшигч эсвэл түрээслэгч бусдад түрээслүүлэх болон түрээслэх үйлчилгээ, жишээлбэл:

- > үйлдвэр, албаны байр, агуулах
- > театр, үзэсгэлэнгийн танхим болон орон сууцны бус, төрөл бүрийн зориулалтаар ашиглах боломжтой байр
- > хөдөө аж ахуйн, ойн аж ахуйн болон энэ төрлийн бусад өмч
- сар буюу жилээр худалдааны цэг, гараж буюу автомашины зогсоолын зориулалт бүхий бусад байрыг түрээслэх, түрээслүүлэх үйлчилгээ

7212 Барилгыг газрын хамт худалдах үйлчилгээ

72121 Орон сууцны газрын хамт худалдах үйлчилгээ

Энэ дэд ангид дараах үйлчилгээ орно. Үүнд:

- орон сууцны барилгыг холбогдох газрын хамт худалдах үйлчилгээ
- байшинг холбогдох газрын хамт, нийтийн орон сууцны барилга, холбогдох газрын хамт, тусгай өрөө буюу хамтын эзэмшилтэй байгууламжийг худалдах үйлчилгээ (ийм төрлийн өмчийг мөн түрээслүүлэх буюу үнэ төлбөргүй суулгаж болно).

Харин эзэнгүй газрыг худалдах үйлчилгээ 72130-д орно.

72122 Орон сууцны бус барилгыг газрын хамт худалдах үйлчилгээ

Энэ дэд ангид дараах үйлчилгээ орно. Үүнд:

- орон сууцны бус барилгыг холбогдох газрын хамт өөрийн нэрээр худалдах үйлчилгээ, жишээлбэл:

- > үйлдвэр, албан газрын барилга, агуулах
- > театр болон төрөл бүрийн зориулалтаар ашиглах боломжтой барилга
- > зочид буудал
- > хөдөө аж ахуй, ойн аж ахуйн өмч
- > адил төстэй барилга

Дээрх төрлийн барилга нь лизингийн эсвэл өмчлөгчийн барилга байж болно.

Харин эзэнгүй газрыг худалдах үйлчилгээ 72130-д орно.

72123 Хөрөнгийг хэсэгчлэн худалдах үйлчилгээ

Энэ дэд ангид өөрийн тооцооны үндсэнд хөрөнгийг хэсэгчлэн худалдах үйлчилгээ орно.

7213 Ашиглагдаагүй газрын худалдаа

72130 Ашиглагдаагүй газрын худалдаа

Энэ дэд ангид өөрийн эзэмшлийн сул чөлөөтэй орон сууцны болон орон сууцны бус газрын худалдах үйлчилгээ орно. Энэхүү сул чөлөөтэй газар нь хэд хэдэн хэсэгт хуваагдаж болно.

722 Төлбөр болон гэрээгээр хийгдэх үл хөдлөх хөрөнгийн үйлчилгээ

7221 Төлбөр болон гэрээгээр хийгдэх хөрөнгийн бүртгэл, удирдлагын үйлчилгээ

72211 Төлбөр болон гэрээгээр орон сууцны барилгатай холбогдох хөрөнгийн бүртгэл, удирдлагын үйлчилгээ

Энэ дэд ангид дараах үйлчилгээ орно. Үүнд:

- төлбөр болон гэрээгээр хийгдэх байшингийн болон орон сууцны бусад барилгын удирдлагын үйлчилгээ
- хэд хэдэн өрөөтэй сууцны тусдаа барилгын удирдлагын үйлчилгээ (сууцны тусдаа байшинг хэд хэдэн зорилгоор ашиглах)
- орон сууцны зориулалттай зөөврийн байшин
- түрээсийн төлбөр цуглуулах үйлчилгээ
- хамтран эзэмшдэг байрны удирдлагын үйлчилгээ

Харин төлбөр болон гэрээгээр хийх хэсэгчилсэн өмчийн удирдлагын үйлчилгээ 72213-т орно.

72212 Төлбөр болон гэрээгээр хийгдэх орон сууцны бус барилга, байгууламжтай холбогдох хөрөнгийн бүртгэл, удирдлагын үйлчилгээ

Энэ дэд ангид дараах үйлчилгээ орно. Үүнд:

- хэд хэдэн өрөөтэй үйлдвэрийн, худалдаа, үйлчилгээний зориулалттай барилгын удирдлагын үйлчилгээ (орон сууцны бус байшинг хэд хэдэн зорилгоор ашиглах)
- хөдөө аж ахуй, ойн аж ахуйн болон адил төстэй зориулалтын барилгын удирдлагын үйлчилгээ

Харин дараах үйлчилгээ орохгүй. Үүнд:

- спорт, амралт зугаалгын зориулалттай барилгын үйлчилгээ (96520-д),
- амралт, зугаа цэнгэлийн бусад байгууламжийн үйлчилгээ (96990-д орно).

72213 Төлбөр болон гэрээгээр хийгдэх түр хугацаагаар эзэмших хөрөнгийн бүртгэл, удирдлагын үйлчилгээ

Энэ дэд ангид төлбөр болон гэрээгээр хийгдэх түр хугацаагаар эзэмших хөрөнгийн бүртгэл, удирдлагын үйлчилгээ орно.

7222 Төлбөр болон гэрээгээр хийгдэх барилга байшин, түүний газар, талбайг борлуулах үйлчилгээ

72221 Төлбөр болон гэрээгээр орон сууцны барилга, түүний газрыг борлуулах үйлчилгээ

Энэ дэд ангид төлбөр болон гэрээгээр хийгдэх байшин, сууцны тусдаа өрөө, сууцны тусдаа байшин болон бусад орон сууцны барилгыг газартай нь худалдан авах, худалдах, түрээслэх үйлчилгээ орно.

Харин дараах үйлчилгээ орохгүй. Үүнд:

- төлбөр болон гэрээгээр хийгдэх өмчийг хэсэгчлэн худалдах үйлчилгээ (72223-т),
- төлбөр болон гэрээгээр газар худалдах үйлчилгээ (72230-д орно).

72222 Төлбөр болон гэрээгээр орон сууцны бус барилга, түүний газрыг борлуулах үйлчилгээ

Энэ дэд ангид албан газрын барилга, үйлдвэр, зочид буудал, дэлгүүр болон адил төстэй орон сууцны бус барилгыг худалдах, түрээслэх үл хөдлөх хөрөнгийн зуучлагч, брокерын төлбөр болон гэрээгээр хийгдэх үйлчилгээ орно.

Харин төлбөр болон гэрээгээр газар худалдаалах үйлчилгээ орохгүй. (72230-д орно).

72223 Төлбөр болон гэрээгээр хөрөнгийг хэсэгчлэн борлуулах үйлчилгээ

Энэ дэд ангид төлбөр болон гэрээгээр хөрөнгийг хэсэгчлэн борлуулах үйлчилгээ орно.

7223 Төлбөр болон гэрээгээр газрыг борлуулах үйлчилгээ

72230 Төлбөр болон гэрээгээр газрыг борлуулах үйлчилгээ

Энэ дэд ангид сул, чөлөөтэй газрыг худалдах, худалдан авах, түрээслэх үл хөдлөх хөрөнгийн зуучлагч, брокерын төлбөр болон гэрээгээр хийгдэх үйлчилгээ орно.

7224 Төлбөр болон гэрээгээр хийгдэх үл хөдлөх хөрөнгийн үнэлгээний үйлчилгээ

72240 Төлбөр болон гэрээгээр хийгдэх үл хөдлөх хөрөнгийн үнэлгээний үйлчилгээ

Энэ дэд ангид гэрээ төлбөрийн үндсэн дээр хийгдэх газар, орон сууцны бус барилга, түүний газар, орон сууцны зориулалттай/зориулалтгүй газар зэрэг үл хөдлөх хөрөнгийн үнэлгээний үйлчилгээ орно.

73 ТҮРЭЭСИЙН БОЛОН ЛИЗИНГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ

Энэ дэд ангид хувийн болон өрхийн зориулалттай бараа, тоног төхөөрөмжийн санхүүгийн лизингийн үйлчилгээ орохгүй, харин 71140-д орно.

Тайлбар: Энд түрээслэх хугацаа нь хамаарахгүй юм.

731 Машин, тоног төхөөрөмжийн /жолоочгүйгээр/ лизингийн үйлчилгээ

7311 Тээврийн хэрэгслийн (жолоочгүй) түрээс, лизингийн үйлчилгээ

73111 Суудлын автомашин болон фургоны (жолоочгүй) түрээс, лизингийн үйлчилгээ

Энэ дэд ангид хувийн тэргийг жолоочтой нь түрээслэх, хөлслөх болон лизингийн үйлчилгээ орохгүй, харин 64116-д орно.

73112 Ачааны машины (жолоочгүй) түрээс, лизингийн үйлчилгээ

Энэ дэд ангид ачааны машиныг (хагас чиргүүл, трактор, ачааны машин, битүү тэрэг зэрэг) жолоочгүйгээр түрээслэх, хөлслөх болон лизингийн үйлчилгээ орно.

Харин худалдааны зориулалттай ачааны тэргийг жолоочтой нь хөлслөх, түрээслэх үйлчилгээ 66012-т орно.

73113 Төмөр замын тээврийн хэрэгслийн (жолоочгүй) түрээс, лизингийн үйлчилгээ

Энэ дэд ангид дараах эд зүйлийг оруулна:

- арилжааны зориулалттай төмөр замын тээврийн хэрэгслийг жолоочгүйгээр түрээслэх болон санхүүгийн бус лизингийн үйлчилгээ, үүнд:

• зүтгүүр болон бусад эргэлдэгч явагч хэрэгсэл, метроны галт тэрэг, гэрэлт төмөр замын төхөөрөмж, трамвай

Энэ төрлийн тээврийн хэрэгслийн түрээс нь түрээслэгч санхүүжилт хийхгүйгээр хийгдэнэ. Түрээс, лизингийн үйлчилгээнд засвар үйлчилгээ, даатгал, баталгаат засвар орсон байж болно.

Энэ дэд ангид дараах эд зүйлийг оруулахгүй:

- төмөр замын тээврийн үйлчилгээ үзүүлэх (тоног төхөөрөмж болон жолооч оператор), 64 болон 65 ангид хамаарах дэд бүлгүүдийг үзнэ үү

- төмөр замын тээврийн хэрэгслийн санхүүгийн лизингийн үйлчилгээ, 71140-ийг үзнэ үү

- хэсэгчлэн зарагддаг төмөр замын тээврийн хэрэгслийн засвар үйлчилгээ, 87149-ийг үзнэ үү.

73114 Хуурай замын бусад төрлийн тээврийн хэрэгслийн (мотоцикл, автобус, хүн болон ердийн хөсгийн тээвэр зэрэг) түрээс, лизингийн үйлчилгээ (жолоочгүй)

Энэ дэд ангид дараах үйлчилгээ орно. Үүнд:

- мотоцикл, аяллын машин зэргийг жолоочгүйгээр түрээслэх, хөлслөх болон лизингийн үйлчилгээ

- автобус зэрэг нийтийн тээврийн хэрэгслийг жолоочгүйгээр түрээслэх, хөлслөх болон лизингийн үйлчилгээ

- хуурай замын бусад тээврийн хэрэгслийн жолоочгүйгээр түрээслэх, хөлслөх болон лизингийн үйлчилгээ

- ердийн хөсгийг жолоочгүйгээр түрээслэх, хөлслөх болон лизингийн үйлчилгээ

Харин дараах үйлчилгээ орохгүй. Үүнд:

- автобус зэрэг нийтийн тээврийн хэрэгслийг жолоочтой нь түрээслэх, хөлслөх болон лизингийн үйлчилгээ (64118, 64223, 66011-д),

- унадаг дугуй, цана, тэшүүрийг түрээслэх, хөлслөх болон лизингийн үйлчилгээ (73240-д орно).

73115 Хөлөг онгоцны түрээс, лизингийн үйлчилгээ (жолоочгүй)

Энэ дэд ангид зорчигч болон ачаа тээврийн зориулалттай завь, хөлөг онгоцыг жолоочгүйгээр түрээслэх, хөлслөх болон лизингийн үйлчилгээ орно.

Харин дараах үйлчилгээ орохгүй. Үүнд:

- хөлөг онгоцыг далайн эргийн болон далайн тээврийн зориулалттай жолоочтойгоор түрээслэх, хөлслөх болон лизингийн үйлчилгээ үзүүлэх (66021-д),

- шумбагч машиныг жолоочтойгоор түрээслэх, хөлслөх болон лизингийн үйлчилгээ үзүүлэх (66022-д),

- амралт, зугаалгын зориулалттай хөлөг онгоцыг түрээслэх, хөлслөх болон лизингийн үйлчилгээ үзүүлэх (73240-д орно).

73116 Агаарын хөлгийн түрээс, лизингийн үйлчилгээ (нисэх баггүй)

Энэ дэд ангид нисэх онгоцыг (нисдэг тэрэг, агаарын хөлөг) нисгэгчгүйгээр түрээслэх, хөлслөх болон лизингийн үйлчилгээ орно.

Харин дараах үйлчилгээ орохгүй. Үүнд:

- нисэх онгоцыг нисгэгчтэй нь түрээслэх, хөлслөх болон лизингийн үйлчилгээ (66031, 66032-т),

- моторгүй, нисэх төхөөрөмжийг түрээслэх, хөлслөх болон лизингийн үйлчилгээ (73240-д орно).

73117 Чингэлгийн түрээс, лизингийн үйлчилгээ

Энэ дэд ангид дараах эд зүйлийг оруулна:

- тээврийн хэрэгслээр тээвэрлэх зориулалттай чингэлгийн лизинг, түрээсийн үйлчилгээ

- Энэ дэд ангид дараах эд зүйлийг оруулахгүй:

- чингэлгийн санхүүгийн лизингийн үйлчилгээ, 71140-ийг үзнэ үү

7312 Бусад төрлийн машин, тоног төхөөрөмжийн түрээс, лизингийн үйлчилгээ (жолоочгүй)
73121 Хөдөө аж ахуйн зориулалттай машин, тоног төхөөрөмжийн (жолоочгүй) түрээс, лизингийн үйлчилгээ

Энэ дэд ангид хураах, цайруулах, ангилах, сортлох зэрэг хөдөө аж ахуйн зориулалттай машин, тоног төхөөрөмжийг (жолоочгүй) түрээслэх болон лизингийн үйлчилгээ орно.

Харин дараах үйлчилгээ орохгүй. Үүнд:

- зүлэг, ногоо арчлахтай холбоотой тоног төхөөрөмжийг түрээслэх, хөлслөх болон лизингийн үйлчилгээ (73270-д),

- хөдөө аж ахуйн зориулалттай машин, тоног төхөөрөмжийг жолоочтой нь түрээслэх болон лизингийн үйлчилгээ (86110 -д орно).

73122 Барилгын машин, механизмын (жолоочгүй) түрээс, лизингийн үйлчилгээ

Энэ дэд ангид барилгын зориулалтаар ашиглах трактор, зам цэвэрлэх төхөөрөмж, бульдозер, ухах, ачих төхөөрөмж, ажиллагчдын түр байр гэх мэт зүйлсийг түрээслэх, хөлслөх болон лизингийн үйлчилгээ орно.

Харин барилгын машин, механизмыг жолоочтой нь түрээслэх, хөлслөх болон лизингийн үйлчилгээ бүлэг 54-т орно.

73123 Компьютерээс бусад төрлийн албан хэргийн машин, тоног төхөөрөмжийн (жолоочгүй) лизинг, түрээсийн үйлчилгээ

Энэ дэд ангид дараах үйлчилгээ орно. Үүнд:

- фото хувилагч, бичгийн машин, тооцоолох машинууд жишээлбэл электрон тооны машин, кассын машин зэрэг албан тасалгааны зориулалттай бүх төрлийн машин төхөөрөмжийг түрээслэх, хөлслөх болон лизингийн үйлчилгээ

-албан тасалгааны зориулалттай тавилга, сейф болон түүнтэй адил зүйлсийг түрээслэх, хөлслөх болон лизингийн үйлчилгээ

Харин дараах үйлчилгээ орохгүй. Үүнд:

- харилцаа холбооны төхөөрөмжийг түрээслэх, хөлслөх болон лизингийн үйлчилгээ (73125-д),

- ажиллуулах операторчингүйгээр компьютер түрээслэх, хөлслөх болон лизингийн үйлчилгээ (73124-т орно).

73124 Компьютерын түрээс, лизингийн үйлчилгээ (операторчингүйгээр)

Энэ дэд ангид операторчингүйгээр тооцоолох машин, тоног төхөөрөмжийн жишээлбэл процессор, боловсруулах төхөөрөмж, оптик уншигч машиныг түрээслэх, хөлслөх болон лизингийн үйлчилгээ орно.

73125 Харилцаа, холбооны тоног төхөөрөмжийн түрээс, лизингийн үйлчилгээ (операторчингүйгээр)

Энэ дэд ангид дараах үйлчилгээ орно. Үүнд:

- радио, зурагт, харилцаа холбооны хэрэгсэл

- утасны аппарат, факсын машин, пейжер болон гар утас

73129 Бусад төрлийн машин, тоног төхөөрөмжийн (жолоочгүй) түрээс, лизингийн үйлчилгээ

Энэ дэд ангид дараах төрөл бүрийн, электроник бус, хувийн эсвэл өрхийн хэрэглээний бус тоног төхөөрөмжийн жолоочгүй түрээс ба лизингийн үйлчилгээ орно. Үүнд:

- хөдөлгүүр ба турбин

- багаж

- олборлох төхөөрөмж

- өргөх болон хамгаалах төхөөрөмж

- цутгах төхөөрөмж
- илрүүлэх төхөөрөмж
- мэргэжлийн болон шинжлэх ухаан, техникийн хяналтын аппарат
- үйлдвэрийн бусад машинууд

Харин дараах үйлчилгээ орохгүй. Үүнд:

- *жолоочгүйгээр хөдөө аж ахуйн зориулалттай машин, тоног төхөөрөмжийг түрээслэх, хөлслөх болон лизингийн үйлчилгээ (73121-д),*
- *жолоочгүйгээр барилгын болон инженерийн машин, тоног төхөөрөмжийг түрээслэх, хөлслөх болон лизингийн үйлчилгээ (73122-т),*
- *албан тасалгааны зориулалттай машин, тоног төхөөрөмж (компьютерээс бусад)-ийг операторчингүйгээр түрээслэх, хөлслөх болон лизингийн үйлчилгээ (73123-т),*
- *операторчингүйгээр компьютер түрээслэх, хөлслөх болон лизингийн үйлчилгээ (73124-т орно).*

- 732 Бусад төрлийн барааны түрээс, лизингийн үйлчилгээ**
7321 Зурагт, хүлээн авагч, дүрс бичлэгийн аппарат болон хуурцаг тоглуулах хэрэгслийн түрээс, лизингийн үйлчилгээ
73210 Зурагт, хүлээн авагч, дүрс бичлэгийн аппарат болон хуурцаг тоглуулах хэрэгслийн түрээс, лизингийн үйлчилгээ

Энэ дэд ангид дараах үйлчилгээ орно. Үүнд:

- доорх төрөл бүрийн цахилгаан болон гэрийн тоглоомын төхөөрөмжийн түрээс, лизингийн үйлчилгээ
 - > систем хөгжим, диск тоглуулагч, зурагт, радио
 - > дүрс бичлэг тоглуулагч болон түүнтэй адилтгах төхөөрөмж
- бичлэггүй, дууны кассет, диск болон түүнтэй адилтгах зүйлсийн түрээсийн болон лизингийн үйлчилгээ

- 7322 Дүрс бичлэгийн кассет, хуурцагны түрээс, лизингийн үйлчилгээ**
73220 Дүрс бичлэгийн кассет, хуурцагны түрээс, лизингийн үйлчилгээ

Энэ дэд ангид дараах үйлчилгээ орно. Үүнд:

- дүрс бичлэгийн зориулалттай бичлэггүй кассет, гэрийн болон хувийн хэрэглээний CD, DVD зэрэг зүйлсийг түрээслэх болон лизингийн үйлчилгээ
- видео тоглоомыг түрээслэх болон лизингийн үйлчилгээ

- 7323 Гэр ахуйн тавилга, хэрэгслийн түрээс, лизингийн үйлчилгээ (хөргөгч, угаалгын машин, агааржуулагч, гал тогооны хэрэгсэл)**
73230 Гэр ахуйн тавилга, хэрэгслийн түрээс, лизингийн үйлчилгээ (хөргөгч, угаалгын машин, агааржуулагч, гал тогооны хэрэгсэл)

Энэ дэд ангид дараах үйлчилгээ орно. Үүнд:

- гэр ахуйн зориулалттай тавилга (гудсыг оруулаад), жишээлбэл хөргөгч, угаалгын машин, агааржуулагч, сэнс, талх шарагч, холигч, гал тогооны болон ширээний зориулалттай зүйлсийг түрээслэх болон лизингийн үйлчилгээ
- гал тогооны зориулалттай сав суулга, хутга, чимэглэлийн эд зүйлийн түрээсийн болон лизингийн үйлчилгээ

- 7324 Амралт, зугаалгын зориулалттай тоног төхөөрөмжийн түрээс, лизингийн үйлчилгээ (дугуй, цана, чарга зэрэг спортын хэрэгсэл зэрэг)**
73240 Амралт, зугаалгын зориулалттай тоног төхөөрөмжийн түрээс, лизингийн үйлчилгээ (дугуй, цана, чарга зэрэг спортын хэрэгсэл зэрэг)

Энэ дэд ангид дугуй, цас, мөсөн дээр гулгагч, моторгүй нисэх төхөөрөмж, усан спортын хэрэгсэл, аяллын усан онгоц, спортын бусад төхөөрөмжүүд, гольфийн хэрэгсэл, талбайн тоглоомын хэрэгсэл, цохиур, морины эмээл, аяллын хэрэгсэл гэх мэт амралт, зугаалгын зориулалттай тоног төхөөрөмжийг түрээслэх болон лизингийн үйлчилгээ орно.

- 7325 Гэр ахуйн хэрэглээний даавуун эдлэлийн түрээс, лизингийн үйлчилгээ**
73250 Гэр ахуйн хэрэглээний даавуун эдлэлийн түрээс, лизингийн үйлчилгээ

Энэ дэд ангид гэр ахуйн цагаан хэрэглэлтэй холбоотой лизингийн болон түрээслүүлэх үйлчилгээ орно.

7326 Хувцас, гутлын түрээс, лизингийн үйлчилгээ

73260 Хувцас, гутлын түрээс, лизингийн үйлчилгээ

Энэ дэд ангид дараах түрээсний үйлчилгээг оруулна:

- нэхмэл эдлэл, хувцас, гуталны лизингийн болон түрээсийн үйлчилгээ
- албан ёсны хувцас, хослол болон гоёл чимэглэлийн эд зүйл, малгай, хиймэл үс, тэдгээртэй холбоотой эд зүйлийн түрээс

Энэ дэд ангид дараах эд зүйлийг оруулахгүй:

- ажлын хувцасны хангалтын үйлчилгээ, 97130-ийг үзнэ үү.

7327 Гэр ахуйн зориулалттай урлан хийх иргэдэд зориулсан машин, тоног төхөөрөмжийн түрээс, лизингийн үйлчилгээ

73270 Гэр ахуйн зориулалттай урлан хийх иргэдэд зориулсан машин, тоног төхөөрөмжийн түрээс, лизингийн үйлчилгээ

Энэ дэд ангид дараах үйлчилгээг оруулна:

- зүлэг тэгшлэгч зэрэг гэр ахуйн болон цэцэрлэгжүүлэлтэд ашиглах машин, тоног төхөөрөмжийн лизинг, түрээсийн үйлчилгээ
- амралтын болон хобби байдлаар ашиглах машин, тоног төхөөрөмжийн лизинг түрээсийн үйлчилгээ

7329 Бусад төрлийн барааны түрээс, лизингийн үйлчилгээ

73290 Бусад төрлийн барааны түрээс, лизингийн үйлчилгээ

Энэ дэд ангид дараах зүйлсийг түрээслэх болон лизингийн үйлчилгээ орно. Үүнд:

- ном, сонин, сэтгүүл
- камер, фото зургийн тоног төхөөрөмж, дуран болон түүний дагалдах хэрэгсэл
- цэцэг, ургамал
- бугуйн болон бусад төрлийн цаг
- хөгжмийн зэмсэг болон түүний дагалдах хэрэгсэл
- эмнэлгийн тоног төхөөрөмж /суга таяг/ болон түүний дагалдах хэрэгсэл

733 Санхүүгийн бус, биет бус хөрөнгийг ашиглах эрхийн лицензийн үйлчилгээ

Энэ бүлэгт дараах үйлчилгээ орно. Үүнд:

- биет бус хөрөнгийг ашиглахыг зөвшөөрөх, санхүүжүүлэх, эрх олгох үйлчилгээ, биет бус хөрөнгийг ашиглах эрхийг олгох, тухайлбал, гуравдагч этгээдэд зөвшөөрөл олгох, програм хангамж, ном зэргийг хуулбарлах, дахин хэвлэх, шинэ бараа үйлдвэрлэх патент ашиглах зэргийг хамруулна. Тухайн бүтээгдэхүүний /баглаа боодол, ном зэрэг/ хязгаарлагдмал лиценз энд орохгүй.

Тайлбар: Үйлдвэрлээгүй бүтээгдэхүүнийг ашиглах эрхийг санхүүжүүлэх үйл ажиллагаа үндэсний тооцооны дансны системд хамаарахгүй тул энд ерөнхийдөө оруулахгүй. Харин патенттай зүйлсийг /үйлдвэрийн тэмдэг, бараа бүтээгдэхүүнийг борлуулах эрх авах зэрэг/ ашиглах эрхийг санхүүжүүлэх нь үндэсний тооцооны системийн үйлчилгээ гэж тооцогдох учир энд орно.

Харин дараах үйлчилгээ орохгүй. Үүнд:

- хэрэглээний барааны ном, бичлэг, програм хангамжийн лицензийн төлбөр /, (0-4 хэсгийн холбогдох дэд ангид),
- патент, худалдааны тэмдэг, зохиогчийн эрх болон бусад оюуны өмчийн эрхийн талаар зөвлөгөө өгөх үйлчилгээ (дэд анги 82130-д),

- патент, худалдааны тэмдэг, зохиогчийн эрх болон бусад оюуны өмчийн эрхийн баримт бичгийг бэлтгэх, төсөл гаргах, баримтжуулах үйлчилгээ (дэд анги 82130-д),

- патент, худалдааны тэмдэг, зохиогчийн эрх болон бусад оюуны өмчийн эрхийг баримтжуулах хуулийн үйлчилгээ (дэд анги 82130-д),
- зохиогчийн эрх ба тэдний бизнесийн орлогыг өсгөх менежментийн үйл ажиллагаа /киноноос гадна/ (дэд анги 85999-д),
- үйлдвэрийн хөрөнгийг эзэмших патент, лиценз, худалдааны тэмдэг, бараа бүтээгдэхүүнийг
- кино зураг авах эрхийн менежментийн үйлчилгээ (дэд анги 96140-д орно).

7331 Компьютерын програм хангамж, мэдээллийн санг ашиглах эрхийн лицензийн үйлчилгээ

73311 Компьютерын програм хангамжийг ашиглах эрхийн лицензийн үйлчилгээ

Энэ дэд ангид компьютерын системийн болон хэрэглээний програм, түүний тайлбар, туслах материалыг хуулбарлах, тархаах, нийлүүлэхтэй холбогдох лицензийн үйлчилгээ орно. Үүнд:

- програм хангамжийг хуулбарлах, тархаах эрх
- програм хангамжийн хэсгүүдийг ашиглан өөр програм боловсруулах эрх

Харин дараах үйлчилгээ орохгүй. Үүнд:

- багц /non-customized/ програм хангамж (бүлэг 478-д),
- бусад програм хангамжийг зохиоход багц програм хангамжийн бүрэлдэхүүний хэсгийг ашиглах лиценз (бүлэг 478-д орно).

73312 Компьютерын мэдээллийн санг ашиглах эрхийн лицензийн үйлчилгээ

Энэ дэд ангид компьютерын мэдээллийн сан, түүний тайлбар, туслах материалыг хуулбарлах, тархаах, нийлүүлэхтэй холбогдох лицензийн үйлчилгээ орно. Үүнд:

- мэдээллийн санг хуулбарлах, тархаах эрх
- мэдээллийн сан, түүний бүрэлдэхүүн хэсгийг ашиглах эрх

Харин дараах үйлчилгээ орохгүй. Үүнд:

- багц /non-customized/ програм хангамж (бүлэг 478-д),
- програм хангамжийг ашиглах эрхийн лиценз 73111-д орно.

7332 Утга зохиол, урлагийн жинхэнэ эх бүтээлийг ашиглах эрхийн лицензийн үйлчилгээ

73320 Утга зохиол, урлагийн жинхэнэ эх бүтээлийг ашиглах эрхийн лицензийн үйлчилгээ

Энэ дэд ангид чөлөөт цагт зориулсан үйлчилгээ, утга зохиол, хөгжим, урлагийн эх хувийг дахин хуулбарлах, тархаах, нийлүүлэх, эрхийн лицензийн үйлчилгээ орно. Үүнд: кино, бичлэг, радио, телевизийн нэвтрүүлэг, видео үзүүлэх, урлагийн бүтээл хувилах, гар бичмэл, ном, сэтгүүл, тогтмол хэвлэлийг дахин хэвлэх, хувилах үйл ажиллагаа орно.

7333 Судалгаа, боловсруулалтын ажлын үр дүнг ашиглах эрхийн лицензийн үйлчилгээ

73330 Судалгаа, боловсруулалтын ажлын үр дүнг ашиглах эрхийн лицензийн үйлчилгээ

Энэ дэд ангид патенттай зүйлс, шинэ бүтээл, үйлдвэрлэлийн загвар ашиглах эрхийн лицензийн үйлчилгээ орно. Тухайлбал, аливаа зүйлийн дүрэм, журам, механизм, цахилгаан болон электроник бараа, тоног төхөөрөмж, эмийн тодорхойлолт, шинээр бүтээсэн бусад төрлийн бараа зэрэг орно.

7334 Барааны тэмдэг, франчайзийг ашиглах эрхийн лицензийн үйлчилгээ

73340 Барааны тэмдэг, франчайзийг ашиглах эрхийн лицензийн үйлчилгээ

Энэ дэд ангид худалдааны тэмдэг, брэнд, франчайзийн гэрээг ашиглах эрхийн лицензийн үйлчилгээ орно.

7339 Санхүүгийн бус, биет бус бусад хөрөнгийг ашиглах эрхийн лицензийн үйлчилгээ

73390 Санхүүгийн бус, биет бус бусад хөрөнгийг ашиглах эрхийн лицензийн үйлчилгээ

Энэ дэд ангид санхүүгийн бус, бусад биет бус хөрөнгийг ашиглах эрхийн лицензийн үйлчилгээ орно. Үүнд:

- газрын тос, байгалийн хий болон газрын тосны бус эрдэс, баялгийн хайгуулын лицензийн үйлчилгээ
- “шинэ мэдээлэл”, “мэргэшсэн мэдлэг” зэрэг биет бус хөрөнгийг ашиглах эрхийн лицензийн үйлчилгээ

8	БИЗНЕС, ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ҮЙЛЧИЛГЭЭ
81	СУДАЛГАА, ШИНЖИЛГЭЭНИЙ АЖИЛ
811	Байгалийн ухаан болон инженерийн салбарын судалгаа, туршилтын ажил
8111	Байгалийн шинжлэх ухааны судалгаа, шинжилгээний ажил
81111	Физикийн ухааны салбарын судалгаа, туршилтын ажил
	Энэ дэд ангид дулаан, гэрэл, цахилгаан соронзон орон, одон орон судлал зэргийн талаарх судалгаа, туршилтын ажил, үйлчилгээ орно.
81112	Хими, биологийн шинжлэх ухааны судалгаа, туршилтын ажил
	Энэ дэд ангид ургамал, амьтан, бичил биетний фермент, физиологи, экологийг судлах, туршилт хийх ажил, үйлчилгээ орно.
81119	Байгалийн шинжлэх ухааны бусад судалгаа, туршилтын ажил
	Энэ дэд ангид хүрээлэн буй байгаль орчны талаарх судалгаа, туршилтын ажил, үйлчилгээ орно.
8112	Инженер, технологийн судалгаа, туршилтын ажил
81121	Биотехнологийн судалгаа, туршилтын ажил
	Энэ дэд ангид биотехнологийн нэг эсвэл хэд хэдэн чиглэлийн техникийг ашиглан хийгдэх бараа, үйлчилгээ, мэдлэгийн талаарх судалгаа, туршилтын ажил, үйлчилгээ орно.
81129	Инженер, технологийн бусад төрлийн салбарын судалгаа, туршилтын ажил
	Энэ дэд ангид дараах үйлчилгээ орно. Үүнд: -металл цутгах, машин, цахилгаан, холбоо, усан онгоц, нисэх онгоц, хот төлөвлөлт, барилга, мэдээлэл зэрэг салбарын судалгаа, туршилтын ажил
8113	Эрүүл мэнд, эм зүйн судалгаа, туршилтын ажил
81130	Эрүүл мэнд, эм зүйн судалгаа, туршилтын ажил
	Энэ дэд ангид эмчилгээ, урьдчилан сэргийлэх, эрүүл ахуй, эм зүй зэргийн талаарх судалгаа, туршилтын ажил, үйлчилгээ орно.
8114	Хөдөө аж ахуйн шинжлэх ухааны судалгаа, туршилтын ажил
81140	Хөдөө аж ахуйн шинжлэх ухааны судалгаа, туршилтын ажил
	Энэ дэд ангид хөдөө аж ахуйн техник, менежмент, жимс жимсгэнэ, ойн аж ахуй, мал үржүүлэг, загасны аж ахуй зэргийн судалгаа, туршилтын ажил, үйлчилгээ орно.
812	Нийгмийн болон хүмүүнлэгийн шинжлэх ухааны судалгаа, туршилтын ажил
8121	Нийгмийн ухааны судалгаа, туршилтын ажил
81211	Сэтгэл зүйн судалгаа, туршилтын ажил
	Энэ дэд ангид сэтгэл зүйн салбар дахь судалгаа, туршилтын ажил, үйлчилгээ орно.
81212	Эдийн засгийн шинжлэх ухааны судалгаа, туршилтын ажил
	Энэ дэд ангид эдийн засгийн онол, бизнесийн удирдлага, санхүү, статистикийн судалгаа, шинжилгээний ажил, үйлчилгээ орно.
	<i>Харин зах зээл судлалын үйлчилгээ 83700-д орно.</i>
81213	Хууль, эрх зүйн судалгаа, туршилтын ажил
	Энэ дэд ангид иргэний болон эрүүгийн хуулийн талаарх судалгаа, шинжилгээний ажил, үйлчилгээ орно.
81219	Нийгмийн шинжлэх ухааны судалгаа, туршилтын бусад ажил

Энэ дэд ангид антропологи /хүн судлал/, хүн ам зүй, газар зүй /хүн ам, эдийн засаг, нийгмийн/ хэл судлал, улс төрийн шинжлэх ухаан, нийгэм судлал зэрэг салбарын судалгаа, шинжилгээний ажил, үйлчилгээ орно.

- 8122 Хүмүүнлэгийн ухааны судалгаа, туршилтын ажил**
- 81221 Хэл судлал, утга зохиолын судалгаа, туршилтын ажил**

Энэ дэд ангид эртний болон орчин үеийн хэл судлал, уран зохиол судлалын ажил үйлчилгээ орно.

- 81229 Хүмүүнлэгийн ухааны судалгаа, туршилтын ажил**

Энэ дэд ангид түүх, философи, урлаг, шашин, шашны номлол зэргийн судлалын ажил, үйлчилгээ орно.

- 813 Хэд хэдэн салбарын судалгаа, туршилтын ажил**
- 8130 Хэд хэдэн салбарын судалгаа, туршилтын ажил**
- 81300 Хэд хэдэн салбарын судалгаа, туршилтын ажил**

Энэ дэд ангид дараах эд зүйлийг оруулна:

- байгалийн / инженерийн ухаан болон нийгмийн / хүмүүнлэгийн ухааны хоёулангийнх нь арга зүй, мэдлэгийг хослуулсан судалгаа, туршилт гүйцэтгэх үйлчилгээ

- 814 Эх бүтээл, гарал үүслийн судалгаа, шинжилгээний ажил**
- 8140 Эх бүтээл, гарал үүслийн судалгаа, шинжилгээний ажил**
- 81400 Эх бүтээл, гарал үүслийн судалгаа, шинжилгээний ажил**

Энэ дэд ангид байгууллагын хөрөнгө, худалдааны нууц, патент зэрэг тусгай зөвшөөрлөөр хамгаалагдсан шинэ санаа, төлөвлөгөө, зураг, дүрэм, бүтээгдэхүүний эх бүтээлийн судлалын ажил, үйлчилгээ орно.

- 82 ХУУЛИЙН БОЛОН НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ҮЙЛЧИЛГЭЭ**
- 821 Хууль зүйн үйлчилгээ**
- 8211 Эрүүгийн хуулийн зөвлөгөө өгөх, танилцуулга хийх үйлчилгээ**
- 82110 Эрүүгийн хуулийн зөвлөгөө өгөх, танилцуулга хийх үйлчилгээ**

Энэ дэд ангид эрүүгийн гэмт хэрэгтэй холбоотой зөвлөгөө өгөх, танилцуулга хийх, бусад холбогдох үйлчилгээ орно /хамгаалах, нотлох баримт хайх, гэрч, шинжээч зэрэг/.

- 8212 Бусад төрлийн хуультай холбоотой хуулийн зөвлөгөө өгөх, танилцуулга хийх үйлчилгээ**
- 82120 Бусад төрлийн хуультай холбоотой хуулийн зөвлөгөө өгөх, танилцуулга хийх үйлчилгээ**

Энэ дэд ангид эрүүгийн хуулиас бусад хуулийн талаар зөвлөгөө өгөх, танилцуулга хийх, холбогдох бусад үйлчилгээ орно.

- 8213 Хуулийн бичиг баримт, гэрчилгээ олгох үйлчилгээ (патент, зохиогчийн эрх, оюуны өмчийн эрх болон гэрлэлтийн баталгаа зэрэг нотариатын үйлчилгээ)**
- 82130 Хуулийн бичиг баримт, гэрчилгээ олгох үйлчилгээ (патент, зохиогчийн эрх, оюуны өмчийн эрх болон гэрлэлтийн баталгаа зэрэг нотариатын үйлчилгээ)**

Энэ дэд ангид дараах үйлчилгээ орно. Үүнд:

- патент, зохиогчийн эрх, бусад оюуны өмчийн эрхтэй холбоотой бичиг, баримтын төсөл боловсруулах, гэрчилгээ олгох үйлчилгээ

- хуулийн бусад бичиг баримт болох гэрээслэл, гэрлэлтийн болон арилжааны гэрээ, бизнесийн гэрээ зэргийн төсөл боловсруулах, гэрчилгээ олгох үйлчилгээ

- 8219 Хуулийн асуудлаарх бусад төрлийн үйлчилгээ**
- 82191 Арбитрын шүүн шийдвэрлэх үйлчилгээ**

Энэ дэд ангид ажилтан болон удирдлагын, байгууллага хоорондын, хувь хүмүүсийн хоорондын маргааныг зохицуулах арбитрын болон зуучлах үйлчилгээ орно.

82199 Хуулийн асуудлаарх бусад төрлийн үйлчилгээ

Энэ дэд ангид дараах үйлчилгээ орно. Үүнд:

- нөхцөлт гэрээний үйлчилгээ /хувь хүмүүс эсвэл байгууллага хооронд байгуулсан гэрээний дагуу мөнгөн эсвэл биет хөрөнгийг гуравдагч этгээд хадгалах ба тодорхой нөхцөлд эргүүлэн өгнө/.

- хуулийн бусад үйлчилгээ

822 Бүртгэл, санхүүгийн хяналт, нягтлан бодох бүртгэлийн үйлчилгээ

8221 Санхүүгийн хяналтын үйлчилгээ

82210 Санхүүгийн хяналтын үйлчилгээ

Энэ дэд ангид дараах үйлчилгээ орно. Үүнд:

- хуулийн этгээд, хувиараа аж ахуй эрхлэгч иргэний санхүүгийн баримтыг захиалагч, үйлчлүүлэгчийн хүсэлтээр шалгаж, баталгаажуулах үйлчилгээ

- санхүүгийн баримтын шалгалт хийж, дүгнэлт гаргах үйлчилгээ

- санхүүгийн байдлыг судалж төлөвлөх, хөрөнгө оруулалт, зээл, тооцооны төрөл бүрийн төсөл, төлөвлөгөө, хөрөнгийн ба бизнесийн үнэлгээ боловсруулахад нь туслах үйлчилгээ

- нягтлан бодох бүртгэлийг стандартын дагуу хөтлөх, нөхөх, тайлан гаргах, зардлын болон удирдлагын бүртгэлийг зохион байгуулахад нь туслах, зөвлөгөө өгөх үйлчилгээ

- аж ахуйн нэгж, байгууллагын санхүүгийн дотоод хяналтыг зохион байгуулахад нь туслах үйлчилгээ

Харин дараах үйлчилгээ орохгүй. Үүнд:

- нягтлан бодох бүртгэлийн үйлчилгээ (82221-д),

- хөндлөнгийн хяналтын үйлчилгээ (83111-д орно).

8222 Нягтлан бодох бүртгэл, бүртгэл хөтлөх үйлчилгээ

82221 Бүртгэлийн үйлчилгээ

Энэ дэд ангид дараах үйлчилгээ орно. Үүнд:

- жилийн болон тодорхой хугацааны санхүүгийн мэдээ, бусад мэдээлэл гаргах үйлчилгээ /Эдгээр үйл ажиллагааны хүрээ нь хөндлөнгийн хяналт, шалгалтыг бодвол нарийвчлал бага байх учраас баталгаа нь арай доогуур байна/.

- үйлчлүүлэгчээс ирүүлсэн мэдээлэлд үндэслэн санхүүгийн баримт бичгийг гаргах үйлчилгээ /Эдгээр баримтын үнэн бодит байдалд ямар нэгэн баталгаа гаргаж өгөхгүй/.

- бизнесийн татварын талаар мэдээлэл гаргах үйлчилгээ

- орлогын бичиг, баримт, тайлан тэнцэл гаргах үйлчилгээ

- тайлан тэнцэлд дүн шинжилгээ хийх

- үнэн бодит байдалд баталгаа гаргах, үнэлгээ хийх, урьдчилан төлөх ёстой төлбөрийн бичиг баримтыг бүрдүүлэх зэрэг санхүүгийн бусад үйлчилгээ

Харин татварын талаар зөвлөгөө өгөх, төлөвлөх үйлчилгээ бүлэг 823-т, санхүүгийн аудитын/хөндлөнгийн хяналтын үйлчилгээ 82210-д орно.

82222 Нягтлан бодох бүртгэлийн үйлчилгээ

Энэ дэд ангид нягтлан бодох бүртгэлийн дэвтэрт мөнгөн болон бусад хөрөнгийн шилжүүлгийг ангилах, бүртгэх үйлчилгээ орно.

Харин дараах үйлчилгээ орохгүй. Үүнд:

- татварын талаар зөвлөгөө өгөх, төлөвлөх үйлчилгээ (бүлэг 823-т),

- цалин бодох үйлчилгээ (82223-т орно).

82223 Цалин бодох үйлчилгээ

Энэ дэд ангид цалин бодох, бүртгэх зэрэг цалингийн үйлчилгээ орно.

823 Татварын талаар зөвлөгөө өгөх, төлөвлөх үйлчилгээ

8231 Аж ахуйн нэгж, байгууллагын орлогын татвар төлөвлөх, зөвлөгөө өгөх, үйлчилгээ

82310 Аж ахуйн нэгж, байгууллагын орлогын татвар төлөвлөх, зөвлөгөө өгөх, үйлчилгээ

Энэ дэд ангид аж ахуйн нэгж, байгууллагын орлогын албан татварыг төлөвлөх, зөвлөгөө өгөх үйлчилгээ орно.

8232 Хувь хүний татвар төлөх, төлөвлөх үйлчилгээ
82320 Хувь хүний татвар төлөх, төлөвлөх үйлчилгээ

Энэ дэд ангид дараах үйлчилгээ орно. Үүнд:

- хувь нийлүүлсэн бус бизнесийн албан татварыг төлөвлөх
- хувь хүмүүсийн албан татварыг төлөвлөх

824 Өр барагдуулах үйлчилгээ
8240 Өр барагдуулах үйлчилгээ
82400 Өр барагдуулах үйлчилгээ

Энэ дэд ангид удирдлага эсвэл зээлдүүлэгчдэд санхүүгийн хүндрэлтэй үед зөвлөгөө өгөх, дампуурсан үед хүлээн авагчаар эсвэл итгэмжлэгчээр оролцох, өр барагдуулах үйлчилгээ орно.

83 МЭРГЭЖЛИЙН, ТЕХНИКИЙН БОЛОН БИЗНЕСИЙН БУСАД ҮЙЛЧИЛГЭЭ
831 Удирдлага зохицуулалтын зөвлөгөө өгөх үйлчилгээ, мэдээллийн технологийн үйлчилгээ

8311 Удирдлага зохицуулалтын зөвлөгөө өгөх үйлчилгээ
83111 Стратеги, урт хугацааны бизнес төлөвлөлтийн зөвлөгөө өгөх үйлчилгээ

Энэ дэд ангид байгууллагын бизнесийн бодлого, стратеги, төлөвлөлт, бүтэц, хяналтын талаар зөвлөгөө, зааварчилга өгөх, үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх үйлчилгээ орно. Үүнд:

- > бодлого боловсруулах үйлчилгээ
- > байгууллагын зорилгод хүрэх хамгийн үр ашигтай бүтцийг /шийдвэр гаргах тогтолцоо/ тодорхойлох үйлчилгээ
- > хууль зүйн зохион байгуулалтын талаар зөвлөгөө өгөх үйлчилгээ
- > стратеги төлөвлөгөө
- > байгууллагын хөгжлийн хандлагын чиглэлээр зөвлөгөө өгөх, бүтцийг өөрчлөх, тухайлбал, байгууллага өөр байгууллагатай нийлэх, өөр байгууллагыг худалдан авах, хувь нийлүүлэх, стратегийн холбоо тогтоох, хувьчлах зэрэг
- > удирдлагын мэдээллийн тогтолцоог тодорхойлох
- > удирдлагын тайлан, хяналтыг боловсронгуй болгох
- > бизнес төлөвлөгөө
- > удирдлагын хөндлөнгийн хяналт
- > ашиг нэмэгдүүлэх хөтөлбөр боловсруулах
- > байгууллагын дээд удирдлагад шаардлагатай бусад үйлчилгээ

83112 Санхүүгийн удирдлагын зөвлөгөө өгөх үйлчилгээ

Энэ дэд ангид санхүүгийн шийдвэр гаргахтай холбоотой зөвлөгөө, зааварчилгаа өгөх, үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх үйлчилгээ орно. Үүнд:

- бэлэн мөнгө, эргэлтийн хөрөнгийн удирдлага, хөрөнгийн зохистой бүтцийг тодорхойлох
- хөрөнгө оруулалтын дүн шинжилгээ
- хөрөнгийн удирдлага
- нягтлан бодох бүртгэлийн тогтолцоог боловсронгуй болгох, төсөв хийх, төсвийн хяналт
- байгууллага бусад байгууллагатай нийлэх, бусад байгууллагыг худалдан авах зэрэг тохиолдолд санхүүгийн зөвлөгөө өгөх, тухайлбал, үнэлгээ хийх, төлбөрийн арга, олон улсын санхүү зэрэг асуудлаар зөвлөгөө өгөх

Харин дараах үйлчилгээ орохгүй. Үүнд:

- *үнэт цаасны брокерын үйлчилгээ (71521-д),*
- *тэтгээрийн сангаас бусад хөрөнгийн багцын удирдлагын үйл ажиллагаа (71530-д),*
- *тэтгээрийн даатгалын сангийн удирдлагыг хангах үйлчилгээ (71640-д орно).*

83113 Хүний нөөцийн удирдлагын зөвлөгөө өгөх үйлчилгээ

Энэ дэд ангид байгууллагын хүний нөөцийн стратеги, бодлого, дадал, үйл ажиллагааны талаар зөвлөгөө, зааварчилга өгөх, дэмжлэг үзүүлэх үйлчилгээ орно. Үүнд:

- хүн ажилд авах, шагнал, нөхөн олговор, гүйцэтгэл, үнэлгээ

- байгууллагын хөгжил /бүлэг хоорондын болон бүлэг доторх үйл ажиллагааг сайжруулах/
- ажилтнуудыг сургах, тэдгээрийн хэрэгцээ, шаардлага
- ажиллагчдад дэмжлэг үзүүлэх төлөвлөгөө
- үйл ажиллагааны дарааллыг төлөвлөх
- эрүүл мэнд, нийгмийн хамгаалал, нөхөн олговор, ажиллагчдын тэгш эрхийн талаар засаг захиргаатай хамтран ажиллах
- хөдөлмөрийн харилцаа
- хүний нөөцийн хөндлөнгийн хяналт

83114 Маркетингийн удирдлагын зөвлөгөө өгөх үйлчилгээ

Энэ дэд ангид байгууллагын маркетингийн стратеги, маркетингийн үйл ажиллагаанд зөвлөгөө, зааварчилга өгөх, үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх үйлчилгээ орно. Үүнд:

- маркетингийн стратеги боловсруулах, дүн шинжилгээ хийх
- үйлчилгээний хөтөлбөр, үнэ, зар сурталчилгаа, бараа, үйлчилгээг хүргэх сувгийг тодорхойлох
- борлуулалтын үйл ажиллагааг удирдах, борлуулалтын ажилтнуудын сургалт
- байгууллагын үйл ажиллагаа, маркетингийн стратегийн дагуу маркетингийн сувгуудыг зохион байгуулах /бөөний худалдаачдад өгөх, эсвэл жижиглэнгийн худалдаачдад шууд худалдах, шууд хүргүүлэх зэрэг/, бараа, бүтээгдэхүүний сав баглаа боодлын загвар гаргах үйлчилгээ

Харин дараах үйлчилгээ орохгүй. Үүнд:

- олон нийттэй харьцах үйлчилгээ (83121-д),
- зар сурталчилгааны үйлчилгээ (бүлэг 836-д орно).

83115 Менежментийн зөвлөх үйлчилгээ

Энэ дэд ангид дараах үйлчилгээ орно. Үүнд:

- үйл ажиллагааны менежментийн зөвлөх үйлчилгээ, жишээлбэл:
- систем болон аргачлалыг сайжруулах асуудлаар зөвлөгөө өгөх
- байгууллагын болон үйлчилгээний үйл явцыг сайжруулах, тухайлбал, албан тасалгааны зориулалттай ерөнхий зураглал; ажлын төлөвлөгөө болон стандарт зохиох
- байгууллагын автомат систем суурилуулах, тухайлбал, автоматжсан системийн сонголт болон суулгалт
- бүтээгдэхүүний хөгжил, чанарын удирдлага
- үйлдвэрийн аюулгүй байдал болон хамгаалалт

Хангамжийн асуудлаар зөвлөгөө өгөх үйлчилгээ 83116-д орно.

83116 Менежментийн зөвлөгөө өгөх бусад төрлийн үйлчилгээ

Энэ дэд ангид дараах үйлчилгээ орно. Үүнд:

- нэгдсэн хангамжийн сүлжээний менежмент зөвлөх үйлчилгээ /Нэгдсэн хангамжийн сүлжээний менежмент зөвлөх үйлчилгээний багцад эд хөрөнгийн менежмент, агуулах зоорь болон түгээх үйлчилгээг хамруулна/.
- материал хангамжийн менежментийн зөвлөх үйлчилгээ, тухайлбал:
 - > эд хөрөнгийн бүртгэл хийх, үйлчлүүлэгчдээ зориулж хамгийн үр ашигтай эд хөрөнгийн бүртгэлийн шаардлагыг тодорхойлох зэрэг эд хөрөнгийн менежментийн материал хангамжийн зөвлөгөө өгөх үйлчилгээ
 - > үйлчлүүлэгчийн хэрэглэдэг, байгууллага дотроо барааг хадгалах, арчлах, зөөх үйл явц мөн барааг үйлчлүүлэгчээс худалдан авагчид ачуулах зэрэг түгээх болон тээвэрлэлтийн материал хангамжийн зөвлөгөө өгөх үйлчилгээ
 - > барааг хүлээж авах, хадгалах, гаргах зэрэг агуулах зоорийн материал хангамжийн зөвлөгөө өгөх үйлчилгээ
 - > засвар үйлчилгээний материал хангамжийн зөвлөгөө
- менежментийн бусад зөвлөх үйлчилгээ

83117 Бизнесийн үйл ажиллагааны зөвлөгөө өгөх үйлчилгээ

Энэ дэд ангид дараах үйлчилгээ орно. Үүнд:

- үйлчлүүлэгчдээ зориулсан бизнесийн үйл явцыг дэмжих мэдээллийн технологи эрчимжүүлсэн үйлчилгээтэй / шийдлээсээ хамааран гар ажиллагаатай эсвэл мэргэжлийн ажилтантай/, машин, тоног төхөөрөмжтэй хослуулсан үйлчилгээ
- санхүүгийн гүйлгээний үйл явц, кредит картны ашиглалт, төлбөрийн болон зээлийн үйлчилгээ
- захиргааны тэтгэмж, цалин хөлс олголт, хувь хүний удирдлага зэрэг хүний нөөцийн менежментийн үйл ажиллагаа
- эд хөрөнгийн менежмент, худалдан авах үйлчилгээ, байгууллагын дотоод хангамжийн үйлчилгээ, бүтээгдэхүүний хуваарь болон захиалгын үйл ажиллагаа зэрэг хангамжийн сүлжээний менежментийн үйл ажиллагаа
- биеэр зөвлөгөө өгөх үйлчилгээ, утсаар зөвлөгөө өгөх үйлчилгээ худалдан авагчтай харьцах менежментийн үйл ажиллагаа
- цахилгаан, хими, түлшний зэрэг үйлдвэрүүдийн вертикал зах зээлийн бизнесийн үйл ажиллагаа
- үйлчлүүлэгчид зориулсан бусад бизнесийн үйл ажиллагаа

8312 Бизнесийн зөвлөгөө өгөх үйлчилгээ

83121 Олон нийттэй харьцах үйлчилгээ

Олон нийт, засгийн газар, сонгогчид, хувьцаа эзэмшигч зэрэг хувь хүн болон байгууллагын холбоо харилцаа, имиджийг нь сайжруулахтай холбогдуулан зөвлөх, чиглүүлэх болон үйл ажиллагааны дэмжлэг үзүүлэх үйлчилгээ орно.

Харин дараах үйлчилгэээ орохгүй. Үүнд:

- төлөөлөлт болон зар сурталчилгааны үйлчилгээ (83611-д),
- олон нийтийн санал асуулгын үйлчилгээ (83700-д орно).

83129 Бизнесийн бусад төрлийн зөвлөгөө өгөх үйлчилгээ

Бүс нутгийг, үйлдвэрлэлийг эсвэл аялал жуулчлалыг хөгжүүлэх үйлчилгээ орно.

8313 Мэдээллийн технологийн техникийн зөвлөгөө болон туслалцаа үзүүлэх үйлчилгээ

83131 Мэдээлэл технологийн техникийн зөвлөгөө өгөх үйлчилгээ

Энэ дэд ангид дараах үйлчилгээ орно. Үүнд:

- мэдээллийн технологийн хэрэглээтэй холбоотой техникийн асуудлууд дээр зөвлөгөө өгөх үйлчилгээ
- компьютерын техник, програм хангамж болон нийлүүлэлттэй холбоотой асуудлаар зөвлөгөө өгөх
- системийн бүрдэлт
- системийн аюулгүй байдал
- мэдээллийн технологийн асуудалд шинжилгээ хийх

Харин дараах үйлчилгэээ орохгүй. Үүнд:

- цахим арилжааны стратегийг хөгжүүлэх болон бизнесийн стратегитэй холбоотой асуудал дээр зөвлөгөө өгөх үйлчилгээ (83111-д),
- мэдээллийн технологийн загвар болон бүтэц, зохион байгуулалт, мөн мэдээллийн технологийн шийдлийн загвар ба хөгжилтэй /вэб хуудас, мэдээллийн сан, тодорхой хэрэглээний програм, компьютерын сүлжээ гэх мэт/ холбоотой үйлчилгээний гэрээ, мэдээллийн технологийн дизайн, түүнийг хөгжүүлэх үйлчилгээ (8314-т орно).

83132 Мэдээллийн технологийн техникийн туслалцаа үзүүлэх үйлчилгээ

Энэ дэд ангид дараах үйлчилгээ орно. Үүнд:

- компьютерын програм хангамж, техникийг ашиглахтай холбогдон гарсан асуудлыг шийдэхэд техникийн туслалцаа үзүүлэх үйлчилгээ
- програм хангамжийн хэрэглээний асуудлаар үйлчлүүлэгчид туслах үйлчилгээ
- техник хангамжийн хэрэглээний асуудлаар үйлчлүүлэгчид туслах, үүнд мэдээллийн технологийн тоног төхөөрөмжийн хэвийн ажиллагааг тогтмол шалгах, засварлах үйлчилгээ
- үйлчлүүлэгчийн компьютерын системийг өөр байрлалд шилжүүлэн суулгахтай холбогдох техникийн туслалцаа үзүүлэх үйлчилгээ
- компьютерын хэрэглээтэй холбоотой асуудлаар үйлчлүүлэгчид туслах үйлчилгээ
- компьютерын системийн хэрэглээтэй холбогдох тусгайлсан асуудлыг шийдэхэд техникийн туслалцаа үзүүлэх үйлчилгээ, тухайлбал:

> ямар нэгэн зөвлөгөө өгөх эсвэл үйлдэлгүйгээр компьютерын үйл ажиллагааг хянах, үнэлэх, үүнд: сервер, компьютерын сүлжээ, бүрэлдэхүүн хэсгийн үйл ажиллагаа компьютерын чадал, үйлдэл гүйцэтгэл, аюулгүй байдал зэрэг

> эвдэрсэн хатуу диск болон бусад гэмтэлтэй мэдээлэл хадгалах төхөөрөмжөөс мэдээллийг сэргээх үйлчилгээ, сүлжээний бус/нөөц компьютерээр хангах, гал, осол, гэнэтийн аюулаас хамгаалан компьютерын мэдээллийг өөр байрлалд хадгалах

- мэдээллийн технологийн бусад үйлчилгээ

8314 Мэдээллийн технологийн бүтцийг загварчлах, зохион байгуулалтыг боловсронгуй болгох үйлчилгээ

83141 Хэрэглээний програм, бүтэц зохион байгуулалтыг боловсруулах үйлчилгээ

Энэ дэд ангид дараах үйлчилгээ орно. Үүнд:

- вэб хуудсын агуулга болон бүтцийг загварчлах, вэб хуудсыг зохиох, шаардлагатай програмыг бичих

- мэдээллийн санг үүсгэх, загварчлахад шаардлагатай програмын код бичих

- вэб хуудас, өгөгдлийн сан, програм хангамжаас бусад хэрэглээний програмыг илүү боловсронгуй болгох, компьютерын код бичих, бүтцийг нь загварчлах

- үйлчлүүлэгчийн мэдээллийн системийн орчинд суурилсан програм хангамжийг дахин суурилуулах, загварчлах, үйлчлүүлэгчийн хэрэгцээнд нийцүүлэн өөрчлөхтэй холбогдсон үйлчилгээ

Харин дараах үйлчилгээ орохгүй. Үүнд:

- *вэб хуудсыг байршуулах үйлчилгээ оролцсон вэб хуудсын бүтцийг загварчлах, боловсронгуй болгох, үйлчилгээний гэрээ (83151-д),*

- *програм хангамжийг суурилуулах үйлчилгээ оролцсон програм зохиох, боловсронгуй болгох үйлчилгээний гэрээ, (83152-т),*

- *мэдээллийн санг бүрдүүлэх үйлчилгээ оролцсон мэдээллийн сангийн бүрэлдэхүүнийг загварчлах, боловсронгуй болгох үйлчилгээний гэрээ (83159-д орно).*

83142 Сүлжээний болон системийн бүтэц загварчлах, зохион байгуулалтыг боловсронгуй болгох үйлчилгээ

Энэ дэд ангид дараах үйлчилгээ орно. Үүнд:

- хэрэглэгчийн компьютерийн дотоод, гадаад болон виртуал хувийн сүлжээг бий болгох, боловсронгуй болгох

- компьютерын сүлжээгээр мэдээлэлд аюулгүйгээр хандах, ашиглахыг зөвшөөрөх, мэдээлэл, програм хангамжид хандалтыг хянах үйл ажиллагаа, түүнд холбогдсон техник хангамжийг загварчлах, боловсронгуй болгох, нэвтрүүлэх

- байгууллагын компьютерын шаардлага, хэрэгцээг тодорхойлох, техник болон програм хангамжийн худалдан авалтад зөвлөгөө өгөх, шинэ системийг байршуулах, тодорхой системийг боловсронгуй болгох зэрэг үйлчилгээ

- хэрэглэгчийн компьютерын системийн анализ, орчин цагийн болон ирээдүйн компьютерын шаардлагууд, шинэ тоног төхөөрөмж, хэрэглээний хангамжийн худалдан авалт болон шинэ хуучин системийн хэсгүүдийг нийлүүлж шинэ нэгтгэсэн систем зохиох зэрэг компьютерын системийг нэгтгэсэн үйлчилгээ

Хэрэглэгчийн компьютерын сүлжээний өдөр тутмын зохион байгуулалтын үйлчилгээ орохгүй. (83161-д орно).

83143 Хэрэглээний програм хангамж зохиох үйлчилгээ

Энэ дэд ангид дараах эд зүйлийг оруулна:

- худалдах зориулалттай, худалдан борлуулах эрх нь баталгаажсан оюуны өмчийн эд зүйл (өөрөөр хэлбэл бүх оролцогч талуудын өмчийн эрхтэй)

- зохиогчийн эрх нь шууд болон шууд бусаар хамгаалагдсан худалдах зориулалттай, оюуны өмчийн эд зүйл (өөрөөр хэлбэл компьютерийн програм хангамж)

Энэ дэд ангид дараах эд зүйлийг оруулахгүй:

- гэрээгээр зохиосон бусад програм хангамж, 83141-ийг үзнэ үү

- програм хангамжийн бөөний болон жижиглэнгийн худалдаа, үйлчилгээ, 61184, 61284, 62184, 62284, 62384, 62484, 62584-ийг үзнэ үү.

8315 Вэб хуудас байршуулах болон мэдээлэл технологийн дэд бүтцийг бий болгох үйлчилгээ

Хэрэглэгчдийн програм хангамж, техникийг байршуулахад шаардагдах мэдээллийн технологийн дэд бүтцийг бий болгох үйлчилгээ энэ ангид орно.

83151 Вэб хуудас байршуулах үйлчилгээ

Энэ дэд ангид хэрэглэгчийн вэб хуудас, түүний холбогдох файлыг интернэтэд найдвартай байршуулах үйлчилгээ орно. Үүнд:

- програм хангамжид нэг зэрэг олон хүн хандах боломжтойгоор эсвэл тогтоосон хэмжээнээс хэтрүүлэхгүй байдлаар нэг серверт хадгалах (серверт хэрэглээний програмыг байршуулах гэдэг нь хэрэглэгчийн хариуцлага болон үйлчилгээний стандартчилагдсан тодорхой түвшинд хязгаартай байна гэсэн үг)

- вэб хуудас болон холбогдох програмыг удирдах, байршуулахад гарсан гэмтлийг засах үйлчилгээ

Интернэтэд түргэн, найдвартай, аюулгүй үйлчилгээгээр хангах нь чухал шинж чанар байна.

83152 Програм хангамжийн үйлчилгээ

Энэ дэд ангид лизингийн програм хангамжийг ашиглах үйлчилгээ орно.

83159 Мэдээллийн технологийн дэд бүтцийг бий болгох үйлчилгээ

Энэ дэд ангид дараах үйлчилгээ орно. Үүнд:

- серверийн байршлыг тодорхойлох талаарх үйлчилгээ

- мэдээлэл хадгалах үйлчилгээ

- мэдээллийг зохион байгуулах үйлчилгээ

- видео болон аудио урсгалын үйлчилгээ

- бусад мэдээллийн технологийг байршуулах дэд бүтцийг хангах үйлчилгээ

8316 Мэдээллийн технологийн дэд бүтэц болон сүлжээ зохион байгуулах үйлчилгээ

Энэ дэд ангид техник болон програм хангамж, сүлжээг оролцуулсан үйлчлүүлэгчийн мэдээллийн технологийн дэд бүтцийг үнэлэх, зохион байгуулах үйлчилгээ орно.

83161 Сүлжээ зохион байгуулах үйлчилгээ

Энэ дэд ангид сүлжээний урсгалын найдвартай ажиллагаа болон зохион байгуулах үйл ажиллагаанд статистикийг ашиглах, багтаамжийг хуримтлуулах, сүлжээний гэмтлийг оношлох зэрэг ашиглагдаж буй техник, тоног төхөөрөмж, сүлжээг үнэлэх, зохион байгуулах үйлчилгээ орно.

83162 Компьютерийн системийг зохион байгуулах үйлчилгээ

Энэ дэд ангид хэрэглэгчийн компьютерын системийн өдөр тутмын үйл ажиллагаа болон зохион байгуулалтын үйлчилгээ орно.

8319 Барилгын төсөл хийхээс бусад зохион байгуулалтын үйлчилгээ

83190 Барилгын төсөл хийхээс бусад зохион байгуулалтын үйлчилгээ

Энэ дэд ангид дараах үйлчилгээ орно. Үүнд:

- үйлчлүүлэгчийн нэрийн өмнөөс төслийг бэлтгэх, явуулах, дуусгах нөөц боломжийг зохицуулах болон удирдах үйлчилгээ

- төслийг зохион байгуулах үйлчилгээ, үүнд төсөв зохиох, санхүү болон үнийн хяналт, худалдан авалт, цаг хугацааны төлөвлөгөө болон бусад үйл ажиллагааны нөхцөлт ажил гүйцэтгэгчийн ажлын удирдамж, чанарын хяналт

- төсөл зохион байгуулах үйлчилгээ, үүнд ажилчдын нөөцтэй, нөөцгүй менежмент болон албан газрын менежмент үйлчилгээ

Харин барилгын төсөл зохион байгуулах үйлчилгээ 83330-д орно.

832 Уран барилга, хот төлөвлөлт, газар зохион байгуулалтын зөвлөх үйлчилгээ

8321 Зураг төсөл боловсруулах, зөвлөгөө өгөх үйлчилгээ

Энэ дэд ангид инженерийн загвараас бусад архитектурын үйлчилгээнд багтах барилгын загвар зохиох үйлчилгээ, барилгын загвартай холбогдох бусад зөвлөх үйлчилгээ, барилгын баримт, загвар, төлөвлөгөө, судалгаа, архитектурын төслийн бүх шат, зөвлөгөө, загвараар хангах үйлчилгээ орно.

Харин бие даасан тусдаа зөвлөх үйлчилгээ 83211-д орно.

83211 Зураг төсөл боловсруулах, зөвлөгөө өгөх үйлчилгээ

Энэ дэд ангид архитектурын талаарх мэдээ, судалгаа болон зөвлөгөө өгөх үйлчилгээ орно.

Харин тодорхой төсөлд зориулсан архитектурын талаарх зөвлөгөө, судалгаа, мэдээллээр хангах үйлчилгээ 83212, 83213, 83214-д орно.

83212 Орон сууцны барилгын зураг төсөл зохиох үйлчилгээ

Энэ дэд ангид дараах үйлчилгээ орно. Үүнд:

- нэг өрхийн орон сууцны архитектур төсөл
- хэд хэдэн өрхөд зориулсан орон сууцны архитектур төсөл

83213 Орон сууцны бус барилгын зураг, төсөл зохиох үйлчилгээ

Энэ дэд ангид дараах үйлчилгээ орно. Үүнд:

- албан газрын барилын төсөл
- худалдаа болон рестораны барилгын төсөл
- зочид буудал болон хурлын танхим
- эрүүл мэндийн төвийн төсөл
- цэнгээнт болон соёлын төвийн барилгын төсөл
- боловсролын барилгын төсөл
- үйлдвэрийн барилгын төсөл
- тээвэр болон түгээх зориулалттай барилгын төсөл
- бусад орон сууцны бус барилгын төсөл

83214 Түүх, соёлын дурсгалт барилга байгууламжийг сэргээн засварлах үйлчилгээ

Энэ дэд ангид түүхийн уран барилгыг сэргээх үйлчилгээ орно.

8322 Хот төлөвлөлт, газар зохион байгуулалтын үйлчилгээ

83221 Хот байгуулалтын баримт бичиг боловсруулах зөвлөх үйлчилгээ

Энэ дэд ангид дараах үйлчилгээ орно. Үүнд:

- газар ашиглах, талбай сонгох, хяналт ба ашиглалт, замын систем болон хот төлөвлөлттэй холбоотой ажил, үйлчилгээ: хотын төлөвлөгөө, орон нутгийн төлөвлөгөө, тээвэр, цахилгаан, ус түгээхтэй холбоотой тусгай төлөвлөгөө
- хот төлөвлөлттэй холбоотой судалгаа, шинжилгээ
- хот төлөвлөлттэй холбоотой байгаль орчны нөлөө, эдийн засгийн дүн шинжилгээ

83222 Аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө боловсруулах зөвлөх үйлчилгээ

Энэ дэд ангид дараах эд зүйлийг оруулна:

- дэд бүтцийн сүлжээ, орон сууцны, үйлдвэрийн, худалдааны, амралт зугаалгын болон бусад барилга, байгууламжийг барьж байгуулахад хөдөөгийн газрыг урт хугацааны зорилгоор ашиглах төлөвлөгөө боловсруулах
- газар зүйн томоохон талбарыг урт хугацаанд хамрах өргөн хүрээтэй төлөвлөгөө

83223 Газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө

Энэ дэд ангид дараах барилга, зам, машины зогсоол зэргийг байгуулах зорилготой газар зохион байгуулалтын үйлчилгээ орно. Үүнд:

- орон сууцны барилгын төсөл
- орон сууцны бус барилгын төсөл
- амралт, зугаалга болон задгай талбайн төсөл

8323 Газар зохион байгуулалтын төлөвлөлт, барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах зөвлөх үйлчилгээ

Энэ ангид тусгай газар зохион байгуулалтын төсөлтэй холбоотой баримт бичиг, төлөвлөгөө, судалгаа, шинжилгээний ажил зэрэг газар төлөвлөлтийн зураг, төслийг хийх үйлчилгээ орно.

83231 Газар төлөвлөлт, уран барилгын зураг төслийн зөвлөгөө өгөх үйлчилгээ

Энэ дэд ангид дараах ажил, үйлчилгээ орно. Үүнд:

- барилга, байгууламжийг барихаас өмнө газар төлөвлөлт болон архитектурын зөвлөгөө өгөх үйлчилгээ
- газар, төлөвлөлттэй холбоотой гэрээ, сургалт, тайланд зөвлөгөө өгөх үйлчилгээ

Харин тусгайлсан газар төлөвлөлт, архитектурын зураг, төсөл боловсруулах үйлчилгээ орохгүй (83232-д орно).

83232 Газар төлөвлөлт, уран барилгын зураг төсөл боловсруулах үйлчилгээ

Энэ дэд ангид дараах барилга, байгууламжийн төсөл, газар төлөвлөлтийг зохиох үйлчилгээ орно. Үүнд:

- орон сууцны барилгын төсөл:
 - > нэг өрхийн дангаараа амьдрах байшингийн төсөл
 - > хэд хэдэн өрх амьдрах зориулалттай орон сууцны төсөл
 - > газрын төсөл
- орон сууцны бус барилгын төсөл:
 - > корпорацийн барилгын төсөл
 - > зочид буудал, хурал, цуглаан хийдэг төв, цэнгэлдэх хүрээлэн болон задгай талбай
 - > боловсрол, сургалтын барилгын төсөл
 - > эрүүл мэнд, эрүүгийн байгууллагын барилгын төсөл
 - > бусад байгууллагын барилгын төсөл
- амралт, зугаалга болон задгай талбайн төсөл
 - > хотын төв болон олон нийтийн талбай
 - > амралтын байгууламж, хүрээлэн болон байгалийн унаган газрууд
 - > рашаан сувилал
 - > бусад амралт зугаалга болон задгай талбайн төсөл
- төслүүдтэй холбоотой газар төлөвлөлт, барилга байгууламжийн зохион байгуулалтын үйлчилгээ
- газар цэвэрлэх, газар, шорооны ажлыг төлөвлөх, ус сувгийн хоолойн төсөл зохиох, элэгдэл, шаар тундасыг хянах төсөл зохиох, барьж байгаа хананы төсөл зохиох
- гэрэлтүүлгийн төлөвлөгөө, хаягийн төлөвлөгөө, замын төлөвлөгөө зохиох үйлчилгээ

833 Инженерийн зураг төсөл боловсруулах үйлчилгээ

Энэ дэд ангид инженерийн зураг төсөл зохиох үйлчилгээ орно.

8331 Инженерийн зураг төслийн зөвлөгөө өгөх үйлчилгээ

83310 Инженерийн зураг төслийн зөвлөгөө өгөх үйлчилгээ

Энэ дэд ангид дараах эд зүйлийг оруулна:

- бодлогын шинжилгээ, зохицуулалтын судалгаа, аудит зэрэг инженерийн төслийг тусдаа гүйцэтгэхэд инженерийн зарчим, арга зүйн зөвлөгөөгөөр захиалагчийг хангах
- тухайн тохиолдолд мэргэшсэн инженерийн туршлага, сургалт, чадвар, мэдлэгээр баталгаа нотолгоо гаргаж өгөх инженерийн ажил
- гэнэтийн хүчин зүйлийг тодорхойлохын тулд эвдэрсэн инженерийн систем, хийцийг хянах инженерийн ажил

Энэ дэд ангид дараах эд зүйлийг оруулахгүй:

- 8332 бүлгийн төрлийн төсөлтэй холбоотойгоор гүйцэтгэсэн зөвлөгөө, судалгаа, тайлан, 8332-ийг үзнэ үү.

8332 Инженерийн тусгай зураг төсөл зохиох үйлчилгээ

83321 Орон сууцны барилгын инженерийн зураг төсөл зохиох үйлчилгээ

Энэ дэд ангид дараах үйлчилгээ орно. Үүнд:

- доор дурьдсан орон сууцны барилгын инженерийн зураг төсөл зохиох, төлөвлөгөө боловсруулах, судалгаа хийх ажил, үйлчилгээ
 - > шинэ болон хуучин байшин
 - > хувийн болон нийтийн орон сууц
 - > орон сууцны байшин барилгад давуу хэрэглэгдэж байсан холимог барилгыг ашиглах зэрэг оршин суух байшин барилгын төсөлд холбоотой судалгаа
- доор дурьдсан барилгуудын хийц, загварыг бэлтгэх, төлөвлөгөө, шинэ ба оршин суух худалдаатай холбоотой судалгаа, олон нийтийн болон албан байгууллагын барилгын төсөл зохиох
 - > албан газрын барилга
 - > дэлгүүр
 - > зочид буудал болон зоогийн газар
 - > үйлчилгээний газар, бөөний худалдааны дэлгүүр
 - > автобус, тээврийн хэрэгсэл
 - > эмнэлэг, сургууль, сүм хийд
 - > цэнгэлдэх хүрээлэн, задгай талбарууд
 - > номын сан болон музей
- олон нийтийн, албан байгууллагын, худалдааны газрын зориулалттай зонхилон ашиглагдаж байсан холимог барилгын төсөл зохиох үйлчилгээ
- олон нийтийн, албан байгууллагын, худалдааны, тусгай оршин суух газрын барилгын төсөлд хамаатай техникийн үйлчилгээ

Харин тусгайлсан төсөлтэй холбоотой инженерийн зөвлөгөө өгөх үйлчилгээ 83310-д орно.

83322 Үйлдвэрийн болон үйлдвэрлэлийн инженерийн зураг төсөл боловсруулах үйлчилгээ

Энэ дэд ангид дараах үйлчилгээ орно. Үүнд:

- аж үйлдвэрийн тоног төхөөрөмж болон үйл ажиллагаа явуулахтай холбоотой инженерийн үйлчилгээ;
 - > ашигт малтмал олборлолт, боловсруулах, хайлуулах үйлдвэр, уул уурхай, төмөрлөгийн тоног төхөөрөмжийн үйлчилгээ, тэдгээрийн иж бүрэн тоног төхөөрөмжийн засвар, техникийн төслийн үйл ажиллагаа
- эрдэс бодис гарган авах, хайлуулах, боловсруулах, металл хэвд цутгах зэрэг уул уурхай, төмөрлөгийн үйл ажиллагаа
 - > тос, хийн тавцан, боловсруулах үйлдвэр, хоолой, газрын тосны үйлдвэрийн тоног төхөөрөмж, тэдгээрийг нэгтгэсэн тоног төхөөрөмж, инженерийн төслийн үйлчилгээ
 - > газрын тос, газрын тосон химийн бүтээгдэхүүнийг гарган авах, боловсруулах, томъёолох
 - > микропроцессор, силикон чип, өрмөцөр, микросхем, хагас дамжуулагчийг үйлдвэрлэх зэрэг микроэлектроникийн тоног төхөөрөмжийн үйлчилгээ, боловсруулалт
 - > хувцасны бөс барааны тоног төхөөрөмжийн үйлчилгээ, боловсруулалт
 - > төмөр гангийн тоног төхөөрөмжийн үйлчилгээ, боловсруулалт
 - > бусад аж үйлдвэр болон үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжийн үйлчилгээ, боловсруулалт
- аж үйлдвэр, үйлдвэрлэлийн бүтээгдэхүүний хийц, загвартай холбоотой инженерийн үйлчилгээ
 - > хөдөө аж ахуй, барилга, байгууламж, уул уурхай, металл боловсруулалт, худалдаа арилжаа, аж үйлдвэрийн үйлчилгээ, халаалт, агааржуулалт болон агааржуулах хэрэгсэл, эрчим хүч дамжуулдаг тоног төхөөрөмж зэрэг аж үйлдвэрийн тоног төхөөрөмж

> компьютер, гадаад тоног төхөөрөмж, харилцаа, холбооны тоног төхөөрөмж, дуу бичлэг, видео тоног төхөөрөмж, хагас дамжуулагч болон электроникийн бусад бүрэлдэхүүн хэсэг зэрэг электроникийн тоног төхөөрөмж

> гэрэлтүүлэг, том, жижиг ахуйн цахилгаан хэрэгсэл, цахилгаан тоног төхөөрөмж

> тээврийн хэрэгсэл, нисэх онгоц, галт тэрэг, далайн хөлөг онгоц, сансрын хөлөг зэрэг тээврийн тоног төхөөрөмж

Харин дараах үйлчилгээ орохгүй. Үүнд:

- судалгаа, шинжилгээний ажил, үйлчилгээ (дэд салбар 81-д),

- аж үйлдвэрийн хийц загварын үйлчилгээ (83912-т орно).

83323 Тээврийн инженерийн зураг төсөл боловсруулах үйлчилгээ

Энэ дэд ангид дараах тээврийн инженерийн зураг төсөл боловсруулах үйлчилгээ орно. Үүнд:

- моторт тээврийн хэрэгсэлд зориулагдсан гүүрэн хурдны зам, хурдны зам, авто зам, гудамжны зам

- гүүр болон хонгил

- амралтын зогсоол, жингийн зогсоол, замын болон гүүрийн хураамж авагч кабин зэрэг тээврийн туслах тоног төхөөрөмж

- хотын төмөр зам, метро зэрэг нийтийн тээврийн систем

- төмөр зам, түүнтэй холбоотой байгууламж

- төмөр замын гүүр, хонгил

- хөлөг онгоц, дотоодын усан боомт

- боомт зогсоол, далан хаалт, суваг болон тээвэрлэлтэнд зориулагдсан далан

- онгоцны буудал, нисэх буух талбай, нисэх онгоцны байр

- нисэх хүчний бусад тоног төхөөрөмж

- сансрын тээвэрлэлтийн төсөл

- тос, хийн тээвэрлэлтийн төсөл

- тээвэрлэлттэй бусад инженерийн үйлчилгээ

83324 Эрчим хүчний инженерийн зураг төсөл боловсруулах үйлчилгээ

Энэ дэд ангид дараах үйлчилгээ орно. Үүнд:

- техникийн үйлчилгээ, тос, хий, чулуун нүүрс, бусад чулуужсан түлшний энерги; цөмийн энерги; уснаас гаргах энерги; нарны эрчим хүч, салхины эрчим хүч, дулаан, цахилгааны эрчим хүчийг үйлдвэрлэх тоног төхөөрөмж, тэдгээрээс гаргах цахилгаан эрчим хүчний байгууламжийн инженерийн зураг төслийн үйлчилгээ

- газар дээрх, газар доорхи цахилгаан эрчим хүчний дамжуулагч, хуваарилалтын шугамын инженерийн шугам төсөл боловсруулах үйлчилгээ

83325 Цахилгаан холбоо болон телевизорын өргөн нэвтрүүлгийн инженерийн зураг төсөл боловсруулах үйлчилгээ

Энэ дэд ангид дараах үйлчилгээ орно. Үүнд:

- шилэн кабель, нэг тэнхлэгтэй кабель, зэсэн кабель зэргээр хийгдэх, дуу, өгөгдлийг сүлжээгээр дамжуулах үйлчилгээ, холбогдох инженерийн зураг төслийн үйлчилгээ

> телефон радио систем

> хиймэл дагуулын радио систем

> хиймэл дагуулын телевизорын өргөн нэвтрүүлгийн систем

- радио, телевизийн дохиолол, нэвтрүүлэг дамжуулахтай холбоотой инженерийн зураг төслийн үйлчилгээ

- радио, телевизийн нэвтрүүлэг дамжуулахтай холбоотой дуун өгөгдөл хөтөлбөрийг дамжуулах, хуваарилах инженерийн зураг төслийн үйлчилгээ

83326 Хог хаягдлын менежментийн инженерийн зураг төсөл боловсруулах үйлчилгээ

Энэ дэд ангид дараах үйлчилгээ орно. Үүнд:

- өрхийн хог хаягдлыг цуглуулах болон зөөвөрлөх менежментийн инженерийн зураг төслийн үйлчилгээ

> дахин боловсруулах тоног төхөөрөмж

> бордоо болгох тоног төхөөрөмж

> дамжуулах газар

> баялгийг нөхөн сэргээх тоног төхөөрөмж

> хог хаях газар

- өрхийн хог хаягдлын хуримтлал, хог зайлуулах системтэй холбоотой инженерийн үйлчилгээ

- аюултай хог хаягдлыг хаях, газрын нөхөн сэргээхтэй холбоотой инженерийн үйлчилгээ
 - > цөмийн хог хаягдлын менежмент
 - > химийн бодисыг арилгах
 - > хог хаягдалд бохирдсон газрын нөхөн сэргээх
 - > хөрсний усыг ашиглалтын менежмент
 - > хордсон талбайг сэргээх

83327 Ус, усны шугам сүлжээ болон бохир усны инженерийн зураг төсөл боловсруулах үйлчилгээ

Энэ дэд ангид усны хуримтлал, хуваарилах, боловсруулах, зайлуулахад зориулсан системтэй холбоотой техникийн үйлчилгээ орно. Үүнд:

- ундны усыг хуваарилах систем, усан шахуургын станц, нөөцлүүр, ус хадгалах тоног төхөөрөмж, ус дамжуулах, хуваарилах, орон нутгийн ундны усны хуваарилалт, түгээх болон ус цэвэршүүлэх далан, суваг
- үерийн усыг хянахад ашиглагдаж байсан далан болон усны даланг сэтлэх менежмент, бохирын систем
- хуримтлал, боловсруулалт болон хаягдал усыг зайлуулах систем
- усжуулалтын систем болон усны дамжуулах хоолой, усжуулах далан

83329 Инженерийн зураг төсөл боловсруулах бусад үйлчилгээ

Энэ дэд ангид дараах үйлчилгээ орно. Үүнд:

- инженерийн үйлчилгээ
- байгалийн хий болон уур хуваарилалтын төсөл
- бусад хэрэглээний төслүүд
- загварын системийн сурталчилгааны ажил, бусад систем, үйл ажиллагаа, тоног төхөөрөмж, бүтээгдэхүүн, үйлчилгээтэй холбоотой инженерийн зураг төсөл боловсруулах үйлчилгээ

83330 Барилга барихад шаардагдах төсөл, менежментийн бусад үйлчилгээ

Энэ дэд ангид дараах үйлчилгээ орно. Үүнд:

- санхүүжилт болон загвар, тендер, хяналтын үйлчилгээ
- инженерийн болон архитектурын менежментийн үйлчилгээ

Харин нийтийн барилга, байгууламжийн үйлчилгээ 541, 542-т орно.

834 Шинжлэх ухаан болон техникийн бусад үйлчилгээ

8341 Геологи, геофизикийн болон хэтийн төлөвлөлтийн үйлчилгээ

83411 Геологи, геофизикийн зөвлөгөө өгөх үйлчилгээ

Энэ дэд ангид дараах үйлчилгээ орно. Үүнд:

- чулуулгийн тогтоц, түүний бүтэц болон дэлхийн баялгийн судалгаа, хөрсний ус, тос, хий, эрдэс бодисын нөөц зэрэгтэй холбоотой геологийн зөвлөгөө өгөх үйлчилгээ
- ашигт малтмал, эрдэс бодис, тос, байгалийн хийн баялаг, түүний хөгжил, судалгаатай хамаатай зөвлөгөө өгөх үйлчилгээ
- геологи, геофизикийн болон геохимийн хэвийн бус байдлын үнэлгээ
- геологийн зурагжуулалт буюу гадаргуу, гадаргуу доорхи байр зүйн зураглал

83412 Геофизикийн үйлчилгээ

Энэ дэд ангид дараах үйлчилгээ орно. Үүнд:

- газрын гадаргын хүчирхийллийг бичдэг багаж, дэлхийн таталцлын хэмжүүр, соронзон хэмжүүрээр хэмжих үйлчилгээ
- гадаргуу доорхи судалгааны бусад арга барилаар дэлхийн тогтолцлын гадаргуу доорхи мэдээллийг өгөх үйлчилгээ

Харин туршилтын өрөмдөлт болон өрөмдлөгийн ажил 54320-д орно.

83413 Ашигт малтмалын судалгаа, түүний үнэлгээ

Энэ дэд ангид дараах эд зүйлийг оруулна:

- хувиараа олж тогтоосон эрдэс баялгийн хайгуул, үнэлгээний мэдээлэл

Энэхүү оюуны өмчийн бүтээгдэхүүн нь ихэвчлэн худалдан борлуулах, бусдад мэдээллийг ашиглуулах зорилготой байдаг.

8342 Хөрсний гүний тогтоц болон газрын зураг хийх үйлчилгээ

83421 Хөрсний гүний тогтоцын судалгаа

Энэ дэд ангид дараах үйлчилгээ орно. Үүнд:

> газрын зураг бэлтгэх зорилготой усны түвшин хэмжих зураглал, гэрэл зураг

> газар зүйн гадаргуу, замын зураглал

> хиймэл дагуулын мэдээллийг цуглуулгах үйлчилгээ

> газрын зурагжуулалтын үйлчилгээ /ашигт малтмалын баялгийн тэмдэглэл, хил хязгаарын тэмдэглэл зэрэг/

83422 Газрын зураг хийх үйлчилгээ

Энэ дэд ангид бусад газрын зураг, мэдээллийн эх үүсвэр, судалгааны үйл явцын үр дүнг ашиглан бүх төрлийн газрын зургийг засах /зам, кадастр, байрлал, усны түвшин хэмжих планметр/ зэрэг газрын зураг хийх үйлчилгээ орно.

Харин газрын зургийн хэвлэл, атлас, дэлхийн бөмбөрцөгийг хэвлэх үйлчилгээ 32220, 89110-д орно.

8343 Ус цаг уурын урьдчилсан мэдээний үйлчилгээ

83430 Ус цаг уурын урьдчилсан мэдээний үйлчилгээ

Энэ дэд ангид агаар мандлын цаг уурын шинжилгээ хийх, цаг агаарын үйл явц, нөхцлийг урьдчилан таамаглах үйлчилгээг оруулна.

8344 Техникийн туршилт болон чанарын хяналтын судалгаа

83441 Хольц, цэвэр найрлага, бохирдлыг судлан тогтоох үйлчилгээ

Энэ дэд ангид дараах үйлчилгээ орно. Үүнд:

- агаар, ус, хог хаягдал, түлш, металл, хөрс, эрдэс, хоол хүнс болон химийн бодис зэрэг материалын хими, биологийн шинж чанарт зориулсан туршилт, задлан шинжилгээний үйлчилгээ

- микро биологи, биохими, бактерлоги зэрэг шинжлэх ухааны талбартай холбоотой туршилт, задлан шинжилгээний үйлчилгээ

Харин эмчилгээ болон шүдний туршилтын үйлчилгээ 93195-д орно.

83442 Биетийн физик шинж чанар, найрлагыг судлан тогтоох үйлчилгээ

Энэ дэд ангид дараах үйлчилгээ орно. Үүнд:

- металл, хуванцар, мод, шил, бетон болон бусад материалын радио идэвхт чанар, цахилгаан дамжуулах чанар, уян чанар, суналт зэрэг физикийн шинж чанарын туршилт, задлан шинжилгээний үйлчилгээ

- суналт, бат бөх чанар, цохилтонд тэсвэртэй уян эсэргүүцэл, өндөр хэмийн нөлөө зэрэгт зориулсан туршилтын ажил

83443 Механик болон цахилгаан иж бүрдлийн тогтолцоог хянах, шалгах үйлчилгээ

Энэ дэд ангид цахилгааны бүрэлдэхүүн хэсэг, бусад тоног төхөөрөмжийн нийлмэл техник, харилцаа холбооны тоног төхөөрөмж, цахилгаан хэрэглэл, багаж хэрэгсэл, мотор, автомашин, иж бүрэн машины цахилгааны онцлог шинж болон механикт туршилт, задлан шинжилгээний үйлчилгээ орно.

83444 Авто тээврийн техникийн туршилт, хяналтын үйлчилгээ

Энэ дэд ангид автомашин, мотоцикл, автобус, ачааны машин, тэрэг болон зам тээврийн бусад хэрэгсэлд зориулсан техникийн тогтмол хяналтын үйлчилгээ орно.

Харин хохирлын үнэлгээний үйлчилгээ (71620-д), тээврийн хэрэгсэл, мотоциклд зориулсан техник засварын үйлчилгээ (87141, 87142-т орно).

83449 Бусад төрлийн техникийн туршилт, хяналт шинжлэх үйлчилгээ

Энэ дэд ангид дараах үйлчилгээ орно. Үүнд:

- эвдрэлийг нь тогтоохоор машины бүтэц болон эд ангийг радио график, соронзон, хэт авиагаар оношлох үйлчилгээ

Энэ оношлох үйлчилгээ нь ихэвчлэн газар дээр хийгдэнэ.

- завь, нисэх онгоц, далан зэргийн гэрчилгээ

- урлагийн бүтээлийн баталгаажуулалт болон гэрчилгээ

- гагнуурын рентген хяналт

- техникийн оношлогоо болон шинжилгээний бусад үйлчилгээ

Харин дараах үйлчилгээ орохгүй. Үүнд:

- даатгалын компаниудын төлөх хохирлын үнэлгээ (71620-д),

- автомашины техникийн хяналтын үйлчилгээ (83444-т),

- эмнэлгийн шинжилгээ болон оношилгооны үйлчилгээ (93195-д орно).

835 Мал эмнэлгийн үйлчилгээ

8351 Гэрийн тэжээвэр амьтны эмнэлгийн үйлчилгээ

83510 Гэрийн тэжээвэр амьтны эмнэлгийн үйлчилгээ

Энэ дэд ангид дараах үйлчилгээ орно. Үүнд:

- мал, амьтны эмнэлгийн болон эмнэлгээс гадуурх эмчилгээ, мэс засал, шүдний үйлчилгээ. Энэ үйлчилгээний зорилго нь амьтны эрүүл мэнд, сэргээх эмчилгээ хийхэд оршино.

- эмнэлэг, лаборатор, техникийн үйлчилгээ, хоол, хүнсний болон бусад үйлчилгээ

8352 Мал эмнэлгийн үйлчилгээ

83520 Мал эмнэлгийн үйлчилгээ

Энэ дэд ангид дараах үйлчилгээ орно. Үүнд:

- мал, амьтны эмнэлгийн болон эмнэлгийн гадуурх эмчилгээ, мэс засал, шүдний үйлчилгээ. Үүнд

- хоол, унд бусад үйлчилгээний эмнэлэг, лаборатор, техникийн үйлчилгээ

Харин хиймэл үр тогтоох зэрэг мал аж ахуйтай холбоотой үйлчилгээ орохгүй (86121-д орно).

8359 Мал эмнэлгийн бусад төрлийн үйлчилгээ

83590 Мал эмнэлгийн бусад төрлийн үйлчилгээ

Энэ дэд ангид дараах үйлчилгээ орно. Үүнд:

- тэжээвэр амьтад (амьтны хүрээлэнгийн амьтад, үслэг арьс болон бусад бүтээгдэхүүнийг авч ашиглахаар өсгөн үржүүлж буй амьтад) болон малаас бусад амьтад үзүүлэх эмнэлгийн болон эмнэлгийн гадуурх, мэс заслын болон шүдний эмчилгээ үйлчилгээ

- хоол, унд (тусгай хоол тэжээлийн зүйл), бусад үйлчилгээтэй эмнэлэг, лаборатор болон техникийн үйлчилгээ

Харин хиймэл үр тогтоох зэрэг амьтан үржүүлэгтэй холбоотой үйлчилгээ 86121-д орно.

836 Зар сурталчилгааны үйлчилгээ болон түүнд холбогдох бусад үйлчилгээ

8361 Зар сурталчилгааг төлөвлөх, бүтээх, байршуулах үйлчилгээ болон холбогдох бусад төрлийн үйлчилгээ

83611 Зар сурталчилгааг төлөвлөх, бүтээх, байршуулах үйлчилгээ

Энэ дэд ангид зар сурталчилгааг төлөвлөх, зохиох, олон нийтэд түгээх дараах үйлчилгээ орно. Үүнд:

- зар сурталчилгааг түгээх мэдээллийн хэрэгслийг сонгох
- өгөгдөл, тайлбар зураг, зурагт хуудас зэргийг бүтээх
- сурталчилгааны бичлэгийн зохиолыг бичих, мэдээллийн хэрэгслээр цацах, сурталчилгааны объект эсвэл кино, бичлэгийг төлөвлөх (шинээр хийлгүйгээр)
- хэрэглэгчдэд шууд хандах маркетинг, шуудангаар сурталчилгаа явуулах компанит ажлыг зохион байгуулах

Харин дараах үйлчилгээ орохгүй. Үүнд:

- олон нийттэй харилцах үйлчилгээ (83121-д),
- маркетингийн судалгаа хийх үйлчилгээ (83700-д),
- зар сурталчилгаатай холбогдох гэрэл зургийн үйлчилгээ (83812-т),
- зар сурталчилгаатай, кино бүтээх үйлчилгээ (96121-д орно).

83612 Сурталчилгааны компанит ажил зохион байгуулах, шуудангийн сурталчилгаа

Энэ дэд ангид олон нийтийн мэдээллийн хэрэгслээс илүү хэрэглэгчдэд бүтээгдэхүүн, үйлчилгээг шууд санал болгосон зар, мэдээлэл, сурталчилгааг хүргэх үйлчилгээ орно.

Энд шуудангаар, утсаар шууд хандах зэрэг аргуудыг ашиглаж болно.

83613 Зар сурталчилгааны загвар, үзэл баримтлалыг бий болгох үйлчилгээ

Энэ дэд ангид дараах үйлчилгээ орно. Үүнд:

- зар сурталчилгааны үндсэн санааг гаргах, текст, уриа үгийг сонгох
- зар сурталчилгааны хэвлэмэл материал, тайлбар зураг, зурагт хуудасны загварыг гаргах
- зар сурталчилгааны бичлэг (кино)-ийн зохиолыг бичих

83619 Зар сурталчилгааны бусад үйлчилгээ

Энэ дэд ангид дараах үйлчилгээ орно. Үүнд:

- агаараас зар сурталчилгаа явуулах үйлчилгээ
- зар сурталчилгааны жишээ болон түүнтэй холбоотой бусад материалыг хүргэх үйлчилгээ
- худалдааны цэг дээр зар сурталчилгаа явуулах, танилцуулга хийх үйлчилгээ
- борлуулалтын идэвхжүүлэлт (хэрэв захиалга хүлээн аваагүй бол)

Харин дараах үйлчилгээ орохгүй. Үүнд:

- загварын агентлагийн үйлчилгээ (85999-т),
- сурталчилгааны шуудангийн үйлчилгээ (85952-т орно).

8362 Зар сурталчилгаа тавих талбай, сурталчилгаа түгээх хугацааг худалдах үйлчилгээ (хураамжтай)

83620 Зар сурталчилгаа тавих талбай, сурталчилгаа түгээх хугацааг худалдах үйлчилгээ (хураамжтай)

Энэ дэд ангид дараах үйлчилгээ орно. Үүнд:

- зар сурталчилгаа тавих талбай, цаг хугацааг худалдах, түрээслэх үйлчилгээ
- зар сурталчилгаа гаргагч, зар сурталчилгааны агентлагийн өмнөөс мэдээллийн хэрэгсэлд зар сурталчилгаа хийх орон зай, цаг хугацааг худалдан авах мэдээллийн хэрэгслийн агентлагийн үйлчилгээ

8363 Зар сурталчилгаа тавих талбай, сурталчилгаа түгээх хугацааг худалдах үйлчилгээ (хураамжгүй)

83631 Хэвлэмэл бүтээгдэхүүний сурталчилгаа байрлуулах талбай худалдах үйлчилгээ (хураамжгүй)

Энэ дэд ангид дараах үйлчилгээ орно. Үүнд:

- хэвлэлийн газраас ном, танилцуулга, эмхтгэл зэрэгт зар сурталчилгаа хийх орон зайг худалдах үйлчилгээ
- хэвлэлийн газраас сонин, сэтгүүл, тогтмол хэвлэлд зар сурталчилгаа хийх орон зайг худалдах үйлчилгээ

- хэвлэлийн газраас ил захидал, цагийн хуваарь, маягт, зурагт хуудас болон бусад хэвлэмэл зүйлсэд зар сурталчилгаа тавих орон зайг худалдах үйлчилгээ

83632 Телевиз, радиогоор дамжуулах зар сурталчилгаа хийх, цагийн төлбөртэй үйлчилгээ (хураамжгүй)

Энэ дэд ангид телевиз, радиогийн дамжуулах нэгжээс телевиз, радиод зар сурталчилгаа шууд явуулах цагийг худалдах үйлчилгээ орно.

83633 Интернэтээр дамжуулан хийх зар сурталчилгаа байршуулах зайг худалдах үйлчилгээ (хураамжгүй)

Энэ дэд ангид вэб хуудас эзэмшигч, вэб хостоос интернэтэд зар сурталчилгаа шууд байрлуулах орон зайг худалдах үйлчилгээ орно.

83639 Зар сурталчилгааг бусад хэрэгсэлээр дамжуулан байршуулах талбай, зар сурталчилгаа явуулах хугацааны төлбөртэй үйлчилгээ

Энэ дэд ангид дараах үйлчилгээ орно. Үүнд:

- шууд эзэмшигчээс зарлалын самбар, барилга байшин, тээврийн хэрэгсэл зэрэгт зар сурталчилгаа байрлуулах орон зайг худалдах үйлчилгээ
- хэвлэлийн газраас интернэтээс бусад электрон мэдээллийн хэрэгсэлд зар сурталчилгаа байрлуулах орон зайг шууд худалдах үйлчилгээ
- видео бичлэг хөдөлгөөнт зурагт зар сурталчилгаа байрлуулах орон зайг худалдах үйлчилгээ
- тэмцээн явагдаж буй байр, талбай, цэнгэлдэх хүрээлэн зэрэг газруудад зар сурталчилгаа байрлуулах эрхийг худалдах үйлчилгээ

837 Зах зээл болон олон нийтийн үзэл бодлыг судлах үйлчилгээ

8370 Зах зээл болон олон нийтийн үзэл бодлыг судлах үйлчилгээ

83700 Зах зээл болон олон нийтийн үзэл бодлыг судлах үйлчилгээ

Энэ дэд ангид дараах үйлчилгээ орно. Үүнд:

- зах зээлийн судалгаа, зах зээлийн өрсөлдөөний болон хэрэглэгчийн зан төлвийн судалгаа
- сэдэвчилсэн судалгаа, статистик, эконометрийн загвар, түүвэр судалгааны аргыг ашиглах
- нийгэм, эдийн засаг, улс төр болон бусад сэдвээр олон нийтийн санал бодлыг судлах, дүн шинжилгээ хийх

838 Гэрэл зураг авах болон боловсруулах үйлчилгээ

8381 Гэрэл зураг авах болон дүрс бичлэг хийх үйлчилгээ

83811 Гэрэл зураг авах үйлчилгээ

Энэ дэд ангид студи болон үйлчлүүлэгчийн албан газар, гэр зэрэг бусад газарт хувь хүний зураг авах үйлчилгээ орно. Энэ үйлчилгээнд хэрэглэгчийн хүсэлтийн дагуу дараах төрлийн зургуудыг авах, боловсруулах, хэвлэн гаргах үйлчилгээг багтаана. Үүнд:

- паспорт болон бусад бичиг баримтын зураг
- нярай болон бага насны хүүхдийн зураг
- гэр бүлийн болон цэргийн зураг
- уран сайхны гэрэл зургийн студийн зураг
- зураг нэгтгэх үйлчилгээ

83812 Үзүүлэн сурталчилгааны болон адил зориулалттай зураг авах үйлчилгээ

Энэ дэд ангид дараах гэрэл зурагтай холбоотой үйлчилгээ орно. Үүнд:

- > худалдааны төв, үйлдвэрийн газрын зураг
- > загварын хувцас болон бусад хувцасны зураг
- > машин, тоног төхөөрөмж, барилгын зураг
- > хувь хүний болон бусад субъектуудын зураг
- > сонины сурталчилгаа, танилцуулга, сурталчилгааны самбар
- > каталоги зэргийн гэрэл зураг авах үйлчилгээ

83813 Гэрэл зураг авах, дүрс бичлэг хийх үйлчилгээ

Энэ дэд ангид хурим, төгсөлт, хурал, цуглаан, хүлээн авалт, загварын шоу, спортын, мэдээллийн үйл ажиллагаа зэрэг бодит үйл явдлын гэрэл зураг авах, дүрс бичлэг хийх үйлчилгээ орно.

Харин телевизийн хөтөлбөр хийх үйлчилгээ 96121-д орно.

83814 Гэрэл зургийн тусгай үйлчилгээ

Энэ дэд ангид дараах үйлчилгээ орно. Үүнд:

- газрын гадаргуу, хэлбэр төрх, бүтэц зэргийн зургийг агаараас авах үйлчилгээ
- тусгай аппарат, техникийн тусламжтайгаар хүн, аливаа биет, байдал төрхийн зургийг авах үйлчилгээ, жишээлбэл:
 - > усан доор зураг авах
 - > анагаах ухааны болон биологийн зориулалттай зураг авах
 - > бичил/микро зураг авах

Харин дараах үйлчилгээ орохгүй. Үүнд:

- сансраас, хиймэл дагуулаар мэдээлэл цуглуулах болон хэмжилтийн зураг авах, бичлэг хийх, (83421-д),
- фото зургийн сэтгүүл, сэтгүүлчийн үйлчилгээ (бүлэг 844-т орно).

83815 Гэрэл зураг сэргээн засах, тодруулах үйлчилгээ

Энэ дэд ангид дараах үйлчилгээ орно. Үүнд:

- хуучин гэрэл зураг сэргээн засах үйлчилгээ
- гэрэл зургийг тодруулах болон гэрэл зургийн бусад эффектүүдийг хийх

83819 Гэрэл зургийн бусад төрлийн үйлчилгээ

Энэ дэд ангид бичил хальсанд зураг авах (микрофильм) үйлчилгээ орно.

Харин гэрэл зураг хувилах үйлчилгээ 85951-д орно.

8382 Гэрэл зураг угаах, хэвлэх үйлчилгээ

83820 Гэрэл зураг угаах, хэвлэх үйлчилгээ

Энэ дэд ангид дараах үйлчилгээ орно. Үүнд:

- хэрэглэгчийн хүсэлтээр хийгдэх зураг хэвлэн гаргах, негатив хальс боловсруулах үйлчилгээ
 - > негатив хальс болон слайдыг томруулах
 - > хар, цагаан зураг боловсруулах
 - > өнгөт зураг хэвлэх
 - > слайд болон негатив хальсыг хувилах, дахин хэвлэх
- зургийг боловсруулах сонирхогчийн болон гэрэл зургийн үйлчилгээ эрхлэгчийн үйлчилгээ
- гэрэл зургийн слайд бэлтгэх үйлчилгээ
- гэрэл зураг хэвлэх, хувилах үйлчилгээ
- гэрэл зураг, гэрэл зургийн хальсыг бусад хэлбэрт хөрвүүлэх

Харин кино зургийн хальс боловсруулах, дахин боловсруулах үйлчилгээ 9613-т орно.

839 Мэргэжлийн, техникийн болон бизнесийн зөвлөгөө, үйлчилгээ

8391 Мэргэжлийн загварын үйлчилгээ

83911 Интерьер загварын үйлчилгээ

Энэ дэд ангид дараах үйлчилгээ орно. Үүнд:

- хэрэглэгчийн бодит, гоо зүйн болон албан хэрэгцээний шаардлагаар дотоод орон зайг төлөвлөх, төсөл зураг гаргах зэрэг интерьер загварын үйлчилгээ
- дотоод засал чимэглэлийн дизайныг зохиомжлох үйлчилгээ
- ширээний бүтээлэг, цонхны хөшиг зэргийг оруулан дотоод засал чимэглэл хийх үйлчилгээ

83912 Аж үйлдвэрийн бүтээгдэхүүний дизайны үйлчилгээ

Энэ дэд ангид аж үйлдвэрийн бүтээгдэхүүний дизайны үйлчилгээ орно.

83919 Тусгай зураг, загварын бусад үйлчилгээ

Энэ дэд ангид дараах үйлчилгээ орно. Үүнд:

- гоо зүйн шийдлийг техникийн болон бусад шаардлагатай уялдуулсан бүтээгдэхүүний хэв загварыг бүтээх, боловсруулах үйлчилгээ
 - > тавилгын дизайн
 - > өргөн хэрэглээний бараа, бүтээгдэхүүний гоо зүйн дизайн
- сав, баглаа боодлын дизайны үйлчилгээ
- гурван хэмжээст загвар (3D) загварыг бүтээх
- график дизайны үйлчилгээ

8392 Эх загвар боловсруулах үйлчилгээ

83920 Эх загвар боловсруулах үйлчилгээ

Энд хувиараа хийсэн эх загварын үйлчилгээ:

- аж үйлдвэрийн бүтээгдэхүүний загвар
- гоо сайхны загвар
- график дизайн

Энэхүү оюуны өмчийн бүтээгдэхүүн нь ихэвчлэн худалдан борлуулах, бусдад мэдээллийг ашиглуулах зорилготой байдаг.

8393 Шинжлэх ухааны болон техникийн зөвлөгөө өгөх бусад үйлчилгээ

83931 Байгаль орчны зөвлөгөө өгөх үйлчилгээ

Энэ дэд ангид дараах үйлчилгээ орно. Үүнд:

- байгаль орчны хяналт, үнэлгээ, өөрөөр хэлбэл дараах зорилгоор судалгаа явуулах үйлчилгээ. Үүнд: хүрээлэн байгаа орчны бохирдолыг тодорхойлох; аливаа төслийг хэрэгжүүлснээр бий болох орчны бохирдлоос хүн амын аюулгүй байдлыг хамгаалах, эрүүл мэндэд учруулах эрсдлийг үнэлэх; хүний болон байгалийн үйл явцын үр дүнд бий болсон хүрээлэн буй орчны өөрчлөлт экологи, эдийн засагт үзүүлэх үр дүнг тодорхойлох
- туршилт, хяналт нь хүрээлэн буй орчны аюулгүй байдлыг хангахад тавих шаардлагад тохирч буй эсэхийг тодорхойлох байгаль орчны хөндлөнгийн хяналт, үнэлгээ, бодлого
- хууль, тогтоомжид заасан техникийн болон бусад шаардлагын дагуу тухайн газрын хүрээлэн буй орчны бохирдлыг арилгах төлөвлөгөө бэлтгэх, нөхөн сэргээх үйл ажиллагааг төлөвлөх
- боловсруулан гаргах хуулийн шийдвэрийн байгаль орчинд нөлөөлөх давуу болон сул талыг тодорхойлох судалгаа явуулах, байгаль орчны шинжилгээг үнэлэх
- газар, ой, усны биетүүд, хий, газрын тос, эрдэс ашигт малтмал, ан амьтад болон байгалийн бусад нөөцийн экологийн зохистой ашиглалтыг бий болгох мэдээлэл, зааварчилгаа удирдлагаар хангах
- хог, хаягдлыг багасгах, тээвэрлэх, хадгалах, дахин ашиглах мэдээлэл, зааварчилгаа, удирдлагаар хангах
- байгаль орчны чиглэлээр дүрэм, журам, зохицуулалт, стандартыг бий болгон хэрэгжүүлэхэд олон нийтийн болон хувийн байгууллагад зөвлөгөө өгөх, байгаль орчны бодлого боловсруулахад зөвлөгөө өгөх
- байгаль орчны бусад чиглэлээр зөвлөгөө өгөх үйлчилгээ

83939 Шинжлэх ухааны болон техникийн зөвлөгөө өгөх бусад үйлчилгээ

Энэ дэд ангид математикч, статистикч зэрэг хүмүүс шинжлэх ухааны зөвлөгөө өгөх үйлчилгээ орно.

8394 Баримт, мэдээллийн эх эмхтгэлийг бий болгох үйлчилгээ

83940 Баримт, мэдээллийн эх эмхтгэлийг бий болгох үйлчилгээ

Энэ дэд ангид шуудангийн хаягийн жагсаалт, үйл явдлын тэмдэглэл, зөвлөгөө зэргийг багтаасан мэдээ, мэдээллийн эх эмхтгэлийг бий болгох үйлчилгээ орно. Эдгээр эмхтгэлийг эзэмших эрх нь хуулиар хамгаалагддаг.

Харин дараах үйлчилгээ орохгүй. Үүнд:

- мэдээ, мэдээллийг эмхтгэх үйлчилгээ (83990-д),
- шуудангийн хаягийг эмхтгэх үйлчилгээ (85952-т орно).

8395 Бичгэн ба аман орчуулга хийх үйлчилгээ
83950 Бичгэн ба аман орчуулга хийх үйлчилгээ

Энэ дэд ангид дараах үйлчилгээ орно. Үүнд:

- нэг хэлээс нөгөө хэл рүү бичвэрийг орчуулан үр дүнг бичгээр гаргахтай холбогдох үйлчилгээ
- нэг хэлээс нөгөө хэл рүү аман орчуулга хийх үйлчилгээ

8399 Мэргэжлийн, шинжлэх ухаан техникийн болон бизнесийн чиглэлийн бусад үйлчилгээ
83990 Мэргэжлийн, шинжлэх ухаан техникийн болон бизнесийн чиглэлийн бусад үйлчилгээ

Энэ дэд ангид дараах үйлчилгээ орно. Үүнд:

- төсөл боловсруулах үйлчилгээ (барилга, байгууламж, системийн нарийвчилсан зураг, төсөл, зурагт танилцуулга болон архитектор, инженер, техникийн ажилтнуудаар хийгдэх инженерийн болон уран барилгын тодорхойлолт)
- шуудангийн хаягаас бусад мэдээ, мэдээллийг эмхтгэх үйлчилгээ

Харин шуудангийн хаягийг эмхтгэх үйлчилгээ 85952-т орно.

84 ЦАХИЛГААН ХОЛБОО, НЭВТРҮҮЛЭГ ДАМЖУУЛАХ БОЛОН МЭДЭЭЛЛЭЭР ХАНГАХ ҮЙЛЧИЛГЭЭ

841 Телефон утас болон цахилгаан холбооны бусад төрлийн үйлчилгээ

8411 Дамжуулагч зөөгчийн үйлчилгээ

84110 Дамжуулагч зөөгчийн үйлчилгээ

Энэ дэд ангид дараах үйлчилгээ орно. Үүнд:

- утастай, утасгүй холбооны хэрэгслээс цахилгаан холбооны зөөгчөөр дамжуулан хийгдэх холболтын үйлчилгээ болон цахилгаан холбооны бусад үйлчилгээ үзүүлэгчийн дуудлагыг дамжуулах
- дотоод холболт, хотын доторх, хот хоорондын болон улс хоорондын дуудлагын төлбөрийг цуглуулах
- төлбөрт утаснаас хийсэн дуудлага болон орон нутгийн сүлжээний бусад дамжуулагч/ зөөгчийн хоорондох алсын дуудлагын төлбөрийг цуглуулах
- антенн зэрэг хамтдаа ашигладаг тоног төхөөрөмжийн төлбөрийг цуглуулах

Харин интернэтийн нэг үйлчилгээ үзүүлэгчээс (ISP) нөгөө үйлчилгээ үзүүлэгч (ISP)-д хандсан интернэтийн холболтыг дамжуулах үйлчилгээ 84210-д орно.

8412 Суурин утасны үйлчилгээ

Энэ дэд ангид дараах үйлчилгээ орно. Үүнд:

- суурин хэрэглэгчээс хийх дуудлагаар дуу, дүрс, өгөгдлийг дамжуулах, холбох нийтийн утасны сүлжээний ашиглалт, үйлчилгээ
- төлбөрт хамааралтай төлбөрийг салгах суурин хэрэглэгчээс хийх дуудлагыг удирдах үйлчилгээ

84121 Суурин утсанд хандах ба ашиглах үйлчилгээ

Энэ дэд ангид дараах үйлчилгээ орно. Үүнд:

- суурин хэрэглэгчийн болон зоос, картаар ажилладаг нийтийн таксафоноос хийх дуудлагаар дуу, дүрс, өгөгдлийг дамжуулах, холбох нийтийн утасны сүлжээний үйлчилгээ
- дотоод болон гадаадаас хандах, ашиглах үйлчилгээ
- богино зурвасын үйлчилгээ (SMS), мультимедиа мессежийн үйлчилгээ (MMS)
- онцгой зангилгааг ашиглан дуудлага хийх үйлчилгээ

Харин дараах үйлчилгээ орохгүй. Үүнд:

- хувийн сүлжээний үйлчилгээ (84140-д),

- орон нутгийн сүлжээнээс бусад утсан холбооны үйлчилгээ үзүүлэгчид рүү хандах үйлчилгээ (84110-д),
- холбооны тоног төхөөрөмжийг түрээслүүлэх (73125-т),
- тусдаа төлбөртэй утасны ярианы бусад (нэмэлт) үйлчилгээ (84122-т орно.)

84122 Суурин утасны дуудлагат үйлчилгээ

Энэ дэд ангид суурин хэрэглэгчдэд үзүүлэх тусдаа төлбөртэй дуудлагыг зохион байгуулах үйлчилгээ орно. Эдгээр үйлчилгээг утасны сүлжээнд суурилуулсан тусгай програм, өгөгдлийн санг ашиглан гүйцэтгэдэг. Жишээлбэл: дуудлага хүлээх, дуудлага дамжуулах, дуудлагыг тодорхойлох, гуравдагч шугамаар холбогдох, дуудлага буцаах, дугаар илрүүлэх, дуудлага хаах, автомат хариулагч, дуут шуудан зэрэг

8413 Үүрэн утасны үйлчилгээ

Энэ дэд ангид үүрэн болон сансарын холбооны утас, пейжер, хөдөлгөөнт радио зөөврийн хэрэгсэл, гар хэрэгслээс оператор руу, оператороос эдгээр хэрэгсэл рүү дуу, дүрс, өгөгдлийг дамжуулах холбогдсон болон холбогдоогүй сүлжээний ашиглалт үйлчилгээ орно. Үүнд:

- > PCS (Personal Commucations Services) - хувийн холбооны үйлчилгээ
- > ESMR (Enhanced Specialized Mobile Radio) - өргөтгөсөн тусгай хөдөлгөөнт радио
- > WLAN(Wireless Local Area Network) - утасгүй дотоод сүлжээ
- хөдөлгөөнт хэрэгслийг ашиглах тусдаа төлбөртэй бусад үйлчилгээ

84131 Үүрэн утасны хандах ба ашиглах үйлчилгээ

Энэ дэд ангид дараах үйлчилгээ орно. Үүнд:

- үүрэн, PCS (хувийн холбооны үйлчилгээ), ESMR (өсгөсөн тусгай хөдөлгөөнт радио), сансрын холбооны утас; пейжер; хөдөлгөөнт радио зөөврийн гар хэрэгслээс оператор руу, оператороос эдгээр хэрэгсэл рүү дуу, дүрс, өгөгдлийг дамжуулах холбогдсон болон холбогдоогүй сүлжээний ашиглалт үйлчилгээ
- тусдаа төлбөртэй утасны ярианы бусад (нэмэлт) үйлчилгээ

Харин дараах үйлчилгээ орохгүй. Үүнд:

- хөдөлгөөнт хэрэгслээс интернэтэд холбогдох үйлчилгээ (8422-т),
- тусдаа төлбөртэй хөдөлгөөнт холбооны бусад (нэмэлт) үйлчилгээ (84132-т),
- цахилгаан холбооны үйлчилгээ үзүүлэгч бусад операторууд руу гарах, хүлээн авах, дамжуулах, сансрын холбооны хэрэгслийн ашиглалт үйлчилгээ (84110-д),
- суурин цэгээс гарах, орох ашигласан хэмжээгээр төлөх өгөгдөл дамжуулах сансрын холбооны хэрэгслийн ашиглалт үйлчилгээ (84150-д),
- хэрэглэгчдийн хувьдаа ашигладаг сансрын холбооны хэрэгслийн ашиглалт үйлчилгээ (84140-д орно).

84132 Үүрэн утасны дуудлагат үйлчилгээ

Энэ дэд ангид зөөврийн хэрэгсэл, гар хэрэгслийг ашиглан тусдаа төлбөртэйгээр дуудлагыг зохион байгуулах үйлчилгээ орно. Энэ үйлчилгээг утасны сүлжээнд суурилуулсан тусгай програм, өгөгдлийн санг ашиглан гүйцэтгэдэг. Жишээлбэл дуудлага хүлээх, дуудлага дамжуулах, дуудлагыг тодорхойлох, гуравдагч шугамаар холбогдох, дуудлага буцаах, дугаар илрүүлэх, дуудлага хаах, автомат хариулагч, дуут шуудан зэрэг

8414 Хувийн сүлжээний үйлчилгээ

84140 Хувийн сүлжээний үйлчилгээ

Энэ дэд ангид хязгаарлагдмал тооны хэрэглэгчид тодорхой цэгүүдийн хоорондох утсан болон утасгүй холбооны ашиглалт үйлчилгээ орно.

Харин цахилгаан холбооны үйлчилгээ үзүүлэгч операторууд руу цахилгаан холбооны дамжуулагч/зөөгчөөр дамжуулан хувийн холболт хийх үйлчилгээ 84110-д орно.

8415 Өгөгдөл дамжуулах үйлчилгээ

84150 Өгөгдөл дамжуулах үйлчилгээ

Энэ дэд ангид утсан болон утасгүй хэрэгсэл ашиглан, ашигласан хэмжээгээр төлөх өгөгдөл дамжуулах тусгай үйлчилгээ орно.

Харин хязгаарлагдмал тооны хэрэглэгчид тодорхой цэгүүдийн хоорондох утсан болон утасгүй холбооны үйлчилгээ 84140-д орно.

8419 Цахилгаан холбооны бусад төрлийн үйлчилгээ

84190 Цахилгаан холбооны бусад төрлийн үйлчилгээ

Энэ дэд ангид телеграф, телекс, аудио хурлын холболт зэрэг өөр газар ороогүй цахилгаан холбооны үйлчилгээ орно.

842 Интернэт холболтын үйлчилгээ

Энэ бүлэгт интернэт болон үүнтэй төстэй компьютерын сүлжээний цахилгаан холбооны үйлчилгээ орно.

8421 Интернэтийн суурь сүлжээний үйлчилгээ

84210 Интернэтийн суурь сүлжээний үйлчилгээ

Энэ дэд ангид нэг интернэтийн үйлчилгээ үзүүлэгч (ISP)-ээс нөгөө интернэтийн үйлчилгээ үзүүлэгч (ISP)-д хандах интернэт холболтын дамжуулагч / зөөгчийн үйлчилгээ орно. (ерөнхийдөө тухайн салбар дахь хамтран ажиллагчид дамжуулах үйлчилгээ эрхлэгчид)

8422 Интернэт түгээх үйлчилгээ

Энэ дэд ангид утастай болон утасгүйгээр интернэтэд шууд холбогдох үйлчилгээ орно. Интернэтийн үйлчилгээ үзүүлэгч (ISP) нь цахим шуудан, хэрэглэгчдийн вэб хуудсыг байрлуулах, загвар вэб хуудасны хэрэгслүүд, чаат, техникийн үйлчилгээ зэрэг интернэт ашиглалттай холбоотой үнэгүй үйлчилгээг мөн үзүүлж болно. Энэ үйлчилгээ нь мөн алсын хандалт болон интернэт хандалтын бусад төрлүүд, нэмэлт төлбөр бүхий нэмэлт олон улсын хандалт (интернэйшнл рүүминг), цахим шуудангийн хайрцаг зэрэг програм хангамж, пакетуудыг багтаана.

84221 Богино зурвасын интернэт түгээх үйлчилгээ

Энэ дэд ангид утастай болон утасгүйгээр, ихэвчлэн дайл-ап холболтоор интернэтэд холбогдох үйлчилгээ орно. Интернэтийн үйлчилгээ үзүүлэгч (ISP) нь цахим шуудан, хэрэглэгчдийн вэб хуудсыг байрлуулах, загвар вэб хуудасны хэрэгслүүд, чаат, техникийн үйлчилгээ зэрэг интернэт ашиглалттай холбоотой үнэгүй үйлчилгээг мөн үзүүлж болно. Энэ үйлчилгээ нь мөн алсын хандалт болон интернэт хандалтын бусад төрлүүд, нэмэлт төлбөр бүхий нэмэлт олон улсын хандалт (интернэйшнл роуминг), цахим шуудангийн хайрцаг зэрэг програм хангамж, пакетуудыг багтаана.

84222 Өргөн зурвасын интернэт түгээх үйлчилгээ

Энэ дэд ангид интернэтэд утастай болон утасгүй холболтоор шууд холбогдож, үйл ажиллагаа явуулах үйлчилгээ орно. Интернэт Үйлчилгээгээр Хангагч (ИҮХ) нь цахим шуудангийн адил интернэт хүлээн авах үйлчилгээгээр үнэгүй хангах, үйлчлүүлэгчид веб хуудас нээх боломж олгох, веб хуудасны дизайн, хүснэгт хийх хэрэгслээр хангах үйлчилгээ хийх юм. Түүнчлэн энэ үйлчилгээ нь алсын зайнаас хүлээн авах буюу эсвэл интернэтийн бусад төрлийн үйлчилгээ хийх тухайлбал улс хооронд хэрсэн чанарын өндөр үзүүлэлт бүхий шуурхай цахим шуудангаар хангах бөгөөд энэ нь голчлон хэрэглэгчдэд нэмэгдэл үнэтэйгээр очих юм.

8429 Интернэт болон цахилгаан холбооны бусад төрлийн үйлчилгээ

84290 Интернэт болон цахилгаан холбооны бусад төрлийн үйлчилгээ

Энэ дэд ангид дараах эд зүйлийг оруулна:

- интернэт ашиглахгүйгээр интернэтэд суурилсан цахилгаан холбооны үйлчилгээ үзүүлэх, тухайлбал:
- интернетээр дамждаг факс, утас, аудио хурал, видео хурал

843 Он-лайн үйлчилгээ

8431 Он-лайн текстэнд суурилсан мэдээлэл

Энэ дэд ангид дараах үйлчилгээ орно. Үүнд:
- он-лайн ном, үүнд, сурах бичиг, лавлах толь, газрын зураг
- гадаад хэлний толь бичиг, нэвтэрхий толь, бусад заавар, зөвлөгөө

84312 Аудио хөгжмийн бичлэг хийж оруулах үйлчилгээ

Энэ дэд ангид дараах үйлчилгээ орно. Үүнд:
- тодорхой интервалтайгаар, долоо хоног, сараар гол санаа нь тусгагдсан интернэтийн хэвлэлийн тойм; эсвэл ганц хувиар захиалагдсан нийтлэл
- өдөр тутмын болон олон давталттай сонины гол утга санаа бүхий сонины хэсэг
- тогтмол сонинд нийтлэгддэг захидлууд

Харин дижитал архивын үйлчилгээ 84520-д орно.

8432 Он-лайн аудио

84321 Аудио хөгжмийн бичлэг хийж оруулах үйлчилгээ

Энэ дэд ангид хөгжмийн аудио бичлэг бүхий цахим файлуудыг бичиж хадгалах үйлчилгээ орно.

84322 Дүрс бичлэгийг хэсэгчлэн хувааж, шахах үйлчилгээ

Энэ дэд ангид аудио урсгалын мэдээллийг интернэт рүү оруулах үйлчилгээ орно.

8433 Он-лайн дүрс бичлэг

84331 Кино болон бусад төрлийн дүрс бичлэг оруулах

Энэ дэд ангид кино, дүрс бичлэг хийсэн цахим файлуудыг програмд хөрвүүлэн оруулж, хадгалах үйлчилгээ орно.

84332 Дүрс бичлэгийг хэсэгчлэн хувааж, шахах үйлчилгээ

Энэ дэд ангид дүрс бичлэгийг интернэтэд оруулах зориулалтаар хэсэгчлэн хувааж, шахах, үйлчилгээ орно.

8434 програм хангамж татаж авах үйлчилгээ

84341 Системийн програм хангамжийн татаж авах үйлчилгээ

Энэ дэд ангид системийн програм хангамжийг агуулсан цахим файлуудыг задлах, суурилуулах зорилгоор татаж авах, хадгалах үйлчилгээ орно.

84342 Хэрэглээний програм хангамжийг татаж авах үйлчилгээ

Энэ дэд ангид хэрэглээний програм хангамж агуулсан цахим файлуудыг задлах, суурилуулах зорилгоор татаж авах үйлчилгээ орно.

8439 Бусад төрлийн он-лайн интерактив програм хангамжийн үйлчилгээ

84391 Он-лайн тоглоомын үйлчилгээ

Энэ дэд ангид интернэтэд зориулсан дараах тоглоомын үйлчилгээ орно.

- үйл явдлын өрнөл бүхий дүрийн оронд тоглох тоглоомууд
- стратегийн тоглоомууд
- адал явдалт, хөдөлгөөнт тоглоомууд
- хөзөр
- хүүхдийн тоглоом

Тоглоомыг тоглох бүрт төлбөр хийгдэнэ.

Харин мөрийтэй тоглоомын үйлчилгээ орохгүй. (96921-д орно).

84392 Он-лайн програм хангамжийн үйлчилгээ

Энэ дэд ангид тоглоомоос бусад он-лайн програм хангамжийн үйлчилгээ орно.

Харин дараах үйлчилгээ орохгүй. Үүнд:
- програм хангамжийг татаж авах үйлчилгээ (84341, 84342-т)
- он-лайн тоглоомын үйлчилгээ (84391-д)
- мөрийтэй тоглоомын үйлчилгээ (96921-д орно).

84393 Насанд хүрэгчдэд зориулсан он-лайн үйлчилгээ

Энэ дэд ангид насанд хүрэгчдэд зориулсан сексийн сэдэвт, агуулгатай бүтээлийг интернэтээр дамжуулах үйлчилгээ орно. Төлбөр нь захиалга хийх, гишүүнчлэлээр орох зэрэг аргаар харах үед хийгдэж болно.

Харин дараах үйлчилгээ орохгүй. Үүнд:
- насанд хүрэгчдэд зориулсан он-лайн сонин, тогтмол хэвлэл, ном товхимол, лавлахын үйлчилгээ (8431-д орно).
- насанд хүрэгчдэд зориулсан дижитал архивын үйлчилгээ (84520-д орно).

84394 ВЕБ хайлт хийх үйлчилгээ

Энэ дэд ангид ВЕБ хайлт, интернэтийн хаягийн санг өргөжүүлэх, хялбархан хайлт хийдэг формат бэлтгэх, хийх

84399 Он-лайн бусад төрлийн агуулгатай үйлчилгээ

Энэ дэд ангид дараах үйлчилгээ орно. Үүнд:
- статистикийн болон бусад мэдээлэл
- нэрийн хуудас, тоглоом, шог зураг, график, газрын зураг зэргээс бусад он-лайн үйлчилгээ

844 Мэдээллийн хэрэгслийн үйлчилгээ

8441 Сонин, тогтмол хэвлэлүүдийг мэдээллээр хангах үйлчилгээ

84410 Сонин, тогтмол хэвлэлүүдийг мэдээллээр хангах үйлчилгээ

Энэ дэд ангид дараах үйлчилгээ орно. Үүнд:
- сонин, тогтмол хэвлэл, номын хэвлэлтэнд өгөх гэж байгаа гар бичмэлээрх мэдээллийг цуглуулах, шинжлэн судлах, мэдээллээр хангах үйлчилгээ
- бие даасан хараат бус сэтгүүлчид, гэрэл зурагчдын бэлдсэн мэдээллийн үйлчилгээ

8442 Аудио-медиагаар үйлчлэх мэдээллийн хэрэгслийн үйлчилгээ

84420 Аудио-медиагаар үйлчлэх мэдээллийн хэрэгслийн үйлчилгээ

Энэ дэд ангид дараах үйлчилгээ орно. Үүнд:
- радио, телевиз, кино компаниудад өгөх гэж байгаа (гар бичмэлээр, гэрэл зургаар) мэдээлэл цуглуулах, шинжлэн судлах, мэдээллээр хангах үйлчилгээ
- бие даасан хараат бус сэтгүүлчид, камерийн зурагчдын бэлдсэн мэдээллээр үйлчилгээ

845 Номын сан, архивын үйлчилгээ

8451 Номын сангийн үйлчилгээ

84510 Номын сангийн үйлчилгээ

Энэ дэд ангид дараах үйлчилгээ орно. Үүнд:
- номыг цуглуулах, каталогжуулах, сэргээн засварлах үйл ажиллагаа
- ном, бичлэгүүдийг зээлдүүлэх үйл ажиллагаа

Харин дараах үйлчилгээ орохгүй. Үүнд:
- видео бичлэгийг түрээслүүлэх (73220-д)
- ном түрээслэх (73290-д орно).

8452 Архивын үйлчилгээ

84520 Архивын үйлчилгээ

Энэ дэд ангид дараах үйлчилгээ орно. Үүнд:
- дижитал архив бүхий нийтийн архивын үйлчилгээ (архивын мэдээг цуглуулах, каталогжуулах, хөрвүүлэх, сэргээх)
- дижитал архив бүхий түүхийн архивын үйлчилгээ

- 846 Радио, телевизийн нэвтрүүлэг, програм хуваарилах үйл ажиллагаа**
8461 Зөвшөөрөлтэй телевиз, радиогийн өргөн нэвтрүүлэг
84611 Зөвшөөрөлтэй радиогийн өргөн нэвтрүүлэг

Энэ дэд ангид оюуны өмчөөр хамгаалагдсан, агаараар дамжуулах радиогийн үйлчилгээ орно.

- 84612 Зөвшөөрөлтэй телевизийн өргөн нэвтрүүлэг**

Энэ дэд ангид оюуны өмч нь хамгаалагдсан агаараар дамжуулах телевизийн үйлчилгээ орно.

- 8462 Радио, телевизийн нэвтрүүлгийн болон сувгийн үйлчилгээ**
84621 Радиогийн нэвтрүүлгийн болон сувгийн үйлчилгээ

Энэ дэд ангид радио сувгийн болон радио өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ орно.

- 84622 Телевизийн нэвтрүүлгийн болон сувгийн үйлчилгээ**

Энэ дэд ангид телевизийн сувгийн болон телевизийн өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ орно.

- 8463 Өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ, олон сувгийн нэвтрүүлгийн дамжуулах үйлчилгээ**

Энэ дэд ангид кабель, хиймэл дагуул, утасгүй холбооны сүлжээг ашиглан аналог болон дижитал хэлбэрийн захиалга аудио болон видео програм, нэвтрүүлэг цацах үйлчилгээ орно.

програмчлал нь сувгуудыг урьдчилан суурилуулсан багц юмуу нэг удаагийн багцаар хангагдсан байна.

- 84631 Өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ**

Энэ дэд ангид дараах үйлчилгээ орно. Үүнд:

- програм сонголт, телевизийн болон радио өргөн нэвтрүүлгийн хуваарь
- програмын бүтээгдэхүүн болон нэвтрүүлгийн үйлчилгээний хослол

Харин интернэтээр дамжуулах нэвтрүүлгийн үйлчилгээ 83159-д орно.

- 84632 Нэвтрүүлгийг гэрт хүргэх үйлчилгээ, энгийн багц**

Энэ дэд ангид сарын төлбөрт үндэслэн хийсэн, ерөнхий нэвтрүүлгийн үйлчилгээгээр захиалагчийг хангах үйлчилгээ орно. Энэ багцын үйлчилгээ нь захиалагчдад хиймэл дагуул болон MDS оператороор дамжуулан хүргэх, боломжит хамгийн цөөн сувгуудаас бүрдэх ба энэхүү худалдан авсан нэвтрүүлгийн багц нь өндөр түвшнийх биш байж болно. Энд сүлжээнд холбогдсон анхны холболт, мөн дахин холболт байж болно.

- 84633 Нэвтрүүлгийг гэрт хүргэх үйлчилгээ, тусгай багц**

Энэ дэд ангид програм хангамжийг захиалагчдад хүргэх үйлчилгээ орно. Энэ үйлчилгээ нь сувгийн, хиймэл дагуул, MDS оператораар хийгдэх нэвтрүүлгийн үйлчилгээ байна.

- 84634 Нэвтрүүлгийг гэрт хүргэх үйлчилгээ, төлбөртэй багц**

Энэ дэд ангид тусгай нэвтрүүлэг (кино, үйл явдал)-ийг захиалж үзэх үйлчилгээ орно.

- 85 ТУСЛАХ ҮЙЛЧИЛГЭЭ**

- 851 Ажлын байраар хангах үйлчилгээ**
8511 Ажилтан ажлын байранд илгээх, зуучлах үйлчилгээ

Энэ анги нь ажил олгогч, ажиллагчдын хооронд зуучлах үйлчилгээ орно.

- 85111 Удирдах/тусгай нарийн мэргэшсэн ажиллах хүч зуучлах үйлчилгээ**

Энэ дэд ангид дараах үйлчилгээ орно. Үүнд:

Энэ дэд ангид тусгайлан бэлтгэгдсэн мэргэшсэн, чадварлаг ахлах мэргэжилтэнг хайх үйлчилгээ орно. Жишээлбэл:

- байгууллагын удирдлагатай нарийвчилсан тодорхой ярилцлага хийх
- ажлын цар хүрээг гаргах, ажилд авах гэж байгаа хүнийг эхлээд өөрийн байгууллагын дотоод нөөцөөсөө хайх
- сонгосон боломжит нэр дэвшигчээ бэлдэх, цаашид хамтран ажиллах түншдээ танилцуулах өндөр мэргэшсэн хүмүүсийнхээ нэрсийн жагсаалтад оруулан хэлэлцүүлэх
- дагалдангаар авахаар тохиролцсон хүнтэйгээ ярилцлага хийх

Цаашид ажиллах хүн/түнш нь хөлслөгдөх гэж байгаа ажлынхаа талаар шийдвэр гаргана. Үйлчилгээний хөлсийг нэр дэвшсэн хүн нь цаашид хөлслөгдөх, эс хөлслөгдөхөөс үл хамааран олгох юм.

85112 Удирдах ажилтнаас бусад төрлийн ажлын байранд зуучлах байнгын үйлчилгээ

Энэ дэд ангид дараах үйлчилгээ орно. Үүнд:

- цаашид ажиллах хүнээ турших, ярилцлага авах, лавлан шалгах, зөвлөгөө өгөх үйлчилгээ
- байнгын ажилтнаар авах хүнээ сонгох, элсүүлэх

Энэ үйлчилгээ нь нөөц ажиллагчид болон цаашид ажиллах хүмүүсийг ажилд зуучлах үйл ажиллагаа юм. Нэр дэвшигч нь ажиллах хүчний нөөцөөс сонгогдон ажилд орно. Байнгын ажлын байранд өөрөөр хэлбэл зөвхөн нэр дэвшигчийн хувьд ашигтай ажлын байр олдох тохиолдолд тооцоолоогүй зардал төлөх явдал байдаг. Энэ дэд ангид хамгийн доод түвшнээс удирдлагын дээд түвшинд ажиллах хүрээнд байнгын ажлын байраар хангах үйлчилгээ орох бөгөөд дотоодын болон олон улсын түвшинд гүйцэтгэгч хайх үйлчилгээ энд орохгүй.

8512 Ажиллах хүчээр хангах үйлчилгээ

Энэ ангид төрөл бүрийн гэрээ, хэлцэл хийх замаар ажиллах хүчээр хангах үйлчилгээ орно.

85121 Гэрээт ажиллах хүчээр хангах үйлчилгээ

Энэ дэд ангид ажиллах нөхцөл, хугацаа зэргийг тусгаж, үнэ өртгөө тохиролцсон гэрээ хэлэлцээрийн үндсэн дээр ажиллах хүчээр хангах үйлчилгээ орно.

85122 Түр ажиллах хүчээр хангах үйлчилгээ

Энэ дэд ангид түр ажиллагчдаар хангах үйлчилгээ орно. Түр ажиллагчдаар хангах үйлчилгээ эрхэлдэг компани нь үндсэн ажиллагсад нь түр эзгүй үед ажиллагч олж өгөх, түр ажиллагсдыг богино хугацааны буюу улирлын чанартай, эсвэл тусгайлсан үүрэг даалгавраар хангана. Ажил олгогч нь түр ажиллагчдын үйл ажиллагааны талаарх бүх асуудлыг хариуцах бөгөөд түр ажиллагсад нь ажил олгогчийн шууд удирдлагын доор ажиллана. Түр ажиллагчаар хангах энэхүү компани нь ажиллагч олж өгсний хөлс, ашиг хүртдэг.

85123 Урт хугацааны ажиллах хүчээр хангах үйлчилгээ

Энэ дэд ангид урт удаан хугацааны турш ажиллах хүчээр хангах үйлчилгээ орно. Энэ үйл ажиллагааны хувьд түнш нь ажиллах хүчээр хангах үйлчилгээ эрхэлдэг компанид хөлслөгдөж байгаа болон ажиллаж байгаа хүнийг ажлын байраар хангах буюу өөрсдийн ажиллах хүч байхгүй үед тодорхой хувийг шилжүүлэх үйл ажиллагаа эрхэлнэ. Урт хугацаагаар ажиллагчид тухайн компанийн цалингийн цэс дээр бичигдсэн байх ба өөрсдийн үйл ажиллагааг хариуцах боловч дээрх компанийнхаа хяналтан дор ажиллах юм. Энэ үйлчилгээ нь ажиллах хүчний лизинг, орон тооны багийн лизинг, ажилтны лизингийн үйлчилгээ болон extended ажиллагсад ба цалин авч буй ажиллагсдыг хамруулна. Энд Мэргэжилтэй Ажиллагсдын Холбоо (MAX)-ын үйлчилгээ орохгүй.

85124 Түр ажиллагчийг байнгын ажлын байраар хангах үйлчилгээ

Энэ дэд ангид ажлын туршилтын хугацааны эцэст байнгын ажилтай болох сонирхолтой түр ажиллагчдын бүрэлдэхүүнээр хангах үйлчилгээ орно. Түр ажиллаж байгаа хүн үндсэн ажилтан болох тушаал гарах хүртэл түр зуурын ажлаар хангах компанийн цалингийн цэсэн дээр нэр нь байна. Үндсэн ажилтан болоогүй тохиолдолд буцаж анхны түр ажлаар хангах компани дээрээ ирнэ. Энэ үйлчилгээнд сургалт, хангах компани дээрээ эргэж ирнэ. Энэ үйлчилгээнд сургалт, зөвлөгөө өгөх, дадлагажуулах, тусламж үзүүлэх болон дахин сургах үйл ажиллагаа орно.

85125 Хамтран ажиллах хүн хүчээр хангах үйлчилгээ

Энэ дэд ангид Мэргэжилтэй Ажиллагчдын Холбоо /MAX/ зэрэг байгууллагын мэргэшсэн бүлэг хүнээр хэлэлцүүлэгдэн гарч, түншийнхээ ажиллах хүчээр хангах үйлчилгээ орно. MAX болон түнш нь гэрээндээ эрх, үүргээ хэрхэн хуваарилах талаар тусгадаг. Энэхүү эрх үүргийн хуваарилалт нь түншийн зөвшөөрсөн тодорхой үйл ажиллагаан дээрээ хариуцлагаа мөн хуваана. Энэ хүрээ нь эхнээсээ дуустлаа багцын үйлчилгээг хамааруулна.

852 Шинжлэн шалгах болон аюулгүй байдлын үйлчилгээ

8521 Мөрдлөгийн үйлчилгээ

85210 Мөрдлөгийн үйлчилгээ

Энэ дэд ангид дараах үйлчилгээ орно. Үүнд:

- эрэн сурвалжлах болон мөрдлөгийн үйлчилгээ, жишээлбэл:

> гэмт хэрэг, хулгай, залилан, дэлгүүр дээрэмдэх, луйвардах, хүн сураггүй алга болох, ахуйн, болон хуулиас гадуур болон хуулийн дагуу үйл ажиллагаануудыг бүртгэхтэй холбогдсон үйлчилгээ

> дотоодын, тагнуулын нууц үйл ажиллагааг байцаах

> дэлгүүрээс хулгай хийхийн эсрэг үйлчилгээ

Харин мөрдлөгийн үйлчилгээ 85910-д орно.

8522 Аюулгүйн зөвлөгөө өгөх үйлчилгээ

85220 Аюулгүйн зөвлөгөө өгөх үйлчилгээ

Энэ дэд ангид түншлэгчийн хэрэгцээг тодорхойлох болон аюулгүйн зөвлөгөө өгөх үйлчилгээ орно.

Харин компьютерын аюулгүй ажиллагааны зөвлөгөө өгөх үйлчилгээ 83131-д орно.

8523 Аюулгүйн системийн үйлчилгээ

85230 Аюулгүйн системийн үйлчилгээ

Энэ дэд ангид шөнийн дээрэмчин орж ирэх, гал түймэр гарах үед дохиолол өгөх зорилгоор дохиоллын систем байрлуулах, хянах үйлчилгээ орно.

8524 Хуягласан машинаар үйлчлэх үйлчилгээ

85240 Хуягласан машинаар үйлчлэх үйлчилгээ

Энэ дэд ангид дараах үйлчилгээ орно. Үүнд:

- их хэмжээний мөнгө, үнэт эдлэлийн зүйлсийг авч явах, тараах тохиолдолд гаднаас халдаж болзошгүй гэж үзээд хуягласан машинаар үйлчлэх үйлчилгээ

- банкны хадгаламж, депозит үйлчилгээ

- хамгаалалтыг шилжүүлэх үйлчилгээ

8525 Харуул хамгаалалтын үйлчилгээ

85250 Харуул хамгаалалтын үйлчилгээ

Энэ дэд ангид хувь хүн болон хувийн өмч, үйлдвэрлэл, худалдааны өмч хөрөнгийг гал түймэр, хулгай, гэнэтийн халдлагаас хамгаалуулахаар хүн хөлсөлж авах үйлчилгээ орно.

- харуул, манаа, эргүүл хийх үйлчилгээ

- харуул хамгаалалт хийх үйлчилгээ

- бие хамгаалах үйлчилгээ

- сургуультай нохойгоор үйлчлэх

- машины зогсоолоор үйлчлэх

- нэвтрүүлэхэд хамгаалалт тавих үйлчилгээ

8529

Бусад төрлийн хамгаалалтын үйлчилгээ

85290

Бусад төрлийн хамгаалалтын үйлчилгээ

Энэ дэд ангид дараах үйлчилгээ орно. Үүнд:

- сургуультай ноход бэлтгэх
- илчлэх бичлэг хийх үйлчилгээ
- хурууны хээ авах үйлчилгээ

Харин компьютерын аюулгүйн үйл ажиллагааны талаарх зөвлөгөө өгөх үйлчилгээ 83131-д орно.

853 Цэвэрлэх үйлчилгээ

8531 Ариутгах, устгах үйлчилгээ

85310 Ариутгах, устгах үйлчилгээ

Энэ дэд ангид дараах үйлчилгээ орно. Үүнд:

- гэр байшин, бусад барилга байгууламжийг ариутгах
- машин тэрэг, дугуй, автобус, галт тэрэг, онгоцыг ариутгах
- шавьж хорхой, мэрэгчин, тахал устгах
- утаж ариутгах болон хор хохирлыг хянах үйлчилгээ

Харин дараах үйлчилгээ орохгүй. Үүнд:

- хөдөө аж ахуйтай холбоотой хохирлыг хянах үйлчилгээ /туулайг оруулан/ (86110-д),
 - мод бэлтгэх үйл ажиллагаа (88130-д),
- д орно).*

8532 Цонх цэвэрлэх үйлчилгээ

85320 Цонх цэвэрлэх үйлчилгээ

Энэ дэд ангид дүүжин шатыг ашиглан гадна талын цонхыг цэвэрлэх үйлчилгээг оруулан барилга байшингийн цонхыг цэвэрлэх үйлчилгээ орно.

8533 Цэвэрлэх үйлчилгээ

85330 Цэвэрлэх үйлчилгээ

Энэ дэд ангид худалдаа, засаг захиргааны болон аж үйлдвэрийн барилга, байгууламжийг бүхэлд нь цэвэрлэх үйлчилгээ орно. Үүнд:

- шал цэвэрлэх, лав түрхэх
- дотор ханыг угаах
- мебель өнгөлөх
- хашаа цэвэрлэх гэх мэт бусад үйлчилгээ

Харин цонх цэвэрлэх үйлчилгээ орохгүй. (85320-д орно).

8534 Цэвэрлэгээний төрөлжсөн үйлчилгээ

85340 Цэвэрлэгээний төрөлжсөн үйлчилгээ

Энэ дэд ангид дараах үйлчилгээ орно. Үүнд:

- компьютерын болон бусад тоноглол бүхий өрөөг цэвэрлэх
- аж үйлдвэрийн, тээврийн тоног төхөөрөмжийн эд анги, том багтаамж бүхий савуудыг тусгайлан цэвэрлэх
- үйл ажиллагаа явуулдаг гол өрөөнүүдийг ариутгах
- зуух, пийшин, яндан, камин зуух цэвэрлэх
- барилгын гадна талын ханыг цэвэрлэх
- ширмэн зуух, цахилгаан зуух, шатаах зуух, буцалгагч, агааржуулалтын хоолой цэвэрлэх
- тээврийн хэрэгсэл цэвэрлэх

Харин дараах үйлчилгээ орохгүй. Үүнд:

- халаалтын системийг угсрах үйлчилгээ (54631-д),
- барилгын ажил дууссаны дараа барилгын гадна хэсгийг цэвэрлэх (54790-д),
- хөдөө аж ахуйн зориулалттай байр, хашаа хороо цэвэрлэх үйлчилгээ, /мал, тахиа, гахайны байр гэх мэт/ (86121-д),
- хивс, бүрээс, нэхмэл материал, хананд өлгөх эдлэл цэвэрлэх үйлчилгээ (97130-д орно).

854 Сав, баглаа боодлын үйлчилгээ

8540 Сав, баглаа боодлын үйлчилгээ

85400 Сав, баглаа боодлын үйлчилгээ

Энэ дэд ангид дараах үйлчилгээ орно. Үүнд:

- хүнсний бүтээгдэхүүн, эмийн, гэр ахуйн цэвэрлэгээ, ариун цэврийн өрөө цэвэрлэх, автомат хэрэглэлийг хэрэглэх заавар, шүд ломбодох, болон бусад бараа үйлчилгээнд хэрэглэдэг бараа материалын сав, баглаа, боодлын үйлчилгээ
- билэг, дурсгалын баглаа, боодол
- алт, мөнгөний баглаа, боодол

Харин дараах үйлчилгээг орохгүй. Үүнд:

- *тээвэрлэлэхэд зориулан, бараа бүтээгдэхүүн савлах үйлчилгээ (64-67-д),*
- *баглаа боодлын загварын үйлчилгээ (83919-д),*
- *баглаа боодол дээрх зөвхөн үйлдвэрлэлийн талын мэдээлэл (89121-д),*
- *өөр үйлдвэрийн бүтээгдэхүүнийг түнш, хэрэглэгчдэд зориулан баглаа, боодол хийх үйлчилгээ (88, 89-р бүлэгт орно).*

855 Аяллын зохион байгуулалт, аялал жуулчлалын үйлчилгээ

8551 Тээврийн захиалгат үйлчилгээ

Энэ дэд ангид дараах үйлчилгээ орно. Үүнд:

- тээвэрлэлтийн, байршуулах байр, тэдгээртэй холбоотой үйлчилгээ, үйлчлүүлэгчдийн хэрэгцээ, шаардлагыг бий болгох, сонголт хийхэд нь зөвлөгөө өгөх
- тээвэрлэж байгаа бараа, бүтээгдэхүүнийг байрлуулах, хадгалахтай холбоотой үйлчилгээ

85511 Агаарын тээврийн суудал захиалгын үйлчилгээ

Энэ дэд ангид дотоодын болон олон улсын агаарын тээврийн тасалбар, суудал захиалах үйлчилгээ орно.

85512 Төмөр замын тээврийн тасалбар захиалах үйлчилгээ

Энэ дэд ангид төмөр замын тээврийн тасалбар суудал захиалах үйлчилгээ орно.

85513 Автобус тээврийн тасалбар захиалах үйлчилгээ

Энэ дэд ангид автобус тээврийн тасалбар, суудал захиалах үйлчилгээ үйлчилгээ орно.

85514 Тээврийн хэрэгслийн түрээсийн үйлчилгээ

Энэ дэд ангид түрээсийн машин захиалах үйлчилгээ орно.

85519 Бусад төрлийн тээвэрлэлтийн хадгалалт, зохион байгуулалтын үйлчилгээ

Энэ дэд ангид дараах үйлчилгээ орно. Үүнд:

- гаталгаа онгоцны тээврийн тасалбар, суудал захиалах үйлчилгээ
- бусад тээврийн тасалбар, суудал захиалах үйлчилгээ

8552 Байр сууц, аялал зугаалгын захиалгат үйлчилгээ

85521 Байр сууцны захиалгат үйлчилгээ

Энэ дэд ангид дотоод болон гадаад байрны үйлчилгээний захиалга хийх үйлчилгээ орно.

85522 Орон байрыг хэсэг хугацаагаар солилцох үйлчилгээ

Энэ дэд ангид орон байрны түр хугацааны захиалга, солилцооны үйлчилгээ орно.

85523 Аяллын захиалгат үйлчилгээ

Энэ дэд ангид аяллын захиалгыг зохион байгуулах үйлчилгээ орно. Үүнд:

- нэг болон цөөн өдрүүдийн аялал
- олон өдрүүдийн аялал

85524 Аялалтай холбоотой захиалгат үйлчилгээ

Энэ дэд ангид аяллын захиалгыг зохион байгуулах үйлчигээ орно. Үүнд:

- дотоодын аяллын багц
- гадаадын аяллын багц

8553 Бусад төрлийн захиалгат үйлчилгээ

85539 Бусад төрлийн зугаа цэнгэл, танилцуулга, үйл ажиллагааны тасалбар болон захиалгат үйлчилгээ

Энэ дэд ангид спорт, театр, концертийн зэрэг үйлчигээнүүдийн захиалга зохион байгуулах үйлчилгээ орно.

8554 Аяллын операторын үйлчилгээ

85540 Аяллын операторын үйлчилгээ

Энэ дэд ангид аялалыг сурталчилж, зохион байгуулах багц үйлчилгээ орно. Үүнд:

- дотоодын болон олон улсын аяллын багц тойрон аялал
- зарим бүлэг, дотоод болон олон улсын аяллыг бүлгээр зохион байгуулах үйлчилгээ

8555 Аяллын хөтчийн үйлчилгээ

85550 Аяллын хөтчийн үйлчилгээ

Энэ дэд ангид жуулчдад зориулсан хөтчийн үйлчилгээ орно.

8556 Жуулчдын урамшуулал, жуулчдыг мэдээллээр хангах үйлчилгээ

85561 Жуулчдад урамшуулал олгох үйлчилгээ

Энэ дэд ангид улсууд, бүс нутаг, орон нутгийхны жуулчлалын сурталчилгааны үйлчилгээ орно.

85562 Жуулчдыг мэдээллээр хангах үйлчилгээ

Энэ дэд ангид явах замын маршрут, танилцуулах товхимол, эсвэл мэдээллээр хангах зэрэг үйлчилгээ орно.

859 Бусад төрлийн туслах үйлчилгээ

8591 Зээлийн товчооны үйлчилгээ

85910 Зээлийн товчооны үйлчилгээ

Энэ дэд ангид дараах үйлчилгээ орно. Үүнд:

- хувь хүнд хувийн болон бизнесийн зээл олгох үйлчилгээ
- зээлийн өргөдөл, өргөдөл гаргагчийн санхүүгийн байдлын үнэлгээ ба зээлийн үнэлгээ
- зээлийн шинжилгээ, судалгааны үйлчигээ

8592 Мэдээлэл цуглуулах үйлчилгээ

85920 Мэдээлэл цуглуулах үйлчилгээ

Энэ дэд ангид дараах үйлчилгээ орно. Үүнд:

- мөнгө шилжүүлэх болон мэдээлэл тайлан, гэрээ, баримт бичиг цуглуулан бүрдүүлэх албадын үйлчилгээ
- буруу данс бүртгэлийг сэргээн засах, байнгын тайланг цуглуулах
- хугацаа нь дууссан дансыг болон өр зээлийг дахин сэргээх, шийдвэрлэх

8593 Утсанд суурилсан туслах үйлчилгээ

85931 Дуудлагын төвийн үйлчилгээ

Энэ дэд ангид дараах үйлчилгээ орно. Үүнд:

- хэрэглэгчдэд зориулж утасны жагсаалт гаргах
- утсанд суурилсан мэдээ өгөх, туслах үйлчилгээ
- утсанд суурилсан бараа борлуулах үйлчилгээ

85939 Утсанд суурилсан бусад төрлийн туслах үйлчилгээ

Энэ дэд ангид утасны хариулах алба, утасны урамшуулах үйлчилгээ орно.

8594 Удирдлагын нэгдсэн үйлчилгээ

85940 Удирдлагын нэгдсэн үйлчилгээ

Энэ дэд ангид захиргааны үйл ажиллагаатай холбоотой үйлчилгээ, угтах үйлчилгээ/ресепшн/, санхүүгийн төлөвлөгч, бичиг баримтын жагсаалт гаргах, хувийн цахилгаан шуудан зэрэг үйлчилгээтэй холбоотой үйлчилгээ орно.

8595 Албан газрын үйл ажиллагааг дэмжсэн туслах үйлчилгээ

85951 Хувилах үйлчилгээ

Энэ дэд ангид бүх төрлийн хэвлэх болон бичиг баримт олшруулах үйлчилгээ орно.

85952 Албан газрын шуудангийн жагсаалтыг бэлтгэх, шуудангийн үйлчилгээ

Энэ дэд ангид нэр, хаягийн жагсаалт эмхлэн бэлтгэх үйлчилгээ, илгээх бичиг баримт бэлтгэхтэй холбоотой үйлчилгээ /зарлагдсан материал, мэдээллийн материал, болон бусад материал/-г оруулна.

Харин дараах үйлчилгээ орохгүй. Үүнд:

- зарлага элчийн үйлчилгээ (68120-д),
- баримт, мэдээллийг цуглуулах үйлчилгээ (83990-д орно).

85953 Бичиг баримт бэлтгэх болон бусад төрлийн туслах үйлчилгээ

Энэ дэд ангид дараах үйлчилгээ орно. Үүнд:

- бичиг баримт бэлтгэх
- бичиг баримт засварлах
- бичиг баримт боловсруулах, хэвлэлтэнд бэлтгэх, болон туслах чанартай үйлчилгээ
- нарийн бичгийн даргын туслах үйлчилгээ
- бичиг баримтыг хуулан бичих болон нарийн бичгийн даргын бусад үйлчилгээ
- захиа эсвэл хураангуйг дахин бичих
- шуудангийн хайрцгийн түрээсийн үйлчилгээ
- мэдээллийг боловсруулах үйлчилгээ
- бусад баримтыг хэвлэх болон хувилах үйлчилгээ /жишээлбэл, хаяг, тайлан хэвлэх, түргэн хэвлэх, дижитал хэвлэлд бэлтгэх үйлчилгээ/

Харин дараах үйлчилгээ орохгүй. Үүнд:

- илтгэл мэдээллийн ерөнхий хэлбэрийг нь бэлтгэх үйлчилгээ (85999-д),
- стенографикийн үйлчилгээ (85999-д орно).

8596 Хурал, цуглаан, худалдааны үзүүлэх тоглолт зохион байгуулахад туслах үйлчилгээ

85961 Хурал, цуглаан зохион байгуулах, түүнд туслах үйлчилгээ

Энэ дэд ангид тохиролцоо, хэлэлцээрийн удирдлага, хурлын зохион байгуулалт, түүнд туслах үйлчилгээ орно.

85962 Үзүүлбэр, шоуны зохион байгуулалтын туслах үйлчилгээ

Энэ дэд ангид яармаг худалдаа, үзэсгэлэн худалдааны зохион байгуулалт, түүнд холбогдох менежментийн туслах үйлчилгээ орно.

8597 Газрын гадаргын арчилгаа, үйлчилгээ

85970 Газрын гадаргын арчилгаа, үйлчилгээ

Энэ дэд ангид цэцэрлэгт хүрээлэн болон задгай талбайтай цэцэрлэгийн засвар орно.

- амины болон нийтийн орон сууцны цэцэрлэгт хүрээлэн
- олон нийтийн зориулалттай барилгын /сургууль, эмнэлэг, захиргааны байшин, сүмийн байшин/ гаднах цэцэрлэгт хүрээлэн
- хотын захиргааны барилгын /цэцэрлэг, ногоон зүлэгт ширэг, оршуулгын газар зэрэг/ гаднах цэцэрлэгт хүрээлэн
- замын хажуу талын өвс ургамал /төмөр зам, агаарын замын, усан зам, далайн боомт зэрэг/
- үйлдвэрийн болон худалдааны байшин, барилгын гаднах цэцэрлэгт хүрээлэн
- өвс, ургамлыг арчлах, засах үйлчилгээ
- байшин доторх цэцэрлэг болон гадаах өвс ургамлууд

- чөлөөт цаг өнгөрөөх болон тоглоомын газар /гольфын талбай, наран шарлагын зүлэг, тоглоомын газар, спортын тоглоомын бусад талбай/-ын ногоон ургамал
- байнгын ба урсгал ус /бассейн, усан сан, цөөрөм, суваг, гол, горхи, урсгал усны бусад тогтоц/
- дуу чимээ, элэгдэл, салхи, нүд гялбахаас сэргийлэх ургамал

8599 Бусад төрлийн туслах үйлчилгээ

85991 Мэдээллийн бусад төрлийн туслах үйлчилгээ

Энэ дэд ангид дараах үйлчилгээ орно. Үүнд:

- утсанд суурилсан туслах үйлчилгээ
- мэдээлэл хайх үйлчилгээ
- мэдээ, сонингийн хайчилбарын үйлчилгээ

Харин утасны төвийн дуудлагын үйлчилгээ 85931-д орно.

85999 Бусад төрлийн туслах үйлчилгээ

Энэ дэд ангид дараах үйлчилгээ орно. Үүнд:

- үл хөдлөх болон бусад хөрөнгийн үнэлгээ, брокерийн үйлчилгээ
- брокер ба зуучлалын бизнесийн үйлчилгээ
- үл хөдлөх хөрөнгийн даатгал, инжнерийн туслах, зөвлөгөө өгөх үйлчилгээ (урлагийн мэргэжлийн зөвлөгөө өгөх, хуулийн мэргэжлийн зөвлөгөө өгөх зэрэг үйлчилгээ энэ орно).
- үзүүлбэр, театрчилсан тоглолт, чөлөөт цагт зориулсан бусад үйлчилгээ, спортын сонирхол татсан үйл ажиллагааны уулзалтанд хувийн бие төлөөлөгч, салбараар үйлчлэх үйлчилгээ
- захиалга авах болон тараах үйлчилгээ
- хөдөлгөөнт зураг, телевиз болон бусад театрчилсан үзүүлбэрийн үйлчилгээ
- зохиогчийн эрх ба тэдний бизнесийн орлогыг өсгөх менежментийн үйл ажиллагаа /киноноос гадна/
- үйлдвэрлэлийн хөрөнгийг зөв зохицуулах менежментийн үйлчилгээ /патент, лиценз, худалдааны марк, франчайз/
- үнэ хаялцуулах үйлчилгээтэй холбоотой хуулийн бусад дэгтэй холбоотой үйлчилгээ
- ус, хий, цахилгааныг хэмжих үйлчилгээ
- мэдээ бэлтгэх үйлчилгээ
- мэргэжлийн таталган бичих үйлчилгээ
- хэвлэлийн таталган бичих үйлчилгээ

Харин дараах үйлчилгээ орохгүй. Үүнд:

- худалдааны хямдрал ба урамшуулалтай холбоотой үйлчилгээ (836-д),
- жүжигчилсэн тоглолтын менежментийн үйлчилгээ (96140-д),
- урлагийн байгууллагын удирдлагын үйлчилгээ (96290-д),
- спортын арга хэмжээг зохион байгуулах үйлчилгээ (9651-д орно).

86 ХӨДӨӨ АЖ АХУЙ, АН АГНУУР, ОЙН АЖ АХУЙ, ЗАГАС БАРИЛТ, УУЛ УУРХАЙН ТУСЛАХ ҮЙЛЧИЛГЭЭ

861 Хөдөө аж ахуйн, ан агнуур, ойн аж ахуйн, загас барилтын туслах үйлчилгээ

8611 Газар тариалангийн туслах үйлчилгээ

86111 Ургац хураалтын дуусгах шатны үйлчилгээ

Энэ дэд ангид дараах үйлчилгээ орно. Үүнд:

- үр тариаг анхдагч зах зээлд бэлтгэх үйлчилгээ
- хөвөн боловсруулах үйлчилгээ

86112 Үр тариа боловсруулах үйлчилгээ

Үр тарианы ургалтыг сайжруулах /генетикийн хувьд сайжруулсан үр тариа орно/ үйлчилгээ орно.

Үүнд:

- үр тарианаас хог хаягдал, дутуу ургасан үр тариа, хортон шавьжинд идэгдсэн үр тариаг ялгах
- үр тариаг хуурай, чийггүй агуулахад хадгалах
- худалдаалагдах үр тариаг хатаах, цэвэрлэх, сортлох, боловсруулах үйлчилгээ

86119 Газар тариалангийн бусад туслах үйлчилгээ

Энэ дэд ангид дараах үйлчилгээ орно. Үүнд:

- талбай бэлтгэх
- үр суулгах
- хөрс бордох
- газар тариалангийн талбайн хортон шавьж устгах
- усан үзэм, жимсний мод тариалах
- ургацаа шилжүүлэх ба суулгах
- тариалах баг гаргах
- механикжсан баг бэлтгэх
- ургац ургуулах үйлчилгээ
 - > ургац ургахад бэлтгэх
 - > хогийн ургамал цэвэрлэх үйлчилгээ
- хөдөө аж ахуйн үйлчигээний бусад шаардлагатай үйлчилгээ

Харин дараах үйлчилгээ орохгүй. Үүнд:

- хөдөө аж ахуйн эдийн засаг, агрономын үйлчилгээ (83115-д),
- бусад хортонг хянах үйлчилгээ (85310-д),
- усжуулах үйлчилгээ (86330-д орно).

8612 Мал аж ахуйн үйлчилгээ

86121 Фермерийн мал аж ахуйн туслах үйлчилгээ

Энэ дэд ангид дараах үйлчилгээ орно. Үүнд:

- хонь хяргах, бэлчээрийн менежмент зэрэг фермийн мал аж ахуйн бусад үйлчилгээ
- хиймлээр хээлтүүлэх үйлчилгээ
- өндөг ангилах үйлчилгээ
- ХАА-н фермийн цэвэрлэгээ /мал, тахиа, гахай, байр цэвэрлэх гэх мэт/

Харин дараах үйлчилгээ орохгүй. Үүнд:

- хөдөө аж ахуйн эдийн засаг ба агрономын үйлчилгээ (83115- д),
- мал, амьтан эмчлэх үйлчилгээ (83520-д),
- чөлөөт цагаараа мориор аялах үйлчилгээ (96520-д орно).

86129 Мал аж ахуйн бусад төрлийн үйлчилгээ

Энэ дэд ангид дараах үйлчилгээ орно. Үүнд:

- гэрийн тэжээвэр амьтдын байраар (нохойн үүр) хангах
- гэрийн тэжээвэр амьтдын арьс үс цэвэрлэх үйлчилгээ

Харин дараах үйлчилгээ орохгүй. Үүнд:

- хамгаалалтын нохой сургах (85290-д),
- гэрийн тэжээвэр амьтан сургах (97990-д),
- спорт, үзвэрийн амьтан сургах (96620-д орно).

8613 Ан агнуурын туслах үйлчилгээ

86130 Ан агнуурын туслах үйлчилгээ

Энэ дэд ангид зэрлэг амьтан агнуурын туслах үйлчилгээ орно.

8614 Ойн аж ахуйн мод бэлтгэлийн туслах үйлчилгээ

86140 Ойн аж ахуйн мод бэлтгэлийн туслах үйлчилгээ

Энэ дэд ангид дараах үйлчилгээ орно. Үүнд:

- ойн мод хамгаалах үйлчилгээ
- мод үржүүлэх, гал түймрээс хамгаалахтай холбоотой үйлчилгээ
- ой мод огтлох, тайрах, тээвэрлэлтэнд бэлтгэх, тайрдас, гуалин бэлтгэх үйлчилгээ

Харин орчны тохижилттой холбогдох мод, бут сөөгийг тайрах, сийрэгжүүлэх, үр суулгах үйлчилгээ 85970-д орно.

8615 Загас агнуурын туслах үйлчилгээ

86150 Загас агнуурын туслах үйлчилгээ

Энэ дэд ангид загасны ферм, загас үржүүлэх, загас барихтай холбогдох туслах үйлчилгээ орно.

- 862** Уул уурхайн туслах үйлчилгээ
8621 Уул уурхайн туслах үйлчилгээ
86211 Газрын тос гаргахад туслах үйлчилгээ

Энэ дэд ангид дараах үйлчилгээ орно. Үүнд:

- газрын тос, хий гаргахад туслах, газраа тэслэх, засах, өрөмдөх, тэгшлэхтэй холбоотой үйлчилгээ
- газрын тос, хий олборлоход зайлшгүй шаардлагатай шахуурга, цорго, худаг ухахтай холбоотой үйлчилгээ
- мэргэжлийн гал унтраах ангийн үйлчилгээ

Харин газрын тос, газрын шинжилгээ, судалгааны үйлчилгээ 83411-д орно.

86219 Уурхайн бусад төрлийн үйл ажиллагааны туслах үйлчилгээ

Энэ дэд ангид дараах үйлчилгээг оруулна:

- уурхайг хатаах, шахуургадах
- газрын тосны болон байгалийн хийн олборлолтоос бусад уул уурхайн салбарын олборлолтонд шаардагдах хоолой гаргах, саад арилгах, уурхайн талбарын бусад бэлтгэл, боловсруулалт
- газрын тосны болон байгалийн хийн олборлолтоос бусад уул уурхайн үйл ажиллагаатай холбоотой туршилтын өрөмдлөгийн үйлчилгээ

Энэ дэд ангид дараах үйлчилгээг оруулахгүй:

- эрдэс баялгийн хайгуул, үнэлгээний үйлчилгээ, 83411-ийг үзнэ үү
- геофизикийн үйлчилгээ, 83412-ийг үзнэ үү.

- 863** Цахилгаан, хий, ус түгээх үйл ажиллагааны туслах үйлчилгээ
8631 Төвлөрсөн цахилгаан дамжуулах, түгээхтэй холбоотой туслах үйлчилгээ
86311 Гэрээ, төлбөрт үндэслэсэн төвийн цахилгаан дамжуулах үйлчилгээ

Энэ дэд ангид цахилгаан дамжуулах, түүний өртгийг тооцох үйлчилгээ орохгүй, харин 69111-д орно.

86312 Төвийн цахилгаан түгээх үйлчилгээ (гэрээ төлбөрт үндэслэсэн)

Энэ дэд ангид цахилгаан тархаах, түүний өртгийг тооцох үйлчилгээ орохгүй, харин 69112-д орно.

- 8632** Төвийн хий түгээхтэй холбоотой туслах үйлчилгээ (гэрээнд үндэслэсэн)
86320 Төвийн хий түгээхтэй холбоотой туслах үйлчилгээ (гэрээнд үндэслэсэн)

Энэ дэд ангид хий түгээлттэй холбоотой бүх үйлчилгээний данс тооцооны үйл ажиллагаа орохгүй, харин 69120-д орно.

- 8633** Ус хуваарилалтын үндсэн үйлчилгээ (энд хөлс болон гэрээгээрх үйлчилгээ)
86330 Ус хуваарилалтын үндсэн үйлчилгээ (энд хөлс болон гэрээгээрх үйлчилгээ)

Энэ дэд ангид дараах үйлчилгээ орохгүй. Үүнд:

- өөрийн хөрөнгөөрх ус хуваарилалтын үндсэн үйлчилгээнүүд (69210-д),
- газар тариаланд зориулсан усжуулалтын системийн ажил (86110-д орно).

8634 Ууршуулалтын хуваарилалтын үйлчилгээ, халуун ус болон агааржуулалтын хангамжийн үндсэн үйлчилгээ (энд хөлс болон гэрээгээрх үйлчилгээ)

86340 Ууршуулалтын хуваарилалтын үйлчилгээ, халуун ус болон агааржуулалтын хангамжийн үндсэн үйлчилгээ (энд хөлс болон гэрээгээрх үйлчилгээ)

Энэ дэд ангид өөрийн хөрөнгөөрх ууршуулалтын хуваарилалтын, халуун ус болон агааржуулалтын хангамжийн үндсэн үйлчилгээ орохгүй, харин 69220-д орно.

- 8635** Сүлжээнээс бусад төрлийн ус хуваарилах үйлчилгээ (энд хөлс болон гэрээгээрх үйлчилгээ орно)
86350 Сүлжээнээс бусад төрлийн ус хуваарилах үйлчилгээ (энд хөлс болон гэрээгээрх үйлчилгээ орно)

Энэ дэд ангид сүлжээнээс бусад ус хуваарилах үйлчилгээ, тухайлбал усны машинаар түгээх үйлчилгээ орно.

Харин дараах үйлчилгээ орохгүй. Үүнд:

- том машинаар ус тээвэрлэлт (65119-д),
- том машинаар ус түгээлтийн үйлчилгээнүүд, /өөрийн хөрөнгөөр/ (69230-д),
- газар тариаланд зориулсан усжуулалтын системийн ажил (86110-д орно).

87 АШИГЛАЛТ, ЗАСВАРЛАЛТ БОЛОН УГСРАЛТЫН ҮЙЛЧИЛГЭЭ (БАРИЛГА УГСРАЛТ ОРОХГҮЙ)

871 Металл бүтээгдэхүүний үйлдвэрийн машин, тоног төхөөрөмжийн ашиглалт болон засвар, үйлчилгээ

8711 Металл бүтээгдэхүүний үйлдвэрийн машин, тоног төхөөрөмжийн ашиглалт болон засвар, үйлчилгээ

87110 Металл бүтээгдэхүүний үйлдвэрийн машин, тоног төхөөрөмжийн ашиглалт болон засвар, үйлчилгээ

Энэ дэд ангид дараах төхөөрөмжийн засвар, ашиглалтын үйлчилгээ орно. Үүнд:

- > үйлдвэрийн уурын тогоо
- > уурын генератор үүсгүүр
- > уурын генераторын туслах төхөөрөмж
- > шахагч, хэмнэгч, халаагуур, уур цуглуулагч, зай хураагуур
- > цөмийн тогоо (зөвхөн уурын тогоо), уурын генератор, бойлерын тоног төхөөрөмж болон үйлдвэрийн төрөл бүрийн дамжуулах хоолойн систем
- > худалдааны картууд, материал боловсруулалтын тоног төхөөрөмж
- металл цистерн, нөөцлүүр, чингэлэг
- усан онгоцны бортогони гангийн засвар
- гар гагнуурын засварын ажил

Харин дараах үйлчилгээ орохгүй. Үүнд:

- нэг эсвэл хоёр сууцны байшингийн доторх бойлер, хийн системийн ажиллагаа, засвар үйлчилгээ (54631-д),
- хими цэвэрлэгээний үйлчилгээ (85340-д орно).

8712 Бичиг хэргийн болон тооцооны машины засвар, үйлчилгээ

87120 Бичиг хэргийн болон тооцооны машины засвар, үйлчилгээ

Энэ дэд ангид хуулбарлах машин, тооцооллын машин, бичгийн машин зэрэг бичиг хэргийн хэрэгсэл болон тооцоолох машин, түүний тоног хэрэгслийн ашиглалт, засвар, үйлчилгээ орно.

Харин цахилгаан утастай холбоотой ажил үйлчилгээ 54611-д орно.

8713 Компьютер болон түүний дагалдах, хэрэгслийн засвар үйлчилгээ

87130 Компьютер болон түүний дагалдах, хэрэгслийн засвар үйлчилгээ

Энэ дэд ангид компьютер болон тооцоолох машин, түүний холбогдох тоног төхөөрөмжийн ашиглалт болон засвар үйлчилгээ орно. Үүнд:

- ширээний компьютер
- зөөврийн компьютерууд
- гар компьютер
- компьютерын сүүлийн үеийн хэрэглэл
- соронзон диск, флаш болон бусад хадгалах байгууламжийн тоног төхөөрөмж
- санах ойн төхөөрөмж (CD-RW, CD-ROM, DVD-ROM, DVD-RW)
- хэвлэх машин
- дэлгэц
- гар
- компьютерын гадаад, дотоод төхөөрөмж
- сканер, түүний эд анги
- смарт карт уншигч

8714 Тээврийн хэрэгслийн машин, тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээ

87141 Моторт машины ашиглалт, засвар, үйлчилгээ

Энэ дэд ангид дараах үйлчилгээ орно. Үүнд:

- моторт машинуудын ашиглалт, засвар, моторын үзлэг, цэнэглэгээ, карбюратор, тохируулга, тоормозны засвар болон тохируулга, хүйтний системийн засвар, тохируулгын ажил
- моторт машины цахилгаан системийн засвар, зай цэнэглэх үйлчилгээ
- дотоод хоолойн засвар, үйлчилгээ
- замын аюулгүй байдлын үйлчилгээ

Харин дараах үйлчилгэээ орохгүй. Үүнд:

- дугуй бүрэх, дахин засварлах, нөхөх үйлчилгээ (36120-д),
- дугуйн жижиглэн худалдааны үйлчилгээ (62281-д),
- автомашины техникийн үзлэгийн үйлчилгээ (83444-т орно).

87142 Мотоцикл, моторт чарганы ашиглалтын засвар, үйлчилгээ

Энэ дэд ангид дараах үйлчилгээ орно. Үүнд:

- моторт чарганы ашиглалт, засвар үйлчилгээ болон гадар засварлах үйлчилгээ
- моторт чарганы эвдрэлд зориулсан тусгай үйлчилгээ

87143 Чиргүүл болон хагас чиргүүл, бусад төрлийн моторт техникүүдийн ашиглалт, засвар, үйлчилгээ

Энэ дэд ангид дараах эд зүйлийг оруулна:

- ачааны болон хагас ачааны машин, аяллын автомашин, өөрөө явагч гэр зэрэг бусад газар ангилагдаагүй бусад тээврийн хэрэгслийн засвар үйлчилгээ
 - согогтой хэсгийг засах, их биеийг нь засварлах
 - хуваарьт болон үйлдвэрийн заасан, урьдчилан сэргийлэх үзлэг засвар, аялалын машин, өөрөө явагч гэрийн сууцны хэсгийн засвар үйлчилгээ
- Энэхүү засвар үйлчилгээний төлбөрийг засуулж буй эд зүйлийн эзэмшигч нь төлөх буюу баталгаат засварын дагуу засварлаж байж болно. Энэхүү үйлчилгээнд засварт орсон сэлбэг, хэрэгсэл, хөдөлмөр орсон байж болно.

87149 Бусад төрлийн тээврийн тоног төхөөрөмжийн ашиглалт болон засвар, үйлчилгээ

Энэ дэд ангид дараах үйлчилгээ орно. Үүнд:

- зорчигчийн хөвөгч давцан болон усан онгоц түүний бүтэц
- спорт болон зугаа цэнгэлийн завь
- төмөр зам болон трамвайн зүтгүүр

Харин агаарын тээврийн үйлчилгээ, засвар ашиглалтын үйлчилгээ 67610-д орно.

8715 Машин, тоног төхөөрөмжийн ашиглалт, засвар, үйлчилгээ

87151 Гэр ахуйн цахилгаан тоног төхөөрөмжийн засвар, үйлчилгээ

Энэ дэд ангид дараах үйлчилгээ орно. Үүнд:

- гэр ахуйн цахилгаан тоног төхөөрөмжийн засвар, үйлчилгээ, тухайлбал хөргөгч, аяга таваг угаагч, гэр ахуйн нөхцөлд тохирсон угаалгын машин болон хатаагч, гал зуухны цахилгаан хэрэгсэл
- гэрийн болон цэцэрлэгийн тоног төхөөрөмжийн засвар, үйлчилгээ

Харин телевиз, радио хүлээн авагч, CD тоглуулагч гэх мэт зүйлсийн ашиглалт, засвар, үйлчилгээ 87155-д орно.

87152 Электрон болон багаж хэрэгслийн засвар, үйлчилгээ

Энэ дэд ангид дараах үйлчилгээ орно. Үүнд:

- цахилгаан моторын /генератор, трансформатор/ ашиглалт, засвар, дахин сэргээх үйлчилгээ
- цахилгааны хуваарилалт болон удирдлагын аппаратын ашиглалт, засвар, үйлчилгээ
- бусад төрлийн цахилгаан тоног төхөөрөмжийн ашиглалт, засвар үйлчилгээ

87153 Теле холбооны тоног төхөөрөмж болон багаж хэрэгслийн засвар, үйлчилгээ

Энэ дэд ангид дараах үйлчилгээ орно. Үүнд:

- телевиз болон радио хүлээн авагчийн ашиглалт болон засвар, үйлчилгээ
- утас, гар утас болон факсийн машины ашиглалт, засварлалтын үйлчилгээ

87154 Эмчилгээ, нарийн хэмжүүр, хараа зүйн багаж хэрэгслийн засвар, үйлчилгээ

Энэ дэд ангид дараах үйлчилгээ орно. Үүнд:

- цахилгаан эмчилгээ, заслын тоног төхөөрөмжийн соронзон оронгийн тоног төхөөрөмжийн засвар, үйлчилгээ
- эмчилгээний хэт/ультра туяаны төхөөрөмж, зүрхний бичлэгийн төхөөрөмжийн засвар, үйлчилгээ
- мэргэжлийн зураг авалтын болон үндсэн тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээ

87155 Хэрэглэгчийн электрон барааны ашиглалт, засварлалтын үйлчилгээ

Энэ дэд ангид дараах үйлчилгээ орно. Үүнд:

Энэ дэд ангид гэр ахуйн зориулалттай цахилгаан барааны засвар үйлчилгээ орно. Үүнд:

- телевиз, радио хүлээн авагч
- видео, кассет уншигч
- CD тоглуулагч
- гэр ахуйн зориулалттай видео камер

Харин гэр ахуйн цахилгаан тоног төхөөрөмжийн засвар, үйлчилгээ 87155-д орно.

87156 Машин, түүний эд ангийн ашиглалт, засвар, үйлчилгээ

Энэ дэд ангид тоног төхөөрөмжийн засвар, үйлчилгээ орно. Үүнд:

- мотор болон хөдөлгүүр
- цорго, гоожуур
- хавхлаг, таг
- пийшин, шатаагч пийшин
- өргөгч болон түүний гар төхөөрөмж
- гадаад агааржуулалтын төхөөрөмж
- ерөнхий хэрэглээний төхөөрөмжүүд
- тоног төхөөрөмжийн машин
- төмөрлөг боловсруулах үйлдэрийн машин
- хайгуул, хайрга үйлдвэрлэх газар болон барилгын машин
- хоол, унд болон тамхи үйлдвэрлэлтийн машин
- цаас болон цаасны самбарын машин
- зэвсэг болон зэвсэгний үйл ажиллагаа
- лифт, лифтний тоног төхөөрөмж, цахилгаан шат болон хөдөлгөөнт явган зам
- газар тариалан, ойн болон цэцэрлэгийн трактор, зүлэг хадагч

Харин дотоод буцалгагч болон шатаагчуудын ашиглалт, засвар, үйлчилгээ 54631-д орно.

87159 Бусад төрлийн тоног төхөөрөмжний ашиглалт болон завсарлалтын үйлчилгээ

Энэ дэд ангид дараах үйлчилгээ орно. Үүнд:

- загасны торны засвар
- бордоо болон химийн хуримтлалын цуглуулалтын төхөөрөмжийн засвар
- орган болон бусад төрлийн үндэсний хөгжмийн багаж зэмсгийн дахин сэргээх үйлчилгээ
- модон ор, хөлөг онгоц, торхыг нөхөн сэргээх, засвар, үйлчилгээ
- автомат тоглоомын машины засвар
- хөгжмийн зэмсгийн засвар, үйлчилгээ

872 Бусад төрлийн барааны засвар, үйлчилгээ

8721 Гутал ба арьс, савхин барааны засвар, үйлчилгээ

87210 Гутал ба арьс, савхин барааны засвар, үйлчилгээ

Энэ дэд ангид ачааны, гар цүнх, гутлын мэргэжлийн засвар, үйлчилгээ орно.

8722 Бугуйн цаг, ширээний цаг ба үнэт эдлэлийн засвар, үйлчилгээ
87220 Бугуйн цаг, ширээний цаг ба үнэт эдлэлийн засвар, үйлчилгээ

Энэ дэд ангид бугуйн цаг ба үнэт эдлэлийн засвар, үйлчилгээ орно.

8723 Хувцас ба гар үйлдвэрлэлийн нэхмэл эдлэлийн засварын үйлчилгээ
87230 Хувцас ба гар үйлдвэрлэлийн нэхмэл эдлэлийн засварын үйлчилгээ

Энэ дэд ангид хэрэглэсэн нэхмэл хувцасны нөхөн сэргэлт эсвэл сэргээн засварлах үйлчилгээ орно.

8724 Тавилга эдлэлийн засварын үйлчилгээ
87240 Тавилга эдлэлийн засварын үйлчилгээ

Энэ дэд ангид гэрийн тавилга ба тавиурын сэргээн засварлах, гадарлах, засварлах үйлчилгээ орно.

8729 Бусад төрлийн барааны засвар, үйлчилгээ
87290 Бусад төрлийн барааны засвар, үйлчилгээ

Энэ дэд ангид дараах үйлчилгээ орно. Үүнд:

- унадаг дугуйны засвар, үйлчилгээ
- гэр ахуйн барааны засвар, үйлчилгээ
- тоног төхөөрөмжийн засвар, үйлчилгээ
- техникийн үйлчилгээ ба хөгжмийн зэмсгийн засвар, үйлчилгээ
- төгөлдөр хуур ба хөгжмийн бусад зэмсгийг хөглөх үйлчилгээ
- зуслангийн болон спортын ангиллын бүтээгдэхүүний засвар, үйлчилгээ
- зургийн аппарат, гэрэл зургийн тоног төхөөрөмжийн засвар, үйлчилгээ
- биеийн байцаалт, үнэмлэхний хуванцар гадарга, гутлын өсгий, түлхүүр олшруулах үйлчилгээ

873 Угсрах, суурилуулах үйлчилгээ /барилга, байгууламжаас бусад төрлийн/
8731 Машин, тоног төхөөрөмжөөс бусад төрлийн үйлдвэрлэсэн металл бүтээгдэхүүнийг угсрах, суурилуулах үйлчилгээ

87310 Машин, тоног төхөөрөмжөөс бусад төрлийн үйлдвэрлэсэн металл бүтээгдэхүүнийг угсрах, суурилуулах үйлчилгээ

8732 Аж үйлдвэр, боловсруулах болон үйлчилгээний машин, тоног төхөөрөмжийг угсрах, суурилуулах үйлчилгээ

87320 Аж үйлдвэр, боловсруулах болон үйлчилгээний машин, тоног төхөөрөмжийг угсрах, суурилуулах үйлчилгээ

Энэ дэд ангид дараах эд зүйлийг оруулна:

- хөдөө аж ахуйд хэрэглэгддэг машин суурилуулах, тухайлбал:
 - саалтуурын машин
- уул уурхайн машин суурилуулах, тухайлбал:
 - чулуу болон хүдрийг ялгах, салгах, угаах, бутлах машин
- боловсруулах үйлдвэрт ашигладаг машин суурилуулах, тухайлбал:
 - хүнсний үйлдвэрийн машин
 - нэхмэлийн үйлдвэрийн машин
 - цаасны үйлдвэрийн машин
 - хуванцар болон резинэн эдлэл үйлдвэрлэх машин
 - мод болон металл боловсруулах машин

- үйлдвэрлэлийн хяналтын тоног төхөөрөмж суурилуулах
- үйлчилгээний салбарт ашигладаг машин суурилуулах, тухайлбал:

- рестораны тоног төхөөрөмж
- жижиглэн худалдааны дэлгүүрийн машин, тоног төхөөрөмж (бэлэн мөнгөний кассын машин орохгүй)

- 8733 Бичгийн болон тооцооны машин, компьютерыг угсрах суурилуулах үйлчилгээ**
87331 Компьютер ба дагалдах тоног төхөөрөмжийг угсрах, суурилуулах үйлчилгээ

Энэ дэд ангид дараах үйлчилгээ орно. Үүнд:

- компьютерын техник хангамжийн угсрах, суурилуулах үйлчилгээ
- компьютерийн програм хангамжийн угсрах, суурилуулах үйлчилгээ

Харин цахилгаан утас ба холбооны төхөөрөмжийн угсрах үйлчилгээ 54611-д орно.

- 87332 Албан газрын тооцооны машин угсрах үйлчилгээ**

Энэ дэд ангид дараах эд зүйлийг оруулна:

- персональ компьютер, гаднах туслах тоног төхөөрөмж суурилуулах
- програм хангамж суулгах

Энэ дэд ангид дараах эд зүйлийг оруулахгүй:

- цахилгаан холбооны болон цахилгааны утас суурилуулах, 54619-ийг үзнэ үү
- үндсэн хэмжээтэй болон түүнтэй адил компьютер суурилуулах, 87331-ийг үзнэ үү.

- 8734 Телевиз, радио, холбооны тоног төхөөрөмж ба аппарат угсрах үйлчилгээ**
87340 Телевиз, радио, холбооны тоног төхөөрөмж ба аппарат угсрах үйлчилгээ

Энэ дэд ангид дараах эд зүйлийг оруулна:

- телевиз, радиогийн дамжуулагч суурилуулах
- утасны сүлжээ суурилуулах
- дүрс, дуу бичлэгийн аппарат суурилуулах

- 8735 Нарийвчлалтай ба оптик хараа зүйн хэрэгсэл, мэргэжлийн эмчилгээний машин, тоног төхөөрөмжийг угсрах үйлчилгээ**

- 87350 Нарийвчлалтай ба оптик хараа зүйн хэрэгсэл, мэргэжлийн эмчилгээний машин, тоног төхөөрөмжийг угсрах үйлчилгээ**

Энэ дэд ангид дараах ажил үйлчилгээг оруулна:

- рентген машин суурилуулах
- цахилгаан оношлогооны аппарат суурилуулах
- ариутгагч тоног төхөөрөмж суурилуулах
- кино зургийн прожектор суурилуулах
- дуран, телескоп (томруулагч шил) суурилуулах

- 8736 Цахилгаан машин, багаж хэрэгслийг угсрах, суурилуулах үйлчилгээ**
87360 Цахилгаан машин, багаж хэрэгслийг угсрах, суурилуулах үйлчилгээ

Энэ дэд ангид дараах эд зүйлийг оруулна:

- цахилгаан мотор, үүсгүүр, трансформатор суурилуулах
- бусад газар ангилагдаагүй цахилгаан машин суурилуулах

- 8739 Бусад төрлийн барааг угсрах, суурилуулах үйлчилгээ**
87390 Бусад төрлийн барааг угсрах, суурилуулах үйлчилгээ

Энэ дэд ангид дараах эд зүйлийг оруулна:

- гэрийн театр болон гэр ахуйн бусад цахилгаан хэрэгсэл суурилуулах
- бусад гэр ахуйн эд зүйл суурилуулах
- бусад газар ангилагдаагүй эд зүйл суурилуулах

- 88 БОЛОВСРУУЛАХ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ТУСЛАХ ҮЙЛЧИЛГЭЭ**

88 дугаар бүлэгт орох үйлчилгээнүүд нь үйлчилгээг үзүүлж буй нэгжээс тухайн зүйлийг эзэмшигч бусад нэгжийн гүйцэтгэсэн бодит оролцоо хувь нэмэр юм. Тиймээс 88 дугаар бүлгийн үйлчилгээнүүд нь үйлдвэрлэлийн үйл явцад хэсэгчлэн аутсорсинг хийсэн, үйлдвэрлэлийн үйл явцад бүхэлд нь аутсорсинг хийсэн гэсэн байдлаар ангилагддаг. Энэ бүлэг боловсруулах үйлдвэрлэлийн үйлчилгээг хамарч байгаа учраас гарц нь үйлчилгээ үзүүлж буй нэгжийн эзэмшилд байдаггүй. Тиймээс энэ бүлгийн үйлчилгээний өртөг үйлдвэрлэсэн бүтээгдхүүний өртөгт бус үйлчилгээнд төлсөн төлбөр дээр үндэслэдэг. Энэ бүлгийн дэд бүлэг, салбар, дэд салбар нь эдгээр үйлчилгээг бий болгосон ISIC Rev.4 ангиллын дэд салбаруудтай тохирдог.

89 ҮЙЛДВЭРЛЭЛИЙН БУСАД ҮЙЛЧИЛГЭЭ

891 Хэвлэх, хувилах, наах, дахин хувилах үйлчилгээ

Боловсруулах салбарын энэ төрлийн үйлчилгээнд биет бус хөрөнгөтэй холбоотой үйлдвэрлэлийн үйл ажиллагаа орно.

8911 Төлбөр болон гэрээгээр хийгддэг, хэвлэх үйлчилгээ

89110 Төлбөр болон гэрээгээр хийгддэг, хэвлэх үйлчилгээ

Энэ дэд ангид төлбөр болон гэрээг үндэслэн хийгдэх хэвлэмэл зүйл бэлтгэх, программ хангамж хэвлэх үйлчилгээ орно.

8912 Хэвлэх, нөхөн сэргээх үйлчилгээ

89121 Хэвлэх үйлчилгээ

Энэ дэд ангид дараах үйлчилгээ орно. Үүнд:

- сонин хэвлэх
- ном хэвлэх
- номын хавтас эвлүүлэх, наах, өрөмдөх, цоолох
- нугалах, боох, ороох, өрөмдөх, цоолох, нүхлэх, хээлэх
- наах, цавуудах, давхарлаж наах
- цахим хэлбэрээр өгөгдсөн мэдээллийг цэгцлэх
- цахим хэлбэрээр өгөгдсөн мэдээллийн хэвлэлийн эхийг бэлтгэх
- хэвлэлийн эх дээр засвар хийх
- дижитал тоо материал боловсруулах
- бусад график, үйлчилгээ
- бусад хэвлэх үйл ажиллагаа

Харин нэхмэл хэвлэлийн үйлчилгээ 88121-д орно.

89122 Төлбөр болон гэрээгээр хийгддэг, бичлэгтэй мэдээлэл агуулсан хуурцаг хувилах үйлчилгээ

Энэ дэд ангид дараах үйлчилгээ орно. Үүнд:

- хэт авианы тоног төхөөрөмж, компакт диск, кассет болон дуу хөгжмийн бусад бичлэгийг хэвлэх, хувилах үйлчилгээ
- лазер диск, DVD, хөдөлгөөнт зураг, бусад видео бичлэг хувилах үйлчилгээ
- компьютерын бүх төрлийн диск, кассетын бичлэг хувилах үйлчилгээ

892 Хуванцар эдлэл цутгах, хэвээр дарах, шахах үйлдвэрлэлийн үйлчилгээ

8920 Хуванцар эдлэл цутгах, хэвээр дарах, шахах үйлдвэрлэлийн үйлчилгээ

89200 Хуванцар эдлэл цутгах, хэвээр дарах, шахах үйлдвэрлэлийн үйлчилгээ

Энэ дэд ангид дараах үйлчилгээ орно. Үүнд:

- хуванцар эд анги үйлдвэрлэлийн үйлчилгээ

Энэ хэсэгт шил, нүүрстөрөгчийн элементүүдийг бэхжүүлэх үйлчилгээ багтана. Мөн хуванцар хайлуулах, хатуурсан материалыг цутгах, хайлуулж цутгах хэсгүүдийн үйлдвэрлэлийн үйлчилгээ орно.

- хуванцар зүйлийг цутгасан, вакуумдах тоног төхөөрөмж, шахсан гялгар бүрээстэй, хуванцар хэсэг, гол цөмтэй цутгасан хэсэг, бэхжүүлсэн, давхраатсан хуванцар материал, целлюлозон эдлэл
- БТКУС-д тодорхойлогдоогүй үйлдвэрлэлд зарцуулдаг завсрын хуванцар бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн үйлчилгээ

893 Металл эдлэл цутгах, хэвээр дарах, шахах үйлдвэрлэлийн үйлчилгээ

89310 **Металл цутгах үйлчилгээ**

Энэ дэд ангид дараах үйлчилгээ орно. Үүнд:

- давтаж болох цутгамал төмрийг цутгах үйлчилгээ
- бөмбөлөг хэлбэртэй цутгамал төмрийг цутгах үйлчилгээ
- бор цутгамал төмрийг цутгах үйлчилгээ
- төмрийг цутгах үйлчилгээ
- өнгөт төмрийг цутгах үйлчилгээ
- төмөр агуулаагүй бусад металлыг цутгах үйлчилгээ

8932 **Металл боловсруулах шахах, хээлэх, дарах үйлчилгээ**

89320 **Металл боловсруулах шахах, хээлэх, дарах үйлчилгээ**

Энэ дэд ангид дараах үйлчилгээ орно. Үүнд:

- төмөр хайлуулах үйлчилгээ
- төмөр хүйтнээр шахах буюу хавтгайлах үйлчилгээ
- төмөр агуулаагүй металл цутгах үйлчилгээ
- төмөр хавтгайлах үйлчилгээ
- зургийн тусламжтайгаар тасдах, цутгах үйлчилгээ
- халаах болон даралтын аргаар төмрийн нунтгаас металл эдлэл үйлдвэрлэх үйлчилгээ

894 **Төлбөр болон гэрээгээр хийгддэг, хог, хаягдал боловсруулах туслах үйлчилгээ**

8941 **Төлбөр болон гэрээгээр хийгддэг, металл хог хаягдлыг нөхөн сэргээх үйлчилгээ**

89410 **Төлбөр болон гэрээгээр хийгддэг, металл хог хаягдлыг нөхөн сэргээх үйлчилгээ**

Энэ дэд ангид металл эдлэл, металлын хог, хаягдлыг хоёрдогч түүхий эд материал болгон ашиглах зорилготой боловсруулах үйлчилгээ орно.

Энэ нь ангилагдсан болон ангилагдаагүй хог, хаягдлаас бүрдэх бөгөөд ихэвчлэн үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд цаашид шууд ашиглахад тохиромжгүй байдаг. Харин гарсан бүтээгдэхүүнийг цаашид боловсруулах үйл ажиллагаанд ашиглахад тохиромжтой бөгөөд завсрын бараагаар хэрэглэгдэнэ. Боловсруулах үйл ажиллагаа нь механик болон химийн үйл ажиллагаа байж болно. Тухайлбал:

- > ангилах болон ялгах зорилгоор, хуучин автомашин, угаалгын машин, дугуй зэрэг төмрийн хаягдлыг механик аргаар бутлах, няцлах,
- > төмөр замын вагон гэх мэт том хэмжээний хавтгай төмрийг механикаар хэсэглэх (reduction)

- > автомашин зэрэг хуучин бараа, бүтээгдэхүүний дахин ашиглах хэсгүүдийг авахын тулд эдгээрийг салгах, задлах

- > автомашин, хөргөгч зэрэг хуучин бараа, бүтээгдэхүүнийг тос, хөргөх шингэн, бензин зэрэг аюултай хаягдлаас салгах, задлах

Харин дараах үйлчилгээ орохгүй. Үүнд:

- *үйлдвэрлэлийн үйл ажиллагаа хийгддэггүй, хог хаягдлыг цуглуулах, ангилах, хайрцаглах болон бөөний худалдааны үйлчилгээ (61295-д),*
- *уран болон тоорын үлдэгдлийг дахин боловсруулах үйлчилгээ (88152-д),*
- *дахин боловсруулах үйлчилгээ бүтээгдэхүүн үйлчилгээнээс хамрааран (салбар 0-4-д орно).*

8942 **Төлбөр болон гэрээгээр хийгддэг, металл бус хог хаягдлыг нөхөн сэргээх үйлчилгээ**

89420 **Төлбөр болон гэрээгээр хийгддэг, металл бус хог хаягдлыг нөхөн сэргээх үйлчилгээ**

Энэ дэд ангид металл бус эдлэл, металлын хог, хаягдлыг хоёрдогч түүхий эд материал болгон ашиглах зорилготой боловсруулах үйлчилгээ орно.

Энэ нь ангилагдсан болон ангилагдаагүй хог, хаягдлаас бүрдэх бөгөөд ихэвчлэн үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд цаашид шууд ашиглахад тохиромжгүй байдаг. Харин гарсан бүтээгдэхүүнийг цаашид боловсруулах үйл ажиллагаанд ашиглахад тохиромжтой бөгөөд завсрын бараагаар хэрэглэгдэнэ. Боловсруулах үйл ажиллагаа нь механик болон химийн үйл ажиллагаа байж болно. Тухайлбал:

- > хоёрдогч түүхий эд материалыг үйлдвэрлэхийн тулд хуучин дугуй зэрэг резинэн бүтээгдэхүүнийг дахин боловсруулах

- > гуурс, хоолой, цэцгийн сав, суурь, тавиур гэх мэтэд зориулсан хоёрдогч түүхий эд материалыг үйлдвэрлэхийн тулд хуванцрыг ялгах, ангилах

- > химийн хаягдлаас химийн бүтээгдэхүүнийг дахин боловсруулах

- > шилийг ангилах, цэвэрлэх, нунтаглах, бутлах

- > хоёрдогч түүхий эд материалыг гаргаж авахын тулд хог хаягдлыг ялгах, цэвэрлэх, нунтаглах, бутлах

9 НИЙГЭМ, ХАМТ ОЛОН, БИЕ ХҮНД ҮЗҮҮЛЭХ ҮЙЛЧИЛГЭЭ

91 ТӨРИЙН УДИРДЛАГА, НИЙГЭМД ҮЗҮҮЛЭХ БУСАД ҮЙЛЧИЛГЭЭ, АЛБАН ЖУРМЫН ДААТГАЛЫН ҮЙЛЧИЛГЭЭ

911 Төрийн удирдлагын үйлчилгээ

9111 Төрийн үйлчилгээ

91111 Хууль тогтоох болон улс, бүс, орон нутгийн гүйцэтгэх байгууллагын үйлчилгээ

Энэ дэд ангид орон нутаг, бүс, төвийн гүйцэтгэх болон хууль тогтоох байгууллагын үйлчилгээ орно.

91112 Санхүү, татвар, мөнгөний бодлогын байгууллагын үйлчилгээ

Энэ дэд ангид дараах үйлчилгээ орно. Үүнд:

- мөнгө, санхүүгийн үйл ажиллагаатай холбоотой нийтийн өргөн хүрээний үйлчилгээ
- мөнгө, санхүүгийн үйл ажиллагаатай холбоотой удирдлага, хяналтын үйлчилгээ
- татварын үйлчилгээ
- татвар, хураамж цуглуулах үйлчилгээ
- татварын зөрчлийг эрэн сурвалжлах үйлчилгээ
- засгийн газрын зээлийн үйлчилгээ болон засгийн газрын санг удирдах үйлчилгээ

91113 Эдийн засаг, нийгмийн төлөвлөлт, статистикийн байгууллагын үйлчилгээ

Энэ дэд ангид дараах үйлчилгээ орно. Үүнд:

- эдийн засаг, нийгмийн төлөвлөлттэй холбоотой удирдах болон гүйцэтгэх үйлчилгээ
- төрийн байгууллагын янз бүрийн түвшинд статистикийн болон төлөвлөгөөний байгууллагын гүйцэтгэх үйлчилгээ
- эдийн засаг, нийгмийн төлөвлөгөө, хөтөлбөрийн гүйцэтгэлийг тогтмол үнэлэх, хянах, зохицуулах, томъёолох зэрэг үйлчилгээг үзүүлдэг бусад газар, товчоо болон төслийн нэгжийн үйлчилгээ

91114 Төрийн эрдэм шинжилгээ, судалгааны байгууллагын үйлчилгээ

Энэ дэд ангид засгийн газрын үйл ажиллагааг санхүүжүүлэх, болон байгаль, нийгэм, хүмүүнлэгийн ухааны судалгаа, шинжилгээний ажлыг гүйцэтгэх, төслийн нэгж, товчоо, газрын үйл ажиллагаагаар хийгдэх удирдлагын үйлчилгээ орно.

91119 Төрийн удирдлагын бусад төрлийн үйлчилгээ

Энэ дэд ангид дараах үйлчилгээ орно. Үүнд:

- өмнөх 4 бүлэгт ороогүй төрийн бусад үйл ажиллагаатай холбоотой дэмжлэг үзүүлэх, гүйцэтгэх, удирдах үйлчилгээ
- төрийн бус байгууллагын оролцоотой хөтөлбөрийн нэгжийн үйлчилгээ
- сонгуулийг удирдах нэгжийн үйлчилгээ

9112 Нийгмийн хамгааллын үйлчилгээнээс бусад төрлийн боловсрол, эрүүл мэнд, соёл, нийгмийн чиглэлийн төрийн удирдах байгууллагын үйлчилгээ

91121 Боловсролын төрийн удирдлагын үйлчилгээ

Энэ дэд ангид дараах үйлчилгээ орно. Үүнд:

- боловсролын төрөл бүрийн байгууллагуудын удирдлагын үйлчилгээ
- бүх төрлийн сургууль, боловсролын байгууллагад бусад зориулсан дэмжлэг үзүүлэх, хянах, шалгах, удирдлагын үйлчилгээ
- боловсролын чиглэлийн төрийн байгууллага, болон тусгай хөтөлбөрийн нэгжийн талаархи олон нийтийн мэдээллийн үйлчилгээ

91122 Эрүүл мэндийн төрийн удирдлагын үйлчилгээ

Энэ дэд ангид дараах үйлчилгээ орно. Үүнд:

- эрүүл мэндийн болон нийгмийн бүх төрлийн төрийн удирдлагын үйлчилгээ

- ерөнхий болон нарийн мэргэжлийн, шүдний эмнэлэг, клиникт зориулсан дэмжлэг, туслалцаа үзүүлэх, үзлэг, шалгалт хийх удирдлагын үйлчилгээ. Үүнд: Гэрээр сувилах болон асрах үйлчилгээ орно.

- төрөлтийг хянах, эмийн чанарын удирдлага, урьдчилан сэргийлэх, өвчний онош тогтоох, цусны төвийн үйлчилгээ зэрэг олон нийтийн эрүүл мэндийн асуудалд дэмжлэг, туслалцаа үзүүлэх, хянах удирдах үйлчилгээ /Эдгээр үйлчилгээг эмнэлэг, клиниктэй холбоогүй эрүүл мэндийн мэргэжлийн бие даасан мэргэжилтэн эсвэл тусгай баг гүйцэтгэнэ /

Харин дараах үйлчилгээ орохгүй. Үүнд:

- хөгжлийн түр зуурын бэрхшээлтэй иргэд болон төрсөн эхийн, өвчний үйл ажиллагаа (91310-д),

- нийгмийн хангамжийн үйлчилгээ (932, 933, 934, 935-д орно).

91123 Орон сууц, нийгмийн хангамжийн удирдлагын үйлчилгээ

Энэ дэд ангид дараах үйлчилгээ орно. Үүнд:

- байр, орон сууц болон нийгмийн хөгжил, усан хангамж, эрүүл ахуй, гудамжны гэрэлтүүлэг зэргийн төрийн удирдлагын үйлчилгээ

- байр орон сууцны стандартыг үнэлэх, дүгнэх, хөгжүүлэхтэй холбоотой үйлчилгээ (барилгын стандартаас бусад)

- улсын мэдлийн орон сууцны байх ёстой стандарт, түрээсийг хянах удирдлагын үйлчилгээ

- тусгай хэрэгцээтэй хүмүүст зориулсан эсвэл нийтэд зориулсан байр, орон сууцны удирдлагын үйлчилгээ

- байр, орон сууцны талаархи мэдээллийн тархаалт

- усан хангамжтай холбоотой удирдлагын зохицуулалт болон хөгжлийн асуудалтай холбоотой хөтөлбөрийн нэгж, газар, хэлтэс, товчооны үйлчилгээ

- гудамжны гэрэлтүүлэг, эрүүл ахуй, усан хангамж, бохир усны системийн үйл ажиллагаа, хог хаягдалтай холбоотой нийтийн үйлчилгээ

- агаарын бохирдлын мэдээллийн тархаалт, агаарын бохирдлын стандарт

91124 Чөлөөт цаг, соёл урлаг, шашны бодлого боловсруулах байгууллагын үйлчилгээ

Энэ дэд ангид дараах үйлчилгээ орно. Үүнд:

- соёл урлагт дэмжлэг үзүүлэх, бие даасан уран бүтээлч, соёл урлагийг дэмжих байгууллагын үйлчилгээ

- орон нутаг, бүс, үндэсний хэмжээний наадмын үйлчилгээ, шашны байгууллагын үйл ажиллагааг явуулах, дэмжих үйлчилгээ

Харин дараах үйлчилгээ орохгүй. Үүнд:

- спортын үйл ажиллагааг дэмжих болон спортын байгууллагын үйлчилгээ (9651-д),

- спортын үйлчилгээ (96520-д),

- бусад чөлөөт цагийн үйлчилгээ (969-д орно).

9113 Бизнесийн ашигтай үйл ажиллагааг дэмжсэн төрийн үйлчилгээ

91131 Хөдөө аж ахуй, ойн аж ахуйн, загас барилт, ан агнуурын чиглэлийн бизнесийн удирдлагын үйл ажиллагаа

Энэ дэд ангид дараах үйлчилгээ орно. Үүнд:

- доорх үйл ажиллагаатай холбоотой удирдлага, хяналтын үйлчилгээ

> ХАА-н газрын менежмент

> газар тариалан, шинэчлэлт, газрын зохицуулалт

> газар тариалангийн зах зээлийн тогтворжуулалт

> мал эмнэлэгийн үйлчилгээ

> хортон шавьжид тавих хяналт

> ойн аж ахуй

> загас, ан агнуурын үйлчилгээ

> ХАА-н судалгаа шинжилгээ, туршилт

- газар, хэлтэс, товчоо, хөтөлбөрийн нэгжээр дамжуулан гүйцэтгэгддэг удирдлагын үйл ажиллагаа

> тариалангийн талбайг хамгаалах

> газрыг нөхөн сэргээх

> газрыг сайжруулах

> фермерт үзүүлэх мал эмнэлгийн үйлчилгээний хангамж

> хортон, шавьж, мэрэгч, мод, ургамлын өвчлөл, бусад хөнөөлт зүйлсийн устгалт, түүний хяналт

> ургацын шинжилгээ, үнэлгээ

- удирдах үйлчилгээ

> ойн аж ахуйн үйл ажиллагааг удирдан зохицуулах

> мод тайрах зөвшөөрөл олгох

> газрын нөөц, ашиглалтыг зүй зохистой болгох

> ойн нөхөн сэргээлтийн ажил

> загас дарах, чанамал хийх үйл ажиллагааг дэмжих, туслахтай холбоотой үйлчилгээ

> дүрэм, зохицуулалтыг үнэлэх, боловсруулах, үүнд ан агнуур, загас барилтын зөвшөөрөл орно.

- дээр дурьдагдсан бүх үйл ажиллагаанд зориулсан мэдээллийн болон дэмжлэг үзүүлэх үйлчилгээ

91132 Түлш, эрчим хүчний удирдлагын үйлчилгээ

Энэ дэд ангид дараах үйлчилгээ орно. Үүнд:

- газар, хэлтэс, товчоо, хөтөлбөрийн нэгжээр дамжуулан гүйцэтгэгддэг үйлчилгээ, жишээлбэл:

> хатуу түлш, түүнийг боловсруулах, хамгаалахтай холбоотой дүрэм, зохицуулалт

> бензин, байгалийн хий

> эрдэс түлш

> мод болон модны хаягдал, спиртэн түлш зэрэг цөмийн болон арилжааны бус түлш

- дээр дурьдагдсан бүх үйл ажиллагаанд зориулсан мэдээллийн болон дэмжлэг үзүүлэх

91133 Уул уурхай, ашигт малтмал, боловсруулах үйлдвэр, барилгын чиглэлийн удирдлагын үйлчилгээ

Энэ дэд ангид дараах үйлчилгээ орно. Үүнд:

- газар, хэлтэс, товчоо, хөтөлбөрийн нэгжээр дамжуулан гүйцэтгэгдэх захиргааны үйл ажиллагаа

- эрдэс бүтээгдэхүүний судалгаа, шинжилгээ, ашиглалт, хамгаалалт, зах зээлийн асуудал хэтийн төлөвтэй холбоотой зохицуулалтыг үнэлэх, шинжлэх, боловсруулах үйл ажиллагааг оруулна. Үүнд:

> уул уурхай, аюулгүй байдлын стандарт

> үйлдвэрлэлийн нэгжийн байдлыг сайжруулах, өргөжүүлэх, хөгжүүлэхтэй холбоотойгоор зохион байгуулсан үйл ажиллагаанууд

> барилгын аюулгүй байдалтай холбоотой зохицуулалтын үнэлгээ дүгнэлт, боловсруулалт, мэргэжлийн үнэмлэх олгох, барилгын стандарттай холбоотой зохицуулалтыг хэрэгжүүлэх, боловсруулахтай холбоотой үйлчилгээ

- дээр дурьдагдсан бүх үйл ажиллагаанд зориулсан мэдээллийн болон дэмжлэг үзүүлэх үйлчилгээ

Харин эрдэс түлштэй холбоотой үйлчилгээ 91132-т орно.

91134 Тээвэр, холбооны удирдлагын үйлчилгээ

Энэ дэд ангид дараах үйлчилгээ орно. Үүнд:

- авто, усан, агаарын болон төмөр замын тээвэр, холбооны үйлчилгээ

- газар, хэлтэс, товчоо, хөтөлбөрийн нэгжээр дамжуулан гүйцэтгэгдэх захиргааны үйл ажиллагаа

> зам, хурдны зам болон нэгдсэн байгууламжийг сайжруулах, засварлах, барих, байгуулах, зураг төсөл хийх, төлөвлөх. Үүнд:

> авто замын сүлжээ, түүний бүтэц

> усан замын төхөөрөмж, төмөр зам, онгоцны нислэгийн зам, нисэх буудал, нисэх онгоцны байр, агаарын удирдах төв, агаарын тээврийн нэгдсэн төхөөрөмж болон бусад холбогдох үл хөдлөх байгууламж

> дамжуулах хоолой болон бусад төхөөрөмжүүд

- тээвэр болон холбогдох төхөөрөмжтэй холбоотой дээр дурьдагдсан бүх үйл ажиллагаанд зориулсан дүрмийг биелүүлэх, боловсруулах, зохицуулах, хяналт тавих үйлчилгээ

- шуудан, утас, цахилгаан, холбооны утастай, утасгүй систем, хиймэл дагуул зэрэг холбооны үйлчилгээ

- холбооны системийг сайжруулах, хэвийн ажиллагааг хангах, төлөвлөх, боловсронгуй болгохтой холбоотой үйлчилгээ

- эдгээр системд зориулсан дүрэм, зохицуулалтыг биелүүлэх, боловсруулахтай холбоотой үйлчилгээ
- дээр дурьдагдсан бүх үйл ажиллагаанд зориулсан мэдээллийн болон дэмжлэг үзүүлэх үйлчилгээ

Харин усан зам, авто замын цагдаагийн хяналтын үйлчилгээ 91260-д орно.

91135 Худалдаа, зочид буудал, зоогийн газрын бодлого, удирдлагын үйлчилгээ

Энэ дэд ангид дараах үйлчилгээ орно. Үүнд:

- зочид буудал, зоогийн газар, агуулах, хадгалах байр, жижиглэн худалдаатай холбоотой төрийн үйлчилгээ
- газар, хэлтэс, товчоо, хөтөлбөрийн нэгжээр дамжуулан гүйцэтгэгддэг захиргааны үйл ажиллагаа, жишээлбэл:
 - > зочид буудал, зоогийн газрын үйл ажиллагаа, агуулах, хадгалах байр, бөөний болон жижиглэнгийн худалдаалагчдын хангамж, үнийн хяналт, хэрэглэгчдийг хамгаалах, бөөний болон жижиглэнгийн худалдаатай холбоотой дүрэм, зохицуулалтыг үнэлэх, шинжлэх, боловсруулах
- зоогийн газрын байр, зочид буудлын барилга, төсөл, загвартай холбоотой үйлчилгээ
- дээр дурьдагдсан бүх үйл ажиллагаанд зориулсан мэдээллийн болон дэмжлэг үзүүлэх үйлчилгээ

91136 Аялал жуулчлалын хэргийг удирдах байгууллагын үйлчилгээ

Энэ дэд ангид дараах үйлчилгээ орно. Үүнд:

- аялал, жуулчлал болон аялал жуулчлалын зар сурталчилгаатай холбоотой үйлчилгээ
- газар, хэлтэс, товчоо, хөтөлбөрийн нэгжээр дамжуулан гүйцэтгэгддэг захиргааны үйл ажиллагаа
 - > зар сурталчилгаа
 - > аялал жуулчлалын мэдээлэл тархаалт
 - > бусад аялал жуулчлалд дэмжлэг үзүүлэх бусад үйлчилгээ

Харин дараах үйлчилгээ орохгүй. Үүнд:

- аялал жуулчлалын сурталчилгааны үйлчилгээ (85561-д),
- зочлогчдын мэдээллийн үйлчилгээ (85562-т орно).

91137 Олон талт төсөл хэрэгжүүлэх ажлыг удирдах байгууллагын үйлчилгээ

Энэ дэд ангид дараах үйлчилгээ орно. Үүнд:

- газар, хэлтэс, товчоо, хөтөлбөрийн нэгжээр дамжуулан гүйцэтгэгддэг захиргааны үйлчилгээ
- олон талт зорилгыг хэрэгжүүлэх төслийн барилга, зураг төсөл, төлөвлөлт түүнийг хөгжүүлэх үйл ажиллагаа /Төсөл нь ихэвчлэн цахилгаан үйлдвэрлэхэд зориулсан нэгдсэн төхөөрөмж, үерийн хяналт, усжуулалт, удирдлага зэргээс бүрдэнэ/.
- дээр дурьдагдсан бүх үйл ажиллагаанд зориулсан мэдээллийн болон дэмжлэг үзүүлэх үйлчилгээ

91138 Эдийн засаг, арилжааны болон ажиллах хүчний асуудалтай холбоотой үйлчилгээ

Энэ дэд ангид дараах үйлчилгээ орно. Үүнд:

- газар, хэлтэс, товчоо, хөтөлбөрийн нэгжээр дамжуулан гүйцэтгэгддэг захиргааны үйлчилгээ:
 - > эдийн засгийн бодлогыг томъёолох
 - > барааны болон хөрөнгийн зах зээл, экспорт, импорт зэрэг эдийн засгийн үйл ажиллагааг дэмжих, зохицуулах үйлчилгээ
 - > нийт орлогын хяналт
 - > худалдааны урамшууллын үйлчилгээ
 - > зах зээлд нэвтрэх, худалдааны бусад хориг, саад, монополийг зохицуулах
 - > арилжааны төрөл бүрийн секторыг шалгах, зөвшөөрөл олгох, зохицуулах
- стандартчлал, цаг уурын урьдчилан тандах төв, худалдааны тэмдгийн болон зохиогчийн эрх, патентын газар зэрэг байгууллагын удирдлагын үйлчилгээ
- ажлын байрны нөхцөл зэрэг ажиллах хүчний бодлого дүрмийг хэрэгжүүлэх тэдгээрийг тодорхойлох, боловсруулах, ажиллах хүч солилцох, ажилгүйдлийг бууруулах, ажиллах хүчийг нэмэгдүүлэх үндэсний болон бүснүтгийн бодлого боловсруулах, нэвтрүүлэх

9119 Төрийн ерөнхий удирдлагын бусад төрлийн үйлчилгээ

91191 Төрийн албан хаагч, боловсон хүчний бодлого хэрэгжүүлэх удирдлагын үйлчилгээ

Энэ дэд ангид дараах үйлчилгээ орно. Үүнд:

- тусгай зориулалтаас үл хамааран төрийн албан хаагч, боловсон хүчний удирдлага, үйл ажиллагааны үйлчилгээ
- төрийн албан хаагчийн сонгох, урамшуулах, үнэлгээний арга зүй, ажлын байрны тодорхойлолт, үнэлгээ, ангилал зэрэг үйл ажиллагааг зохицуулсан бодлого, түүнийг боловсруулах, хэрэгжүүлэх үйлчилгээ, иргэний үйлчилгээний дүрэм болон адил төстэй зохицуулалтын удирдлагын үйлчилгээ

91199 Төрийн ерөнхий удирдлагын бусад үйлчилгээ

Энэ дэд ангид дараах эд зүйлийг оруулна:

- 911 дүгээр бүлгийн бусад дэд ангиудад ангилагдснаас бусад төрийн удирдлагын үйлчилгээ

912 Улс, нийгэм даяар үзүүлэх үйлчилгээ

9121 Гадаад харилцаа, дипломат болон төлөөлөгчийн газрын үйлчилгээ

91210 Гадаад харилцаа, дипломат болон төлөөлөгчийн газрын үйлчилгээ

Энэ дэд ангид дараах үйлчилгээ орно. Үүнд:

- гадаад хэргийн яам, гадаад улс орны явуулж байгаа дипломат болон консулын газрын үйл ажиллагаа болон төрийн удирдлагын үйл ажиллагаа
- олон улсын байгууллагуудын номын сан, уншлагын өрөө, лавлагаа өгөх үйлчилгээ зэргийг багтаасан соёл, урлагийн үйлчилгээ, мэдээллийн үйлчилгээ, тэдгээрт дэмжлэг үзүүлэх болон удирдлагын үйлчилгээ

9122 Гадаад эдийн засгийн тусламжийн үйлчилгээ

91220 Гадаад эдийн засгийн тусламжийн үйлчилгээ

Энэ дэд ангид дараах үйлчилгээ орно. Үүнд:

- хөгжиж буй оронд олон улсын байгууллагаар дамжуулсан/дамжуулаагүй эдийн засгийн тусламж үзүүлэх төрийн үйлчилгээ
- газар, хэлтэс, товчоо, хөтөлбөрийн нэгжээр дамжуулан гүйцэтгэгдэх хөгжиж буй орнуудад үзүүлэх цэргийн бус тусламжийн хөтөлбөрийн удирдлагын үйлчилгээ
- техникийн туслалцаа болон сургалт зохион байгуулах зэрэг дэмжлэг үзүүлэх үйлчилгээ
- дүрвэлт, өлсгөлөнгөөс чөлөөлөх хөтөлбөр зэрэг олон улсын байгууллагын тусламж
- гадаад засгийн газрын үзүүлэх эдийн засгийн итгэмжит тусламжийн байгууллагын үйлчилгээ

9123 Гадаад оронд цэргийн тусламж үзүүлэх үйлчилгээ

91230 Гадаад оронд цэргийн тусламж үзүүлэх үйлчилгээ

Энэ дэд ангид дараах үйлчилгээ орно. Үүнд:

- газар, хэлтэс товчоо, хөтөлбөрийн нэгжээр дамжуулан гадаад засгийн газарт үзүүлэх цэргийн итгэмжит тусламжийн байгууллагын үйлчилгээ, олон улсын цэргийн байгууллагын холбооны үйлчилгээ
- цэргийн тусламж болон зээлийн үйлчилгээ
- зэвсэгт хүчний бие бүрэлдэхүүний хуваарилалт болон энх тайвныг сахиулах үйл ажиллагаа

9124 Батлан хамгаалах байгууллагын үйлчилгээ

91240 Батлан хамгаалах байгууллагын үйлчилгээ

Энэ дэд ангид дараах үйлчилгээ орно. Үүнд:

- батлан хамгаалах төрийн байгууллагын удирдлагын үйлчилгээ
- үйлчилгээний болон хянах үйл ажиллагааны гүйцэтгэх байгууллагын үйлчилгээ:
 - > батлан хамгаалах болон хүчний газар, тэнгис, агаар, сансрын хүчин
 - > техник, тээвэр, цахилгаан, холбоо
 - > тагнуул
 - > зэвсэгт хүчний арын алба, жанжин штаб, бие бүрэлдэхүүн цэргийн техник хэрэгсэл
 - > батлан хамгаалахын үйл ажиллагаанд зориулсан нөөц, туслах хүчин

> эрүүл мэндийн хээрийн үйлчилгээ болон цэргийн байгууламж, тоног төхөөрөмжийн хангамжийн үйлчилгээ

> цэргийн судалгаа, туршилт явуулах үйлчилгээ

Харин дараах үйлчилгэээ орохгүй. Үүнд:

- батлан хамгаалах яамны үйлчилгээ (91111-д),
- гадаадад цэргийн тусламж үзүүлэх үйлчилгээ (91230-д),
- цэргийн шүүх, шүүн таслах байгууллагын үйлчилгээ (91270-д),
- батлан хамгаалахын боловсролын үйлчилгээ, батлан хамгаалахын сургууль, коллеж, академийн үйл ажиллагаа (92-д),
- батлан хамгаалахын эмнэлгийн үйл ажиллагаа (9311-д орно).

9125 Иргэний хамгаалалтын үйлчилгээ

91250 Иргэний хамгаалалтын үйлчилгээ

Энэ дэд ангид дараах үйлчилгээ орно. Үүнд:

- иргэний хамгаалалтын үйл ажиллагаа
- гэнэтийн гамшгаас хамгаалах үйлчилгээ
- хүн ам болон байгууллагуудын иргэний хамгаалалтын ажил, сургуулилт

9126 Цагдаагийн газар, гал түймэртэй тэмцэх газрын үйлчилгээ

91260 Цагдаагийн газар, гал түймэртэй тэмцэх газрын үйлчилгээ

Энэ дэд ангид дараах үйлчилгээ орно. Үүнд:

- төрөөс санхүүждэг цагдаагийн байгууллага, түүний туслах агентлаг, цагдаагийн орогнох байр, хилийн цагдаа, эргийн харуул болон бусад тусгай зориулалтын цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны удирдлагын үйлчилгээ
- замын хөдөлгөөнийг зохицуулах цагдаагийн үйл ажиллагаа
- гадаадын иргэдийг бүртгэх байгууллага, цагдаагийн лабораторын үйл ажиллагаа, цагдаагийн бүртгэлийн үйлчилгээ
- төрөөс санхүүжүүлсэн гал түймэртэй тэмцэх болон гал унтраах анги, тэдгээрийн туслах ангиудын үйлчилгээ
- байгалийн гамшиг болон үер усны аюултай тэмцэх ангийн үйл ажиллагаа
- уул, ус, далайн эрэг зэрэг газруудад ажиглалт хийх, хянах, гарсан гамшигтэй тэмцэх, иргэдийг аврах үйл ажиллагаа
- цагдаагийн байгууллага болон цэргийн ангиар иргэдийг хамгаалах үйл ажиллагаа
- усан цэргийн, гал командын ангийн үйл ажиллагаа

9127 Хууль зүй, шүүх, прокурорын байгууллагын удирдлагын үйлчилгээ

91270 Хууль зүй, шүүх, прокурорын байгууллагын удирдлагын үйлчилгээ

Энэ дэд ангид дараах үйлчилгээ орно. Үүнд:

- гэмт үйл ажиллагаа болон иргэний хэргийг шүүх улсын шүүх захиргааны байгууллага, цэргийн шүүх болон шүүхийн системийн үйлчилгээ
- засгийн газар болон бусад төрийн байгууллагуудын өмнөөс иргэдэд хуулийн талаархи мэдлэг олгох, хуулийн зөвлөгөө өгөх хуулийн төлөөлөгчийн газрын үйл ажиллагаа
- иргэний өргөдлийг шийдвэрлэх, хуулийн тайлбар хийх болон шүүхийн шийдвэр биелүүлэх байгууллагын үйл ажиллагаа

Харин иргэний хэрэг болон гэмт хэрэг, бусад хэргийн талаар зөвлөгөө өгөх болон түүнтэй холбоотой үйлчилгээ 8211-д орно.

9128 Хорих, засан хүмүүжүүлэх байгууллагын удирдлагын үйлчилгээ

91280 Хорих, засан хүмүүжүүлэх байгууллагын удирдлагын үйлчилгээ

Энэ дэд ангид дараах үйлчилгээ орно. Үүнд:

- засан хүмүүжүүлэх байгууллагын үйлчилгээ
- хэрэгтэнг хорих шорон, хүүхдийн болон насанд хүрэгчдийн засан хүмүүжүүлэх анги болон албадан ажил хийлгэж хүмүүжүүлэхтэй холбоотой үйл ажиллагаа эрхэлдэг байгууллагууд

Харин дараах үйлчилгэээ орохгүй. Үүнд:

- шорон болон засан хүмүүжүүлэх ангийн боловсролын үйлчилгээ (92-д),

- шоронгийн эмнэлгийн үйлчилгээ (9311-д орно).

- 9129 Бусад төрлийн нийгмийн хэв журам аюулгүй байдлыг хангах үйлчилгээ**
91290 Бусад төрлийн нийгмийн хэв журам аюулгүй байдлыг хангах үйлчилгээ

Энэ дэд ангид дараах үйлчилгээ орно. Үүнд:

- цагдаагийн байгууллагатай холбоотой ажилладаг, нийгмийн хэв журам аюулгүй байдлыг хангах болон бусад олон нийтийн үйл ажиллагааг дэмжих, зохицуулах, удирдах үйл ажиллагаа

- цаг үе, энх тайван цагт гарч болзошгүй аюул, осол гамшгийн талаархи мэдээлэл өгөх болон нөөцийн газрын үйл ажиллагаа

- аюулгүй байдлыг хангах бусад үйлчилгээ

- 913 Нийгмийн зайлшгүй хамгааллын удирдлагын үйлчилгээ**
9131 Өвчлөх, хөдөлмөрийн чадвараа түр хугацаагаар алдах, жирэмсний болон амаржсаны, ажилгүйдлийн тэтгэмж авахад нийгмийн даатгалын сангаас үзүүлэх үйлчилгээ
91310 Өвчлөх, хөдөлмөрийн чадвараа түр хугацаагаар алдах, жирэмсний болон амаржсаны, ажилгүйдлийн тэтгэмж авахад нийгмийн даатгалын сангаас үзүүлэх үйлчилгээ

Энэ дэд ангид нийгмийн хамгааллын үйлчилгээ, өвчлөх, жирэмсний тэтгэлэг, бэртэх болон бусад хэлбэрээр ажлын чадвараа түр алдах тохиолдолд төрөөс үзүүлэх нийгмийн тусламжийн үйлчилгээ орно.

Харин эмнэлэг болон эрүүл мэндийг хангах үйлчилгээ 91122-т орно.

- 9132 Өндөр насны тэтгэвэр, хөдөлмөрийн чадвар алдсаны болон гэнэтийн осолд өртөгдөгчдөд төрөөс үзүүлэх тэтгэвэр, тэтгэмжийн үйлчилгээ**

- 91320 Өндөр насны тэтгэвэр, хөдөлмөрийн чадвар алдсаны болон гэнэтийн осолд өртөгдөгчдөд төрөөс үзүүлэх тэтгэвэр, тэтгэмжийн үйлчилгээ**

Энэ дэд ангид дараах үйлчилгээ орно. Үүнд:

- төрийн алба болон бусад захиргааны байгууллагад ажиллагчдад хөдөлмөрийн чадвараа алдсан болон гэнэтийн осолд өртөгчдөд төрөөс тусламж үзүүлэх, өндөр насны тэтгэвэр, тэтгэмжийн үйлчилгээг үзүүлэх

- төрийн албан хаагч, ажиллагчдад тусламж, тэтгэлэг олгох, гэнэт ажлаас халагдсан тохиолдолд болон ослын улмаас хөдөлмөрийн чадвараа бүрэн эсвэл хагас алдсан, жирэмсний улмаас ажлаа түр хийхгүй байх зэрэг тохиолдлуудад төрөөс тусламж, тэтгэмж үзүүлэх

- 9133 Ажилгүйдлийн тэтгэмж авахад нийгмийн даатгалын сангаас үзүүлэх үйлчилгээ**

- 91330 Ажилгүйдлийн тэтгэмж авахад нийгмийн даатгалын сангаас үзүүлэх үйлчилгээ**

Энэ дэд ангид ажилгүйдлийн тохиолдолд үзүүлэх тусламж, тэтгэлгийн үйлчилгээ, хөдөлмөрийн чадвараа алдсаны улмаас ажилгүй болох тохиолдолд төрөөс үзүүлэх тэтгэлэг, тэтгэмжийн үйлчилгээ орно

Харин дээрх тохиолдолтой холбогдолтой эрүүл мэндийг хамгаалах, эрүүл мэндийн үйлчилгээ 933-т орно.

- 9134 Хүүхэд, гэр бүлд төрөөс мөнгөн тусламж үзүүлэх үйлчилгээ**

- 91340 Хүүхэд, гэр бүлд төрөөс мөнгөн тусламж үзүүлэх үйлчилгээ**

Энэ дэд ангид дараах үйлчилгээ орно. Үүнд:

- өрх, олон хүүхэдтэй гэр бүлд төрөөс үзүүлэх тусламж, тэтгэлгийн үйлчилгээ

- олон хүүхэдтэй, орлогогүй өрхөд мөнгөн тэтгэлэг олгох

- хүүхдийн тооноос хамааран өрхөд олгох мөнгөн тэтгэлэг

Харин төрөх үеийн тусламж, тэтгэлэгийн үйлчилгээ орохгүй. (91310-д орно).

- 92 БОЛОВСРОЛЫН ҮЙЛЧИЛГЭЭ**

- 921 Сургуулийн өмнөх боловсрол олгох үйлчилгээ**

9210 Сургуулийн өмнөх боловсрол олгох үйлчилгээ

92100 Сургуулийн өмнөх боловсрол олгох үйлчилгээ

Энэ дэд ангид дараах үйлчилгээ орно. Үүнд:

- цэцэрлэг, ясли, хүүхдийн асрах газар зэрэг сургуулийн өмнөх насны хүүхдийн боловсролыг хангах үйлчилгээ /Эдгээр байгууллагууд нь сургуулийн өмнөх бага насны хүүхдүүдэд анхан шатны боловсрол олгох (Олон улсын боловсролын салбарын стандарт ангиллын 0 түвшин) сургуулийн орчныг танилцуулах, цаашид үзэх, судлах зүйлийн талаар ойлголт өгөх сургуульд бэлтгэх гүүр болж өгдөг/

- энэ боловсролын шатанд ердийнхөөс илүү нэмэлт гүнзгийрүүлсэн програм үзэх, боловсрол олгохтой холбоотой үйлчилгээ

Харин хүүхэд өдрийн цагаар асрах (ямар нэг боловсрол олгох үйл ажиллагаа явагдахгүй) үйлчилгээ 93510-д орно.

922 Бага боловсрол олгох үйлчилгээ

9220 Бага боловсрол олгох үйлчилгээ

92200 Бага боловсрол олгох үйлчилгээ

Энэ дэд ангид дараах үйлчилгээ орно. Үүнд:

- боловсролын 1-р түвшний үйл ажиллагаа, (Олон улсын боловсролын салбарын стандарт ангиллын түвшин 1) сурагчдад унших, бичих, энгийн хялбар тоо, газар зүй, түүх, байгалийн шинжлэх ухаан, зураг, хөгжмийн хичээлийг заах зэрэг үйлчилгээ

- ердийн програмаас гадна нэмэлт, гүнзгийрүүлсэн програмаар боловсрол олгохтой холбоотой үйлчилгээ

- насанд хүрэгчдийн бичиг үсэг тайлах хөтөлбөртэй холбоотой үйлчилгээ

923 Дунд боловсрол олгох үйлчилгээ

Энэ дэд ангид сурагчдыг эхний шатнаас дараах шатны дэвшсэн боловсролыг олгох үйлчилгээ орно. Энэ програм нь ерөнхий мэдлэгийн эсвэл техникийн мэргэжлийн мэдлэг олгох гэсэн хэсгүүдээс бүрдэнэ. Тухайлбал:

> ерөнхий мэдлэгийн програм: нарийн мэргэжил болон мэргэжил олгох бусад сургуульд элсэхээр бэлтгэгчдэд зориулсан тодорхой нэг чиглэлээр дагнасан бус ерөнхий мэдлэг олгох програм байна.

> техникийн мэргэжлийн мэдлэг олгох програм: нарийн мэргэжил болон мэргэжил олгох бусад сургуульд шууд элсэн ороход бэлтгэх үйлчилгээ байна. Амжилтай сургалтыг дууссан тохиолдолд мэргэжлийн боловсролтойгоор хөдөлмөрийн зах зээлд ажиллах эрхтэй болно.

9231 Суурь боловсрол олгох үйлчилгээ

92310 Суурь боловсрол олгох үйлчилгээ

Энэ дэд ангид дараах үйлчилгээ орно. Үүнд:

- хичээлүүд нь ихэнхдээ тодорхой чиглэлүүдэд хандсан, тэдгээр чиглэлүүдээр мэргэшсэн багш нар тухайн чиглэлээрээ ангиудтай ажилладаг, суурь мэдлэг, чадвар олгох Олон улсын боловсролын салбарын стандарт ангиллын 2-р түвшний боловсролын үйлчилгээ. Техникийн талаар болон тухайн чиглэл рүү илүү гүнзгийрсэн эсвэл бизнес болон мэргэжлийн тусгай ангиудад ороход нь бэлтгэх зэрэг боловсролын үйлчилгээ байна.

- энэ түвшний тусгай боловсролын хөтөлбөрүүдтэй холбоотой үйлчилгээ

- насанд хүрэгчдийн бичиг үсэг тайлагдалтын хөтөлбөрийн үйлчилгээ

9232 Бүрэн дунд боловсрол олгох үйлчилгээ

92320 Бүрэн дунд боловсрол олгох үйлчилгээ

Энэ дэд ангид дараах үйлчилгээ орно. Үүнд:

- хичээлүүд нь ихэнхдээ тодорхой чиглэлүүдэд хандсан, тэдгээр чиглэлүүдээр мэргэжсэн багш нар тухайн чиглэлээрээ ангиудтай ажилладаг, суурь мэдлэг, чадвар олгох Олон улсын боловсролын салбарын стандарт ангиллын 2-р түвшний боловсролын үйлчилгээ. Энэхүү үйлчилгээ нь тусгай мэргэжилрүү илүү нэмэлт хичээлгүйгээр шууд ороход сурагчдаа бэлтгэдэг боловсролыг хамарна. Тус сургалтыг амжилттай төгссөн нөхцөлд тухайн мэргэжлийн хөдөлмөрийн зах зээл дээр тэргүүлдэг.

- энэ түвшинд тусгай боловсролын хөтөлбөрүүдээр хангахтай холбогдсон үйлчилгээ

- энэ түвшинд насанд хүрэгчдэд зориулсан уран зохиолын хөтөлбөрөөр хангахтай холбогдсон үйлчилгээ

9233 Мэргэжлийн сургалттай бүрэн дунд боловсрол олгох үйлчилгээ

92330 Мэргэжлийн сургалттай бүрэн дунд боловсрол олгох үйлчилгээ

Энэ дэд ангид хоёр дахь түвшинтэй харьцуулахад тодорхой чиглэлүүдийн багш нар нь илүү мэргэшсэн мэргэжлийн өндөр зэрэг олгодог боловсролын үйлчилгээ орно (Олон улсын боловсролын салбарын стандарт ангилалын 3-р түвшин). Энэ түвшний боловсролын хөтөлбөрүүдийн төрөл өөр өөр байна. Ерөнхийдөө 3-р түвшний боловсролыг эзэмшихэд дээд боловсролын сургуулийн хамгийн бага шаардлагыг хангасан байна. Энэ дэд ангид тусгай мэргэжил эсвэл нарийн техник мэргэжлийн боловсрол олгох үйлчилгээ хамаарахгүй.

9234 Бүрэн дунд, техник, мэргэжлийн боловсрол олгох үйлчилгээ

92340 Бүрэн дунд, техник, мэргэжлийн боловсрол олгох үйлчилгээ

Энэ дэд ангид хоёр дахь түвшинтэй харьцуулахад тодорхой чиглэлүүдийн багш нар нь илүү мэргэшсэн мэргэжлийн өндөр зэрэг олгодог боловсролын үйлчилгээ орно. (Олон улсын боловсролын салбарын стандарт ангилалын 3-р түвшин). Энэ түвшний боловсролын хөтөлбөрийн төрөл өөр өөр байна. Ерөнхийдөө 3-р түвшний боловсролыг эзэмшихэд дээд боловсролын хөтөлбөрийн хамгийн бага шаардлагыг хангасан байна. Энэ дэд бүлгийн үйлчилгээнд хамрагдсан хүмүүсийг тусгай мэргэжилд ороход дахин сургах шаардлагагүйгээр шууд орохоор бэлтгэгдэг. Энэ хөтөлбөрийг амжилттай төгссөн хүмүүс нь тухайн мэргэжлийн чиглэлээр зах зээлд ажиллах боломжтой.

924 Техник, мэргэжлийн боловсрол олгох үйлчилгээ

9241 Мэргэжлийн анхан шатны боловсрол олгох үйлчилгээ

92410 Мэргэжлийн анхан шатны боловсрол олгох үйлчилгээ

Энэ дэд ангид олон улсын боловсролын стандарт салбарын ангилалын 4-р түвшний боловсролын үйлчилгээ орно. Бүрэн дунд боловсрол эзэмшилт нь хөтөлбөрийн агуулга, арга ухаан нь дундаас дээш боловсролоос илүү ахисан түвшинд боловч дээд боловсрол олгох сургалт юм.

9242 Мэргэжлийн дунд шатны боловсрол олгох үйлчилгээ

92420 Мэргэжлийн дунд шатны боловсрол олгох үйлчилгээ

Энэ дэд ангид олон улсын боловсролын салбарын стандарт ангиллын 4-р түвшний боловсролын үйлчилгээ орно. Бүрэн дунд боловсрол эзэмшилт нь хөтөлбөрийн агуулга, арга ухаан нь дундаас дээш боловсролоос илүү ахисан түвшинд боловч дээд боловсрол олгох сургалт юм.

925 Дээд боловсрол олгох үйлчилгээ

9251 Диплом, бакалаврын боловсрол олгох үйлчилгээ

92510 Диплом, бакалаврын боловсрол олгох үйлчилгээ

Энэ дэд ангид их сургуулийн зэрэг дэвтэй тэнцэхүйц хэмжээний боловсрол олгох үйлчилгээ, их, дээд сургууль, коллежуудтэй тэнцэхүйц хэмжээний өндөр боловсрол олгодог институт, бусад байгууллагын үйлчилгээ орно.

9252 Докторын боловсрол олгох үйлчилгээ

92520 Докторын боловсрол олгох үйлчилгээ

Энэ дэд ангид докторын зэрэг олгох, эрдэм шинжилгээний ажил хийлгэх, мэргэшил дээшлүүлэх зэрэг боловсролын үйлчилгээ орно.

929 Бусад боловсрол олгох, сургалт явуулах үйлчилгээ

9291 Бусад боловсрол олгох сургалт явуулах үйлчилгээ

92911 Соёлын боловсрол олгох үйлчилгээ

Энэ дэд ангид дараах үйлчилгээ орно. Үүнд:

- төгөлдөр хуур болон бусад хөгжмийн боловсролыг олгох үйлчилгээ
- урлагийн боловсрол олгох үйлчилгээ
- бүжиг заах болон бүжгийн студи, бүжгийн курс
- урлагийн академиас гадуур урлаг заах
- гэрэл зураг авах сургалт

Энэ дэд ангид дээр дурьдсан мэргэжлийн зэрэг, диплом олгодог үйлчилгээ хамаарахгүй.

92912 Чөлөөт цагаа зөв өнгөрөөх болон спортын боловсрол олгох үйлчилгээ

Энэ дэд ангид дараах үйлчилгээ орно. Үүнд:

- мэргэжлийн сургуулийн спортын багш нар болон дасгалжуулагчаар спортын сургалт явуулах үйлчилгээ хамаарна /Харин академи, коллеж, их сургуулиудын спортоор дасгалжуулах үйлчилгээ нь үүнд орохгүй/. Жишээлбэл:

- спортын сургалт (Бейсбол, сагс, крикет, хөлбөмбөг гэх мэт)
- дасгалжуулалт, спортын сургалт
- дасгалжуулагчийн сургалт
- гимнастикийн сургалт
- морин сургалт
- усан сэлэлтийн сургалт
- цэргийн сургалт
- хөзрийн тоглоомны сургалт
- ёогийн сургалт

92919 Боловсролын бусад төрлийн сургалтын үйлчилгээ

Энэ дэд ангид дараах үйлчилгээ орно. Үүнд:

- машин, автобус, мопед, мотоциклийн жолооны сургалтад зөвшөөрөл олгох
- нисгэгчийн гэрчилгээ болон усан онгоцны зөвшөөрөл олгох
- компьютер сургалтын үйлчилгээ
- удирдах ажилтныг сургах үйлчилгээ
- түвшингээс нь хамаарахгүйгээр боловсрол олгох үйлчилгээ

Харин дараах үйлчилгээ орохгүй. Үүнд:

- *насанд хүрэгчдэд бичиг үсгийн мэдлэг олгох үйлчилгээ (92190-д),*
- *ердийн боловсролын системтэй харьцуулагдахуйц дээд боловсролын үйлчилгээ (92310, 92390-д),*
- *академийн сургалтын бусад соёл боловсролын үйлчилгээ (92911-д),*
- *зааварлагч, дасгалжуулагчаар дамжуулан авдаг боловсролын үйлчилгээ (92912-т орно).*

9292 Боловсролыг дэмжих үйлчилгээ

92920 Боловсролыг дэмжих үйлчилгээ

Энэ дэд ангид дараах үйлчилгээ орно. Үүнд:

- боловсролын зөвлөгөө өгөх
- боловсролын заавар, зөвлөгөөний үйлчилгээ
- боловсролын төстийн үнэлгээ хийх үйлчилгээ
- боловсролын төстийн үйлчилгээ
- оюутан солилцооны хөтөлбөр зохион байгуулах үйлчилгээ

93 ЭРҮҮЛ МЭНД, НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭ

931 Хүний эрүүл мэндийн үйлчилгээ

9311 Эмнэлгийн үйлчилгээ

Энэ ангид эмнэлэгт хэвтэж эмчлүүлж байгаа өвчтөнд үзүүлэх үйлчилгээ орно.

93111 Өвчтөнд үзлэг хийх үйлчилгээ

Энэ дэд ангид эмчийн удирдлагын дор өвчтөнд хийгдэж байгаа мэс засал, өвчнийг анагаах, өвчтний эрүүл мэндийг сайжруулах, сэргээх үйлчилгээ орно.

Харин дараах үйлчилгээ орохгүй. Үүнд:

- гадуур эмчлүүлэгчид үзүүлж байгаа эмнэлгийн үйлчилгээ (93121, 93122-т),
- шүд эмчлэх үйлчилгээ (93123-т орно).

93112 Хэвтэн эмчлүүлж байгаа эмэгтэйчүүдэд үзүүлэх үйлчилгээ

Энэ дэд ангид эмчийн хяналтын дор хийгдэх эмэгтэйчүүдийн болон жирэмсэн эмэгтэйчүүдэд хийгдэх мэс заслын үйлчилгээ, өвчтөнд цуврал эмчилгээ, асаргаа хийх, өвчтний (хэвтэж эмчлүүлэгчдийн) эрүүл мэндийн байдалд дэмжлэг үйлчилгээ үзүүлэх орно.

Харин гадуур эмчлүүлэгчид үзүүлэх үйлчилгээ 93121, 93122 –т орно.

93113 Сэтгэл мэдрэлийн өвчтөнд үзүүлэх үйлчилгээ

Энэ дэд ангид эмчийн хяналтын дор хийгдэх сэтгэл мэдрэлийн өвчтөнүүдэд хийгдэх мэс заслын үйлчилгээ, өвчтөнд цуврал эмчилгээ, асаргаа хийх, өвчтний (хэвтэж эмчлүүлэгчдийн) эрүүл мэндийн байдалд дэмжлэг үзүүлэх үйлчилгээ орно.

Харин гадуур эмчлүүлэгчид үзүүлэх үйлчилгээ 93121, 93122 –т орно.

93119 Өвчтөнд үзүүлэх бусад төрлийн үйлчилгээ

Энэ дэд ангид эмчийн хяналтын дор хийгдэх бусад мэс заслын үйлчилгээ, өвчтөнд цуврал эмчилгээ, асаргаа хийх, өвчтний (хэвтэж эмчлүүлэгчдийн) эрүүл мэндийн байдалд дэмжлэг үзүүлэх үйлчилгээ орно. Эдгээр үйлчилгээнд эмнэлгээний, эмийн сан, нөхөн сэргээх эмчилгээ, сувилагчийн, лаборатори болон техникийн үйлчилгээ, радиолокацийн болон өвчин намдаах үйлчилгээ багтана.

Харин дараах үйлчилгээ орохгүй. Үүнд:

- гадуур эмчлүүлэгчид үзүүлэх үйлчилгээ (93121, 93122-т),
- шүдний эмчилгээ (93123-т),
- амбулаторын үйлчилгээ (93194-д орно).

9312 Эмнэлгийн эмчийн ерөнхий үзлэг хийх үйлчилгээ

93121 Эмнэлгийн ерөнхий үйлчилгээ

Энэ дэд ангид биеийн болон оюун санааны өвчнийг эмчийн хяналтын дор оношилж эмчлэх, урьдчилан сэргийлэх үзлэг зэргээс бүрдэх эмнэлгийн ерөнхий үйлчилгээ орно. Тухайлбал:

- эмчийн зөвлөгөө
- үзлэг

Эдгээр үйлчилгээ нь тусгайлсан буюу тухайн нөхцөл, өвчин эсвэл биеийн хэсгүүд гэж хязгаарлагдахгүй. Эдгээр үйлчилгээг хувийн эмч нар үзүүлж болох бөгөөд гадуур эмчлүүлэгч, өрхийн эмч, компани, сургуулийн эмчээр дамжуулан авах боломжтой. Эсвэл утсаар, интернэтээр зэрэг бусад аргаар зөвлөгөө авч болно.

93122 Эмнэлгийн тусгай мэргэжлийн эмчийн үйлчилгээ

Энэ дэд ангид дараах үйлчилгээ орно. Үүнд:

- хүүхэд, эмэгтэйчүүд, мэдрэл, сэтгэл мэдрэлийн зэрэг төрөл бүрийн эмчийн зөвлөгөө өгөх үйлчилгээ
- мэс заслын зөвлөгөө өгөх үйлчилгээ
- гадуур эмчлүүлэгчид хийх эмчилгээ, тухайлбал, химийн эмчилгээ, инсулин эмчилгээ, туяа эмчилгээ гэх мэт
- эмнэлгийн зарим шинжилгээний хариунд анализ, тайлбар бичих үйлчилгээ, /рентген зураг, эхо/

Эдгээр үйлчилгээг хувийн эмч нар үзүүлж болох бөгөөд гадуур эмчлүүлэгч, өрхийн эмч, компани, сургуулийн эмчээр дамжуулан авах боломжтой. Эсвэл утсаар, интернэтээр зэрэг бусад аргаар зөвлөгөө авч болно.

93123 Шүдний эмчийн үйлчилгээ

Энэ дэд ангид дараах үйлчилгээ орно. Үүнд:

- шүдний эмнэлгийн ерөнхий үйлчилгээ, тухайлбал, шүдний гажигийг засах, илүү шүд авах, оргой шүдийг тэгшлэх, хэвтэж эмчлүүлж байгаа хүмүүст үзүүлэх шүдний мэс заслын үйлчилгээ

- амны хөндийн мэс засал

- шүдний тусгайлсан бусад эмчилгээ

- амны хөндийн өвчтэй хүмүүсийн оношилгоо, эмчилгээ хийх үйлчилгээ болон шүдний өвнөөс урьдчилан сэргийлэх үйлчилгээ

Энэхүү үйлчилгээг клиник болон сургууль, компани зэрэг газрын эмнэлгээр дамжуулан үзүүлж болох бөгөөд өөрийн тусгай зөвлөгөө өгөх өрөөтэй байна.

9319 Хүний эрүүл мэндийн бусад төрлийн үйлчилгээ

93191 Жирэмсэн болон төрсөн эмэгтэйчүүд, хүүхдүүдийг асрах, эмчлэх эмнэлгийн дунд мэргэжлийн ажилтны үйлчилгээ

Энэ дэд ангид дараах үйлчилгээ орно. Үүнд:

- жирэмсэн эхчүүд болон төрөх үед үзүүлэх үйлчилгээ

- төрсний дараа үзүүлэх үйлчилгээ

93192 Сувилгааны үйлчилгээ

Энэ дэд ангид сувилагчийн байранд хийгдэх үйлчилгээ, гэрээр явж өвчтөнд зөвлөгөө өгөх, урьдчилан сэргийлэх үзлэг хийх, жирэмсэн болон төрсөн эхчүүд, хүүхдийн эрүүл ахуйг хангах үйлчилгээ орно.

93193 Физик эмчилгээний үйлчилгээ

Энэ дэд ангид бие эрхтний болон мэргэжлээс шалтгаалсан өвчинд үзүүлэх үйлчилгээ орно.

93194 Түргэн тусламжийн үйлчилгээ

Энэ дэд ангид сэхээн амьдруулах тоног төхөөрөмжтэй буюу төхөөрөмжгүй тээврийн хэрэгслээр түргэн тусламжийн үйлчилгээ үзүүлэх орно.

93195 Эмнэлгийн лабораторийн үйлчилгээ

Энэ дэд ангид эмнэлгийн шинжилгээний лабораторын үйлчилгээ орно.

93196 Дүрс оношлогоо хийх үйлчилгээ

Энэ дэд ангид ямар нэгэн анализ, тайлбаргүй шинжилгээ хийх үйлчилгээ орно. Тухайлбал цээжний зураг авах, эхо, соронзон бичлэг гэх мэт

93197 Цус, дусал хийх, бумба тавих үйлчилгээ

Энэ дэд ангид цус солих сэлбэх, дусал хийх, бумба тавих үйлчилгээ орно.

93199 Хүний эрүүл мэндийн бусад төрлийн үйлчилгээ

Энэ дэд ангид өөр газар ангилагдаагүй эрүүл мэндийн бусад уламжлалт үйлчилгээ, тухайлбал зүү тавих, сайхан үнэртэй зүйл үнэрлүүлэх, яриагаар эмчлэх, байгалийн гаралтай бэлдмэлээр эмчлэх жишээ нь шавар эмчилгээ, ургамлын гаралтай эмээр эмчлэх, хоол тэжээлээр эмчлэх гэх мэт.

932 Ахмад настан болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үзүүлэх төрөлжсөн асрамжийн үйлчилгээ

9321 Эмнэлгийн үйлчилгээнээс бусад төрлийн эрүүл мэндийн төрөлжсөн асрамжийн үйлчилгээ

93210 Эмнэлгийн үйлчилгээнээс бусад төрлийн эрүүл мэндийн төрөлжсөн асрамжийн үйлчилгээ

Энэ дэд ангид эмчийн хяналтгүйгээр эмнэлгийн үйлчилгээ, байраар хангах үйлчилгээ орно.

9322 Эмчилгээний суурин салбаруудаар дамжуулан ахмад настан болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үзүүлэх нийгмийн халамжийн үйлчилгээ

93221 Эмчилгээний суурин салбаруудаар дамжуулан ахмад настануудад үзүүлэх нийгмийн халамжийн үйлчилгээ

Энэ дэд ангид эмчилгээний суурин цэг салбаруудаар дамжуулан өндөр настануудад үзүүлж байгаа нийгмийн тусламжийн үйлчилгээ орно.

Харин дараах үйлчилгээ орохгүй. Үүнд:

- эмчийн хяналттай, байраар хангагдсан эмнэлгийн үйлчилгээ (9311-д),
- эмчийн хяналтгүйгээр, байраар хангагдсан эмнэлгийн үйлчилгээ (93210-д орно).

93222 Эмчилгээний суурин салбараар дамжуулан хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд үзүүлэх нийгмийн халамжийн үйлчилгээ

Энэ дэд ангид эмчилгээний суурин цэг салбаруудаар дамжуулан хөгжлийн бэрхшээлтэй залуучуудад / хараагүй, хэлгүй, дүлий / үзүүлж байгаа нийгмийн тусламжийн үйлчилгээ орно.

Харин дараах үйлчилгээ орохгүй. Үүнд:

- боловсролын үйлчилгээ (92-д),
- эмчийн хяналттай, байраар хангагдсан эмнэлгийн үйлчилгээ (9311-д),
- эмчийн хяналтгүйгээр, байраар хангагдсан эмнэлгийн үйлчилгээ (93210-д орно).

93223 Эмчилгээний суурин салбараар дамжуулан хөгжлийн бэрхшээлтэй насанд хүрэгчдэд үзүүлэх нийгмийн халамжийн үйлчилгээ

Энэ дэд ангид эмчилгээний суурин цэг салбаруудаар дамжуулан хөгжлийн бэрхшээлтэй насанд хүрэгчдэд / хараагүй, хэлгүй дүлий / үзүүлж байгаа нийгмийн тусламжийн үйлчилгээ орно.

Харин дараах үйлчилгээ орохгүй. Үүнд:

- боловсролын үйлчилгээ (92-д),
- эмчийн хяналттай, байраар хангагдсан эмнэлгийн үйлчилгээ (9311-д),
- эмчийн хяналтгүйгээр, байраар хангагдсан эмнэлгийн үйлчилгээ (93210-д орно).

933 Орон байрны хангамжтай нийгмийн бусад төрлийн үйлчилгээ

9330 Орон байрны хангамжтай нийгмийн бусад төрлийн үйлчилгээ

93301 Оюуны хөгжил сул, оюуны хөгжлийн бэрхшээлтэй болон мансууруулах бодис хэрэглэх хандлагатай хүүхдэд үзүүлэх төрөлжсөн асрамжийн үйлчилгээ

Энэ дэд ангид архи болон хар тамхинд орсон болон сэтгэл санааны дарамтанд орсон хүүхдүүдийг үйлчилгээний байрандаа эмчлэх, мөн оюун ухааны хомсдолтой хүүхдүүдэд үзүүлэх үйлчилгээ орно.

93302 Хүүхдэд зориулсан орон байрны хангамжтай нийгмийн бусад төрлийн үйлчилгээ

Энэ дэд ангид асрамжийн газар, хүүхдийг хамгаалах байр, сэтгэлийн дарамттай хүүхдүүдийг байлгах байр, өсвөр үеийг хүмүүжүүлэх байр зэргээр хүүхэд залуучуудад үзүүлэх нийгмийн халамжийн үйлчилгээ орно.

93303 Оюуны хөгжил сул, оюуны хөгжлийн бэрхшээлтэй болон мансууруулах бодис хэрэглэх хандлагатай насанд хүрэгчдэд үзүүлэх төрөлжсөн асрамжийн үйлчилгээ

Энэ дэд ангид архи болон хар тамхинд орсон, сэтгэл санааны дарамтанд орсон насанд хүрэгчдийг үйлчилгээний байрандаа эмчлэх, мөн оюун ухааны хомсдолтой насанд хүрэгчдэд үзүүлэх үйлчилгээ орно.

93304 Насанд хүрэгчдэд зориулсан, орон байрны хангамжтай нийгмийн бусад төрлийн үйлчилгээ

Энэ дэд ангид дараах үйлчилгээ орно. Үүнд:

- эмчилгээний суурин цэг салбаруудаар дамжуулан насанд хүрэгчдэд үзүүлж байгаа нийгмийн тусламжийн үйлчилгээ
- ганц бие эхчүүдийн байр
- нийгмийн бусад үйлчилгээ / сэтгэл санааг сэргээх гэх мэт/

934 Нийгмийн эмзэг бүлэгт төрөөс үзүүлэх тэтгэвэр, тэтгэмж, хөнгөлөлт, тусламжийн үйлчилгээ

9341 Хөдөлмөрийн чадварыг сэргээх үйлчилгээ

93411 Хөгжлийн бэрхшээлтэй насанд хүрэгчдийн хөдөлмөрийн чадварыг сэргээх үйлчилгээ

Энэ дэд ангид хөгжлийн бэрхшээлтэй насанд хүрэгчдэд нийгмийн тусламж давамгайлсан мэргэжлийн боловсрол олгох үйлчилгээ орно.

Харин боловсролын үйлчилгээ давамгайлсан мэргэжлийн боловсрол олгох үйлчилгээ 92-д орно.

93412 Ажилгүйчүүдэд зориулсан мэргэжлийн боловсрол олгох үйлчилгээ

Энэ дэд ангид ажилгүйчүүдэд нийгмийн тусламж давамгайлсан мэргэжлийн боловсрол олгох үйлчилгээ орно.

Харин боловсролын үйлчилгээ давамгайлсан мэргэжлийн боловсрол олгох үйлчилгээ 92-д орно.

9349 Ахмад настан болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үзүүлэх нийгмийн хөнгөлөлт, тусламжийн бусад төрлийн үйлчилгээ /байрлуулахгүйгээр/

93491 Ахмад настанд үзүүлэх нийгмийн тусламжийн бусад төрлийн үйлчилгээ /байрлуулахгүйгээр/

Энэ дэд ангид өндөр настныд очиж, тусламж, дэмжлэг үзүүлэх үйлчилгээ орно.

93492 Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд үзүүлэх нийгмийн тусламжийн бусад төрлийн үйлчилгээ

Энэ дэд ангид хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд өдөр өнжүүлэх, бага боловсролыг тоглоомын аргаар заах зэрэг суурин биш байдлаар үзүүлэх нийгмийн үйлчилгээ орно.

93493 Хөгжлийн бэрхшээлтэй насанд хүрэгчдэд үзүүлэх нийгмийн тусламжийн бусад төрлийн үйлчилгээ

Энэ дэд ангид хөгжлийн бэрхшээлтэй насанд хүрэгчдэд тусламж үзүүлэх үйлчилгээ орно.

935 Зориулалтын байргүй нийгмийн халамжийн бусад төрлийн үйлчилгээ

9351 Өдрөөр хүүхэд халамжлах үйлчилгээ

93510 Өдрөөр хүүхэд халамжлах үйлчилгээ

Энэ дэд ангид бага насны хүүхдүүдэд өдөр өнжүүлэх, бага боловсролыг тоглоомын аргаар заах сувлагчийн үйлчилгээ зэрэг суурин биш байдлаар үзүүлэх нийгмийн үйлчилгээ орно.

9352 Хүүхэдтэй холбоотой зааварчлага, зөвлөгөө өгөх үйлчилгээ

93520 Хүүхэдтэй холбоотой зааварчлага, зөвлөгөө өгөх үйлчилгээ

Энэ дэд ангид өөр газар ороогүй эцэг эхчүүдэд зориулан хүүхэдтэй холбоотой зааварчлага зөвлөгөө өгөх үйлчилгээ орно /тэдний гэрт нь эсвэл өөр газарт/.

Гэр бүл салалт, сургууль дээрх асуудал, хүчирхийллээс хамгаалах үйлчилгээ, үрчлэлтийн үйлчилгээ зэрэг хүүхдийн сэтгэл зүйтэй холбоотой үйлчилгээ багтана.

Харин гэрээр хийгдэх эрүүл мэндийн үйлчилгээ 93191, 93192-т орно.

9359 Зориулалтын байргүй нийгмийн халамжийн бусад төрлийн үйлчилгээ

93590 Зориулалтын байргүй нийгмийн халамжийн бусад төрлийн үйлчилгээ

Энэ дэд ангид хурим зохион байгуулах үйлчилгээ, хэрэгтэнг хугацаанаас өмнө суллах эсвэл тэнсэн харгалзах үйлчилгээ үзүүлэх, гамшгийн хохирогчид, дүрвэгсэд, цагаач, гадаадаас шилжин ирэгсдэд нийгмийн тусламж үзүүлэх үйлчилгээ, байрны үйлчилгээгүй нийгмийн бусад үйлчилгээ орно.

94 БОХИР УС, ХОГ ХАЯГДЛЫГ БОЛОВСРУУЛАХ, ЦЭВЭРЛЭХ БОЛОН БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ БУСАД ҮЙЛЧИЛГЭЭ

941 Бохир усны шугам, бохир ус, бохирдсон усан санг ариутгах, цэвэрлэх үйлчилгээ

9411 Бохир усны шугам, бохир усыг ариутгах, цэвэрлэх үйлчилгээ

94110 Бохир усны шугам, бохир усыг ариутгах, цэвэрлэх үйлчилгээ

Энэ дэд ангид дараах үйлчилгээ орно. Үүнд:

- шахуурга, хоолой, суваг зэрэг төхөөрөмжөөс бохирдсон усыг зайлуулах үйлчилгээ
- бохир усыг хаах, шүүх, тунгаах, химийн аргаар цэвэрлэх

Харин дараах үйлчилгээ орохгүй. Үүнд:

- усны хуримтлал, ариутгал (18000-д),
- сувгийн хоолой, дамжуулах хоолойг засварлах (54241, 54251-д),
- ус түгээх хувийн үйлчилгээ (69210-д),
- төлбөр эсвэл гэрээний үндсэн дээр ус түгээх (86330-д орно).

9412 Усан сангийн усыг юүлэх болон цэвэрлэх үйлчилгээ

94120 Усан сангийн усыг юүлэх болон цэвэрлэх үйлчилгээ

Энэ дэд ангид дараах үйлчилгээ орно. Үүнд:

- бохирдсон бассейн ба усан санг хоослох, цэвэрлэх үйлчилгээ
- бие засах газрын химийн үйлчилгээ

942 Хаягдал цуглуулах үйлчилгээ

9421 Аюултай хог, хаягдал цуглуулах үйлчилгээ

94211 Эмнэлгийн хортой хаягдал болон бусад төрлийн био аюултай хог, хаягдал цуглуулах үйлчилгээ

Энэ дэд ангид онцгой чанарын хог/ хаягдал цуглуулах үйлчилгээ орно. Үүнд:

- анатомийн болон анатомийн бус хог хаягдал, хурц үзүүртэй, иртэй хаягдал цуглуулах
- лаборатор, эмнэлгийн биологийн халдварт хаягдал
- биологийн бусад аюултай хаягдал

94212 Үйлдвэрлэлийн аюултай хог, хаягдал цуглуулах үйлчилгээ

Энэ дэд ангид аж үйлдвэрийн онцгой чанарын хог/ хаягдал цуглуулах үйлчилгээ орно. Үүнд:

- хүний эрүүл мэнд эсвэл байгаль орчинд сөргөөр нөлөөлөх /эмнэлгийн болон биологийн хаягдлаас бусад/ түүхий эд материал аюултай хаягдал

94219 Бусад төрлийн аюултай хог, хаягдлыг цуглуулах үйлчилгээ

Энэ дэд ангид дараах үйлчилгээ орно. Үүнд:

- аж үйлдвэрийн бус дараах онцгой чанарын хог/ хаягдал цуглуулах үйл ажиллагаа
- > хүний эрүүл мэнд эсвэл байгаль орчинд сөргөөр нөлөөлөх материал эд анги бүхий аюултай хаягдал

9422 Дахин боловсруулах аюулгүй хог, хаягдал цуглуулах үйлчилгээ

94221 Орон сууцны дахин боловсруулах аюулгүй хог, хаягдал цуглуулах үйлчилгээ

Энэ дэд ангид аюултай бус, дахин ашиглагдах хаягдал цуглуулах үйлчилгээ орно. Үүнд:

- оршин суугчдын хаясан ялгаж ангилаагүй цаас, хуванцар, шил, хөнгөн цагаан, төмөр

94229 Бусад төрлийн дахин боловсруулах аюулгүй хог, хаягдал цуглуулах үйлчилгээ

Энэ дэд ангид аж үйлдвэрийн бус дараах онцгой чанарын хог/ хаягдал цуглуулах үйлчилгээ орно. Үүнд:

- нийтийн эзэмшлийн газарт хаягдсан ялгаж ангилаагүй цаас, хуванцар, шил, хөнгөн цагаан, төмөр болон бусад хаягдлууд

9423 Орон сууцны нийтлэг хог, хаягдал цуглуулах үйлчилгээ

94231 Оршин суугчдын нийтлэг хог, хаягдал цуглуулах үйлчилгээ,

Энэ дэд ангид оршин суугчдын ахуйн хог, хаягдал цуглуулах үйлчилгээ орно.

94239 Нийтлэг бусад төрлийн хог, хаягдал цуглуулах үйлчилгээ

Энэ дэд ангид оршин суугчдын бус ахуйн хог, хаягдал цуглуулах үйлчилгээ орно.

943 Бусад төрлийн хог, хаягдлыг ариутгах, цэвэрлэх үйлчилгээ

9431 Хог цуглуулах, нийлүүлэх, хадгалах үйлчилгээ

94311 Аюултай хог, хаягдал цуглуулах, нийлүүлэх ба хадгалах үйлчилгээ

Энэ дэд ангид дараах үйлчилгээ орно. Үүнд:

- аюултай хог хаягдал нийлүүлэлт, түр хадгалах ба бэлтгэх үйлчилгээ
- аюултай хог хаягдлыг хог боловсруулах зориулалтын газарт тээвэрлэхэд бэлтгэн нийлүүлэх үйлчилгээ
- чингэлэг ба дамжуулах байгууламж, буулгах төвүүдийн үйлчилгээ

94312 Усан онгоцны эвдрэлийг засах, эвдэрч хэмхэрсэн эд ангийг задалж салгах үйлчилгээ

Энэ дэд ангид дараах үйлчилгээ орно. Үүнд:

- усан онгоцны эвдрэл
- эвдэрсэн автомашин, компьютер зэрэг дахин ашиглаж болох материал, эд ангийг салгах, эвдэрч хэмхэрсэн эд зүйлийг цуглуулах

Харин худалдах зорилгоор автомашины болон бусад эд ангийг цуглуулах үйлчилгээ бүлэг 61, 62-т орно.

94313 Аюулгүй хог хаягдлыг цуглуулах, нийлүүлэх, хадгалах, дахин боловсруулах үйлчилгээ

Энэ дэд ангид дараах үйлчилгээ орно. Үүнд:

- аюулгүй, дахин боловсруулж болох материал нийлүүлэх, түр хадгалах, бэлтгэх үйлчилгээ
- аюулгүй, дахин боловсруулах болох материалыг тээвэрлэх төхөөрөмжийн үйлчилгээ
- цэвэрлэх, төрөлжүүлэх гэх мэтээр аюултай бус, дахин боловсруулж болох материалыг сэргээх, бэлтгэх үйлчилгээ
- аюулгүй, дахин боловсруулж, болох материалын овор хэмжээг багасган, тээвэрлэхэд бэлтгэх үйлчилгээ

94319 Бусад төрлийн аюулгүй хог, хаягдал бэлтгэх, нийлүүлэх, хадгалах үйлчилгээ

Энэ дэд ангид дараах үйлчилгээ орно. Үүнд:

- аюултай биш хог хаягдал нийлүүлэх, түр хадгалах ба бэлтгэх
- аюултай биш хог хаягдлыг дамжуулан тээвэрлэх үйлчилгээ
- аюултай биш, дахин боловсруулж болох материалыг зориулалтын газарт овор хэмжээг багасган тээвэрлэхэд бэлтгэн нийлүүлэх

9432 Аюултай хог, хаягдал боловсруулах, зайлуулах үйлчилгээ

94321 Аюултай хог, хаягдал боловсруулах үйлчилгээ

Энэ дэд ангид аюултай хог хаягдлыг багасгах, устгах, хувиргах үйлчилгээ орно.
Дээрхи боловсруулалт нь биологийн, химийн ба физикийн эсвэл шатаах арга байж болно. Эдгээр боловсруулалтын үр дүнд материал гарган авч болно.

94322 Аюултай хог, хаягдал зайлуулах үйлчилгээ

Энэ дэд ангид хуулиар зөвшөөрөгдсөн стандартын тоног төхөөрөмжөөр аюултай хог хаягдлыг зайлуулах үйлчилгээ орно.

9433 Аюулгүй хог, хаягдал боловсруулах, зайлуулах үйлчилгээ

94331 Эрүүл ахуйн шаардлага хангасан аюулгүй хог хаягдлыг булаах, зайлуулах үйлчилгээ

Энэ дэд ангид хууль, журмын шаардлага хангасан газарт аюулгүй хог хаягдлыг булж зайлуулах үйлчилгээ орно.

94332 Аюулгүй хог хаягдлыг булаах, зайлуулах бусад төрлийн үйлчилгээ

Энэ дэд ангид шаардлага хангасан газраас өөр газарт аюулгүй хог хаягдлыг булж зайлуулах үйлчилгээ орно.

94333 Аюулгүй хог хаягдлыг шатаах үйлчилгээ

Энэ дэд ангид аюулгүй хог хаягдлыг хууль дүрмийн дагуу зөвшөөрөгдсөн газарт шатаах үйлчилгээ орно.

94339 Аюулгүй бусад хог хаягдлыг боловсруулах, зайлуулах үйлчилгээ

Энэ дэд ангид дараах үйлчилгээ орно. Үүнд:
- хөдөө аж ахуйн хог хаягдлын хими, биологийн аргаар хувиргах үйлчилгээ ба түүнтэй ижил үйлчилгээ

944 Байгалийг нөхөн сэргээх үйлчилгээ

Энэ бүлэгт аваарь ослын болон байгалийн бусад бохирдлоос үүсэн гарах байгаль орчны бохирдлыг нөхөн сэргээх үйлчилгээ багтана. Эдгээр үйлчилгээ нь хөрс, ус, агаарын бохирдлыг арилгахад чиглэгдэнэ.

9441 Агаарын бохирдлыг бууруулах үйлчилгээ

94411 Агаарын бохирдлыг бууруулах үйлчилгээ

Энэ дэд ангид бохирдсон газар нутгийн агаарын бохирдлыг нөхөн сэргээхэд чиглэсэн үйлчилгээ орно.

94412 Гадаргын ус нөхөн сэргээх, цэвэрлэх үйлчилгээ

Энэ дэд ангид бохирдсон газар нутгийн гадаргуугийн усыг цэвэршүүлэхэд чиглэсэн үйлчилгээ орно.

94413 Хөрс, хөрсний усыг нөхөн сэргээх, цэвэрлэх үйлчилгээ

Энэ дэд ангид дараах үйлчилгээ орно. Үүнд:
- бохирдсон газар нутгийн хөрс ба хөрсний усыг цэвэршүүлэхэд чиглэсэн үйлчилгээ
- зайлуулах, газар булаах үйлчилгээ
- аюултай хог хаягдлыг зайлуулах тоног төхөөрөмжийн үйлчилгээ, ашиглалт ба хориглох үйлчилгээ

9442 Газрын хяналт, шинжилгээ болон бусад төрлийн нөхөн сэргээх үйлчилгээ

94420 Газрын хяналт, шинжилгээ болон бусад төрлийн нөхөн сэргээх үйлчилгээ

Энэ дэд ангид дараах үйлчилгээ орно. Үүнд:

- талбайн бохирдлыг арилгахад чиглэсэн үйлчилгээ
- талбайн хяналтаас гарсан бохирдлын нүүлтийг таслан зогсоох үйлчилгээ
- нөхөн сэргээх үйл ажиллагааны үр дүнг тогтоох зорилгоор мониторинг хийх үйлчилгээ
- бохирдолтой газар нутгийг хянах үйлчилгээ
- нөхөн сэргээх бусад үйлчилгээ

9443 Барилгын талбайг нөхөн сэргээх үйлчилгээ

94430 Барилгын талбайг нөхөн сэргээх үйлчилгээ

Энэ дэд ангид барилгыг нүүлгэн шилжүүлэх, нураах эсвэл барилга доторхи асбест, хар тугалга, радон ба бусад бохирдлыг багасгах үйлчилгээ орно.

9449 Нөхөн сэргээх бусад төрлийн үйлчилгээ

94490 Нөхөн сэргээх бусад төрлийн үйлчилгээ

Энэ дэд ангид дараах үйлчилгээ орно. Үүнд:

- яаралтай тусламжийн үйлчилгээ
- нөхөн сэргээх бусад үйлчилгээ

945 Орчныг цэвэрлэх, ариутгах болон түүнтэй адил төстэй үйлчилгээ

94510 Хог цэвэрлэх болон цас арилгах үйлчилгээ

Энэ дэд ангид дараах үйлчилгээ орно. Үүнд:

- замын хогийг сорох үйлчилгээ
- гудамж шүүрдэх болон цэвэрлэх үйлчилгээ
- зам дээр элс болон давс цацах үйлчилгээ
- цасыг малтаж арилгах үйлчилгээ

94590 Ариутгах, цэвэрлэх бусад үйлчилгээ

Энэ дэд ангид дараах үйлчилгээ орно. Үүнд:

- далайн эргийг цэвэрлэх үйлчилгээ
- хог болон усны хоолойг цэвэрлэх үйлчилгээ

Харин дараах үйлчилгээ орохгүй. Үүнд:

- барилгын болон ХАА-н бус байгууламжийг халдваргүйжүүлэх устгал хийх (85310-д),
- ХАА-тай холбогдсон хортон шавьжийг устгах үйлчилгээ (86110-д орно).

949 Байгаль орчноо хамгаалах бусад төрлийн үйлчилгээ

94900 Байгаль орчноо хамгаалах бусад төрлийн үйлчилгээ

Энэ дэд ангид дараах үйлчилгээ орно. Үүнд:

- исэлдэлтийг арилгах (хүчлийн бороо) хяналт тавих, хохирлыг үнэлэх үйлчилгээ
- орчин тойрныг хамгаалах бусад үйлчилгээ (ангиллын бусад хэсэгт ороогүй)

95 ГИШҮҮНЧЛЭЛ БҮХИЙ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛЧИЛГЭЭ

Энэ дэд салбарт дараах үйлчилгээ орно. Үүнд:

- шашны үйл ажиллагааг зохион байгуулах, тэтгэх үйлчилгээ
- нийгэм, улс төрийг сурталчлах төрөл бүрийн үйлчилгээ
- гишүүдийн эрх ашгийг хамгаалах, дэмжих үйлчилгээ

Харин дараах үйлчилгээ орохгүй. Үүнд:

- дээрх байгууллагуудаас бусад орон байраар хангах үйлчилгээ (631-д),
- дээрх байгууллагуудаас үзүүлсэн боловсролын үйлчилгээ (92-д),
- дээрх байгууллагуудаас үзүүлсэн эрүүл мэнд, нийгмийн үйлчилгээ (93-д),
- дээрх байгууллагуудаас үзүүлсэн соёл, чөлөөт цаг, спортын үйлчилгээ (96-д орно).

951 Бизнесийн, ажил олгогчдын болон мэргэжлийн байгууллагуудын үйлчилгээ

9511 Бизнесийн болон ажил олгогч байгууллагын үйлчилгээ

95110 Бизнесийн болон ажил олгогч байгууллагын үйлчилгээ

Энэ дэд ангид худалдаа болон бизнесийн хөгжил, сайн сайхны төлөө сонирхол нэгтэй гишүүдийг нэгтгэсэн, төлөөлөх, хэлэлцээр хийх, мэдээлэл тархаах үйлчилгээг үзүүлдэг худалдаа, аж үйлдвэрийн танхим, бизнесийн болон ажил олгогч нарын гишүүнчлэлтэй байгууллагуудын үйлчилгээ орно.

Харин тухайн байгууллагыг төлөөлөн үзүүлсэн олон нийттэй харилцах үйлчилгээ 83121-д орно.

9512 Мэргэжлийн чиглэлийн гишүүнчлэл бүхий байгууллагын үйлчилгээ

95120 Мэргэжлийн чиглэлийн гишүүнчлэл бүхий байгууллагын үйлчилгээ

Энэ дэд ангид мэргэжлийн чиглэлээр онол, техник, арга барилыг онцлон сонирхсон гишүүдээс бүрдсэн мэргэжлийн байгууллагын төлөөлөх, хэлэлцээр хийх, мэдээлэл тархаах зэрэг үйлчилгээ орно.

952 Үйлдвэрчний эвлэлийн байгууллагын үйлчилгээ

95200 Үйлдвэрчний эвлэлийн байгууллагын үйлчилгээ

Энэ дэд ангид ажилчин, албан хаагчдаас бүрдсэн гишүүдтэй ажлын байдал болон зохион байгуулалтын талаар ажиллагчдыг төлөөлөх, хэлэлцээр хийх, мэдээлэл тархаах зэрэг үйл ажиллагаа явуулдаг холбооны үйлчилгээ орно.

959 Олон нийтийн бусад төрлийн байгууллагын үйлчилгээ

9591 Шашны байгууллагын үйлчилгээ

95910 Шашны байгууллагын үйлчилгээ

Энэ дэд ангид дараах үйлчилгээ орно. Үүнд:

- шашинд сүсэглэх, сургалтын болон судлах үйлчилгээ
- шашны тусгай үйлчилгээ (гэрлэлт, нас баралттай холбоотой)
- шашны бусад үйлчилгээ (шашны ёсыг хэрэгжүүлдэг газраас явуулдаг үйлчилгээ, жнь: хүмүүсийг тайван орчинд байлгах г/м)
- шашны төлөөлөгчийн үйлчилгээ

95920 Улс төрийн намуудын үйл ажиллагаа

Энэ дэд ангид улс төрийн намууд болон түүнтэй адилтгах байгууллагуудаас үзүүлж буй мэдээлэл тархаах, олон нийттэй харилцах, санхүүжилтийг нэмэгдүүлэх зэрэг үйлчилгээ орно.

9599 Гишүүнчлэл бүхий бусад төрлийн байгууллагын үйлчилгээ

95991 Хүний эрхийн байгууллагын үйлчилгээ

Энэ дэд ангид иргэдийн санаачилгын болон эсэргүүцлийн хөдөлгөөнүүдэд мэдээлэл тархаах, улс төрийн нөлөө үзүүлэх, санхүүжилтээ нэмэгдүүлэх зэрэг иргэдийн эрхийг хамгаалах зорилготой гишүүнчлэлтэй байгууллагуудын үйлчилгээ орно.

95992 Байгаль орчны сурталчилгаа хийх, зөвлөгөө өгөх байгууллагын үйлчилгээ

Энэ дэд ангид зэрлэг амьтдыг хамгаалах байгууллагын үзүүлэх үйлчилгээ, байгаль хамгаалах зорилготой гишүүнчлэлтэй байгууллагын мэдээлэл тархаах, улс төрийн нөлөөлөл, санхүүжилтээ өсгөхөөр байгаль хамгаалах, яриа хэлэлцээр явуулах үйлчилгээ орно.

95993 Бусад төрлийн тусгай бүлэглэлийн сурталчилгааны үйлчилгээ

Энэ дэд ангид тусгай бүлгийн хүмүүсийг хамгаалах тухайлбал хөгжлийн бэрхшээлтэй, үндэстэн, ястан, бусад жижиг бүлгийн хүмүүсийн бүх нийтийн боловсрол, улс төрийн нөлөөлөл, тэдний нэгдэл, нийгмийн үйл ажиллагааг дэмжих, сайжруулах үйлчилгээ орно.

95994 Иргэдийн амьжиргааг сайжруулах, тэдэнд үзүүлж буй нийгмийн үйлчилгээг дэмжих бусад төрлийн үйлчилгээ

Энэ дэд ангид дараах үйлчилгээ орно. Үүнд:

- гишүүнчлэлийн байгууллагуудаас үзүүлж буй нийтийг хамарсан боловсрол, улс төрийн нөлөөлөл зорилготой үйлчилгээ
- эх оронч байгууллагуудын болон ахмад дайчдын холбооны үйлчилгээ
- нийгмийг дэмжсэн болон боловсрол, нийгмийн үйл ажиллагааг сайжруулахад чиглэсэн байгууллагуудын үйлчилгээ

95995 Залуучуудын холбооны үйлчилгээ

Энэ дэд ангид дараах үйлчилгээ орно. Үүнд:

- залуучуудын болон хүүхдийн холбооны үйлчилгээ
- оюутны холбоо болон клуб, ах дүүгийн холбооны үйлчилгээ
- охидын болон хөвгүүдийн скаутын холбооны үйлчилгээ

Харин оюутны дотуур байр болон оюутан ах дүүсийн орон байраар хангах үйлчилгээ 63210-д орно.

95996 Тусламжийн байгууллагын үйлчилгээ

Энэ дэд ангид гишүүнчлэлт байгууллагууд эсвэл сангуудаас боловсрол, бүх нийтийн болон нийгмийн сонирхлыг судлахад зориулсан судалгааг санхүүжүүлэх тусламжийн үйлчилгээ орно.

Харин зээлийн тусламжийн үйлчилгээ 713-т орно.

95997 Соёлын болон чөлөөт цагийн холбоо (спорт, тоглоомынхоос бусад төрлийн)

Энэ дэд ангид яруу найраг, уран зохиолын болон номын, түүхчдийн, цэцэрлэгчдийн, киноны, фото зургийн, хөгжмийн, урлагийн, уран дархны, цуглуулагчдын зэрэг холбоо болон хобби(спортын тоглоомоос бусад), соёл, чөлөөт цагийн үйл ажиллагааг дэмжих үйлчилгээ орно.

Харин дараах үйлчилгээ орохгүй. Үүнд:

- спортын клубын үйлчилгээ (96512-д),
- мэргэжлийн жүжигчдийн байгууллагын үйлчилгээ (962-д орно).

95998 Иргэний болон нийгмийн бусад төрлийн байгууллагын үйлчилгээ

Энэ дэд ангид дараах үйлчилгээ орно. Үүнд:

- хэрэглэгчдийн нийгэмлэгийн үйлчилгээ
- автомашины холбооны үйлчилгээ
- олонд танигдсан нийгмийн зорилготой холбоонууд, "Ротари" клубийн үйлчилгээ

95999 Гишүүнчлэл бүхий бусад төрлийн байгууллагын холбооны үйлчилгээ

Энэ дэд ангид дараах үйлчилгээ орно. Үүнд:

- сууц өмчлөгчдийн болон түрээслэгчдийн холбооноос үзүүлж буй үйлчилгээ
- бусад хэсэгт ороогүй гишүүнчлэлтэй байгууллагын үзүүлж буй үйлчилгээ

96 ЧӨЛӨӨТ ЦАГ, СОЁЛ, БИЕЙН ТАМИРЫН АРГА ХЭМЖЭЭНИЙ ҮЙЛЧИЛГЭЭ

961 Дуу, дүрс бичлэгийн үйлчилгээ

9611 Дуу бичлэг хийх үйлчилгээ

96111 Дуу бичлэг хийх үйлчилгээ

Энэ дэд ангид дуу бичлэгийн студи, тусгай тоног төхөөрөмжийг ашиглан дуу, үг болон хөгжмийг хувиргахтай холбогдсон үйлчилгээ орно.

Харин дараах үйлчилгээ орохгүй. Үүнд:

- *студиас гадуур концертын танхим, цэнгэлдэх хүрээлэн, хурлын танхим зэрэгт хийгдсэн амьд бичлэг (96112-д),*

- *дуу бичлэгийн студи болон дуу бичлэгийн хэрэгслээр хангах(хэрэглэгч нь анхан шатны техникч болон операторчаар өөрсдөө хангах үед) үйлчилгээ (73129-д орно).*

96112 Амьд бичлэг хийх үйлчилгээ

Энэ дэд ангид дараах үйлчилгээ орно. Үүнд:

- хурал, семинар, уулзалт, концерт зэрэг олон нийтийн үйл ажиллагаан дээр амьдаар бичлэг хийх үйлчилгээ

-дуу, бичлэгийн студид хийгдсэн радиогийн амьд бичлэг

Харин студид хийгдсэн дуу бичлэгийн үйлчилгээ 96111-д орно.

96113 Дуу бичлэгийн эх бэлтгэх үйлчилгээ

Энэ дэд ангид дуу, үг, хөгжмийг тоон(дигитал) болон аналог хэлбэрт хөрвүүлсэн бичлэг хийх үйлчилгээ орно.

9612 Кино зураг авах, дүрс/видео бичлэг хийх, телевиз, радиогийн нэвтрүүлэг бэлтгэх үйлчилгээ

96121 Кино зураг авах, дүрс/видео бичлэг хийх, телевизийн нэвтрүүлэг бэлтгэх үйлчилгээ

Энэ дэд ангид дараах үйлчилгээ орно. Үүнд:

- кинотеатрт үзүүлэх зориулалттай, шог зургийг амьдруулах зэргийг оролцуулсан кино зургийн үйлдвэрлэл

- телевизийн зориулалттай олон ангит цуврал, телекино, шог зургийг амилуулсан зэрэг бүх төрлийн кино зургийн үйлдвэрлэл

- рекламн зориулалттай кино зургийн үйлдвэрлэл

- телевизийн шууд эсвэл урьдчилан бэлдсэн нэвтрүүлгийн үйлдвэрлэл

Харин киноны үйл явдлыг харуулсан зураг болон слайд хэлбэрийн киноны үйлдвэрлэл 8381-д орно.

96122 Радио нэвтрүүлэг бэлтгэх үйлчилгээ

Энэ дэд ангид радиогийн шууд эсвэл урьдчилан бэлтгэсэн нэвтрүүлгийн үйлчилгээ орно.

96123 Кино, кассет, телевиз болон радиогийн нэвтрүүлэг эх хувь бэлтгэх үйлчилгээ

9613 Бичлэгийн дараах үйлдвэрлэл, үйлчилгээ

Энэ дэд ангид кино, дүрс бичлэг эсвэл дигитал хэрэгсэл зэрэг бичлэгийн ажилд компьютержсэн болон электроник дүрс дууны боловсруулалт хийх үйлчилгээгээр хангах: Жишээ нь засвар, хөрвүүлэг, өнгөний засвар, харагдах үр дүн, хөдөлгөөнт хэлбэрт оруулах, хувиргах формат, шахах тоон хэлбэрт оруулж кодчлох (дигитал), тайлбар хийх, гарчиглах, дэлгэцийн доор орчуулгыг гүйлгэн гаргах, дууны засвар болон загварчлах үйлчилгээ орно.

96131 Дуу, дүрс/видео бичлэгийн засвар хийх үйлчилгээ

Энэ дэд ангид дараах үйлчилгээ орно. Үүнд:

- слайдын төхөөрөмж, прожектор, DVD зэрэг техник, тоног төхөөрөмжийг ашиглан үйл явдлын уялдаа холбоо, жүжгийн болон үзвэр үйлчилгээний талаас үйл явдлыг сонгож, үнэлж, шинжилгээ хийснээр кино, дүрс бичлэг, дигитал хэрэгсэл зэрэг бичлэгийн ажлын үзэгдэх байдал болон аудио талыг төлөвлөх болон зохион байгуулах үйлчилгээ орно.

- жүжигчдийн тоглолтыг кино болон видео дүрсийн сангаас нэгтгэх үйлчилгээ

96132 Эх хувийг хуулбарлах болон хөрвүүлэх үйлчилгээ

Энэ дэд ангид дараах үйлчилгээ орно. Үүнд:

Энэ дэд ангид баримт нотолгооны онцлог шинжүүдийг хадгалах эсвэл форматыг тохируулах зорилгоор нэг форматаас нөгөөд хөрвүүлэх, кино, дүрс бичлэг, дигитал хэрэгсэл зэрэг бичлэгийн ажлыг хөрвүүлэх

(Тухайлбал эх хувь нь элэгддэг учраас эх хувь эсвэл хуулбарын нөөцийг бий болгох) Жишээлбэл: хальсыг хуурцагт, хуурцгаа хальсанд, дижитал хэрэгслээс хальсанд, дижитал хэрэгслээс хуурцагт, дуу хэлбэрээс дүрс бичлэгт, зургийг дүрс бичлэгт гэх зэргээр хөрвүүлэх

- хальснаас бусад бичлэгийн ажлыг хуулбарлах болон олшруулах үйлчилгээ, өөрөөр хэлбэл, олон төрлийн хэрэглээнд видео, дижитал хэрэгсэл гэх зэрэг бичлэгийн ажлын урт болон богино хугацааны хуулбаруудыг бий болгох үйлчилгээ. Энэ хуулбарыг VHS, DVD, олон ангит зэрэг төрөл бүрийн форматаар хийж болно.

96133 Өнгөний тохиргоо болон дижитал /тоон/ системийг сэргээн засварлах үйлчилгээ

Энэ дэд ангид дараах үйлчилгээ орно. Үүнд:

- өнгөний тохиргоо хийх үйлчилгээ өөрөөр хэлбэл дижитал технологи ашиглан электронигоор хальс, дүрс бичлэг эсвэл дижитал хэрэгсэл зэрэг бичлэгийн ажлаас өнгө нэмэх, өөрчлөх эсвэл хасах

- бичлэгт ажилд дижитал сэргээн засварлах үйлчилгээ, өөрөөр хэлбэл, киног хөрвүүлэх үйл явцад процессд бэлэн байлгахын тулд дижитал техникийг ашиглаж хальс, дүрс бичлэг эсвэл дижитал хэрэгсэл зэрэг бичлэгийн ажлаас зурагдсан хэсгийг хасах

96134 Визуал /хараа зүйн/ нөлөө хийх үйлчилгээ

Энэ дэд ангид үндсэн зураг эсвэл тохиолдсон гол үйл явдал, бага хэмжээний зураг, дурангийн болон дижитал үр дүн, бүдэг зураг, давхардсан хэвлэлт, өнгө алдалт болон бага хэмжээний тайлбар гэх мэтийн дараагийн шатанд зургийн эсвэл дижитал технологийг ашиглан хальс, дүрс бичлэг эсвэл дижитал хэрэгсэл зэрэг бичлэгийн ажилд харагдах үр дүнг оруулах үйлчилгээ орно.

96135 Хөдөлгөөн оруулах үйлчилгээ

Энэ дэд ангид дараах үйлчилгээ орно. Үүнд:

- дараалсан зургууд эсвэл компьютерээр хөдөлгөөн оруулан олон төрлийн техникийг ашигласан зураг, хийсвэр загвар болон төсөөтэй жинхэнэ зохиолуудыг бүтээх үйлчилгээ

- шавраар хийсэн дүрүүд болон амьгүй зүйлүүдийг хөдөлгөөнд оруулах үйлчилгээ

96136 Тайлбар хийх, гарчиглах болон дэлгэцийн доор орчуулга, тайлбар гүйлгэх үйлчилгээ

Энэ дэд ангид дараах үйлчилгээ орно. Үүнд:

- бичлэгийн ажилд тайлбар хийх үйлчилгээ:

> дэлгэцэн дээр тогтмол харагддаг ил тайлбарын үйлчилгээ

> хэрэглэгчийн сонголтоор дэлгэцэн дээр ил харагдах далд тайлбарын үйлчилгээ

- бичлэгийн ажилд гарчиг өгөх үйлчилгээ өөрөөр хэлбэл эхний гарчиг, жүжигчдийн нэрс болон үгсийг агуулсан текстээр хальс, дүрс бичлэг, эсвэл дижитал хэрэгсэл зэрэг бичлэгийн ажлыг нэмэгдүүлж тодруулах үйлчилгээ бүхий дэлгэцэн дээр харуулах төхөөрөмж болон график элементүүдийг нэмэх

- бичлэгт орчуулгыг дэлгэцийн доор гүйлгэн харуулах үйлчилгээ, өөрөөр хэлбэл, харилцан яриа болон жинхэнэ бичлэгийн ажлын гарчгийг тухайн кино эсвэл видео дүрсийг үзүүлж буй улсын хэл рүү орчуулан дэлгэцэн дээр оруулсан текст

96137 Дуу засвар хийх болон загварын/дизайны үйлчилгээ

Энэ дэд ангид дараах үйлчилгээ орно. Үүнд:

- дуу бичлэгийн давхцлыг оруулахад аудио визуал ажлын дууны элемент (харилцан яриа, хөгжим, дуу чимээ болон нам гүм)-ийг оруулах, бичих нэмэх үйлчилгээ

> аудио визуал бичлэгийн ажлын киноны дууны дахь зохиосон, бичсэн, тааруулсан, нэгтгэсэн эхний хөгжим болон дуу чимээ

> аудио визуал бичлэгийн ажлын дэс дараалалд тохируулсан хөгжмийн бичлэг

> аудио визуал бичлэгийн ажилд хэрэглэгчийн тусгай зөвшөөрөлтэй нийлүүлсэн хөгжим, аяыг оруулах үйлчилгээ

- дуу болон хөгжмийн лицензтэй агентийн үйлчилгээ болон дуу, аяыг нэгтгэх үйлчилгээ

96139 Үйлдвэрлэлийн дараах бусад төрлийн үйлчилгээ

Энэ дэд ангид форматын хувиргалт, шахах үйлчилгээ зэрэг бичлэгийн ажлын дараах бусад үйлчилгээ орно.

9614 Кино, хуурцаг, телевиз, радиогийн нэвтрүүлэг үзүүлэх үйлчилгээ

96140 Кино, хуурцаг, телевиз, радиогийн нэвтрүүлэг үзүүлэх үйлчилгээ

Энэ дэд ангид театр, телевизор, гэрийн видео, зах зээлд ихэвчлэн зориулагдсан шууд нэвтрүүлэг эсвэл хөдөлгөөнт кино, видео, дижитал бичлэгийн оруулах зөвшөөрөлтэй, захиалагчийн эрх хамгаалагдсан бичлэгийн ажлыг түрээслэх, нэвтрүүлэх, гаргах, зөвшөөрөл олгох үйлчилгээ орно.

9615 Кино болон видео бичлэгийг үзүүлэх үйлчилгээ

96151 Кино үзүүлэх үйлчилгээ

Энэ дэд ангид кино театрууд, задгай талбай, кино клубууд, хувийн кино үзүүлдэг өрөөнүүд эсвэл бусад проекцын тоног төхөөрөмжүүдээр кино үзүүлэх үйлчилгээ орно.

96152 Видео бичлэг үзүүлэх үйлчилгээ

Энэ дэд ангид кино театрууд, задгай талбай, кино клубууд, хувийн кино үзүүлдэг өрөөнүүд эсвэл бусад проекцын тоног төхөөрөмжүүдээр видео бичлэг үзүүлэх үйлчилгээ орно.

962 Урлагийн тоглолт болон бусад төрлийн урлаг, уран сайхны тоглолт зохион байгуулах үйлчилгээ

9621 Уран бүтээл туурвих үйлчилгээ

96210 Уран бүтээл туурвих үйлчилгээ

Энэ дэд ангид доор дурьдсан тоглолтуудыг туурвих үйлчилгээ орно.

- > театр, дуурь, балет, хөгжмийн, концертын тоглолт
- > дуу болон гэрлийн тоглолт
- > хүүхэлдэйн шоу
- > галын наадам
- > циркийн урлагийн тоглолт

9622 Урлаг, уран сайхны тоглолтын үйлчилгээ

96220 Урлаг, уран сайхны тоглолтын үйлчилгээ

Энэ дэд ангид доор дурьдсан тоглолтуудыг хийх, үзүүлэх үйлчилгээ орно.

- > театр, дуурь, балет, хөгжмийн, концертын тоглолт
- > хүүхэлдэйн шоу
- > циркийн урлагийн тоглолт

Харин гэрлийн болон галын наадам зохион байгуулах үйлчилгээ орохгүй. (96990-д орно).

9623 Урлагийн тоглолтыг тоног хэрэгслээр хангах үйлчилгээ

96230 Урлагийн тоглолтыг тоног хэрэгслээр хангах үйлчилгээ

Энэ дэд ангид дараах үйлчилгээ орно. Үүнд:

- концертын танхим, театр, дуурийн театр, хөгжмийн танхимуудыг ашиглах үйлчилгээ. Үүнд: тасалбарын үйлчилгээ
- янз бүрийн зорилго бүхий төв болон урлагийн зориулалт бүхий ижил төстэй тоног төхөөрөмжийн үйлчилгээ

Харин цэнгэлдэх хүрээлэн болон тайз, дэвжээг ашиглах үйлчилгээ орохгүй. (96520-д орно).

9629 Урлагийн болон хөгжөөнт бусад төрлийн тоглолт үзүүлэх үйлчилгээ

96290 Урлагийн болон хөгжөөнт бусад төрлийн тоглолт үзүүлэх үйлчилгээ

Энэ дэд ангид дараах үйлчилгээ орно. Үүнд:

- аудио визуал бичлэгийн ажил болон кино урлагаас бусад хөгжмийн, утга зохиолын, урлагийн тоглолтуудыг нэгтгэсэн эрх бүхий байгууллагын удирдах үйлчилгээ
- үзвэр үйлчилгээнд туслах үйлчилгээ (тайз засал болон хөшигний ашиглалт, гэрэлтүүлэг, дууны төхөөрөмж)

Харин хувийн театрын эсвэл урлагийн агентлагуудын үйлчилгээ орохгүй. (85999-д орно).

- 963 Урлаг, уран сайхны бусад төрлийн үйлчилгээ**
9631 Жүжигчид, дуучид, хөгжимчид, бүжигчдийн тоглолт үзүүлэх үйлчилгээ
96310 Жүжигчид, дуучид, хөгжимчид, бүжигчдийн тоглолт үзүүлэх үйлчилгээ

Энэ дэд ангид дараах үйлчилгээ орно. Үүнд:

- жүжигчид, уран уншигчид, дуучид, хөгжимчид, бүжигчид, орлон тоглогчид, телевизийн мэргэжлийн хөтөлөгчид болон бусад жүжигчдийн тоглолтын үйлчилгээ
- загвар өмсөгчдийн бие даасан үйлчилгээ

- 9632 Зохиогч, хөгжмийн зохиолч, барималч болон бусад төрлийн урлагийн ажилтны үйлчилгээ; урлагийн бүтээлийг сэргээх үйлчилгээ**
96320 Зохиогч, хөгжмийн зохиолч, барималч болон бусад төрлийн урлагийн ажилтны үйлчилгээ; урлагийн бүтээлийг сэргээх үйлчилгээ

Энэ дэд ангид дараах үйлчилгээ орно. Үүнд:

- зохиолчид, хөгжмийн зохиолчид, уран барималчдын үйлчилгээ
- тайз засагчид, гэрлийн техникчид, хувцасны загвар зохион бүтээгчийн үйлчилгээ
- урлагийн бүтээлийг сэргээн засварлах үйлчилгээ

- 9633 Урлагийн жүжигчид, зураачид, уран барималчдаас бусад төрлийн жүжигчид, зохиолчид, хөгжмийн зохиолчдын эх бүтээл**
96330 Урлагийн жүжигчид, зураачид, уран барималчдаас бусад төрлийн жүжигчид, зохиолчид, хөгжмийн зохиолчдын эх бүтээл

Энэ дэд ангид дараах үйлчилгээ орно. Үүнд:

- зохиолчдын бүтээл болох номын гар бичмэл
 - хөгжмийн зохиолчдын бүтээл болох зохиолчийн эрхээ шилжүүлээгүй эх бүтээл
 - тоглолтын жүжигчид, зураачид, уран барималчдаас бусад жүжигчид
- Эдгээр эх бүтээлүүдийг өөрөө туурвисан байна. Өөрөөр хэлбэл гэрээ, хэлэлцээр эсвэл нэртэй худалдан авагчдын захиалгаар хийгээгүй зөвхөн худалдах зориулалтаар зохиосон бүтээлүүд орно.

Харин зураачид болон уран барималчдын эх бүтээл туурвих үйлчилгээ 38961-д орно.

- 964 Музей, түүх, соёлын дурсгалт эд зүйл хамгаалах үйлчилгээ**
9641 Музей болон түүх, соёлын дурсгалт газар, байшин, барилгыг хамгаалах үйлчилгээ
96411 Музейн үйлчилгээ

Энэ дэд ангид дараах үйлчилгээ орно. Үүнд:

- олон төрлийн цуглуулгыг дэлгэн харуулах үйлчилгээ (урлаг, шинжлэх ухаан болон технологи, түүхийн бүтээл)
- цуглуулгыг хамгаалах болон зохион байгуулах үйлчилгээ
- цуглуулга, үзмэрийн үзэсгэлэнгийн аяллыг зохион байгуулах

Харин дараах үйлчилгээ орохгүй. Үүнд:

- худалдааны урлагийн галерейны үйлчилгээ болон дэлгэн харуулах үйлчилгээ (62299-д),
- түүхийн дурсгалт газрын болон барилгын үйлчилгээ (96412-т),
- ургамлын цэцэрлэг болон амьтдын хүрээлэнгийн үйлчилгээ (96421-д орно).

- 96412 Түүх, соёлын дурсгалт газар, байшин, барилгыг хамгаалах үйлчилгээ**

Энэ дэд ангид дараах үйлчилгээ орно. Үүнд:

- түүхийн дурсгалт газар, хөшөө, барилгуудыг хамгаалах үйлчилгээ, түүгээр аялах болон ашиглах үйлчилгээ
- түүхийн дурсгалт газар, хөшөө, барилгуудыг хамгаалах үйлчилгээ

- 9642 Ургамал, амьтны хүрээлэн, дархан цаазат газрын үйлчилгээ**
96421 Ургамал, амьтны хүрээлэнгийн үйлчилгээ

Энэ дэд ангид дараах үйлчилгээ орно. Үүнд:

- ургамлын цэцэрлэг болон амьтны хүрээлэнгийн үйлчилгээ, түүгээр аялах болон ашиглах үйлчилгээ
- ургамлын цэцэрлэг болон амьтны хүрээлэнгийн хамгаалалт болон засвар үйлчилгээ

96422 Дархан цаазат газар, байгалийн цогцолборт газрыг хамгаалах үйлчилгээ

Энэ дэд ангид дараах үйлчилгээ орно. Үүнд:

- үндэсний парк, байгалийн парк, байгалийн цогцолбор, нөөц газрын үйлчилгээ болон аяллын үйлчилгээ
- үндэсний парк, байгалийн парк, байгалийн цогцолбор, нөөц газрыг хянан шалгах үйлчилгээ
- үндэсний парк, байгалийн парк, байгалийн цогцолбор, нөөц газрын хамгаалалт болон дахин сэргээх үйлчилгээ

965 Биеийн тамир, амралт, зугаа цэнгэлийн үйлчилгээ

9651 Биеийн тамир, бие бялдар чийрэгжүүлэх спортын тоглолт зохион байгуулах үйлчилгээ

96511 Спорт болон чөлөөт цагийн спортын үйл ажиллагааг дэмжих үйлчилгээ

Энэ дэд ангид спортын тоног төхөөрөмжөөр хангагдаагүй спортын арга хэмжээг дэмжигч эсвэл продюсорын үйлчилгээ орно.

96512 Спортын клубын үйлчилгээ

Энэ дэд ангид хөл бөмбөгийн, боулингийн, усанд сэлэлтийн, гольфийн, боксын, бялдаржуулах урлагийн, өвлийн спортын, хөнгөний болон талбайн спортын үйл ажиллагааг явуулахад дэмжлэг үзүүлдэг, спортын арга хэмжээг зохион байгуулах болон зохицуулах үүрэг бүхий клубуудын үйлчилгээ орно.

9652 Спорт болон чөлөөт цагийн спортын тоног төхөөрөмжөөр үйлчлэх үйлчилгээ

96520 Спорт болон чөлөөт цагийн спортын тоног төхөөрөмжөөр үйлчлэх үйлчилгээ

Энэ дэд ангид дараах үйлчилгээ орно. Үүнд:

- цэнгэлдэх хүрээлэн, тайз, дэвжээ, усан сан, спортын талбар, гүйлтийн зам, гольфийн талбай, боулингийн талбай, теннисний талбай зэрэг талбайн болон танхимын спорт, чөлөөт цагийн спортын үйл ажиллагааг явуулах, тоноглолыг ажиллуулах болон ашиглуулах үйлчилгээ
- морь унах спортын хүрээлэнгийн үйлчилгээ

Харин төлбөр болон гэрээний үндсэн дээр хийгддэг орон сууцны барилгын удирдлага, зохион байгуулалтын үйлчилгээ 72212-т орно.

9659 Биеийн тамирын бусад төрөл, чийрэгжүүлэх спортын үйлчилгээ

96590 Биеийн тамирын бусад төрөл, чийрэгжүүлэх спортын үйлчилгээ

Энэ дэд ангид дараах үйлчилгээ орно. Үүнд:

- шүхрийн спортын үйлчилгээ
- дельтапланы спортын үйлчилгээ
- амьсгалын багажтай усан доогуур шумбах спортын үйлчилгээ

966 Тамирчин болон тэдний бэлтгэл сургуулилтанд туслах үйлчилгээ

9661 Тамирчдын бэлтгэл сургуулилын үйлчилгээ

96610 Тамирчдын бэлтгэл сургуулилын үйлчилгээ

Энэ дэд ангид хувийн тооцоотой ажилладаг, бэлтгэл сургуулилт хийдэг тамирчдад үзүүлэх ажил, үйлчилгээ орно.

9662 Спортод зориулсан туслах үйлчилгээ

96620 Спортод зориулсан туслах үйлчилгээ

Энэ дэд ангид дараах үйлчилгээ орно. Үүнд:

- шүүгч, цаг бүртгэгчээр хангагдсан үйлчилгээ
- ууланд хөтөч хамт явуулах үйлчилгээ
- анчтай цуг анд явах үйлчилгээ
- загасчинтай загасанд явах үйлчилгээ
- спортын болон үзүүлэнгийн амьтдыг сургахтай холбоотой үйлчилгээ

- бусад ангид ороогүй спортын болон чөлөөт цагийн үйлчилгээ

Харин спортын тоног төхөөрөмжийн түрээсийн үйлчилгээ 73240-д орно.

969 Чөлөөт цагт зориулсан бусад үйлчилгээ

96910 Амралт, чөлөөт цагт зориулагдсан цэнгэлдэх хүрээлэнгийн үйлчилгээ

Энэ дэд ангид дараах үйлчилгээ орно. Үүнд:

- цэнгэлдэх хүрээлэнгийн үйлчилгээ
- сонирхол татсан болон хөгжилтэй яармаг, үзэсгэлэнгийн үйлчилгээ
- хамгаалалтын төмөр замыг ашиглах үйлчилгээ

9692 Мөрийтэй, бооцоотой тоглоом тоглуулах үйлчилгээ

96921 Сүлжээгээр /он-лайн/ мөрийтэй тоглоом тоглуулах үйлчилгээ

Энэ дэд ангид сүлжээгээр мөрий тавих үйлчилгээ орно.

96929 Бусад төрлийн мөрийтэй болон бооцоот тоглоом тоглуулах үйлчилгээ

Энэ дэд ангид дараах үйлчилгээ орно. Үүнд:

- хонжворт сугалаа, лото, морины уралдааны бооцоот үйлчилгээ үзүүлэх болон зохион байгуулах
- казино болон танхимд бооцоо тавих үйлчилгээ
- жетоноор ажилладаг мөрийтэй тоглоомын үйлчилгээ

9693 Зоосоор ажилладаг тоглоом тоглуулагч машины үйлчилгээ

96930 Зоосоор ажилладаг тоглоом тоглуулагч машины үйлчилгээ

9699 Амралт, чөлөөт цагт зориулагдсан бусад төрлийн үйлчилгээ

96990 Амралт, чөлөөт цагт зориулагдсан бусад төрлийн үйлчилгээ

Энэ дэд ангид дараах үйлчилгээ орно. Үүнд:

- үдэшлэг явуулах үйлчилгээ, бүжгийн өрөө болон бусад амралт, чөлөөт цагийн төхөөрөмжийн үйлчилгээ
- цанын үйлчилгээ
- амралт, чөлөөт цагийн цэцэрлэг болон далайн наран шарлагын газрын үйлчилгээ
- дараах уран сайхны бүтээл болон урлагийн тоглолтын үйлчилгээ:
 - > дуу болон гэрэлтүүлэг
 - > гэрлэн чимэглэлийн үйлчилгээ

Харин дараах үйлчилгээ орохгүй. Үүнд:

- төлбөр болон гэрээний үндсэн дээр явуулдаг орон сууцны бус хөрөнгийн үйлчилгээ (72212-т),
- хувь хүний театрын болон уран сайхны агентлагийн үйлчилгээ (85999-д),
- хөдөлгөөнт зураг, телевиз болон бусад театрын үйлчилгээ (85999-д),
- биеийн тамирын үйл ажиллагаа явуулах үйлчилгээ болон бусад амралт, чөлөөт цагт зориулсан биеийн тамирын төхөөрөмжийн үйлчилгээ (96520-т орно).

97 БУСАД ҮЙЛЧИЛГЭЭ

971 Угаах, цэвэрлэх, будах үйлчилгээ

9711 Нийтийн төлбөрт, угаалгын машины үйлчилгээ

97110 Нийтийн төлбөрт, угаалгын машины үйлчилгээ

Энэ дэд ангид зоосоор ажилладаг машинаар нэхмэл эдлэлийг хувь хүн өөрөө цэвэрлэх үйлчилгээ орно.

9712 Хими цэвэрлэгээний үйлчилгээ (үслэг эдлэл цэвэрлэх үйлчилгээ орно)

97120 Хими цэвэрлэгээний үйлчилгээ (үслэг эдлэл цэвэрлэх үйлчилгээ орно)

Энэ дэд ангид хувцас, бусад нэхмэл эдлэл, үслэг болон арьсан эдлэлийн хуурай цэвэрлэгээний үйлчилгээ орно.

9713 Нэхмэл эдлэл цэвэрлэх бусад төрлийн үйлчилгээ

97130 Нэхмэл эдлэл цэвэрлэх бусад төрлийн үйлчилгээ

Энэ дэд ангид дараах үйлчилгээ орно. Үүнд:

- нэхмэл хувцас, эдлэл угаах, цэвэрлэх, индүүдэх үйлчилгээ
- угаалгын газарт зориулсан угаах, цэвэрлэх, индүүдэх үйлчилгээ
- өрхөд зориулсан угаах, цэвэрлэх, индүүдэх үйлчилгээ
- нэхмэл эдлэл, хивс цэвэрлэх үйлчилгээ
- хивс, нэхмэл бүрээс, хананд өлгөдөг аравч цэвэрлэх үйлчилгээ

Харин дараах үйлчилгээ орохгүй. Үүнд:

- хувцас түрээслэх үйлчилгээ (73260-т),
- хуурай цэвэрлэгээний үйлчилгээ (97120-т орно).

9714 Нэхмэл эдлэл дээрх хээ, дүрс хэвлэх үйлчилгээ

97140 Нэхмэл эдлэл дээрх хээ, дүрс хэвлэх үйлчилгээ

Энэ дэд ангид хувцас болон бусад нэхмэл эдлэлийн хэвлэлийн үйлчилгээ орно.

9715 Будах, өнгө оруулах үйлчилгээ

97150 Будах, өнгө оруулах үйлчилгээ

Энэ дэд ангид бэлэн хувцас болон бусад нэхмэл эдлэлийн зүйлсийг хатаах, өнгө оруулах үйлчилгээ орно.

Харин нэхмэлийн утас, бөс даавууг хатаах, өнгө оруулах үйлчилгээ 88122-т орно.

972 Гоо сайхан, бие махбодыг эрүүл байлгах үйлчилгээ

9721 Үс засах үйлчилгээ

97210 Үс засах үйлчилгээ

Энэ дэд ангид дараах үйлчилгээ орно. Үүнд:

- үс угаах, хайчлах, засах үйлчилгээ
- сахал хусах болон засах үйлчилгээ

9722 Гоо засал, хумс засах үйлчилгээ

97220 Гоо засал, хумс засах үйлчилгээ

Энэ дэд ангид дараах үйлчилгээ орно. Үүнд:

- гоо заслын эмчилгээ оруулаад нүүрний болон арьс эмчилгээ
- хумс болон хөлийн хумс засах, будах үйлчилгээ
- гоо сайхан, нүүрний арьс хамгаалах болон будах зөвлөгөө өгөх үйлчилгээ

Харин нүүрний мэс заслын үйлчилгээ зэрэг эрүүл мэнд хамгаалах үйлчилгээ орохгүй. (931-д орно).

9723 Эрүүлжүүлэх физик эмчилгээний үйлчилгээ

97230 Эрүүлжүүлэх физик эмчилгээний үйлчилгээ

Энэ дэд ангид турк ванн, саун, уурын ванн, нар тусах өрөө, рашаанд оруулах, жин бууруулах болон усан бассейн, бялдаржуулалтын төв, иллэгийн үйлчилгээ орно (эмчилгээний иллэг орохгүй).

Харин эрүүл мэндийн эмчилгээний үйлчилгээ 931-д орно.

9729 Гоо сайхны бусад төрлийн үйлчилгээ

97290 Гоо сайхны бусад төрлийн үйлчилгээ

Энэ дэд ангид хувь хүний ариун цэвэр, биеийн арьс хамгаалах, биеийн үс авах, хэт ягаан туяа болон инфрагаар шарах болон ариун цэврийн бусад үйлчилгээ орно.

Харин эрүүл мэндийн эмчилгээний үйлчилгээ 931-д орно.

973 Оршуулга, түүнд холбогдох үйлчилгээ

9731 Оршуулах, чандарлах үйлчилгээ

97310 Оршуулах, чандарлах үйлчилгээ

Энэ дэд ангид дараах үйлчилгээ орно. Үүнд:

- оршуулгын газрыг болон булш манах, хамгаалах үйлчилгээ
- хүүр шатаах үйлчилгээ

Энэ дэ ангид оршуулгын газрыг цэцэрлэгжүүлэх, засах үйлчилгээ орохгүй. (85991-д орно).

9732 Оршуулах ёслолын үйлчилгээ
97320 Оршуулах ёслолын үйлчилгээ

Энэ дэд ангид дараах үйлчилгээ орно. Үүнд:

- оршуулах болон хүүр шатаах үйлчилгээний ёслолын ажлыг зохион байгуулах үйлчилгээ
- булшлах болон үл булшлах үйлчилгээ
- занданшуулах үйлчилгээ, оршуулгын авс бэлтгэх үйлчилгээ
- хүүр зөөх үйлчилгээ

979 Төрөл бүрийн бусад төрлийн үйлчилгээ
9791 Хувь хүнийг хүн болон машин, унаа, эд зүйлээр хамгаалах, дагалдуулан явуулах үйлчилгээ

97910 Хувь хүнийг хүн болон машин, унаа, эд зүйлээр хамгаалах, дагалдуулан явуулах үйлчилгээ

Энэ дэд ангид дараах үйлчилгээ орно. Үүнд:

- олон нийтийн үйл явдал болон үзвэр тоглолтын үеэр үзүүлэх үйлчилгээ
- биеэ үнэлэх үйлчилгээ

9799 Бусад төрөл бүрийн үйлчилгээ
97990 Бусад төрөл бүрийн үйлчилгээ

Энэ дэд ангид дараах үйлчилгээ орно. Үүнд:

- гэрлэлтийн бүртгэлийн үйлчилгээ
- хэл, бичиг болон уг гарлын судлалын үйлчилгээ
- одон орон, зурхай, сүнстэй ярилцах үйлчилгээ
- олон нийтийн нийтлэгчийн үйлчилгээ
- шивээс хийх үйлчилгээ
- бие цоолох үйлчилгээ
- малгай, гутал өнгөлөх болон машины гараажийн үйлчилгээ
- нийтийн угаалгын өрөөний/жорлонгийн үйлчилгээ
- амьтан сургах үйлчилгээ
- цусны даралт хэмжих, гутал өнгөлөх, зураг авах зэрэг хувь хүн өөрөө зоосоор ажиллуулдаг машины үйлчилгээ
- дээр ороогүй бусад үйлчилгээ

Харин дараах үйлчилгээ орохгүй. Үүнд:

- хууль зүйн баримтын эх зохиох үйлчилгээ (82130-д),
- зохиолчийн үйлчилгээ (96320-д),
- ил зогсоолын үйлчилгээ (67430-д орно).

98 ДОТООД ҮЙЛЧИЛГЭЭ
980 Дотоод үйлчилгээ
9800 Дотоод үйлчилгээ
98000 Дотоод үйлчилгээ

Энэ дэд ангид зарц, тогооч, хүүхэд асрагч, гэрийн хүмүүжүүлэгч зэрэг өрхөд хувиараа хөдөлмөр эрхэлж байгаа хүмүүсийн үйлчилгээ орно.

Харин өрхөд үйлчилгээ үзүүлдэг бие даасан нэгжийн үйлчилгээ орохгүй. (хувь хүнийг оруулаад)

99 ОЛОН УЛСЫН БАЙГУУЛЛАГА, СУУРИН ТӨЛӨӨЛӨГЧИЙН ЭРХЛЭН ЯВУУЛДАГ ҮЙЛЧИЛГЭЭ

990 Олон улсын байгууллага, суурин төлөөлөгчийн эрхлэн явуулдаг үйлчилгээ
9900 Олон улсын байгууллага, суурин төлөөлөгчийн эрхлэн явуулдаг үйлчилгээ
99000 Олон улсын байгууллага, суурин төлөөлөгчийн эрхлэн явуулдаг үйлчилгээ

Энэ дэд ангид дараах үйлчилгээ орно. Үүнд:

- улс орноос суугаа элчин сайдын яамд болон төлөөлөгчийн газруудаас үзүүлж буй үйлчилгээ
- НҮБ болон түүний төрөлжсөн байгууллага, АНУ, ЕХ, Африкийн холбоо, Арабын улсуудын холбоо, ЭЗХАХБ, Дэлхийн Гаалийн Байгууллага, газрын тос экспортлогч орнуудын байгууллага зэрэг олон улсын байгууллагууд, нутаг дэвсгэрээс гадна оршиж буй байгууллага, хувь хүмүүсийн үзүүлж буй үйлчилгээ.